



67.91
T 534
19047

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

Тусгай дугаар

IVБОТЬ

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

Улсын Их Хурлын Тамгын газар,
Гадаад хэргийн яам
Улаанбаатар хот
2006 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2006 оны 3 дугаар сарын 1-ний өдөр

ТУСГАЙ ДУГААРЫН IV БОТЬ

Гарчиг



УНШЛАГА

Найм. ТЕРРОРИЗМЫН ЭСРЭГ КОНВЕНЦУУД

72. Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенц 865
73. Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай конвенц 870
74. Олон улсын хамгаалалтад байдаг хүмүүс, түүний дотор дипломат төлөөлөгчдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон шийтгэх тухай конвенц.....877
75. Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенц..... 883
76. Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенц 895
77. Хүн барьцаанд авахын эсрэг олон улсын конвенц 904
78. Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай Монреаль хотноо 1971 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр үйлдсэн конвенцийн Олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудал дахь хүч хэрэглэсэн хууль бус үйлдлийг хориглох тухай нэмэлт протокол 911
79. Хуванцар тэсрэх бодис илрүүлэх зорилгоор тэмдэг тавих тухай конвенц 914
80. Терроризмын зорилгоор бөмбөг хэрэглэхийг хориглох тухай олон улсын конвенц 922
81. Терроризмыг санхүүжүүлэхийг хориглох тухай олон улсын конвенц 933

Ес. БУСАД ГЭМТ ХЭРГИЙН ЭСРЭГ КОНВЕНЦУУД

82. Боолчлол, боолын худалдааг хориглох тухай конвенц 947
83. Боолчлол, боолын худалдаа болон боолчлолтой адилтгах ёс, заншлыг устгах тухай нэмэлт конвенц..... 951
84. Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц 957



85. Соёлын үнэт зүйлсийн хууль бус экспорт, импорт, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай конвенц..... 996
86. Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц 1005
87. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенц..... 1033

Найм. ТЕРРОРИЗМЫН ЭСРЭГ КОНВЕНЦУУД

**72. АГААРЫН ХӨЛГИЙГ ХУУЛЬ БУСААР БУЛААН
АВАХ ҮЙЛДЛИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ КОНВЕНЦ**

1970 оны 12 дугаар сарын 16-ны өдөр баталж,
1971 оны 10 дугаар сарын 14-ний өдөр хүчин төгөлдөр болсон*

Энэхүү конвенцид оролцогч улс,

нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийг булаан авах хууль бус үйлдэл нь хүмүүсийн болон эд хөрөнгийн аюулгүй байдалд занал учруулж нисэхийн үйл ажиллагаанд ноцтой нөлөөлж, иргэний нисэхийн аюулгүй байдалд дэлхийн хүмүүсийн итгэлийг бууруулж байгааг харгалзаж,

ийм үйлдэл гарч байгаа нь сэтгэл ихэд түгшүүлж байгааг харгалзаж,

ийм үйлдлийг таслан зогсоох зорилгоор гэмт этгээдүүдийг шийтгэх талаар зохих арга хэмжээ авах нь нэн шаардлагатай болсныг харгалзаж,

дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

1 дүгээр зүйл

Нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн бүхээгт дараахь үйлдэл хийсэн аливаа этгээдийг гэмт хэрэг (цаашид “гэмт хэрэг” гэх) үйлдсэн гэж үзнэ:

(а) хууль бусаар хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл айлган сүрдүүлэх бусад хэлбэрээр агаарын хөлгийг булаан авсан, эсхүл хяналтаа тогтоосон, эсхүл ийм үйлдэл хийхийг завдсан, эсхүл

(б) ийм үйлдлийг үйлдсэн, эсхүл үйлдэхийг завдсан этгээдтэй хамтран оролцсон бол.

2 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч улс бүр дурдсан гэмт хэрэгт хүнд ял оногдуулах үүрэг хүлээнэ.

3 дугаар зүйл

1. Энэхүү конвенцийн зорилгод ачаалсны дараа бүх гадна хаалгыг хаасан үеэс эхлэн ачаа буулгахаар уг хаалгуудын аль нэгийг нээх хүртэл агаарын хөлгийг нислэг үйлдэж байгаад тооцно. Албадан буулт хийлгэсэн тохиолдолд зохих эрх бүхий этгээд агаарын хөлөг, түүний бүхээгт байгаа хүмүүс, эд хөрөнгийн төлөө хүлээх хариуцлагыг өөртөө шилжүүлж авах хүртэл нислэгийг үргэлжилж байгаад тооцно.

2. Энэхүү конвенцийг цэрэг, гааль, цагдаагийн албанд ашигладаг агаарын хөлгийн хувьд хэрэглэхгүй.

* Монгол Улс 1971.01.18-нд гарын үсэг зурж, 1971.10.08-нд нэгдэн орсон

3. Энэхүү конвенцийг зөвхөн бүхээгт нь гэмт хэрэг үйлдэгдсэн агаарын тухайн хөлгийн хөөрсөн, буусан газар нь агаарын тухайн хөлгийг бүртгэсэн улсын нутаг дэвсгэрийн гадна байгаа тохиолдолд хэрэглэх бөгөөд уг агаарын хөлөг олон улсын, дотоодын нислэгийн алиныг эрхэлдгээс үл хамаарна.

4. 5 дугаар зүйлд дурдсан тохиолдолд бүхээгт нь гэмт хэрэг үйлдэгдсэн агаарын тухайн хөлгийн хөөрсөн болон буусан газар нэг улсын нутаг дэвсгэрт харьяалагдах бөгөөд уг улс нь дээрх зүйлд дурдсан улсын нэг мөн бол энэхүү конвенцийг хэрэглэхгүй.

5. Энэ зүйлийн 3, 4 дэх хэсэгт заасныг үл харгалзан хэрэв гэмт этгээд буюу гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа этгээдийг агаарын хөлгийг бүртгэсэн улсаас өөр улсын нутаг дэвсгэрт олж тогтоосон бол агаарын хөлгийн хөөрсөн, буусан газраас үл хамааран 6, 7, 8, 10 дугаар зүйлийг хэрэглэнэ.

4 дүгээр зүйл

1. Хэлэлцэн тохирогч улс бүр дор дурдсан тохиолдолд онгоцны баг болон зорчигчдын эсрэг сэжиглэгдэж байгаа этгээдийн үйлдсэн гэмт хэрэг болон хүч хэрэглэсэн бусад үйлдлийг харьяалан шийдвэрлэх талаар тухайн гэмт хэрэгтэй холбогдох шаардлагатай байж болох арга хэмжээ авна:

(a) гэмт хэргийг тухайн улсад бүртгэгдсэн агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн;

(b) бүхээгт нь гэмт хэрэг үйлдэгдсэн агаарын хөлөг сэжигтэн этгээд бүхээгт нь байхад тус улсын нутаг дэвсгэр дээр буусан;

(c) үйл ажиллагаа явуулдаг үндсэн газар нь, эсхүл тийм газар байхгүй бол байнга оршин суудаг газар нь тухайн улсад байдаг түрээслэгчид агаарын хөлгийг багийн гишүүдгүйгээр түрээсэлсэн байхад түүний бүхээгт гэмт хэрэг үйлдэгдсэн бол.

2. Хэлэлцэн тохирогч улс бүр тухайн сэжигтэн түүний нутаг дэвсгэр дээр байгаа бөгөөд түүнийг 8 дугаар зүйлд зааснаар энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан улсын аль нэгэнд шилжүүлж өгөхгүй бол хэргийг харьяалан шийдвэрлэх арга хэмжээ нэгэн адил авна.

3. Энэхүү конвенц нь үндэсний хууль тогтоомжийн дагуу аливаа эрүүгийн хэргийн харьяаллыг хэрэгжүүлэхэд саад болохгүй.

5 дугаар зүйл

Хамтарсан буюу олон улсын бүртгэлд бүртгүүлбэл зохих агаарын хөлөг ашигладаг хамтарсан агаарын тээврийн ашиглалтын байгууллага буюу олон улсын ашиглалтын агентлаг байгуулж байгаа хэлэлцэн тохирогч улсууд агаарын хөлөг бүрийн хувьд өөрсдийн дотроос аль улс нь энэхүү конвенцийн зорилгод хэргийн харьяаллаа хэрэгжүүлэх, бүртгэгч улс болохыг тогтоож, энэ тухайгаа Олон улсын иргэний нисэхийн байгууллагад мэдэгдэх бөгөөд тухайн байгууллага уг мэдээллийг энэхүү конвенцид оролцогч бүх улсад дамжуулна.

6 дугаар зүйл

1. Нөхцөл байдал тийнхүү шаардаж байгаа гэж үзвэл гэмт этгээд буюу сэжигтэн этгээд нутаг дэвсгэр дээр нь байгаа хэлэлцэн тохирогч аль нэгэн улс түүнийг цагдан хорих буюу бэлэн байлгах нөхцөлийг хангах арга хэмжээ авна. Цагдан хорих болон бусад арга хэмжээг тухайн улсын хуульд зааснаар авах боловч гагцхүү эрүүгийн байцаан шийтгэх буюу шилжүүлэн өгөх ажиллагаанд шаардагдах хугацаагаар үргэлжлүүлж болно.

2. Тухайн улс нь хэргийн талаархи урьдчилсан мөрдөн байцаалтыг нэн даруй явуулна.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар цагдан хоригдсон аливаа этгээдэд өөрийн улсын хамгийн ойр байгаа зохих төлөөлөгчтэй нэн даруй холбоо тогтоох бололцоо олгоно.

4. Энэ зүйлд зааснаар цагдан хорьсон улс агаарын хөлгийг бүртгэсэн улс, 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн (с)-д дурдсан улс болон уг этгээдийг харьяалах улсад нэн даруй мэдэгдэх, түүнчлэн шаардлагатай гэж үзвэл сонирхогч бусад улсад тийм этгээдийг цагдан хорьсон, цагдан хорих болсон нөхцөл байдлыг мэдэгдэнэ. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан урьдчилсан мөрдөн байцаалт явуулж байгаа улс олж тогтоосон зүйлийг дээр дурдсан улсад шуурхай мэдээлж хэргийг харьяалан шийдвэрлэх эсэхээ мэдэгдэнэ.

7 дугаар зүйл

Нутаг дэвсгэр дээр нь сэжигтэн этгээд илэрч тогтоогдсон хэлэлцэн тохирогч улс түүнийг шилжүүлэн өгөхгүй байвал гэмт хэрэг түүний нутаг дэвсгэр дээр гарсан эсэхээс үл хамааран яллуулахаар өөрийн эрх бүхий байгууллагад шилжүүлнэ. Тэрхүү эрх бүхий байгууллага нь тухайн улсын хуульд заасны дагуу ноцтой шинж агуулсан ердийн хэрэгтэй адил журмаар шийдвэрлэнэ.

8 дугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч улсын хооронд байгуулсан шилжүүлэн өгөх тухай аль нэгэн гэрээнд тухайн гэмт хэргийг шилжүүлэн өгвөл зохих гэмт хэрэгт оруулан заана. Хэлэлцэн тохирогч улсууд хоорондоо байгуулах шилжүүлэн өгөх тухай гэрээ бүртгээ уг гэмт хэргийг оруулах үүрэг хүлээнэ.

2. Шилжүүлэн өгөхийг гэрээ байгуулсан эсэхээс хамааруулан авч үздэг хэлэлцэн тохирогч улс тийм гэрээ байхгүй хэлэлцэн тохирогч өөр улсаас шилжүүлэн өгөх хүсэлт хүлээж авсан бол өөрийн үзэмжээрээ энэ конвенцийг тухайн гэмт хэргийг шилжүүлэн өгөх хууль зүйн үндэслэл болгож болно. Шилжүүлэн өгөхийг хүсэлт хүлээж авсан улсын хуулийн дагуу гүйцэтгэнэ.

3. Шилжүүлэн өгөхийг гэрээ байгуулсан эсэхээс хамааруулан авч үздэггүй хэлэлцэн тохирогч улс тухайн гэмт хэргийг хоорондоо шилжүүлэн өгвөл зохих гэмт хэрэг гэж хүсэлт хүлээж авсан улсын хуулийн дагуу хүлээн зөвшөөрнө.

4. Хэлэлцэн тохирогч улсуудын хооронд шилжүүлэн өгөх зорилгоор тухайн гэмт хэргийг зөвхөн үйлдэгдсэн газар нь бус, мөн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу харьяаллаа тогтоохыг шаардсан улс болгоны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэж үзнэ.

9 дүгээр зүйл

1. 1 дүгээр зүйлийн (а)-д дурдсан аль нэг үйлдлийг үйлдсэн буюу үйлдэхийг завдсан бол хэлэлцэн тохирогч улсууд багийн хууль ёсны ахмадын агаарын хөлөгт тавих хяналтыг сэргээн тогтоох буюу агаарын хөлөгт тавих хяналтыг хадгалах зохих бүхий л арга хэмжээ авна.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан тохиолдолд агаарын хөлөг, түүний зорчигчид буюу баг байгаа аливаа хэлэлцэн тохирогч улс зорчигчид, багийн нислэгийг аль болохоор түргэн үргэлжлүүлэх явдлыг хялбар болгон агаарын хөлөг, түүний ачааг хууль ёсны эзэмшигчид хойшлуулалгүйгээр эргүүлэн өгнө.

10 дугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч улс 4 дүгээр зүйлд дурдсан гэмт хэрэг, бусад үйлдэлд явуулж байгаа эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны талаар бие биедээ аль болох бүрэн хэмжээгээр туслалцаа үзүүлнэ. Хүсэлт хүлээж авсан улсын хууль бүх тохиолдолд үйлчилнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалт эрүүгийн хэргийн талаар харилцан туслалцаа үзүүлэх тухай аливаа хоёр талт буюу олон талт бусад гэрээгээр хүлээсэн үүрэгт нөлөөлөхгүй.

11 дүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч улс бүр дотоодынхоо хуулийн дагуу өөрт байгаа дараахь мэдээ баримтыг Олон улсын иргэний нисэхийн байгууллагын зөвлөлд яаралтай хүргүүлнэ:

(а) гэмт хэргийн нөхцөл байдал;

(b) 9 дүгээр зүйлийн дагуу гүйцэтгэсэн ажиллагаа;

(c) гэмт хэрэгтэн буюу сэжигтэн этгээдийн талаар авсан арга хэмжээ, тухайлбал, шилжүүлэн өгөх ажиллагаа буюу эрх зүйн бусад ажиллагааны үр дүн.

12 дугаар зүйл

1. Энэхүү конвенцийг тайлбарлах буюу хэрэглэх талаар хэлэлцэн тохирогч хоёр, түүнээс дээш улсын хооронд хэлэлцээ хийх замаар шийдвэрлэх боломжгүй аливаа маргааныг тэдгээрийн аль нэгийн хүсэлтээр арбитраг шилжүүлнэ. Арбитрын тухай хүсэлт гаргаснаас хойш зургаан сарын хугацаанд талууд арбитраг зохион байгуулах талаар тохиролцож чадаагүй бол талуудын аль нь ч хэргийг Олон улсын шүүхэд түүний дүрэмд заасны дагуу хүсэлт гарган шилжүүлж болно.

2. Энэхүү конвенцид гарын үсэг зурах, түүнийг соёрхон батлах буюу нэгдэн орох үед өмнөх хэсэгт заасан үүргийг хүлээхгүй гэж үзэж байгаагаа мэдэгдэж болно. Хэлэлцэн тохирогч бусад улс ийм тайлбар хийсэн хэлэлцэн тохирогч аливаа улсын өмнө өмнөх хэсэгт заасан үүргийг хүлээхгүй.

3. Энэ зүйлийн өмнөх хэсэгт зааснаар тайлбар хийсэн хэлэлцэн тохирогч аливаа улс эх хадгалагч засгийн газруудад мэдэгдэх замаар түүнийгээ хэдийд ч хүчингүй болгож болно.

13 дугаар зүйл

1. Энэхүү конвенц нь 1970 оны 12 дугаар сарын 1-16-ны өдөр Гаагад болсон Олон улсын агаарын эрх зүйн бага хурал (цаашид “Гаагийн бага хурал” гэх)-д оролцогч улсын хувьд 1970 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Гаагад гарын үсэг зурахад нээлттэй байна. 1970 оны 12 дугаар сарын 31-нээс хойш конвенц нь бүх улсын хувьд Москва, Лондон, Вашингтон хотноо гарын үсэг зурахад нээлттэй байна. Энэ конвенцид энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар хүчин төгөлдөр болохоос өмнө гарын үсэг зураагүй аливаа улс түүнд хэдийд ч нэгдэн орж болно.

2. Энэхүү конвенцид гарын үсэг зурсан улс түүнийг соёрхон батална. Батламж жуух бичиг болон нэгдэн орсон тухай баримт бичгийг Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газарт хадгалуулах бөгөөд эдгээр улсыг эх хадгалагч засгийн газраар энэхүү конвенцоор томилсон болно.

3. Энэхүү конвенц нь Гаагийн бага хуралд оролцож конвенцид гарын үсэг зурсан арван улс батламж жуух бичгээ хадгалуулсан өдрөөс хойш гуч хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

4. Бусад улсын хувьд энэхүү конвенц нь энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар хүчин төгөлдөр болсон өдөр, эсхүл тэдгээрээс батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгийн аль сүүлд өгч хадгалуулсан өдрөөс хойш гуч хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

5. Эх хадгалагч засгийн газрууд гарын үсэг зурсан болон нэгдэн орсон бүх улсад гарын үсэг зурсан өдөр, батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулсан өдөр, энэхүү конвенцийн хүчин төгөлдөр болох өдөр болон бусад зүйлийн талаар даруй мэдэгдэнэ.

6. Энэхүү конвенцийг хүчин төгөлдөр болмогц Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн 102, Олон улсын иргэний нисэхийн тухай конвенц (Чикаго, 1944 он)-ийн 83 дугаар зүйлд заасны дагуу эх хадгалагч засгийн газруудад бүртгүүлнэ.

14 дүгээр зүйл

1. Хэлэлцэн тохирогч аливаа улс эх хадгалагч засгийн газруудад бичгээр мэдэгдэх замаар энэхүү конвенцоос гарч болно.

2. Конвенцоос гарах нь эх хадгалагч засгийн газрууд мэдэгдлийг хүлээж авсан өдрөөс хойш 6 сарын дараа хүчин төгөлдөр болно.

Дээр дурдсаныг нотолж зохих ёсоор засгийн газраасаа бүрэн эрх олгогдсон төлөөлөгчид энэ конвенцид гарын үсэг зурав.

Нэг мянга есөн зуун далан оны арван хоёрдугаар сарын арван зургааны өдөр Гаага хотноо тус бүр нь жинхэнэ эх болох адил хүчинтэй англи, франц, орос, испани дөрвөн хэлээр гурван хувь үйлдэв.

73. ИРГЭНИЙ НИСЭХИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ХУУЛЬ БУС ҮЙЛДЛИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ КОНВЕНЦ

1971 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр баталж,
1973 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр хүчин төгөлдөр болсон*

Энэхүү конвенцид оролцогч улс,

иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн хууль бус явдал хүний амь нас болон эд хөрөнгийн аюулгүй байдалд заналхийлж, агаарын харилцааг ноцтой зөрчиж, иргэний нисэхийн аюулгүй байдалд дэлхийн улс түмний итгэх итгэлийг эвдэнэ гэж үзэж,

ийм явдал гарсаар байгаад сэтгэл ихэд түгшиж байгаагаа илэрхийлж,

ийм явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор гэмт этгээдийг шийтгэхийн тулд зохих арга хэмжээ нэн даруй авах зайлшгүй шаардлагатай болсон гэж үзэж,

дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

1 дүгээр зүйл

1. Хэрэв аливаа этгээд дараахь үйлдлийг хууль бусаар болон санаатайгаар үйлдсэн бол түүнийг гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ:

(a) нислэг үйлдэж буй агаарын хөлгийн бүхээгт яваа хүний эсрэг хүч хэрэглэсэн бөгөөд энэ нь агаарын тухайн хөлгийн аюулгүй байдалд аюул учруулахаар байвал;

(b) нислэг хийх боломжгүй болгох буюу нислэгийн үед аюул учруулахуйц байдлаар ашиглалтанд байгаа агаарын хөлгийг бүрмөсөн эвдсэн, эсхүл түүнд гэмтэл учруулсан;

(c) ашиглалтанд байгаа агаарын хөлгийг эвдэх, эсхүл түүнийг бүрмөсөн эвдэх буюу нислэг үйлдэх боломжгүй болохуйц хохирол учруулахаар гэмтээх чадалтай төхөөрөмж, бодисыг ямар нэг аргаар байрлуулах буюу байрлуулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулсан;

(d) агаарын навигацын тоног төхөөрөмжийг эвдсэн, гэмтээсэн, эсхүл түүний ашиглалтад саад учруулсан бөгөөд аливаа иймэрхүү үйл ажиллагаа нь агаарын хөлгийн нислэгийн аюулгүй байдалд аюул учруулсан;

(e) худал гэдгийг нь мэдсээр байж агаарын хөлгийн нислэгт аюул учруулж болохуйц мэдээлэл өгснийг тус тус гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ.

* Монгол Улс 1972.01.26-нд гарын үсэг зурж, 1972.09.14-нд соёрхон багтасан

2. Хэрэв аливаа этгээд дараахь үйлдлийг мөн хийсэн гүйцэтгэсэн бол түүнийг гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ:

(a) энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдэхээр завдсан;

(b) ийм гэмт хэрэг үйлдсэн буюу үйлдэхийг завдаж байгаа этгээдийн үйлдэлд хамтран оролцсон.

2 дугаар зүйл

Энэхүү конвенцийн зорилгод:

(a) ачаалсны дараа бүх гадна хаалгыг хаасан үеэс эхлэн ачаа буулгахаар уг хаалгуудын аль нэгийг нээх хүртэл агаарын хөлгийг нислэг үйлдэж байгаад тооцно. Албадан буулт хийлгэсэн тохиолдолд зохих эрх бүхий этгээд агаарын хөлөг, түүний бүхээгт байгаа хүмүүс, эд хөрөнгийн төлөө хүлээх хариуцлагыг өөртөө шилжүүлж авах хүртэл нислэгийг үргэлжилж байгаад тооцно;

(b) газрын бие бүрэлдэхүүн буюу багаас тодорхой нислэг хийхээр агаарын хөлгийг нислэгийн өмнө бэлтгэж эхэлсэн үеэс уг агаарын хөлөг бууснаас хойш хорин дөрвөн цаг өнгөрөх хүртэл хугацаанд агаарын хөлгийг ашиглалтанд байгаад тооцно. Энэ зүйлийн (a) хэсэгт заасан агаарын хөлөг нислэгээ аль ч тохиолдолд үргэлжлүүлж байгаа бүх хугацааг онгоц ашиглалтанд байгаа хугацаанд тооцно.

3 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч улс бүр энэхүү конвенцийн 1 дүгээр зүйлд дурдсан гэмт хэрэгт хүнд ял оногдуулах үүрэг хүлээнэ.

4 дүгээр зүйл

1. Энэхүү конвенц нь цэрэг, гааль, цагдаагийн албанд ашигладаг агаарын хөлгийн хувьд хэрэглэхгүй.

2. Энэхүү конвенцийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн (a), (b), (c), (d) дэд хэсэгт дурдсан тохиолдолд агаарын хөлөг олон улсын буюу дотоодын агаарын шугамд нислэг хийж байсан эсэхийг үл хамааран дараахь тохиолдолд энэхүү конвенцийг хэрэглэнэ:

(a) агаарын хөлгийн жинхэнэ хөөрсөн буюу буусан, хөөрөхөөр буюу буухаар төлөвлөсөн газар нь агаарын тухайн хөлгийг бүртгэсэн улсын нутаг дэвсгэрийн гадна байгаа;

(b) агаарын тухайн хөлгийн бүртгэлтэй улсаас өөр улсын нутаг дэвсгэр дээр гэмт хэрэг үйлдэгдсэн бол.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үл харгалзан 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн (a), (b), (c), (d) дэд хэсэгт заасан тохиолдолд хэрэв гэмт хэрэгтэн буюу сэжигтэн этгээдийг агаарын хөлгийн бүртгэлтэй улсаас өөр улсын нутаг дэвсгэрт олж тогтоосон бол энэхүү конвенцийг мөн адил хэрэглэнэ.

4. 9 дүгээр зүйлд заасан улсууд болон 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн (a), (b), (c), (d) дэд хэсэгт заасан тохиолдлын хувьд хэрэв энэ зүйлийн 2 дахь хэсгийн (a) дэд хэсэгт заасан газар 9 дүгээр зүйлд дурдсан улсын аль нэгнийх нь нутаг дэвсгэрт байрлаж байгаа бол тухайн улсаас өөр улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдэгдсэн, эсхүл гэмт этгээдийг олж тогтоохоос бусад үед энэхүү конвенцийг хэрэглэхгүй.

5. Хэрэв агаарын навигацын тоног төхөөрөмжийг олон улсын агаарын навигацад ашиглаж байгаа бол энэхүү конвенцийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн (d) дэд хэсэгт заасан тохиолдолд энэхүү конвенцийг хэрэглэнэ.

6. Энэ зүйлийн 2, 3, 4, 5 дахь хэсгийн заалтыг энэхүү конвенцийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан тохиолдолд мөн хэрэглэнэ.

5 дугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч улс бүр дор дурдсан тохиолдолд гэмт хэргийн харьяаллаа тогтоох шаардлагатай байж болох арга хэмжээ авна:

(a) гэмт хэрэг тухайн улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн;

(b) гэмт хэрэг тухайн улсад бүртгэгдсэн агаарын хөлгийн эсрэг, эсхүл бүхээгт нь үйлдэгдсэн;

(c) бүхээгт нь гэмт хэрэг үйлдэгдсэн агаарын хөлөг сэжигтэн этгээд бүхээгт нь байхад тус улсын нутаг дэвсгэр дээр буусан;

(d) үйл ажиллагаа явуулдаг үндсэн газар нь, эсхүл тийм газар байхгүй бол байнга оршин суудаг газар нь тухайн улсад байдаг түрээслэгчид агаарын хөлгийг багийн гишүүдгүйгээр түрээсэлсэн байхад түүний бүхээгт гэмт хэрэг үйлдэгдсэн бол.

2. Хэлэлцэн тохирогч улс бүр өөрийн улсын нутаг дэвсгэр дээр байгаа сэжигтэн этгээдийг энэ зүйлийн 1-дэх хэсэгт дурдсан улсын аль нэгэнд 8 дугаар зүйлийн дагуу шилжүүлэн өгөөгүй бол 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн (a), (b), (c) дэд хэсэгт дурдсан гэмт хэрэг, мөн эдгээр гэмт хэрэгтэй холбогдох 2 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт харьяаллаа тогтоохын тулд шаардлагатай байж болох арга хэмжээ мөн авна.

3. Энэхүү конвенц нь үндэсний хууль тогтоомжийн дагуу аливаа эрүүгийн хэргийн харьяаллыг хэрэгжүүлэхэд саад болохгүй.

6 дугаар зүйл

1. Нөхцөл байдал тийнхүү шаардаж байгаа гэж үзвэл гэмт этгээд буюу сэжигтэн этгээд нутаг дэвсгэр дээр нь байгаа хэлэлцэн тохирогч аль нэгэн улс түүнийг цагдан хорих буюу бэлэн байлгах нөхцөлийг хангах арга хэмжээ авна. Цагдан хорих болон бусад арга хэмжээг тухайн улсын хуульд зааснаар авах боловч гагцхүү эрүүгийн байцаан шийтгэх буюу шилжүүлэн өгөх ажиллагаанд шаардагдах хугацаагаар үргэлжлүүлж болно.

2. Тухайн улс нь хэргийн талаархи урьдчилсан мөрдөн байцаалтыг нэн даруй явуулна.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар цагдан хоригдсон аливаа этгээдэд өөрийн харьяаллын улсын хамгийн ойр байгаа зохих төлөөлөгчтэй нэн даруй холбоо тогтооход тусална.

4. Энэ зүйлд зааснаар аливаа этгээдийг цагдан хорьсон улс тухайн этгээдийг цагдан хорьсон, цагдан хорих болсон нөхцөл байдлын тухай 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан улс болон уг этгээдийг харьяалах улсад нэн даруй мэдэгдэх, түүнчлэн шаардлагатай гэж үзвэл сонирхогч бусад улсад мэдэгдэнэ. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан урьдчилсан мөрдөн байцаалт явуулж байгаа улс олж тогтоосон зүйлийг дээр дурдсан улсад шуурхай мэдээлж, хэргийг харьяалан шийдвэрлэх эсэхээ мэдэгдэнэ.

7 дугаар зүйл

Нутаг дэвсгэр дээр нь сэжигтэн этгээд илэрч тогтоогдсон хэлэлцэн тохирогч улс түүнийг шилжүүлэн өгөхгүй байвал гэмт хэрэг түүний нутаг дэвсгэр дээр гарсан эсэхээс үл хамааран яллуулахаар өөрийн эрх бүхий байгууллагад шилжүүлнэ. Тэрхүү эрх бүхий байгууллага нь тухайн улсын хуульд заасны дагуу ноцтой шинж агуулсан ердийн хэрэгтэй адил журмаар шийдвэрлэнэ.

8 дугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч улсын хооронд байгуулсан шилжүүлэн өгөх тухай аль нэгэн гэрээнд тухайн гэмт хэргийг шилжүүлэн өгвөл зохих гэмт хэрэгт оруулан заана. Хэлэлцэн тохирогч улсууд хоорондоо байгуулах шилжүүлэн өгөх тухай гэрээ бүртгээ уг гэмт хэргийг оруулах үүрэг хүлээнэ.

2. Шилжүүлэн өгөхийг гэрээ байгуулсан эсэхээс хамааруулан авч үздэг хэлэлцэн тохирогч улс тийм гэрээ байхгүй хэлэлцэн тохирогч өөр улсаас шилжүүлэн өгөх хүсэлт хүлээж авсан бол өөрийн үзэмжээрээ энэ конвенцийг тухайн гэмт хэргийг шилжүүлэн өгөх хууль зүйн үндэслэл болгож болно. Шилжүүлэн өгөхийг хүсэлт хүлээж авсан улсын хуулийн дагуу гүйцэтгэнэ.

3. Шилжүүлэн өгөхийг гэрээ байгуулсан эсэхээс хамааруулан авч үздэггүй хэлэлцэн тохирогч улс тухайн гэмт хэргийг хоорондоо шилжүүлэн өгвөл зохих гэмт хэрэг гэж хүсэлт хүлээж авсан улсын хуулийн дагуу хүлээн зөвшөөрнө.

4. Хэлэлцэн тохирогч улсуудын хооронд шилжүүлэн өгөх зорилгоор тухайн гэмт хэргийг зөвхөн үйлдэгдсэн газар нь бус, мөн 5 дугаар зүйлийн 1(b),(c), (d) хэсэгт заасны дагуу харьяаллаа тогтоохыг шаардсан улс болгоны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэж үзнэ.

9 дүгээр зүйл

Хамтарсан буюу олон улсын бүртгэлд бүртгүүлбэл зохих агаарын хөлөг ашигладаг хамтарсан агаарын тээврийн ашиглалтын байгууллага буюу олон улсын ашиглалтын агентлаг байгуулж байгаа хэлэлцэн тохирогч улсууд агаарын хөлөг бүрийн хувьд өөрсдийн дотроос аль улс нь энэхүү конвенцийн зорилгод хэргийн харьяаллаа хэрэгжүүлэх, бүртгэгч улс болохыг тогтоож, энэ тухайгаа Олон улсын иргэний нисэхийн байгууллагад мэдэгдэх бөгөөд тухайн байгууллага уг мэдээллийг энэхүү конвенцид оролцогч бүх улсад дамжуулна.

10 дугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч улсууд 1 дүгээр зүйлд заасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлж болох бүхий л арга хэмжээг олон улсын эрх зүйн болон дотоодын хууль тогтоомжийн дагуу авахыг эрмэлзэнэ.

2. Энэхүү конвенцийн 1 дүгээр зүйлд заасан аль нэг гэмт хэрэг үйлдсэнээс агаарын хөлгийн нислэгийг хойшлуулсан буюу зогсоосон үед агаарын хөлөг, зорчигчид буюу баг нутаг дэвсгэрт нь байгаа хэлэлцэн тохирогч аливаа улс зорчигчид болон багийн бүрэлдэхүүнээс нислэгээ аль болохоор хурдан үргэлжлүүлэхэд тус дөхөм үзүүлэх бөгөөд агаарын хөлөг болон ачааг хууль ёсны эзэмшиж буй этгээдэд саадгүйгээр буцааж өгнө.

11 дүгээр зүйл

1. Хэлэлцэн тохирогч улс гэмт хэргийн талаар авсан эрүүгийн байцаан шийтгэх арга хэмжээтэй холбогдуулан бие биедээ аль болох бүрэн хэмжээгээр туслалцаа үзүүлнэ. Хүсэлт хүлээж авсан улсын хууль бүх тохиолдолд үйлчилнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэг нь эрүүгийн гэмт хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх явдлыг бүрэн буюу хэсэгчлэн зохицуулж байгаа болон зохицуулах хоёр талт болон олон талт аливаа өөр гэрээгээр хүлээсэн үүрэгт нөлөөлөхгүй.

12 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч аливаа улс нь 1 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн аль нэг нь гарч магадгүй гэж үзэх шалтгаан байвал үндэснийхээ хууль тогтоомжийн дагуу өөртөө байгаа аливаа холбогдох мэдээллийг энэхүү конвенцийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан улс мөн гэж үзсэн улсад өгнө.

13 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч улс бүр дотоодынхоо хуулийн дагуу өөрт байгаа дараахь мэдээ баримтыг Олон улсын иргэний нисэхийн байгууллагын зөвлөлд өөрийн үндэсний хууль тогтоомжийнхоо дагуу яаралтай хүргүүлнэ:

(а) гэмт хэргийн нөхцөл байдал;

(б) энэ конвенцийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн дагуу гүйцэтгэсэн ажиллагаа;

(с) гэмт хэрэгтэн буюу сэжигтэн этгээдийн талаар авсан арга хэмжээ, ялангуяа шилжүүлэн өгөх ажиллагаа буюу эрх зүйн бусад ажиллагааны үр дүн буюу бусад хууль зүйн арга хэмжээ.

14 дүгээр зүйл

1. Энэхүү конвенцийг тайлбарлах буюу хэрэглэх талаар хэлэлцэн тохирогч хоёр, түүнээс дээш улсын хооронд хэлэлцээ хийх замаар шийдвэрлэх боломжгүй аливаа маргааныг тэдгээрийн аль нэгийн хүсэлтээр арбитраг шилжүүлнэ. Арбитраг тухай хүсэлт гаргаснаас хойш зургаан сарын хугацаанд талууд арбитраг зохион байгуулах талаар тохиролцож чадаагүй бол талуудын аль нь ч хэргийг Олон улсын шүүхэд түүний дүрэмд заасны дагуу хүсэлт гарган шилжүүлж болно.

2. Энэхүү конвенцид гарын үсэг зурах, түүнийг соёрхон батлах буюу нэгдэн орох үед өмнөх хэсэгт заасан үүргийг хүлээхгүй гэж үзэж байгаага мэдэгдэж болно. Хэлэлцэн тохирогч бусад улс ийм тайлбар хийсэн хэлэлцэн тохирогч аливаа улсын өмнө өмнөх хэсэгт заасан үүргийг хүлээхгүй.

3. Энэ зүйлийн өмнөх хэсэгт зааснаар тайлбар хийсэн хэлэлцэн тохирогч аливаа улс эх хадгалагч засгийн газруудад мэдэгдэх замаар түүнийгээ хэдийд ч хүчингүй болгож болно.

15 дугаар зүйл

1. Энэхүү конвенц нь Монреаль хотноо 1971 оны 9 дүгээр сарын 8-23-нд хуралдсан Агаарын эрх зүйн олон улсын бага хуралд (цаашид “Монреалийн бага хурал” гэх) оролцогч улсын хувьд энэхүү конвенц 1971 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр Монреаль хотноо гарын үсэг зурахад нээлттэй байна. 1971 оны 10 дугаар сарын 10-наас хойш конвенц нь бүх улсын хувьд Москва, Лондон, Вашингтон хотноо гарын үсэг зурахад нээлттэй байна. Энэ зүйлийн 3 дахь хэсгийн дагуу энэхүү конвенцийг хүчин төгөлдөр болохоос өмнө конвенцид гарын үсэг зураагүй аль ч улс хэзээ ч энэ конвенцид нэгдэн орж болно.

2. Энэхүү конвенцид гарын үсэг зурсан улс түүнийг соёрхон батална. Батламж жуух бичиг болон нэгдэн орсон тухай баримт бичгийг Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газарт хадгалуулах бөгөөд эдгээр улсыг эх хадгалагч засгийн газраар энэхүү конвенцоор томилсон болно.

3. Энэхүү конвенц нь Монреалийн бага хуралд оролцож конвенцид гарын үсэг зурсан арван улс батламж жуух бичгээ хадгалуулсан өдрөөс хойш гуч хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

4. Бусад улсын хувьд энэхүү конвенц нь энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар хүчин төгөлдөр болсон өдөр, эсхүл тэдгээрээс батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгийн аль сүүлд өгч хадгалуулсан өдрөөс хойш гуч хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

5. Эх хадгалагч засгийн газрууд гарын үсэг зурсан болон нэгдэн орсон бүх улсад гарын үсэг зурсан өдөр, батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулсан өдөр, энэхүү конвенцийн хүчин төгөлдөр болох өдөр болон бусад зүйлийн талаар даруй мэдэгдэнэ.

6. Энэхүү конвенцийг хүчин төгөлдөр болмогц Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн 102, Олон улсын иргэний нисэхийн тухай конвенц (Чикаго, 1944 он)-ийн 83 дугаар зүйлд заасны дагуу эх хадгалагч засгийн газруудад бүртгүүлнэ.

16 дугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч аливаа улс эх хадгалагч засгийн газруудад бичгээр мэдэгдэх замаар энэхүү конвенцоос гарч болно.

2. Конвенцоос гарах нь эх хадгалагч засгийн газрууд мэдэгдлийг хүлээж авсан өдрөөс хойш зургаан сарын дараа хүчин төгөлдөр болно.

Дээр дурдсаныг нотолж зохих ёсоор засгийн газраасаа бүрэн эрх олгогдсон төлөөлөгчид энэхүү конвенцид гарын үсэг зурав.

Нэг мянга есөн зуун далан нэгэн оны есдүгээр сарын хорин гуравны өдөр Монреаль хотноо орос, англи, испани, франц хэлээр гурван эх хувь үйлдсэн бөгөөд бүх эх хувь нь адил хүчинтэй байна.

**74. ОЛОН УЛСЫН ХАМГААЛАЛТАД БАЙДАГ ХҮМҮҮС,
ТҮҮНИЙ ДОТОР ДИПЛОМАТ ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ЭСРЭГ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БОЛОН
ШИЙТГЭХ ТУХАЙ КОНВЕНЦ**

*Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий ассамблей 1973 оны 12 дугаар сарын 14-ний өдөр баталж, 1977 оны 2 дугаар сарын 20-ны өдөр хүчин төгөлдөр болсон**

Энэхүү конвенцид оролцогч улсууд,

Олон улсын энх тайвныг сахиулах, улс хоорондын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн зорилго, зарчмыг анхааран үзэж,

дипломат төлөөлөгчид болон бусад олон улсын хамгаалалтад байдаг хүмүүсийн эсрэг гэмт хэрэг нь тэдний аюулгүй байдалд заналхийлж, улс хоорондын хамтын ажиллагаа явуулахад шаардлагатай олон улсын хэвийн харилцаанд ноцтой занал учруулж байна гэж үзэж,

ийм гэмт хэрэг үйлдэх нь олон улсын хамтын нийгэмлэгийг ноцтой түгшээж байгаа гэж итгэж,

ийм гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон шийтгэхийн тулд зохих тууштай арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатай болсон гэж үзэж,

дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

1 дүгээр зүйл

Энэхүү конвенцийн зорилгод:

1. "Олон улсын хамгаалалтад байдаг хүн" гэж:

(a) төрийн тэргүүн, ялангуяа тухайн улсын үндсэн хуулийн дагуу төрийн тэргүүний чиг үүргийг гүйцэтгэж буй хамтын удирдлагын байгууллагын аливаа гишүүн, засгийн газрын тэргүүн буюу гадаад хэргийн сайд, түүнчлэн тэднийг дагалдан яваа гэр бүлийн гишүүд гадаад улсад байх үед нь;

(b) гэмт хэрэг гарсан газарт олон улсын эрх зүйн дагуу өөрийгөө, өөрийн эрх чөлөө болон нэр төрөө аливаа халдлагаас тусгайлан хамгаалуулах эрхтэй аливаа улсын төлөөлөгч буюу албан тушаалтан, олон улсын засгийн газар хоорондын байгууллагын албан тушаалтан буюу өөр төлөөлөгч, түүний албан байр, орон сууц, тээврийн хэрэгслийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн үед, түүнчлэн тэдэнтэй хамт амьдардаг гэр бүлийн гишүүдийг хэлнэ.

2. "Сэжигтэн этгээд" гэж 2 дугаар зүйлд дурдсан гэмт хэргийн аль нэгийг буюу хэд хэдийг үйлдсэн, эсхүл үйлдэхэд оролцсныг *prima facie* тогтооход хангалттай баримт бүхий этгээдийг хэлнэ.

* Монгол Улс 1974.12.18-нд соёрхон батласан

2 дугаар зүйл

1. Санаатайгаар:

(a) олон улсын хамгаалалтад байдаг хүний амийг хөнөөх, хулгайлах, түүнд болон түүний эрх чөлөөнд халдах;

(b) олон улсын хамгаалалтад байдаг хүн, түүний эрх чөлөөнд аюул учруулах магадлалтайгаар түүний албан байр, орон сууц, тээврийн хэрэгсэлд хүч хэрэглэн халдах;

(c) ийм аливаа халдлага хийхийг заналхийх;

(d) ийм аливаа халдлага хийхийг завдах; болон

(e) ийм аливаа халдлага үйлдэхэд хамтран оролцсон үйлдлийг оролцогч улс бүр өөрийн дотоодын хууль тогтоомжийн дагуу гэмт хэрэг гэж үзвэл зохино.

2. Оролцогч улс бүр эдгээр гэмт хэрэгт тэдгээрийн ноцтой шинжийг харгалзсан зохих шийтгэл оногдуулахаар тогтооно.

3. Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэг нь оролцогч улсуудыг олон улсын эрх зүйн дагуу олон улсын хамгаалалтад байдаг хүн, түүний эрх чөлөө, нэр төрийг бусад халдлагаас урьдчилан сэргийлэхийн тулд бүхий л зохистой арга хэмжээ авах талаар хүлээсэн үүргээс чөлөөлөхгүй.

3 дугаар зүйл

1. Оролцогч улс бүр дараахь тохиолдолд 2 дугаар зүйлд дурдсан гэмт хэргийн хувьд хэргийн харьяаллыг тогтооход шаардагдах арга хэмжээ авна:

(a) гэмт хэргийг тухайн улсын нутаг дэвсгэр дээр буюу тухайн улсад бүртгүүлсэн хөлөг онгоцны тавцан, эсхүл агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн;

(b) сэжигтэн этгээд тухайн улсын иргэн;

(c) гэмт хэргийг 1 дүгээр зүйлд тодорхойлсны дагуу тухайн улсыг төлөөлөн үүрэг гүйцэтгэж буйн үндсэн дээр ийнхүү хамгаалагдах эрх эдэлж буй олон улсын хамгаалалтад байдаг хүний эсрэг үйлдсэн.

2. Оролцогч улс бүр гэмт этгээд тухайн улсын нутаг дэвсгэр дээр байгаад түүнийг энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан улсуудын алинд нь ч 8 дугаар зүйлийн дагуу шилжүүлэхгүй тохиолдолд эдгээр гэмт хэргийн хувьд хэргийн харьяаллаа тогтооход шаардагдах арга хэмжээ мөн авна.

3. Энэхүү конвенц үндэсний хууль тогтоомжийн дагуу эрүүгийн хэргийн харьяаллаа хэрэгжүүлэхийг үгүйсгэхгүй.

4 дүгээр зүйл

Оролцогч улсууд 2 дугаар зүйлд дурдсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар дараахь хэлбэрээр хамтран ажиллана:

(а) эдгээр гэмт хэргийг өөрсдийн нутаг дэвсгэрт буюу түүний гадна үйлдэх бэлтгэлийг өөрсдийн нутаг дэвсгэр дээр хийхээс урьдчилан сэргийлэх талаар боломжтой бүхий л арга хэмжээ авах;

(b) эдгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд мэдээлэл солилцох, захиргааны болон шаардлагатай бусад арга хэмжээ авах явдлыг зохион байгуулах.

5 дугаар зүйл

1. Нутаг дэвсгэр дээр нь 2 дугаар зүйлд дурдсан гэмт хэргийн аль нэг, эсхүл хэд хэдэн гэмт хэрэг үйлдэгдсэн бөгөөд хэрэв сэжигтэн этгээд тухайн улсаас гарч явсан гэж үзэх үндэслэл оролцогч улсад байвал уг гэмт хэрэгтэй холбогдолтой болон сэжигтэн этгээдийг таньж тогтоох талаар бүх баримтын тухай бусад сонирхогч бүх улсад шууд, эсхүл Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргаар дамжуулан мэдэгдэнэ.

2. Олон улсын хамгаалалтад байдаг хүний эсрэг 2 дугаар зүйлд дурдсан гэмт хэргийн аль нэгийг үйлдсэн тохиолдолд тухайн гэмт хэрэг гарсан нөхцөл байдал, хохирогчийн талаар мэдээлэл бүхий оролцогч аливаа улс дотоодын хууль тогтоомжид заасан нөхцлийн дагуу бүрэн, тодорхой мэдээллийг уг хүн нэрийх нь өмнөөс үүрэг гүйцэтгэж байсан оролцогч улсад өгөхийг эрмэлзэнэ.

6 дугаар зүйл

1. Нөхцөл байдал тийнхүү шаардаж байгаа гэж үзвэл нутаг дэвсгэр дээр нь сэжигтэн этгээд байгаа оролцогч улс түүнийг яллах буюу шилжүүлэх зорилгоор бэлэн байлгах явдлыг хангасан шаардлагатай арга хэмжээг дотоодын хууль тогтоомжийн дагуу авна. Эдгээр арга хэмжээний тухай дор дурдсан улс, байгууллагад цаг алдалгүй шууд буюу Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргаар дамжуулан мэдэгдэнэ:

(а) нутаг дэвсгэр дээр нь гэмт хэрэг үйлдэгдсэн улс;

(b) сэжигтэн этгээд иргэн нь байх улс буюу улсууд, хэрэв тэрбээр харьяалалгүй этгээд бол нутаг дэвсгэрт нь байнга оршин суудаг улс;

(c) олон улсын хамгаалалтад орох холбогдох хүн иргэн нь буюу нэрийх нь өмнөөс үүрэг гүйцэтгэж байсан улс буюу улсууд;

(d) холбогдох бусад бүх улс;

(e) олон улсын хамгаалалтад байдаг холбогдох хүн, албан тушаалтан буюу төлөөлөгч нь байх олон улсын байгууллага.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан арга хэмжээг өөрт нь холбогдуулан авч байгаа этгээд дор дурдсан эрх эдэлнэ:

(а) уг этгээд иргэн нь байх улсын буюу өөрөөр эрхийг нь хамгаалах эрхтэй буюу хэрэв тэрбээр харьяалалгүй бол эрхээ хамгаалуулах хүсэлт гаргахад зөвшөөрсөн улсын хамгийн ойр байгаа төлөөлөгчтэй цаг алдалгүй холбоо тогтоох;

(b) тухайн улсын төлөөлөгч түүнтэй очиж уулзах.

7 дугаар зүйл

Нутаг дэвсгэр дээр нь сэжигтэн этгээд байгаа оролцогч улс түүнийг шилжүүлэхгүй тохиолдолд түүнийг байцаан шийтгэх ажиллагаа явуулж яллах зорилгоор хэргийг тухайн улсын хуулийн дагуу өөрийн эрх бүхий байгууллагад аливаа болзолгүйгээр болон үндэслэлгүй саатуулалгүй шилжүүлнэ.

8 дугаар зүйл

1. 2 дугаар зүйлд дурдсан гэмт хэргийг оролцогч улсуудын хооронд байгуулсан шилжүүлэх тухай аливаа гэрээнд шилжүүлбэл зохих гэмт хэрэг гэж тусгаагүй бол тэдгээрийг ийм гэмт хэрэг гэж тухайн гэрээнд тусгасанд тооцно. Оролцогч улсууд өөр хоорондоо цаашид байгуулах шилжүүлэх тухай аливаа гэрээнд дээр дурдсан гэмт хэргийг шилжүүлбэл зохих гэмт хэрэг гэж тусган оруулж байх үүрэг хүлээнэ.

2. Шилжүүлэх асуудлыг гэрээгээр зохицуулахыг шаарддаг оролцогч улс ийм гэрээгүй оролцогч өөр улсаас түүнийг шилжүүлэх хүсэлт хүлээн аваад тухайн улс гэмт хэрэгтнийг шилжүүлэхээр шийдвэл энэхүү конвенцийг шилжүүлэлтийн эрх зүйн үндэслэл гэж үзэж болно. Гэмт хэргийг хүсэлт хүлээж авсан улсын байцаан шийтгэх хуулийн заалт, хууль тогтоомжид заасан бусад нөхцлийн дагуу шилжүүлнэ.

3. Шилжүүлэх асуудлыг гэрээгээр зохицуулахыг шаарддаггүй оролцогч улсууд өөр хоорондын харилцаандаа дээр дурдсан гэмт хэргийг хүсэлт хүлээж авсан улсын байцаан шийтгэх хуулийн заалт, хууль тогтоомжид заасан бусад нөхцлийн дагуу шилжүүлэх гэмт хэрэг гэж үзнэ.

4. Оролцогч улсуудын хооронд гэмт хэрэг шилжүүлэх зорилгоор гэмт хэрэг бүрийн хувьд түүнийг зөвхөн үйлдэгдсэн газраа төдийгүй мөн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу эрүүгийн хэргийн харьяаллаа тогтоовол зохих улсын нутаг дэвсгэрт мөн үйлдэгдсэн гэж үзнэ.

9 дүгээр зүйл

2 дугаар зүйлд заасан аливаа гэмт хэрэгтэй холбогдуулан байцаан шийтгэх ажиллагаа явуулж байгаа аль ч этгээдэд байцаан шийтгэх ажиллагааны бүх үе шатанд шударгаар хандах баталгаагаар хангана.

10 дугаар зүйл

1. Оролцогч улсууд 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хувьд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаатай холбогдуулан эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд шаардлагатай өөрийн мэдэлд буй бүх нотлох баримтыг өгөх зэргээр аль болох бүрэн хэмжээгээр өөр хоорондоо туслалцаа үзүүлнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэг өөр аливаа гэрээгээр тогтоосон эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай үүргийг хөндөхгүй.

11 дүгээр зүйл

Сэжигтэн этгээдийн талаар эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулж байгаа оролцогч улс үүний эцсийн үр дүнгийн талаар Нэгдсэн Үндэстний

Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэх бөгөөд тэрбээр энэ мэдээллийг оролцогч бусад улсад хүргүүлнэ.

12 дугаар зүйл

Энэхүү конвенцийн заалтууд түүнийг батлах үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа орогнолын тухай гэрээнүүдийг эдгээр гэрээнд оролцогч улсууд өөр хоорондоо хэрэглэх явдлыг хөндөхгүй. Гэхдээ энэхүү конвенцид оролцогч улс эдгээр гэрээнд оролцдоггүй боловч энэхүү конвенцид оролцогч өөр улсын хувьд тэдгээр гэрээг хэрэглэхгүй.

13 дугаар зүйл

1. Энэхүү конвенцийг тайлбарлах, хэрэглэх талаар түүнд оролцогч хоёр буюу түүнээс дээш улсын хооронд гарсан хэлэлцээний аргаар зохицуулж чадаагүй аливаа маргааныг тэдгээрийн аль нэгний хүсэлтээр арбитраг шилжүүлнэ. Хэрэв энэ хүсэлтийг гаргасан өдрөөс хойш зургаан сарын дотор талууд арбитраг зохион байгуулах асуудлаар эс тохиролцвол талуудын аль нэгний хүсэлтээр тухайн маргааныг Олон улсын шүүхийн дүрмийн дагуу Олон улсын шүүхэд шилжүүлж болно.

2. Оролцогч улс бүр энэхүү конвенцид гарын үсэг зурах, соёрхон батлах, эсхүл нэгдэж орохдоо энэ зүйлийн 1 дэх хэсгээр үүрэг хүлээхгүй гэсэн мэдэгдэл хийж болно. Оролцогч бусад улс ийм тайлбар хийсэн аливаа улсын хувьд энэ зүйлийн 1 дэх хэсгээр үүрэг хүлээхгүй.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн дагуу тайлбар хийсэн оролцогч аливаа улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэх замаар уг тайлбараа хэдийд ч буцааж авч болно.

14 дүгээр зүйл

Энэхүү конвенц нь 1974 оны 12 дугаар сарын 31-ны өдөр хүртэл Нью-Йорк хот дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын төв байранд бүх улс гарын үсэг зурахад нээлттэй байна.

15 дугаар зүйл

Энэхүү конвенцийг соёрхон батална. Батламж жуух бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулахаар өгнө.

16 дугаар зүйл

Энэхүү конвенц нь аливаа улсын хувьд нэгдэн ороход нээлттэй байна. Нэгдэн орсон тухай баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

17 дугаар зүйл

1. Энэхүү конвенц нь хорин хоёр дахь батламж жуух бичиг буюу нэгдэж орох тухай баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш гуч дахь өдрөөс хүчин төгөлдөр болно.

2. Хорин хоёр дахь батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулснаас хойш конвенцийг соёрхон батлах буюу түүнд нэгдэн орох улс бүрийн хувьд батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш гуч дахь өдөр энэхүү конвенц хүчин төгөлдөр болно.

18 дугаар зүйл

1. Оролцогч улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад бичгээр мэдэгдэж энэхүү конвенцийг цуцалж болно.

2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга уг мэдэгдлийг хүлээж авсан өдрөөс хойш зургаан сар болмогц цуцлалт хүчин төгөлдөр болно.

19 дүгээр зүйл

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга бүх улсад дор дурдсан зүйлийг *inter alia* мэдээлж байна:

(a) энэхүү конвенцид гарын үсэг зурсан болон 14, 15, 16 дугаар зүйлийн дагуу батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулсан, 18 дугаар зүйлийн дагуу хийсэн мэдэгдлийн тухай;

(b) энэхүү конвенц 17 дугаар зүйлийн дагуу хүчин төгөлдөр болсон өдрийн тухай.

20 дугаар зүйл

Англи, испани, хятад, орос, франц хэлээр үйлдсэн эх бичвэрүүд нь адил хүчинтэй энэхүү конвенцийн эх бичвэрийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулах бөгөөд тэрбээр түүний баталгаат хуулбарыг бүх улсад хүргүүлнэ.

Дээр дурдсаныг нотолж засгийн газраасаа зохих ёсоор бүрэн эрх олгогдсон дор гарын үсэг зурагсад Нью-Йорк хотноо 1973 оны 12 дугаар сарын 14-ний өдөр гарын үсэг зурахад нээлттэй болсон энэхүү конвенцид гарын үсэг зурав.

75. ЦӨМИЙН МАТЕРИАЛЫГ БИЕЧЛЭН ХАМГААЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ

*1979 оны 10 дугаар сарын 26-ны өдөр баталж,
1987 оны 2 дугаар сарын 8-нд хүчин төгөлдөр болсон**

Энэхүү конвенцид оролцогч улсууд,

цөмийн энергийг энх тайвны зорилгоор хөгжүүлэх, хэрэглэх бүх улсын эрх, цөмийн энергийг энх тайвны зорилгоор хэрэглэснээс үүдэж ашиг олох тэдгээрийн хууль ёсны ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрч,

цөмийн энергийг энх тайвны зорилгоор ашиглах олон улсын хамтын ажиллагаанд тус дөхөм үзүүлэх шаардлагатай гэдэгт итгэж,

цөмийн материалыг хууль бусаар эзэмшиж ашигласнаас гарч болох ослоос урьдчилан сэргийлэхийг эрмэлзэж,

цөмийн материалтай холбогдолтой гэмт хэрэг бол ноцтой сэтгэл түгшээсэн зүйл бөгөөд ийм гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шийтгэх үр дүнтэй, зохих ёсны арга хэмжээг авах зайлшгүй шаардлагатай гэдэгт итгэж,

оролцогч улс бүрийн үндэсний хууль тогтоомж, энэхүү конвенцийн дагуу цөмийн материалыг биечлэн хамгаалах үр дүнтэй арга хэмжээ боловсруулахын тулд олон улсын хэмжээнд хамтран ажиллах шаардлагатай байгааг ухамсарлаж,

энэхүү конвенц цөмийн материалыг аюулгүй зөөвөрлөхөд тус дөхөм үзүүлнэ гэдэгт итгэж,

дотоодын хэрэгцээнд ашиглах, хадгалах, тээвэрлэхэд цөмийн материалыг биечлэн хамгаалахын чухлыг мөн цохон тэмдэглэж,

цэргийн зорилгоор ашиглаж буй цөмийн материалыг үр дүнтэй биечлэн хамгаалахын чухлыг хүлээн зөвшөөрч, ийм материал нь биечилсэн хатуу чанд хамгаалалтад байгаа хийгээд цаашид энэ хэвээр байх ёстойг ойлгож,

дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

1 дүгээр зүйл

Энэхүү конвенцийн зорилгод:

(а) "цөмийн материал" гэж 80%-иас илүү плутони-238 изотоп агуулсан плутоноос бусад плутони, уран-233, уран-235 буюу уран 233 изотопоор баяжуулсан уран, байгальд байдаг хэлбэрээрээ хүдэр болон хүдрийн үлдэгдлээс ялгаатай изотопын

* Монгол Улс 1986.01.23-нд гарын үсэг зурж, 1986.05.28-нд соёрхон батласан

холимгийг агуулсан уран, мөн дээр заасан элементийн аль нэгийг буюу хэд хэдийг агуулсан аливаа материалыг хэлнэ;

(b) "уран-235 буюу уран-233 изотопоор баяжуулсан уран" гэж уран-235 буюу уран-233 изотопыг агуулсан, эсхүл уран-238 изотоп хоёрын харьцаа нь байгальд тохиолдох уран-235, уран-238 хоёрын харьцаанаас илүү хэмжээгээр уран-235 буюу уран-233 буюу хоёуланг агуулсан ураныг хэлнэ;

(c) "цөмийн материалын олон улсын тээвэрлэлт" гэж аль нэг улсын нутаг дэвсгэрээс гадагш гаргахаар ачуулсан цөмийн материалыг тухайн улс дахь илгээгч этгээдийн төхөөрөмж дээрээс хөдөлгөж явуулахаас эхлэн хүргэх эцсийн улсын хүлээн авагч этгээдийн зохих төхөөрөмж дээр хүрч ирэх хүртэл тээврийн ямар нэг хэрэгслээр тээвэрлэхийг хэлнэ.

2 дугаар зүйл

1. Энэхүү конвенцийг энх тайвны зорилгоор ашиглаж байгаа бөгөөд олон улсын тээвэрлэлтэд байгаа цөмийн материалын хувьд хэрэглэнэ.

2. 3, 4 дүгээр зүйл болон 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үл оролцуулан улсын дотоодод энх тайвны зорилгоор ашиглаж, хадгалж, тээвэрлэж байгаа цөмийн материалын хувьд энэхүү конвенцийг мөн хэрэглэнэ.

3. Улсын дотоодод энх тайвны зорилгоор ашиглаж, хадгалж, тээвэрлэж байгаа цөмийн материалын талаар оролцогч улсуудаас энэ зүйлийн 2 дахь хэсгээр тусгайлан хүлээсэн үүргээс бусад энэхүү конвенцийн аль ч заалтыг улсын дотоодод цөмийн материалыг ашиглах, хадгалах, тээвэрлэх тухайн улсын бүрэн эрхийг хөндөх байдлаар тайлбарлахгүй.

3 дугаар зүйл

Оролцогч улс бүр өөрийн нутаг дэвсгэр дээр буюу эрх мэдэлд нь байгаа хөлөг онгоцны тавцанд буюу агаарын хөлгөөр цөмийн материал тээвэрлэж олон улсын тээвэрлэлт гүйцэтгэж байгаа бөгөөд хэрэв тухайн хөлөг онгоц буюу агаарын хөлөг уг улс уруу, эсхүл уг улсаас тээвэрлэж байгаа үед уг улс өөрийн үндэсний хууль тогтоомжийн хүрээнд болон олон улсын эрх зүйн дагуу цөмийн материалыг I дүгээр хавсралтаар тодорхойлсон түвшингийн дагуу хамгаалахад шаарддагатай арга хэмжээг боломжийн хэрээр авна.

4 дүгээр зүйл

1. Олон улсын тээвэрлэлтийн үед цөмийн материалыг I дүгээр хавсралтаар тодорхойлсон түвшинд хүртэл хамгаалах талаар баталгаа аваагүй тохиолдолд оролцогч улс бүр цөмийн материалыг экспортлохгүй буюу экспортлохыг зөвшөөрөхгүй.

2. Олон улсын тээвэрлэлтийн үед цөмийн материалыг I дүгээр хавсралтаар тодорхойлсон түвшинд хүртэл хамгаалах талаар баталгаа аваагүй тохиолдолд

конвенцид оролцогч улс бүр энэхүү конвенцид оролцогч бус аливаа улсаас цөмийн материалыг импортлохгүй буюу импортлохыг зөвшөөрөхгүй.

3. Олон улсын тээвэрлэлтийн үед цөмийн материалыг I дүгээр хавсралтаар тодорхойлсон түвшинд хүртэл боломжийн хэрээр хамгаалах тухай баталгаа аваагүй тохиолдолд энэхүү конвенцид оролцогч бус улсуудын хооронд өөрийн нутаг дэвсгэр, хуурай зам, дотоодын усан зам буюу нисэх онгоцны буудал, далайн боомтоороо цөмийн материалыг дамжин өнгөрүүлэхийг оролцогч улс зөвшөөрөхгүй.

4. Оролцогч улс бүр цөмийн материалыг өөрийн улсын нэг хэсгээс нөгөө хэсэг рүү олон улсын усан буюу агаарын замаар тээвэрлэхдээ өөрийн үндэсний хууль тогтоомжийн хүрээнд I дүгээр хавсралтаар тодорхойлсон түвшингийн дагуу цөмийн материалыг биечлэн хамгаалах арга хэмжээ авна.

5. Энэ зүйлийн 1-ээс 3 дахь хэсэгт дурдсаны дагуу цөмийн материалыг I дүгээр хавсралтаар тодорхойлсон түвшинд хүртэл хамгаалах тухай баталгаа авах үүрэгтэй оролцогч улс нь хуурай болон дотоодын усан зам бүхий нутаг дэвсгэрээр нь цөмийн материалыг дамжин өнгөрүүлэх буюу нисэх онгоцны буудал, далайн боомтод нь цөмийн материалтай нэвтрэх улсуудыг тогтоож, эдгээр улсад энэ тухай урьдчилан мэдэгдэнэ.

6. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан баталгаа авах үүргийг тээвэрлэлтэд импортлогч улсын үүрэг гүйцэтгэх оролцогч улсад харилцан тохирсноор шилжүүлж болно.

7. Энэ зүйлийн аль ч заалтыг аливаа улсын агаар мандал, нутгийн усыг оролцуулан тухайн улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, шүүхийн харьяаллыг ямар нэгэн хэлбэрээр хөндсөн гэж тайлбарлахгүй.

5 дугаар зүйл

1. Цөмийн материалыг зөвшөөрөлгүй зөөвөрлөх, ашиглах, өөрчлөх буюу тухайн үйлдлээс учрах бодит аюулын тохиолдолд оролцогч улсууд цөмийн материалыг биечлэн хамгаалах, түүнийг буцаах талаар тохиролцсон арга хэмжээ авах, хариу үйлдэл гүйцэтгэх үүрэг бүхий өөрийн төв байгууллага болон холбоо барих цэгийг тогтоож энэ тухайгаа өөр хоорондоо шууд буюу Цөмийн эрчим хүчний олон улсын агентлагаар дамжуулан мэдэгдэнэ.

2. Цөмийн материалыг хулгайлах, дээрэмдэх буюу хууль бус өөр аливаа замаар булаан авах болон ийм үйлдэл учирч болох бодит аюулын үед цөмийн материалыг эгүүлэн авах, хамгаалуулах талаар хүсэлт гаргасан аливаа улстай оролцогч улсууд үндэсний хууль тогтоомжийнхоо дагуу бүрэн хэмжээгээр хамтран ажиллаж, түүнд туслалцаа үзүүлэх бөгөөд тухайлбал:

(а) цөмийн материалыг хулгайлах, дээрэмдэх буюу хууль бус өөр аливаа замаар булаан авах болон ийм үйлдэл учирч болох бодит аюулын тухай холбогдолтой гэж үзсэн бусад улсад боломжийн хэрээр яаралтай мэдэгдэх бөгөөд шаардлагатай бол олон улсын байгууллагуудад мэдэгдэх талаар оролцогч улс зохих арга хэмжээ авна;

(b) шаардлагатай бол оролцогч холбогдох улсууд аюулд өртсөн цөмийн материалыг хамгаалах, тээврийн чингэлгүүдийн бүрэн бүтэн байдлыг шалгах буюу хууль бусаар булаан авсан цөмийн материалыг эгүүлэн авахын тулд өөр хоорондоо буюу олон улсын байгууллагуудтай мэдээлэл солилцох бөгөөд:

(i) Өөрсдийн хүчин чармайлтыг дипломат болон харилцан тохиролцсон бусад хэлбэрээр зохицуулна;

(ii) Хүсэлт тавьсан үед туслалцаа үзүүлнэ;

(iii) Дээр дурдсан үйлдлийн улмаас хулгайлагдсан буюу алга болсон цөмийн материалыг буцааж өгөх явдлыг хангана.

Ийм хамтын ажиллагааг хэрэгжүүлэх арга замыг оролцогч холбогдох улсууд тодорхойлон тогтооно.

3. Олон улсын тээвэрлэлтийн үед цөмийн материалыг биечлэн хамгаалах системийг зохион байгуулах, хэрэгжүүлэх, сайжруулах талаар зааварчилгаа авах зорилгоор оролцогч улсууд өөр хоорондоо шууд буюу олон улсын байгууллагын тусламжтайгаар зохих үед хамтран ажиллаж, зөвлөлдөнө.

6 дугаар зүйл

1. Оролцогч улсууд энэхүү конвенцийн дагуу буюу энэхүү конвенцийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцох замаар оролцогч нөгөө улсаас хүлээн авсан нууцалсан аливаа мэдээллийн нууцыг хадгалахын тулд өөрийн улсын хууль тогтоомжид нийцэх зохих арга хэмжээг авна. Хэрэв оролцогч улсууд олон улсын байгууллагуудыг нууцалсан мэдээллээр хангасан бол тухайн мэдээллийн нууцлалыг хамгаалах шаардлагатай арга хэмжээ авна.

2. Холбогдох улсын аюулгүй байдал, эсхүл цөмийн материалыг биечлэн хамгаалахад занал учруулж болох буюу үндэсний хууль тогтоомжоор нь зөвшөөрөгдөөгүй аливаа мэдээллийг гаргаж өгөхийг энэхүү конвенцийн заалт оролцогч улсуудаас үл шаардана.

7 дугаар зүйл

1. Санаатайгаар:

(a) хүний амь насыг хороох буюу хүнд ноцтой гэмтэл учруулж болох, өмч хөрөнгөд ноцтой хохирол учруулж болох цөмийн материалыг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй хүлээн авах, эзэмших, ашиглах, дамжуулах, хэлбэрийг нь өөрчлөх, байрлуулах болон цацаж сарниулах үйлдэл хийсэн;

(b) цөмийн материалыг хулгайлах буюу дээрэмдэх замаар булаан авсан;

(c) залилан мэхлэх, эсхүл төөрөгдүүлэх замаар цөмийн материалыг олж авсан;

(d) хүч хэрэглэх, түүнийг хэрэглэхээр заналхийлэх буюу айлган сүрдүүлэх бусад хэлбэрээр цөмийн материал өгөхийг шаардсан үйлдэл хийсэн;

(e) дор дурдсанаар заналхийлсэн:

(i) хүний амь насыг хороох, түүнд хүнд гэмтэл учруулах буюу өмч хөрөнгөд нь ноцтой хохирол учруулах зорилгоор цөмийн материалыг ашиглахаар, эсхүл

(ii) ямарваа үйлдэл хийх буюу түүнээс түдгэлзэхийг хувь хүн болон хуулийн этгээд, олон улсын байгууллага буюу улсад тулган хүлээлгэх зорилгоор (b) дэд хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэхээр;

(f) (a), (b), буюу (c) дэд хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэхийг завдсан;

(g) (a) - (f) дэд хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэхэд оролцсон

бол оролцогч улс бүрийн үндэсний хууль тогтоомжоор шийтгэл хүлээх гэмт хэрэг гэж тогтооно.

2. Оролцогч улс бүр энэ зүйлд дурдсан гэмт хэрэгт шийтгэл оногдуулахдаа хэргийн ноцтой шинжийг харгалзан үзнэ.

8 дугаар зүйл

1. Оролцогч улс бүр 7 дугаар зүйлд дурдсан гэмт хэргийн хувьд хэргийн харьяаллаа тогтооход шаардагдах арга хэмжээг дараахь тохиолдолд авна:

(a) гэмт хэргийг тухайн улсын нутаг дэвсгэрт буюу тэр улсад бүртгэсэн хөлөг онгоцны тавцан буюу агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн үед;

(b) сэжигтэн этгээд тухайн улсын харьяат бол.

2. Оролцогч улс бүр өөрийн нутаг дэвсгэр дээр байгаа сэжигтэн этгээдийг 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан аль нэг улсад шилжүүлэхгүй тохиолдолд дээр дурдсан хэргийн хувьд хэргийн харьяаллаа тогтооход шаардагдах арга хэмжээг мөн авна.

3. Энэхүү конвенц үндэсний хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж буй аливаа эрүүгийн хэргийн харьяаллыг үгүйсгэхгүй.

4. 1, 2 дахь хэсэгт дурдсан оролцогч улсаас гадна цөмийн материалыг экспортолж байгаа буюу импортолж байгаа оролцогч улс бүр 7 дугаар зүйлд дурдсан гэмт хэргийн хувьд олон улсын эрх зүйн дагуу өөрийн хэргийн харьяаллаа тогтоож болно.

9 дүгээр зүйл

Нөхцөл байдал тийнхүү шаардаж буй гэж үзвэл нутаг дэвсгэр дээр нь сэжигтэн этгээд байгаа оролцогч улс өөрийн үндэсний хууль тогтоомжийн дагуу тухайн сэжигтэн этгээдийг яллах, шилжүүлэн өгөх зорилгоор цагдан хорихыг оролцуулан түүнийг бэлэн байлгах явдлыг хангах арга хэмжээ авна. Энэ зүйлийн дагуу авсан арга хэмжээний тухай 8 дугаар зүйлд заасанчлан хэргийн харьяаллаа тогтоох үүрэгтэй оролцогч улсуудад болон шаардлагатай үед бусад холбогдох бүх улсад цаг алдалгүй мэдэгдэнэ.

10 дугаар зүйл

Сэжигтэн этгээд нутаг дэвсгэрт нь байгаа оролцогч улс түүнийг шилжүүлж өгөхгүй бол тухайн улсын хууль тогтоомжийн дагуу байцаан шийтгэх ажиллагаа явуулж яллах зорилгоор уг хэргийг өөрийн эрх бүхий байгууллагуудад цаг алдалгүй шилжүүлнэ.

11 дүгээр зүйл

1. Оролцогч улсуудын хооронд гэмт хэргийг шилжүүлэн өгөх тухай аливаа гэрээнд 7 дугаар зүйлд дурдсан гэмт хэргийг шилжүүлэн өгвөл зохих гэмт хэрэгт оруулан тусгана. Оролцогч улсууд цаашид өөр хоорондоо байгуулах бүх гэрээнд ийм гэмт хэргийг шилжүүлэн өгвөл зохих гэмт хэрэгт тооцох үүрэг хүлээнэ.

2. Гэмт хэрэгтнийг гэрээний үндсэн дээр шилжүүлж өгдөг оролцогч улс гэмт хэрэгтэн шилжүүлэн өгөх тухай гэрээгүй оролцогч өөр улсаас шилжүүлэн өгөх хүсэлт хүлээн авбал энэхүү конвенцийг шилжүүлэн өгөх эрх зүйн үндэс гэж үзэж болно. Шилжүүлэн өгөх ажиллагааг хүсэлт хүлээн авсан улсын хууль тогтоомжид заасан бусад нөхцөлийн дагуу гүйцэтгэнэ.

3. Гэрээ байгаа эсэхээс үл хамааран шилжүүлэн өгдөггүй оролцогч улсууд тийм хүсэлт хүлээн авсан улсын хууль тогтоомжид заасан нөхцөлийн дагуу тухайн гэмт хэргийг шилжүүлэн өгвөл зохих гэмт хэрэг гэж өөр хоорондоо хүлээн зөвшөөрнө.

4. Оролцогч улсууд өөр хоорондоо гэмт хэрэгтнийг шилжүүлэх зорилгоор тухайн гэмт хэрэг бүрийг үйлдсэн нутаг дэвсгэрээс гадна мөн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу хэргийн харьяаллаа тогтоовол зохих оролцогч улсуудын нутаг дэвсгэрт үйлдсэн гэж үзнэ.

12 дугаар зүйл

7 дугаар зүйлд дурдсан аливаа гэмт хэрэгтэй холбогдуулан байцаан шийтгэгдэж байгаа этгээдэд байцаан шийтгэх ажиллагааны бүх үе шатанд шударга хандах явдлыг хангана.

13 дугаар зүйл

1. Оролцогч улсууд байцаан шийтгэх ажиллагаанд шаардлагатай өөрт байгаа баримт өгөхийг оролцуулан 7 дугаар зүйлд дурдсан гэмт хэргийн хувьд явуулж буй эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаатай холбогдолтой бүрэн хэмжээний туслалцаа бие биедээ үзүүлнэ. Бүх тохиолдолд хүсэлт хүлээн авсан улсын хууль тогтоомжийг хэрэглэнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэг нь эрүүгийн хэргийн талаар харилцан туслалцах явдлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн зохицуулж байгаа буюу зохицуулах хоёр болон олон талт аливаа гэрээгээр хүлээсэн үүргийг хөндөхгүй.

14 дүгээр зүйл

1. Оролцогч улс бүр энэхүү конвенцид нийцүүлж гаргасан өөрийн хууль тогтоомжийн талаар эх хадгалагчид мэдэгдэнэ. Эх хадгалагч тухайн мэдээллийг оролцогч бүх улсад тогтмол хүргүүлж байна.

2. Нутаг дэвсгэрт нь сэжигтэн этгээд яллагдаж буй оролцогч улс байцаан шийтгэх ажиллагааны эцсийн үр дүнгийн талаар эхлээд шууд холбогдох улсуудад мэдэгдэнэ. Оролцогч улс тухайн эцсийн үр дүнгийн талаар эх хадгалагчид мөн мэдэгдэх бөгөөд эх хадгалагч энэ тухай оролцогч бүх улсад мэдэгдэнэ.

3. Тухайн улс дотор энх тайвны зорилгоор ашиглаж, хадгалж, тээвэрлэж байгаа цөмийн материалтай гэмт хэрэг нь холбоотой бөгөөд оролцогч улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн сэжигтэн этгээд болон цөмийн материалын аль аль нь байгаа бол энэхүү конвенцийн аль ч заалтыг тухайн гэмт хэргээс үүдэх эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны тухай мэдээллийг оролцогч улсаас гаргуулахыг шаардаж буй хэмээн тайлбарлахгүй.

15 дугаар зүйл

Хавсралтууд энэхүү конвенцийн салшгүй хэсэг мөн.

16 дугаар зүйл

1. Энэхүү конвенц нь хүчин төгөлдөр болсон өдрөөс таван жилийн хугацаа өнгөрсний дараа энэхүү конвенцийн хэрэгжилт, удиртгал, үндсэн хэсэг болон хавсралт нь тухайн үеийн нөхцөл байдлын шаардлагад хэрхэн нийцэж байгааг хэлэлцэх зорилгоор оролцогч улсуудын бага хурлыг конвенцийн эх хадгалагч зарлан хуралдуулна.

2. Цаашид конвенцид оролцогч улсын олонхи нь дурдсан зорилгоор эх хадгалагчид зохих саналаа тавьж, дараа дараагийн бага хурлыг таван жилд нэг удаа зарлан хуралдуулж болно.

17 дугаар зүйл

1. Энэхүү конвенцийг тайлбарлах, хэрэглэх талаар хоёр буюу түүнээс дээш оролцогч улсын хооронд маргаан үүсэх тохиолдолд оролцогч тухайн улсууд маргааныг хэлэлцээний замаар буюу маргаанд оролцогч бүх тал зөвшөөрөх бусад энхийн аргаар зохицуулахаар зөвлөлдөнө.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн дагуу зохицуулах боломжгүй маргааныг маргаанд оролцогч аль нэг талын хүсэлтээр арбитрад буюу Олон улсын шүүхэд шийдвэрлүүлэхээр шилжүүлнэ. Талууд маргааныг арбитрад шилжүүлэх хүсэлт гаргаснаас хойш зургаан сарын хугацаанд уг шүүхийн зохион байгуулах талаар тохиролцож чадахгүй бол аль нэг тал нэг буюу хэд хэдэн арбитрад томилуулах хүсэлтийг Олон улсын шүүхийн Ерөнхийлөгч, эсхүл Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад гаргаж болно. Маргаанд оролцогч талууд санал зөрүүтэй байвал Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хүсэлт тавихыг урьдал болгоно.

3. Оролцогч аливаа улс энэхүү конвенцид гарын үсэг зурах, соёрхон батлах, батлах, буюу түүнд нэгдэж орохдоо 2 дахь хэсэгт дурдсан маргаан шийдвэрлэх журмын аль нэгийг буюу хоёуланг хүлээн зөвшөөрөхгүй тухай мэдэгдэж болно. Тайлбар хийсэн оролцогч улсын хувьд оролцогч бусад улс 2 дахь хэсэгт дурдсан маргаан шийдвэрлэх журмыг дагаж мөрдөхгүй.

4. 3 дахь хэсгийн дагуу тайлбар хийсэн оролцогч аливаа улс эх хадгалагчид мэдэгдэх замаар аль ч үед уг тайлбараа эгүүлэн авч болно.

18 дугаар зүйл

1. Энэхүү конвенц Вена дахь Цөмийн эрчим хүчний олон улсын агентлагийн төв байр болон Нью-Йорк дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Төв байранд 1980 оны 3 дугаар сарын 3-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох хүртэл бүх улсын хувьд гарын үсэг зурахад нээлттэй байна.

2. Энэхүү конвенцид гарын үсэг зурсан улс түүнийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх буюу батална.

3. Энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш бүх улсын хувьд түүнд нэгдэн ороход нээлттэй байна.

4. (а) Энэхүү конвенц бүрэн эрхт улсуудаас бүрдсэн бөгөөд энэхүү конвенцид заасан асуудлаар хэлэлцээ хийх, олон улсын хэлэлцээр байгуулж хэрэгжүүлэх эрх бүхий олон улсын байгууллага, бүсийн хамтын ажиллагааны болон бусад адил шинж чанарын байгууллага гарын үсэг зурах буюу нэгдэж ороход нээлттэй байна.

(б) ийм байгууллага өөрийн нэрийн өмнөөс эрх мэдлийнхээ хүрээнд оролцогч улсуудын нэгэн адил энэхүү конвенцийн дагуу эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

(с) ийм байгууллага конвенцид оролцогч болохдоо гишүүнчлэлдээ багтаадаг улс болон энэхүү конвенцийн заалтыг хэрэглэхгүй тухайгаа заасан мэдэгдлийг эх хадгалагчид гаргаж өгнө.

(d) ийм байгууллага өөрийн гишүүн улсуудын саналын тооноос илүү саналтай байж болохгүй.

5. Соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн, батласан буюу нэгдэж орсон тухай баримт бичгийг эх хадгалагчид хадгалуулна.

19 дүгээр зүйл

1. Энэхүү конвенц түүнийг соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн буюу батласан тухай хорин нэг дэх баримт бичгийг хадгалуулахаар эх хадгалагчид өгсөн өдрөөс хойш гуч дахь өдөр хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү конвенц түүнийг соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн буюу батласан тухай хорин нэг дэх баримт бичгийг хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш түүнийг соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн, батласан улс бүрийн хувьд соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн, батласан буюу нэгдэж орсон тухай баримт бичгийг өгсөн өдрөөс хойш гуч дахь өдөр хүчин төгөлдөр болно.

20 дугаар зүйл

1. Оролцогч улс 16 дугаар зүйлийн заалтыг хөндөхгүйгээр энэхүү конвенцид нэмэлт өөрчлөлт оруулах санал тавьж болно. Нэмэлт өөрчлөлт оруулах саналыг эх хадгалагчид хүргүүлэх бөгөөд тэрбээр түүнийг оролцогч бүх улсад цаг алдалгүй тараана. Хэрэв конвенцид оролцогч улсуудын олонхи нэмэлт өөрчлөлт оруулах саналыг хэлэлцэх бага хурал хийлгэх хүсэлтийг эх хадгалагчид тавьсан тохиолдолд эх хадгалагч оролцогч бүх улсыг уг бага хуралд урих бөгөөд урилга илгээсэн өдрөөс доод тал нь гуч хоногийн дараа бага хурлыг эхлүүлнэ. Бага хуралд оролцогч бүх улсын гуравны хоёрын олонхийн саналаар батласан аливаа нэмэлт өөрчлөлтийг эх хадгалагч оролцогч бүх улсад цаг алдалгүй илгээнэ.

3. Нэмэлт өөрчлөлт нь түүнийг соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн буюу батласан тухай баримт бичгийг хадгалуулахаар өгсөн оролцогч улс бүрийн хувьд ийнхүү соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн буюу батласан оролцогч улсын гуравны хоёр уг баримт бичгийг хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш гуч дахь өдөр хүчин төгөлдөр болно. Үүнээс хойш ийм нэмэлт өөрчлөлт нь оролцогч бусад улсын хувьд тухайн улс бүр түүнийг соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн буюу батласан тухай баримт бичгийг хадгалуулахаар өгсөн өдөр хүчин төгөлдөр болно.

21 дүгээр зүйл

1. Оролцогч аливаа улс эх хадгалагчид бичгээр мэдэгдсэнээр энэхүү конвенцийг цуцалж болно.

2. Мэдэгдлийг эх хадгалагч хүлээн авснаас хойш нэг зуун наян хоногийн дараа цуцлалт хүчин төгөлдөр болно.

22 дугаар зүйл

Эх хадгалагч дараахь зүйлийн талаар бүх улсад даруй мэдэгдэнэ:

- (a) Энэхүү конвенцид гарын үсэг зурсан тухай;
- (b) Соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн, батласан буюу нэгдэж орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар өгсөн тухай;
- (c) 17 дугаар зүйлийн дагуу хийсэн тайлбар буюу түүнийг эгүүлэн авсан тухай;
- (d) 17 дугаар зүйлийн 4 (c) дэд хэсгийн дагуу аливаа байгууллагаас илгээсэн мэдэгдлийн тухай;
- (e) Энэхүү конвенц хүчин төгөлдөр болсон тухай;
- (f) Энэхүү конвенцид оруулсан аливаа нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болсон тухай;
- (g) 21 дүгээр зүйлийн дагуу цуцлах мэдэгдэл хийсэн тухай.

23 дугаар зүйл

Англи, араб, испани, хятад, орос, франц хэлээрх эх бичвэрүүд нь адил хүчинтэй энэхүү конвенцийг Цөмийн эрчим хүчний олон улсын агентлагийн Ерөнхий захиралд хадгалуулах бөгөөд тэрбээр конвенцийн баталгаат хуулбарыг бүх улсад илгээнэ.

Дээр дурдсаныг нотолж зохих ёсоор бүрэн эрх олгогдсон дор гарын үсэг зурагсад 1980 он 3 дугаар сарын 3-ны өдрөөс Вена, Нью-Йорк хотноо гарын үсэг зурахад нээлттэй энэхүү конвенцид гарын үсэг зурав.

I ХАВСРАЛТ

II ХАВСРАЛТАД АНГИЛСАН ЦӨМИЙН МАТЕРИАЛЫГ ОЛОН УЛСЫН ТЭЭВЭРЛЭЛТИЙН ҮЕД БИЕЧЛЭН ХАМГААЛАХ ТҮВШИН

1. Олон улсын тээвэрлэлттэй холбогдуулан цөмийн материалыг хадгалах үеийн биечлэн хамгаалалтын түвшинд дараахь зүйл орно:

(a) III зэрэглэлийн материалын хувьд хяналттай нэвтрэх бүсийн дотор хадгалах;

(b) II зэрэглэлийн материалын хувьд хамгаалалт буюу зохих хяналттайгаар нэвтрэх хязгаарлагдмал тооны орох хаалгатай бөгөөд биет хаалтаар хүрээлэгдсэн манааны буюу цахим хэрэглэлийн байнгын ажиглалтад байдаг бүсийн дотор, эсхүл дээрхтэй адил хэмжээнд биечлэн хамгаалагдсан бүсийн дотор хадгалах;

(c) I зэрэглэлийн материалын хувьд дээр тодорхойлсон II зэрэглэлийн материалын хамгаалалттай бүсэд хадгалахын дээр зөвхөн итгэлтэй болох нь тогтоогдсон хүмүүс нэвтрэн орохыг зөвшөөрсөн бөгөөд хариу арга хэмжээ авах холбогдох хүчинтэй байнгын холбоо барьдаг манаатай байна. Энэ тохиолдолд авах тодорхой арга хэмжээний зорилго нь аливаа дайран довтлох, зөвшөөрөлгүйгээр нэвтрэн орох, материалыг зөвшөөрөлгүйгээр авах үйлдлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэхэд оршино.

2. Олон улсын тээвэрлэлтийн үед цөмийн материалыг биечлэн хамгаалах түвшинд дараахь зүйл орно:

(a) II, III зэрэглэлийн материалын хувьд материалыг илгээгч, хүлээн авагч, ачигчийн хооронд хийсэн урьдчилсан тохиролцоо болон тээвэрлэлтийн үед хариуцлагыг шилжүүлэн өгөх цаг, газар, журмыг тогтоож, экспортлох болон импортлох талаар тухайн улсын хууль тогтоомжийг удирдлага болгосон буюу түүний хэргийн харьяалалд байгаа хувь хүн, хуулийн этгээдийн хооронд урьдчилан байгуулсан хэлэлцээрийн дагуу болгоомжтой тээвэрлэх талаар тусгай арга хэмжээ авах;

(b) I зэргийн материалын хувьд дээр тодорхойлсон II, III зэргийн материалыг тээвэрлэх талаар анхаарал болгоомжтой байх тусгай арга хэмжээг баримтлахаас гадна хариу арга хэмжээ авах холбогдох хүчинтэй нягт холбоо бүхий хамгаалалт манааны байнгын ажиглалт дор тээвэрлэх;

(c) Хүдэр, хүдрийн үлдэгдлээс өөр хэлбэртэй байгалийн уран 500 кг-аас дээш байвал түүний тээвэрлэлтийн хамгаалалтад тээврийн хэрэгслийн төрөл, ачаа, хүрэхээр төлөвлөсөн хугацаа, түүнийг хүлээн авсан нотолгоо бүхий тээвэрлэлтийн тухай урьдчилсан мэдэгдэл авна.

II ХАВСРАЛТ

Цөмийн материалын ангилал

Материал	Хэлбэр	Зэрэглэл		
		I	II	III ^c
1. Плутони ^a	Цацрагжуулаагүй ^b	2 кг. буюу түүнээс дээш	2 кг. бага боловч 500 гр. илүү	500 гр. буюу түүнээс бага боловч 15 гр. их
2. Уран-235	Цацрагжуулаагүй ^b - 20% буюу түүнээс дээш уран-235-аар баяжуулсан	5 кг. буюу түүнээс дээш	5 кг. бага боловч 1кг. илүү	1 кг. буюу түүнээс бага боловч 15 гр. их
	- 10% хүртэл боловч 20%-иас бага уран-235-аар баяжуулсан		10 кг. буюу түүнээс илүү	10 кг. бага боловч 1 кг. их
	- хэвийнээс дээш боловч 10%-иас бага уран-235-аар баяжуулсан			10 кг. буюу түүнээс их
3. Уран-233	Цацрагжуулаагүй ^b	2 кг. буюу түүнээс дээш	2 кг. бага боловч 500 гр. илүү	500 гр. буюу түүнээс бага боловч 15 гр. их
4. Цацрагжуулсан түлш			Ашигласан, эсхүл байгалийн уран, ториум буюу бага хэмжээгээр баяжуулсан түлш /10% иас бага задардаг/ ^{d,e}	

^a Изотопны концентариц нь плутони-238 нь 80%-аас илүү байх плутониос бусад бүх плутони

^b Реакторт цацрагжуулаагүй материал, эсхүл реакторт цацрагжуулсан боловч 1 метр зайд хамгаалалтгүй 100 рад/ц-тай ижил, эсхүл түүнээс бага байх цацрагийн хэмжээтэй материал

^c III зэрэглэлд үл хамаарах тоо хэмжээ болон практик хэрэглээнээс үүдэж хамгаалах ёстой байгалийн уран

^d Уг түвшинд хамгаалах талаар зөвлөмж болгож байгаа боловч нөхцөл байдлаас шалтгаалж улсууд биечлэн хамгаалах бусад түвшинг тогтоож болно

^e Хуваагдаж буй материалын анхны бүрэлдэхүүнээс шалтгаалж цацрагжуулах хүртэл I буюу II дугаар зэрэглэлд хамаарах болон хэрэв түлшний цацрагийн түвшин 1 метр зайд хамгаалалтгүй 100 рад/ц-аас их байхад аль нэг зэрэглээс түвшиний хувьд бага байж болох бусад түлш

76. АГААРЫН ХӨЛГИЙН БҮХЭЭГТ ҮЙЛДСЭН ГЭМТ ХЭРЭГ БОЛОН ТОДОРХОЙ БУСАД ҮЙЛДЛИЙН ТУХАЙ КОНВЕНЦ

*1963 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр баталж,
1969 оны 12 дугаар сарын 4-ний өдөр хүчин төгөлдөр болсон**

Энэхүү конвенцид оролцогч улсууд дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

I Бүлэг

Энэхүү конвенцийн үйлчлэх хүрээ

1 дүгээр зүйл

1. Энэхүү конвенцийг дараахь тохиолдолд хэрэглэнэ:

(a) эрүүгийн хуулийг зөрчсөн гэмт хэрэг;

(b) гэмт хэрэг мөн эсэхээс үл шалтгаалан агаарын хөлөг, түүний дотор байгаа хүмүүс, эд хөрөнгө, түүнчлэн агаарын хөлгийн дотоод сахилга, дэг журамд аюул учруулсан хийгээд учруулж болзошгүй үйлдэл.

2. III дугаар бүлэгт зааснаас бусад тохиолдолд агаарын хөлөг нислэгт буюу их далайн гадаргуу дээр байх үед, эсхүл аливаа улсын нутаг дэвсгэрээс гадна байгаа оролцогч улсад бүртгүүлсэн аливаа агаарын хөлгийн бүхээгт хэн нэг этгээд гэмт хэрэг буюу бусад үйлдэл үйлдсэн тохиолдолд энэхүү конвенцийг хэрэглэнэ.

3. Энэхүү конвенцийн зорилгод хөөргөхөөр хөдөлгүүрээ асаасан мөчөөс эхлэн буух гүйлт нь дуусах мөч хүртэл агаарын хөлгийг нислэгт байгаа гэж үзнэ.

4. Энэхүү конвенцийг цэрэг, гааль, цагдаагийн албанд ашиглаж байгаа агаарын хөлгийн тухайд хэрэглэхгүй.

2 дугаар зүйл

4 дүгээр зүйлийн заалтыг хөндөхгүйгээр буюу агаарын хөлөг, түүний бүхээгт байгаа хүмүүс болон эд хөрөнгийн аюулгүй байдал үүнийг шаардахаас бусад тохиолдолд энэхүү конвенцийн аль ч заалтыг улс төрийн шинж чанартай гэмт хэрэг буюу арьс үндэс, шашин шүтлэгээр алагчилах явдалд үндэслэсэн гэмт хэргийн хувьд аливаа арга хэмжээ авахыг зөвшөөрсөн буюу шаардсан хэмээн тайлбарлахгүй.

* Монгол Улс 1990.10.22-нд нэгдэн орсон

II Бүлэг Хэргийн харьяалал

3 дугаар зүйл

1. Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон аливаа бусад үйлдлийн хувьд тухайн агаарын хөлгийг бүртгэсэн улс хэргийн харьяаллаа хэрэгжүүлэх эрхтэй.

2. Хэлэлцэн тохирогч улс бүр түүнд бүртгэлтэй агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэргийн тухайд бүртгэгч улсын хувьд өөрийн эрүүгийн хэргийн харьяаллаа тогтооход шаардлагатай арга хэмжээ авна.

3. Энэхүү конвенц нь үндэсний хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн аливаа эрүүгийн хэргийн харьяаллыг үгүйсгэхгүй.

4 дүгээр зүйл

Тухайн агаарын хөлгийг бүртгээгүй хэлэлцэн тохирогч улс дор дурдсанаас бусад тохиолдолд бүхээгт нь үйлдэгдсэн гэмт хэргийн хувьд өөрийн эрүүгийн хэргийн харьяаллаа хэрэгжүүлэх зорилгоор нислэгт буй агаарын хөлөгт хөндлөнгөөс нөлөөлж болохгүй:

(a) гэмт хэрэг тухайн улсын нутаг дэвсгэрт ул мөрөө үлдээсэн;

(b) гэмт хэргийг тухайн улсын иргэн буюу байнга оршин суугч өөрөө, эсхүл түүний эсрэг үйлдсэн байх;

(c) гэмт хэрэг тухайн улсын аюулгүй байдлын эсрэг чиглэсэн;

(d) гэмт хэрэг нь агаарын хөлгийн нислэг буюу хөдөлгөөний талаар тухайн улсад мөрдөгдөж буй аливаа дүрэм буюу журмыг зөрчсөн;

(e) тухайн улс олон улсын олон талт хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд хэргийн харьяаллаа хэрэгжүүлэх шаардлагатай байх.

III Бүлэг Агаарын хөлгийн даргын эрх

5 дугаар зүйл

1. Энэхүү бүлгийн заалтууд сүүлчийн удаа хөөрсөн болон нисэх чиглэлийн дагуу буух цэг нь агаарын хөлгийг бүртгэсэн улсаас өөр улсад орших, эсхүл өөр улсын агаарын орон зайд нисэж байх үед гэмт хэрэг үйлдсэн буюу үйлдэхийг завдсан этгээд бүхээгт нь байсаар байгаа агаарын хөлгөөс бусад, тухайлбал бүртгэсэн улсын агаарын орон зай, эсхүл их далай болон аливаа улсын нутаг дэвсгэрээс гадна аль ч улсын

дээгүүр нисэж байгаа агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн буюу үйлдэх гэж буй гэмт хэрэг, буюу үйлдлийн тухайд хэрэглэхгүй.

2. Энэ зүйлийн зорилгод 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үл харгалзан ачаалсны дараа бүх гадна хаалгыг хаасан үеэс эхлэн ачаа буулгахаар уг хаалгуудын аль нэгийг нээх хүртэл агаарын хөлгийг нислэг үйлдэж байгаад тооцно. Албадан буулт хийлгэсэн тохиолдолд зохих эрх бүхий этгээд агаарын хөлөг, түүнийн бүхээгт байгаа хүмүүс, эд хөрөнгийн төлөө хүлээх хариуцлагыг өөртөө шилжүүлж авах хүртэл энэ бүлгийн заалтуудыг хэрэглэнэ.

6 дугаар зүйл

1. Агаарын хөлгийн дарга 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан гэмт хэрэг буюу үйлдлийг агаарын хөлгийн бүхээгт аливаа этгээд үйлдсэн, эсхүл үйлдэхээр завдаж байна гэж үзэх боломжит үндэслэл байвал түүнийг дараахь зорилгоор эрх чөлөөг нь хязгаарлах хүртэл боломжит арга хэмжээ авч болно:

(a) агаарын хөлөг, эсхүл түүнд байгаа хүмүүс буюу эд хөрөнгийн аюулгүй байдлыг хамгаалах;

(b) агаарын хөлгийн бүхээгт дэг журам сахиулах;

(c) тухайн этгээдийг эрх бүхий байгууллагуудад хүргэх, эсхүл энэ бүлгийн заалтуудын дагуу агаарын хөлгөөс буулгах бололцоо бүрдүүлэх.

2. Агаарын хөлгийн дарга эрх чөлөөг нь хязгаарлавал зохих аливаа этгээдийн эрх чөлөөг хязгаарлахад багийн бусад гишүүнээс туслахыг шаардах буюу тэдэнд зөвшөөрч болох бөгөөд харин зорчигчдоос хүсэх буюу зөвшөөрч болох ба шаардаж болохгүй. Багийн аливаа гишүүн буюу зорчигч агаарын хөлөг, түүнд байгаа хүмүүс буюу эд хөрөнгийн аюулгүй байдлыг хамгаалахад яаралтай арга хэмжээ авах шаардлагатай гэж үзэх боломжит үндэслэл байвал зөвшөөрөлгүйгээр урьдчилан сэргийлэх боломжит арга хэмжээ мөн авч болно.

7 дугаар зүйл

1. Дараахь тохиолдлоос бусад үед 6 дугаар зүйлийн дагуу аливаа этгээдэд авсан эрх чөлөөг нь хязгаарлах арга хэмжээг тухайн агаарын хөлөг буусан цэгээс цааш үргэлжлүүлж болохгүй:

(a) тухайн цэг нь хэлэлцэн тохирогч бус улсын нутаг дэвсгэрт байх болон тэрхүү улсын эрх баригчид тухайн этгээдийг агаарын хөлгөөс буулгахыг зөвшөөрөхгүй байх, эсхүл 6 дугаар зүйлийн 1(c) дэд хэсгийн дагуу тухайн этгээдийг эрх мэдэл бүхий этгээдэд хүлээлгэн өгөх зорилгоор хязгаарлалтын арга хэмжээг авсан байх;

(b) агаарын хөлөг албадан буулт хийсэн бөгөөд агаарын хөлгийн дарга тухайн этгээдийг эрх мэдэл бүхий этгээдэд хүлээлгэн өгөх боломжгүй байх;

(с) тухайн этгээд хязгаарлалтад байхыг өөрөө зөвшөөрсөн байх;

2. Бүхээгт нь 6 дугаар зүйлийн дагуу эрх чөлөөг нь хязгаарласан этгээд бүхий агаарын хөлгийн дарга аливаа улсын нутаг дэвсгэрт буухаасаа өмнө тухайн улсын эрх бүхий этгээдэд бүхээгт нь эрх чөлөөг нь хязгаарласан этгээд байгаа болон ямар шалтгааны улмаас тийнхүү хязгаарлах болсноо аль болох богино хугацаанд боломжийн хэрээр мэдэгдэнэ.

8 дугаар зүйл

1. Агаарын хөлгийн дарга 6 дугаар зүйлийн 1 (а), эсхүл 1 (b) дэд хэсгийн зорилгоор шаардлагатай бол аливаа улсын нутаг дэвсгэрт буусан үедээ агаарын хөлгийн бүхээгт нь 1 дүгээр зүйлийн 1(b) дэд хэсэгт заасан үйлдэл үйлдсэн буюу үйлдэхийг завдаж байгаа гэж үзэх боломжит үндэслэл байвал аль ч этгээдийг агаарын хөлгөөс албадан буулгаж болно.

2. Агаарын хөлгийн дарга нутагт нь энэ зүйлд заасны дагуу аливаа этгээдийг буулгасан тухай болон болсон үйл явдал, үндэслэлийн талаар тухайн улсын эрх мэдэл бүхий этгээдэд мэдэгдэнэ.

9 дүгээр зүйл

1. Агаарын хөлгийн даргын үзэж байгаагаар агаарын хөлгийг бүртгэсэн улсын эрүүгийн хуулиар ноцтой гэмт хэрэг болох үйлдэл хийсэн гэж үзэх боломжит үндэслэл түүнд байвал ямар ч этгээдийг нутаг дэвсгэр дээр нь буусан аливаа хэлэлцэн тохирогч талын эрх мэдэл бүхий этгээдэд тэрбээр хүлээлгэн өгч болно.

2. Агаарын хөлгийн дарга хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрт буухаас өмнө дээрх заалтад дурдсаны дагуу бүхээгтээ байгаа этгээдийг шилжүүлэх гэж буй тухайн улсын эрх мэдэл бүхий этгээдэд тухайн этгээдийг хүлээлгэн өгөх зорилго болон үндэслэлийн талаар аль болох богино хугацаанд боломжийн хэрээр мэдэгдэнэ.

3. Агаарын хөлгийн дарга сэжигтэн этгээдийг энэ зүйлийн дагуу хүлээлгэн өгөх эрх мэдэл бүхий этгээдэд агаарын хөлгийг бүртгэсэн улсын хуулийн дагуу хууль ёсоор олж авсан баримт сэлт, мэдээллийг өгнө.

10 дугаар зүйл

Энэхүү конвенцийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухайд агаарын хөлгийн дарга, багийн бусад аль ч гишүүн, зорчигч, агаарын хөлгийн эзэмшигч буюу ашиглагч, тухайн нислэгийг нэрийнх нь өмнөөс үйлдэж байгаа этгээдийн хэн нь ч шүүн таслах аль ч үед тухайн этгээдийн хувьд хэрэгжүүлсэн арга хэмжээний төлөө хариуцлагыг хүлээхгүй.

IV Бүлэг

Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах

11 дүгээр зүйл

1. Агаарын хөлгийн бүхээгт байгаа этгээд хүч хэрэглэн, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлэн нислэгт буй агаарын хөлгийн удирдлагад хууль бусаар саад учруулах, удирдлагыг булаан авах буюу хууль бус бусад үйлдэл үйлдсэн буюу үйлдэхийг завдсан тохиолдолд хэлэлцэн тохирогч улсууд агаарын хөлгийн удирдлагыг түүний хууль ёсны даргад эгүүлэн өгөх буюу түүний хяналтанд байлгахад шаардлагатай бүхий л арга хэмжээ авна.

2. Өмнөх хэсэгт дурдсан тохиолдолд агаарын хөлөг нутагт дэвсгэрт нь буусан хэлэлцэн тохирогч улс зорчигчид болон багт аяллаа үргэлжлүүлэхийг аль болох богино хугацаанд зөвшөөрөх бөгөөд агаарын хөлөг, ачаа тээшийг хууль ёсны эзэмшигчид нь эргүүлэн өгнө.

V Бүлэг

Улсуудын эрх хэмжээ, үүрэг

12 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч аливаа улс хэлэлцэн тохирогч өөр улсад бүртгэлтэй агаарын хөлгийн даргад 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу ямарваа нэгэн этгээдийг агаарын хөлгөөс албадан буулгах зөвшөөрөл олгоно.

13 дугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч аливаа улс агаарын хөлгийн даргын 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн дагуу хүргэж өгсөн ямар ч этгээдийг хүлээн авна.

2. Нөхцөл байдал тийнхүү шаардаж байгаа гэж үзвэл хэлэлцэн тохирогч аливаа улс түүнд хүргэж өгсөн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдэлд сэжиглэгдэж байгаа аливаа этгээдийг бэлэн байлгахын тулд цагдан хорих болон бусад таслан сэргийлэх арга хэмжээ авна. Цагдан хорих болон таслан сэргийлэх бусад арга хэмжээг тухайн улсын хуулийн дагуу авах бөгөөд тэдгээр нь зөвхөн эрүүгийн байцаан шийтгэх, эсхүл шилжүүлэн өгөх ажиллагаанд үндэслэлтэйгээр шаардагдах хугацаанд үргэлжилнэ.

3. Өмнөх хэсэгт дурдсаны дагуу цагдан хорьсон аливаа этгээдэд өөрийг нь харьяалах улсын хамгийн ойр орших зохих ёсны төлөөлөгчтэй яаралтай холбоо барихад нь туслалцаа үзүүлнэ.

4. 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн дагуу аливаа этгээдийг хүлээж авсан буюу 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас агаарын хөлөг нутаг дэвсгэрт нь буусан хэлэлцэн тохирогч аливаа улс тухайн хэргийн талаар урьдчилсан мөрдөн байцаалт яаралтай явуулж эхэлнэ.

5. Энэ зүйлийн дагуу аливаа этгээдийг цагдан хорьсон улс агаарын хөлгийг бүртгэсэн улс болон цагдан хоригдсон этгээдийг харьяалах улс, түүнчлэн шаардлагатай гэж үзвэл сонирхогч аливаа улсад тухайн этгээдийг цагдан хорьсон болон тийнхүү хорих болсон нөхцөл байдлын талаар даруй мэдэгдэнэ. Энэ зүйлийн 4 дэх хэсгийн дагуу урьдчилсан мөрдөн байцаалт явуулж эхэлсэн улс дээр дурдсан улсад өөрийн олж илрүүлсэн зүйлийн тухай шуурхай мэдээллэх бөгөөд хэргийн харьяаллаа хэрэгжүүлэх эсэхээ мэдэгдэнэ.

14 дүгээр зүйл

1. Аливаа этгээдийг 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу агаарын хөлгөөс албадан буулгасан буюу 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн дагуу хүргэж өгсөн, эсхүл 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэрэг үйлдсэний улмаас агаарын хөлгөөс албадан буулгасан буюу тухайн этгээд аяллаа цааш нь үргэлжлүүлж чадахгүй, эсхүл хүсэхгүй байх болон газардсан улс түүнийг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд тухайн улс уг этгээд нь түүний харьяат буюу байнгын оршин суугч биш бол уг этгээдийг түүнийг харьяалах буюу байнга оршин суудаг улсын, эсхүл тухайн аяллаа эхэлсэн улсын нутаг дэвсгэрт нь буцааж болно.

2. Албадан буулгах, хүргэж өгөх, цагдан хорих буюу 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан бусад арга хэмжээ авах, түүнчлэн холбогдох этгээдийг буцааж өгөх явдлын аль алиныг хэлэлцэн тохирогч тухайн улсын нэвтрэх буюу хүлээн авах тухай хууль тогтоомжийн дагуу түүний нутаг дэвсгэрт нэвтрэлээ гэж үзэхгүй бөгөөд энэхүү конвенцийн аль ч заалт аливаа этгээдийг нутаг дэвсгэрээсээ албадан гаргах тухай хэлэлцэн тохирогч улсын хуулийг хөндөхгүй.

15 дугаар зүйл

1. Шилжүүлэн өгөх буюу эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахын тулд агаарын хөлөг буусан улсын хуулийн дагуу тухайн этгээд биеэр байлцах шаардлагагүй бол 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу албадан буулгасан, эсхүл 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн дагуу хүргэж өгсөн, мөн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэрэг үйлдсэний улмаас агаарын хөлгөөс албадан буулгасан аливаа этгээд 14 дүгээр зүйлд харшлахгүйгээр аяллаа цааш нь үргэлжлүүлэхийг хүсвэл түүний сонгосон аль нэгэн газар хүртэл нислэгийг үргэлжлүүлж болно.

2. Нэвтрэх буюу хүлээн авах тухай, нутаг дэвсгэрээс нь шилжүүлэн өгөх болон албадан гаргах тухай хэлэлцэн тохирогч улсын хууль тогтоомжид харшлахгүйгээр түүний нутаг дэвсгэр дээр 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу агаарын хөлгөөс албадан буулгасан буюу 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн дагуу хүргэж өгсөн, эсхүл 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэрэгт сэжиглэгдэж буй этгээдийг хамгаалах, түүний аюулгүй байдлыг хангах талаар тухайн нөхцөл байдалд өөрийн иргэнд олгодгоос дутуугүй тааламжтай нөхцөл олгоно.

VI Бүлэг Бусад заалт

16 дугаар зүйл

1. Шилжүүлэн өгөх зорилгоор хэлэлцэн тохирогч улсад бүртгэлтэй агаарын хөлөгт үйлдсэн гэмт хэргийг зөвхөн үйлдэгдсэн газарт биш, мөн агаарын хөлгийг бүртгэсэн улсад үйлдсэн гэж үзнэ.

2. Дээрх хэсгийн заалтад харшлахгүйгээр энэхүү конвенцийн аль ч заалтыг шилжүүлэн өгөх үүрэг хүлээлгэсэн гэж үзэхгүй.

17 дугаар зүйл

Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн аливаа гэмт хэрэгтэй холбогдуулан мөрдөн байцаалт явуулах, эсхүл баривчлах арга хэмжээ авах, эсхүл хэргийн харьяаллаа хэрэгжүүлэхдээ хэлэлцэн тохирогч улсууд агаарын навигацийн аюулгүй байдал болон бусад эрх ашгийг харгалзан агаарын хөлөг, зорчигчид, баг буюу ачаа тээшийг шаардлагагүйгээр саатуулахгүй байхад анхаарна.

18 дугаар зүйл

Хэрэв хэлэлцэн тохирогч улсууд аль нэгэн улсад нь бүртгэлгүй агаарын хөлөг ашигладаг агаарын тээврийн хамтарсан байгууллага, эсхүл олон улсын агентлаг байгуулбал тухайн нөхцлөөс шалтгаалан энэхүү конвенцийн зорилгоор агаарын тухайн хөлгийг бүртгэсэн улс гэж үзэх улсыг дотроосоо сонгож түүнийхээ тухай Олон улсын иргэний нисэхийн байгууллагад мэдэгдэх бөгөөд тухайн байгууллага уг мэдэгдлийн талаар энэхүү конвенцид оролцогч бүх улсад уламжилна.

VII Бүлэг Төгсгөлийн заалтууд

19 дүгээр зүйл

21 дүгээр зүйлийн дагуу хүчин төгөлдөр болох өдрийг хүртэл энэхүү конвенц тухайн өдрийн байдлаар Нэгдсэн Үндэстний Байгууллага, эсхүл түүний аль нэгэн төрөлжсөн байгууллагуудын гишүүн аливаа улсын нэрийн өмнөөс гарын үсэг зурахад нээлттэй байна.

20 дугаар зүйл

1. Гарын үсэг зурсан улсууд энэхүү конвенцийг үндсэн хуулийнхаа дагуу соёрхон батална.

2. Соёрхон батласан батламж жуух бичгийг Олон улсын иргэний нисэхийн байгууллагад хадгалуулна.

21 дүгээр зүйл

1. Энэхүү конвенцид гарын үсэг зурсан арван хоёр улс батламж жуух бичгээ хадгалуулмагц энэхүү конвенц нь арван хоёр дахь батламж жуух бичгийг хадгалуулахаар өгсөн өдрөөс ер дэх өдөр тэдгээр улсын хооронд хүчин төгөлдөр болно. Түүнээс хойш соёрхон батласан улсуудын хувьд батламж жуух бичгээ хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш ер дэх өдөр хүчин төгөлдөр болно.

2. Олон улсын иргэний нисэхийн байгууллага энэхүү конвенцийг хүчин төгөлдөр болмогц Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад бүртгүүлнэ.

22 дугаар зүйл

1. Энэхүү конвенц хүчин төгөлдөр болсны дараа Нэгдсэн Үндэстний Байгууллага буюу түүний төрөлжсөн аливаа байгууллагын гишүүн улсын хувьд нэгдэн ороход нээлттэй байна.

2. Нэгдэн орох аливаа улс нэгдэн орох тухай баримт бичгээ Олон улсын иргэний нисэхийн байгууллагад хадгалуулахаар өгөх бөгөөд ийнхүү хадгалуулахаар өгснөөс хойш ер дэх өдөр түүнийг энэхүү конвенцид нэгдэн орсонд тооцно.

23 дугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч аль ч улс Олон улсын иргэний нисэхийн байгууллагад мэдэгдэх замаар энэхүү конвенцийг цуцалж болно.

2. Цуцалсан тухай мэдэгдлийг Олон улсын иргэний нисэхийн байгууллага хүлээн авснаас хойш зургаан сарын дараа цуцлалт хүчин төгөлдөр болно.

24 дүгээр зүйл

1. Хоёр буюу түүнээс дээш хэлэлцэн тохирогч улсын хооронд энэхүү конвенцийг тайлбарлах буюу хэрэглэх талаар гарсан аливаа маргааныг хэлэлцээний журмаар шийдвэрлэж чадахгүй нөхцөлд аль нэгнийх нь хүсэлтээр арбитрад шилжүүлнэ. Арбитрад хүсэлт гаргасан өдрөөс хойш зургаан сарын дотор талууд арбитраг зохион байгуулж эс чадвал тэдгээр талын аль нэгний хүсэлтээр маргааныг Олон улсын шүүхийн дүрмийн дагуу Олон улсын шүүхэд шилжүүлнэ.

2. Энэхүү конвенцид гарын үсэг зурах, батлах буюу түүнд нэгдэн орохдоо улс бүр өмнөх заалтын дагуу үүрэг хүлээхгүйгээ мэдэгдэж болно. Хэлэлцэн тохирогч бусад улс тийнхүү тайлбар хийсэн улсын хувьд өмнөх заалтын дагуу үүрэг хүлээхгүй.

3. Өмнөх заалтын дагуу тайлбар хийсэн аливаа хэлэлцэн тохирогч улс Олон улсын иргэний нисэхийн байгууллагад мэдэгдэх замаар хийсэн тайлбараа аль ч үед эгүүлэн авч болно.

25 дугаар зүйл

24 дүгээр зүйлд зааснаас өөрөөр энэхүү конвенцид тайлбар хийж болохгүй.

26 дугаар зүйл

Олон улсын иргэний нисэхийн байгууллага нь Нэгдсэн Үндэстний Байгууллага буюу түүний төрөлжсөн байгууллагуудын гишүүн бүх улсад дараахь зүйлийг мэдэгдэнэ:

(a) энэхүү конвенцид гарын үсэг зурсан болон гарын үсэг зурсан өдрийн тухай;

(b) батламж жуух бичиг болон нэгдэн орох тухай баримт бичгийг хадгалуулахаар өгсөн болон хадгалуулахаар өгсөн өдрийн тухай;

(c) 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн дагуу энэхүү конвенц хүчин төгөлдөр болсон өдрийн тухай;

(d) цуцлах тухай мэдэгдэл хүлээн авсан өдрийн тухай;

(e) 24 дүгээр зүйлийн дагуу хийсэн мэдэгдэл буюу тайлбарыг хүлээн авсан өдрийн тухай.

Дээр дурдсаныг нотолж зохих ёсоор бүрэн эрх олгогдсон дор гарын үсэг зурагсад энэхүү конвенцид гарын үсэг зурав.

Нэг мянга есөн зуун жаран гурван оны 9 дүгээр сарын арван дөрөвний өдөр Токио хотноо адил хүчинтэй гурван эх хувийг англи, франц, испани хэлээр үйлдэв.

Энэхүү конвенц нь Олон улсын иргэний нисэхийн байгууллагад хадгалагдан, 19 дүгээр зүйлийн дагуу гарын үсэг зурахад нээлттэй байх бөгөөд дурдсан байгууллага түүний баталгаат хуулбаруудыг Нэгдсэн Үндэстний Байгууллага болон түүний төрөлжсөн аливаа байгууллагын гишүүн бүх оронд илгээнэ.

77. ХҮН БАРЬЦААНД АВАХЫН ЭСРЭГ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦ

*Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей 1979 оны 12 дугаар сарын 18-ны өдөр баталж, 1983 оны 6 дугаар сарын 3-ны өдөр хүчин төгөлдөр болсон**

Энэхүү конвенцид оролцогч улсууд,

олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахиулах, улсуудын хооронд найрсаг харилцаа, хамтын ажиллагааг дэмжин хөгжүүлэх тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн зорилго, зарчмыг анхааралдаа авч,

Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад дурдсаны дагуу хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй гэдгийг хүлээн зөвшөөрч,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм, Улсууд Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн дагуу найрсагаар харилцах, хамтран ажиллах талаархи олон улсын эрх зүйн зарчмуудын тухай тунхаглал, түүнчлэн Ерөнхий Ассамблейн холбогдох бусад тогтоолд тусгасан улс түмний тэгш эрх, өөртөө засан тохинох зарчмыг дахин нотолж,

хүн барьцаанд авах нь олон улсын хамтын нийгэмлэгийн сэтгэлийг ноцтой түгшээсэн гэмт хэрэг бөгөөд хүн барьцаанд авах үйлдэл хийж буй аливаа этгээдийг энэхүү конвенцийн заалтын дагуу эрүүгийн журмаар яллах эсхүл шилжүүлэн өгөх ёстой гэж үзэж,

хүн барьцаанд авах бүх үйлдлийг олон улсын терроризмын илрэл гэж үзэн тэдгээрээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг яллах болон шийтгэх талаар үр нөлөөтэй арга хэмжээ боловруулж, батлах зорилгоор олон улсын хамтын ажиллагааг улсуудын хооронд хөгжүүлэх тулгамдсан шаардлагатай байгаад итгэж;

дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

1 дүгээр зүйл

1. Гурав дахь этгээдээр, тухайлбал улс, засгийн газар хоорондын олон улсын байгууллага, хувь хүн, хуулийн этгээд, эсхүл бүлэг этгээдээр аливаа үйлдэл гүйцэтгүүлэх буюу гүйцэтгэхээс татгалзуулах зорилгоор өөр нэг хүн (цаашид “барьцааны хүн” гэх)-ийг суллах шууд буюу шууд бус болзол болгон тавьж түүнийг олзлох буюу саатуулах, амийг нь хөнөөх, бие махбодид нь гэмтэл учруулах, эсхүл үргэлжлүүлэн саатуулахаар заналхийлж буй аливаа этгээдийг энэхүү конвенцийн хүрээнд хүн барьцаалах гэмт хэрэг (хүн барьцаалах) үйлдсэн гэж үзнэ.

2. Аливаа этгээд:

(a) хүн барьцаалах үйлдэл хийхийг завдсан; эсхүл

(b) хүн барьцаалах үйлдэл хийсэн буюу чингэхийг завдсан этгээдийн гэмт хэрэгт хамтран оролцсон

* Монгол Улс 1992.06.09-нд нэгдэн орсон

бол энэхүү конвенцийн зорилгод гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ.

2 дугаар зүйл

Оролцогч улс тус бүр 1 дүгээр зүйлд заасан гэмт хэргүүдэд тэдгээрийн ноцтой шинжийг харгалзан зохих шийтгэл ногдуулна.

3 дугаар зүйл

1. Гэмт хэрэгтэн нутаг дэвсгэрт нь хүн барьцаалсан бол оролцогч тухайн улс барьцааны хүний байдлыг хөнгөвчлөх, тухайлбал, түүнийг суллах, сулласны дараа шаардлагатай тохиолдолд уг улсаас гарахад нь тусламж, дэмжлэг үзүүлэх талаар зохистой гэж үзсэн бүх арга хэмжээг авна.

2. Гэмт этгээдийн хүн барьцаалж байж олж авсан аливаа зүйл оролцогч улсын мэдэлд орсон бол тухайн оролцогч улс түүнийг аль болох түргэн хугацаанд барьцааны хүн буюу тухайн тохиолдлоос хамаарч 1 дүгээр зүйлд заасан гурав дахь этгээдэд, эсхүл тэдгээрийн эрх бүхий холбогдох байгууллагад буцааж өгнө.

4 дүгээр зүйл

Оролцогч улсууд 1 дүгээр зүйлд заасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хамтран ажиллана. Тухайлбал:

(а) нутаг дэвсгэрт нь буюу түүний гадна эдгээр гэмт хэргийг үйлдэхээр нутаг дэвсгэрт нь бэлтгэл хийхээс урьдчилан сэргийлэх талаар боломжтой бүх арга хэмжээ, тухайлбал аливаа этгээд, бүлэг этгээд болон байгууллага хүн барьцаалах үйлдлийг өөгшүүлэх, өдөөн хатгах, зохион байгуулах буюу оролцох зэрэг хууль бус үйл ажиллагаа явуулахыг өөрсдийн нутаг дэвсгэрт хориглох арга хэмжээ авна;

(b) эдгээр гэмт хэргийг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээлэл солилцох, түүнчлэн захиргааны болон бусад арга хэмжээ авах ажлыг зохион байгуулна.

5 дугаар зүйл

1. 1 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн алийг ч дор дурдсан байдлаар үйлдсэн бол оролцогч улс бүр тухайн хэрэгт харьяаллаа тогтооход шаардлагатай байж болох арга хэмжээг авна:

(а) нутаг дэвсгэрт нь, эсхүл тухайн улсад бүртгэлтэй хөлөг онгоц буюу агаарын хөлөгт үйлдсэн;

(b) харьяат нь, эсхүл тухайн улс зохистой гэж үзвэл нутаг дэвсгэрт нь байнга оршин суудаг харьяалалгүй этгээд үйлдсэн;

(c) тухайн улсаар аливаа үйлдэл гүйцэтгүүлэх буюу гүйцэтгэхээс татгалзуулах зорилгоор үйлдсэн; эсхүл

(d) тухайн улс зохистой гэж үзвэл, тухайн улсын харьяат болох хүнийг барьцаалж үйлдсэн.

2. Оролцогч улс бүр сэжигтэн этгээд нутаг дэвсгэрт нь байгаа бөгөөд тухайн улс түүнийг энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан улсын аль нэгэнд шилжүүлээгүй тохиолдолд 1 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт харьяаллаа тогтооход шаардлагатай байж болох арга хэмжээг мөн адилаар авна.

3. Энэхүү конвенц нь дотоодын хууль тогтоомжийн дагуу хэрэгжих эрүүгийн хэргийн харьяаллыг үгүйсгэхгүй.

б дугаар зүйл

1. Нөхцөл байдал тийнхүү шаардаж байгаа гэж үзсвэл сэжигтэн этгээд нутаг дэвсгэрт нь байгаа оролцогч аливаа улс эрүүгийн байцаан шийтгэх буюу шилжүүлэх ажиллагаа явуулахад шаардлагатай хугацаанд уг этгээдийг цагдан хорих буюу бэлэн байлгах бусад арга хэмжээг хууль тогтоомжийхоо дагуу авна. Оролцогч улс тухайн хэргийн талаархи урьдчилсан мөрдөн байцаалтыг нэн даруй явуулна.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан цагдан хорих арга эмжээний талаар дараахь этгээдэд шууд буюу Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргаар уламжлан хойшлуулахгүй мэдэгдэнэ:

(a) нутаг дэвсгэрт нь тухайн гэмт хэрэг үйлдэгдсэн улс;

(b) тулган шаардалт өөрийнх нь эсрэг чиглэсэн буюу чингэхийг завдсан улс;

(c) өөрийн нь харьяат хувь хүн буюу хуулийн этгээдийнх нь эсрэг тулган шаардалт чиглэсэн буюу чингэхийг завдсан улс;

(d) барьцаанд байгаа хүн харьяат нь буюу нутаг дэвсгэрт нь байнга оршин суудаг улс;

(e) сэжигтэн этгээд харьяат нь буюу тэрбээр харьяалалгүй этгээд бол түүний байнга оршин суудаг улс;

(f) тулган шаардалт өөрийнх нь эсрэг чиглэсэн буюу чингэхийг завдсан засгийн газар хоорондын олон улсын байгууллага;

(g) холбогдох бусад улс.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан арга хэмжээ авахуулж буй аливаа этгээд дараахь эрх эдэлнэ:

(a) харьяат нь болох улсынхаа хамгийн ойр байгаа буюу ийм холбоо тогтоох эрх бүхий зохих төлөөлөгчтэй, эсхүл хэрэв тэрбээр харьяалалгүй этгээд бол байнга оршин суудаг улсынхаа төлөөлөгчтэй хойшлуулалгүй холбоо тогтоох;

(b) тухайн улсын төлөөлөгчтэй уулзах.

4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан эрхийг сэжигтэн этгээд нутаг дэвсгэрт нь байгаа улсын хууль тогтоомжийн дагуу эдлүүлэх бөгөөд эдгээр хууль тогтоомж нь энэ зүйлийн 3 дахь хэсгийн дагуу эрх олгож буй зорилгыг бүрэн хэрэгжүүлэхэд чиглэсэн байвал зохино.

5. Энэ зүйлийн 3, 4 дэх хэсгийн заалтууд нь 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (b) дэд хэсгийн заалтын дагуу хэргийн харьяаллаа тогтоохыг хүссэн оролцогч аливаа улс Олон улсын улаан загалмайн нийгэмлэгийг сэжигтэн этгээдтэй холбоо барих, уулзалт хийхийг урих эрхийг хөндөхгүй.

6. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалтын дагуу урьдчилсан мөрдөн байцаалт явуулж буй улс олж тогтоосон зүйлээ энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан улсууд буюу байгууллагуудад даруй тайлагнаж, хэргийн харьяаллаа хэрэгжүүлэх эсэхээ мэдэгдэнэ.

7 дугаар зүйл

Нутаг дэвсгэрт нь сэжигтэн этгээдийг яллаж буй оролцогч улс уг ажиллагааны эцсийн үр дүнгийн талаар өөрийн хууль тогтоомжийн дагуу Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэх бөгөөд Ерөнхий нарийн бичгийн дарга нь уг мэдээллийг холбогдох бусад улс болон засгийн газар хоорондын олон улсын холбогдох байгууллагад дамжуулна.

8 дугаар зүйл

1. Оролцогч улс нь нутаг дэвсгэрт нь олж тогтоосон сэжигтэнг шилжүүлээгүй бол гэмт хэрэг нутаг дэвсгэрт нь үйлдэгдсэн эсэхээс үл хамаарч уг хэрэгт тухайн улсын хууль тогтоомжийн дагуу байцаан шийтгэх ажиллагаа явуулж өөрийн эрх бүхий байгууллагад яллуулахаар шилжүүлэх үүргийг аливаа нөхцөлгүйгээр хүлээнэ. Эдгээр байгууллага шийдвэрээ тухайн улсын хууль тогтоомжийн дагуу ноцтой шинж бүхий ердийн гэмт хэргийг шийдвэрлэдгийн адилаар гаргана.

2. 1 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт холбогдуулан байцаан шийтгэх ажиллагаа явуулж буй аливаа этгээдэд байцаан шийтгэх ажиллагааны бүх үе шатанд шударга хандаж үүний дотор түүнийг байгаа улсынх нь хууль тогтоомжид заасан бүх эрх, баталгаагаар бүрэн хангана.

9 дүгээр зүйл

1. Шилжүүлэх тухай хүсэлт хүлээн авсан оролцогч улс дор дурдсан хангалттай үндэслэл байна гэж үзвэл сэжигтэн этгээдийг энэхүү конвенцийн дагуу шилжүүлэх тухай хүсэлтийг биелүүлэхгүй байж болно:

(a) аль нэг этгээдийг 1 дүгээр зүйлд дурдсан гэмт хэргийг үйлдсэн хэмээн түүнийг шилжүүлэн өгөхийг арьс үндэс, шашин шүтлэг, үндэс, угсаа эсхүл улс төрийн үзэл бодлоос нь шалтгаалан яллах буюу шийтгэх зорилгоор хүсвэл;

(b) шилжүүлэх нь тухайн этгээдийн байдалд дараахь байдлаар хохирол учруулж болох бол:

(i) энэ хэсгийн (a) дэд хэсэгт дурдсан аль нэг шалтгаанаар, эсхүл

(ii) түүнийг хамгаалах эрх бүхий улсын зохих байгууллагууд түүнтэй холбоо барих боломжгүй болох бол.

2. Энэхүү конвенцид тодорхойлсон гэмт хэргийн тухайд оролцогч улсуудын хооронд үйлчилж буй гэмт хэрэгтнийг шилжүүлэх тухай гэрээ, хэлэлцээрийн заалтыг энэхүү конвенцид нийцэхгүй байгаа хэмжээнд оролцогч улсуудын хооронд өөрчилнө.

10 дугаар зүйл

1. 1 дүгээр зүйлд заасан гэмт хэргүүдийг гэмт хэрэгтнийг шилжүүлэх тухай оролцогч улсуудын хоорондын аливаа гэрээнд шилжүүлбэл зохих гэмт хэрэгт багтаан тусгах ёстой. Оролцогч улсууд ийм гэмт хэргийг гэмт хэрэгтнийг шилжүүлэх тухай өөр хоорондоо байгуулах гэрээ бүртээ шилжүүлбэл зохих гэмт хэрэгт багтаан тусгах үүрэг хүлээнэ.

2. Хэрэв гэмт хэрэгтнийг гэрээний үндсэн дээр шилжүүлэх нөхцөл тавьдаг оролцогч улс түүнтэй гэрээ байгуулаагүй оролцогч нөгөө улсаас гэмт хэрэгтэн шилжүүлэх тухай хүсэлт хүлээн авбал 1 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн хувьд энэхүү конвенцийг гэмт хэрэгтнийг шилжүүлэх эрх зүйн үндэслэл гэж өөрийн үзэмжээр тооцож болно. Шилжүүлэх ажиллагааг хүлээн авагч улсын хуульд заасан бусад нөхцлийн дагуу гүйцэтгэнэ.

3. Гэмт хэрэгтнийг гэрээний үндсэн дээр шилжүүлэх нөхцөл тавьдаггүй оролцогч улсууд 1 дүгээр зүйлд заасан гэмт хэргийг хүсэлт хүлээн авагч улсын хуульд заасан нөхцлийн дагуу өөр хоорондоо шилжүүлбэл зохих гэмт хэрэг хэмээн хүлээн зөвшөөрнө.

4. 1 дүгээр зүйлд заасан гэмт хэргийг тухайн гэмт хэрэг үйлдэгдсэн газар төдийгүй 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу хэргийн харьяаллаа тогтоох ёстой улсын нутаг дэвсгэрт үйлдсэн гэж оролцогч улсуудын хооронд гэмт хэрэгтнийг шилжүүлэх зорилгын үүднээс үзнэ.

11 дүгээр зүйл

1. Оролцогч улсууд 1 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахтай холбогдуулан байцаан шийтгэх ажиллагаанд шаардлагатай өөрсдийн мэдэлд байгаа бүх нотлох баримтыг гаргаж өгөх зэргээр бие биедээ бүрэн хэмжээгээр туслалцаа үзүүлэх бүхий л арга хэмжээг авна.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх талаар аливаа бусад гэрээгээр хүлээсэн үүргийг хөндөхгүй.

12 дугаар зүйл

Дайнд хэлмэгдэгсдийг хамгаалах тухай 1949 оны Женевийн конвенцууд буюу тэдгээрийн нэмэлт протоколуудыг хүн барьцаалах тодорхой үйлдлийн хувьд хэрэглэдэг бөгөөд энэхүү конвенцид оролцогч улсууд дээрх конвенцуудын дагуу хүн барьцаалсан этгээдийг яллах буюу шилжүүлэн өгөх үүрэг хүлээсний хэрээр 1977 оны нэмэлт I протоколын 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн дагуу улсууд найрсаар харилцах, хамтран ажиллах талаархи олон улсын эрх зүйн зарчмын тухай тунхаглалд дурдсан өөртөө засан тохинох эрхээ хэрэгжүүлэх үүднээс колонийн дарлал, харийн эзлэн түрэмгийлэл, арьсны үзэлт дэглэмийн эсрэг хийж буй ард түмнүүдийн тэмцлээс үүдсэн зэвсэгт мөргөлдөөн зэрэг 1949 оны Женевийн конвенцууд болон

тэдгээрийн протоколуудад заасан зэвсэгт мөргөлдөөний үед хүн барьцаалах үйлдлийн хувьд энэхүү конвенцийг хэрэглэхгүй.

13 дугаар зүйл

Гэмт хэргийг нэг улсын нутаг дэвсгэрт үйлдсэн бөгөөд барьцаанд байгаа хүн болон сэжигтэн этгээд хоёул тухайн улсын харьяат, түүнчлэн сэжигтэн этгээдийг тухайн улсын нутаг дэвсгэрт олж тогтоосон тохиолдолд энэхүү конвенцийг хэрэглэхгүй.

14 дүгээр зүйл

Энэхүү конвенцийн аль ч заалтыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн эсрэг аливаа улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улс төрийн тусгаар тогтнолыг зөрчих явдлыг зөвтгөх утгаар тайлбарлаж болохгүй.

15 дугаар зүйл

Энэхүү конвенцийн заалтууд энэхүү конвенцийг батласан өдөр оролцогч улсуудын хооронд мөрдөгдөж байсан Орогнолын тухай гэрээнүүдийг хэрэглэхийг хөндөхгүй боловч энэхүү конвенцийн оролцогч улс дээрх гэрээнүүдийн тал бус энэхүү конвенцийн оролцогч өөр улсын хувьд дээрх гэрээнүүдийг зааж хэрэглэхгүй.

16 дугаар зүйл

1. Энэхүү конвенцийг тайлбарлах буюу хэрэглэх талаар хоёр буюу түүнээс дээш оролцогч улсын хооронд гарсан бөгөөд хэлэлцээний замаар зохицуулж чадаагүй аливаа маргааныг тэдгээрийн аль нэгний хүсэлтээр арбитраг шилжүүлнэ. Хэрэв арбитраг хүсэлт гаргасан өдрөөс хойш зургаан сарын дотор талууд арбитраг зохион байгуулах талаар тохиролцож чадаагүй бол аль нэг талын хүсэлтээр маргааныг Олон улсын шүүхэд уг шүүхийн дүрмийн дагуу шилжүүлж болно.

2. Улс бүр энэхүү конвенцид гарын үсэг зурах, буюу түүнийг соёрхон батлах, эсхүл түүнд нэгдэн орохдоо энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг заавал биелүүлэх үүрэг хүлээхгүй гэж үзэж байгаа талаар мэдэгдэж болно. Ийм тайлбар хийсэн оролцогч улсын хувьд оролцогч бусад улс нь энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг заавал биелүүлэх үүрэг хүлээхгүй.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу тайлбар хийсэн аливаа оролцогч улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэх замаар тайлбараа хэдийд ч эгүүлэн авч болно.

17 дугаар зүйл

1. Энэхүү конвенц 1980 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл Нью-Йорк хот дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын төв байранд бүх улс гарын үсэг зурахад нээлттэй байна.

2. Энэхүү конвенцийг соёрхон батлана. Батламж жуух бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

3. Энэхүү конвенц нь аливаа улс нэгдэн ороход нээлттэй байна. Нэгдэн орсон тухай баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

18 дугаар зүйл

1. Энэхүү конвенц нь хорин хоёр дахь батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулсан өдрөөс хойш гуч дахь өдрөөс хүчин төгөлдөр болно.

2. Хорин хоёр дахь батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш энэхүү конвенцийг соёрхон баталж байгаа буюу түүнд нэгдэн орж байгаа улсын хувьд тухайн улс батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулсан өдрөөс хойш гуч дахь өдрөөс энэхүү конвенц хүчин төгөлдөр болно.

19 дүгээр зүйл

1. Оролцогч аливаа улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад бичгээр мэдэгдэх замаар энэхүү конвенцийг цуцалж болно.

2. Цуцлах тухай мэдэгдлийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга хүлээн авсан өдрөөс хойш нэг жилийн дараа цуцлалт хүчин төгөлдөр болно.

20 дугаар зүйл

Англи, араб, испани, хятад, орос, франц хэлээрх эх бичвэр нь адил хүчинтэй бүхий энэхүү конвенцийн жинхэнэ эхийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулах бөгөөд тэрбээр тэдгээрийн баталгаат хуулбарыг бүх улсад илгээнэ.

Дээр дурдсаныг нотолж зохих ёсоор засгийн газраасаа бүрэн эрх орлогдсон дор гарын үсэг зурагсад 1979 оны 12 дугаар сарын 18-ны өдрөөс Нью-Йорк хотноо гарын үсэг зурахад нээлттэй болсон энэхүү конвенцид гарын үсэг зурав.

**78. ИРГЭНИЙ НИСЭХИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ХУУЛЬ БУС
ҮЙЛДЛИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ МОНРЕАЛЬ ХОТНОО 1971 ОНЫ 9 ДҮГЭЭР
САРЫН 23-НЫ ӨДӨР ҮЙЛДСЭН КОНВЕНЦИЙН ОЛОН УЛСЫН ИРГЭНИЙ
НИСЭХЭД ҮЙЛЧИЛДЭГ НИСЭХ БУУДАЛ ДАХЬ ХҮЧ ХЭРЭГЛЭСЭН ХУУЛЬ БУС
ҮЙЛДЛИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ НЭМЭЛТ ПРОТОКОЛ**

*1988 оны 2 дугаар сарын 24-ний өдөр баталж,
1989 оны 8 дугаар сарын 6-ны өдөр хүчин төгөлдөр болсон**

Энэхүү протоколд оролцогч улсууд,

олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудал дахь хүмүүсийн аюулгүй байдалд занал учруулж буй буюу занал учруулж болзошгүй, эсхүл эдгээр нисэх буудлын аюулгүй ажиллагаанд саад учруулж буй хүч хэрэглэсэн хууль бус үйлдлүүд нь эдгээр нисэх буудлын аюулгүй ажиллагаанд итгэх дэлхийн ард түмний итгэлийг бууруулж, бүх улсын хувьд иргэний нисэхийг аюулгүй, журамтай удирдахад саад болж байгаа гэж үзэж,

ийм үйлдэл гарч байгаа нь олон улсын хамтын нийгэмлэгийн сэтгэлийг ноцтой түгшээж байгаа бөгөөд ийм үйлдлийг таслан зогсоох зорилгоор гэмт этгээдүүдийг шийтгэхэд зохих арга хэмжээ авах тулгамдсан хэрэгцээ байгаа гэж үзэж,

олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудал дахь хүч хэрэглэсэн хууль бус ийм үйлдлийг зохицуулахын тулд Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай Монреаль хотноо 1971 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр үйлдсэн конвенцийн заалтуудад нэмэлт заалт батлах шаардлагатай байгаа гэж үзэж,

дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

1 дүгээр зүйл

Энэхүү протокол нь Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай Монреаль хотноо 1971 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр үйлдсэн конвенц (цаашид “Конвенц” гэх)-ийн нэмэлт бөгөөд энэхүү протоколд оролцогч улсууд Конвенц болон Протоколыг хамтад нь нэг баримт бичиг хэмээн үзэж, тайлбарлана.

2 дугаар зүйл

1. Конвенцийн 1 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай Ibis хэсэг шинээр нэмнэ:

“Ibis. Дараахь үйлдлийг хууль бусаар санаатайгаар аливаа төхөөрөмж, бодис буюу зэвсэг хэрэглэн хийснийг гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ:

(а) олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудал дахь хүний эсрэг түүнд хүнд гэмтэл учруулах буюу амь насыг нь хохироох, эсхүл хүнд гэмтэл учруулж буюу амь насыг нь хохироож болзошгүй үйлдлийг хүч хэрэглэн хийсэн; эсхүл

* Монгол Улс 1999.10.22-нд нэгдэн орсон

(b) олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудлын төхөөрөмж буюу уг нисэх буудал дахь ашиглалтад бус байгаа агаарын хөлгийг эвдсэн буюу ноцтой хохирол учруулсан, эсхүл нисэх буудлын ажиллагааг тасалдуулсан

нь тухайн нисэх буудлын аюулгүй байдалд заналхийлсэн буюу заналхийлж болзошгүй байвал”.

2. Конвенцийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн (a) дэд хэсгийн “1 дэх хэсэг” гэсэн үгийн дараа дараахь үгийг нэмнэ:

“буюу Ibis хэсэг”.

3 дугаар зүйл

Конвенцийн 5 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 2bis хэсэг шинээр нэмнэ:

“2 bis. Хэлэлцэн тохирогч улс тус бүр сэжигтэн этгээд нутаг дэвсгэрт нь байгаа бөгөөд тухайн улс түүнийг энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан улсад 8 дугаар зүйлийн дагуу шилжүүлээгүй тохиолдолд 1 дүгээр зүйлийн Ibis хэсэгт заасан болон 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн эдгээр гэмт хэрэгт хамаарахын хэрээр уг хэсэгт заасан гэмт хэрэгт харьяаллаа тогтооход шаардлагатай байж болох арга хэмжээг мөн адилаар авна.”

4 дүгээр зүйл

Энэхүү протокол 1988 оны 2 дугаар сарын 9-нөөс 24-ний өдөр Монреаль хотноо болсон Агаарын эрх зүйн талаархи олон улсын бага хуралд оролцогч улсуудын хувьд 1988 оны 2 дугаар сарын 24-ний өдөр гарын үсэг зурахад нээлттэй байна. Протокол нь 1988 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс хойш VI зүйлд заасны дагуу хүчин төгөлдөр болох хүртэл бүх улсын хувьд Лондон, Москва, Вашингтон, Монреаль хотуудад гарын үсэг зурахад нээлттэй байна.

5 дугаар зүйл

1. Протоколыг гарын үсэг зурагч улсууд соёрхон батална.

2. Конвенцийн хэлэлцэн тохирогч улс бус аливаа улс Конвенцийг түүний 15 дугаар зүйлийн дагуу соёрхон батлах буюу түүнд нэгдэн орохдоо энэхүү протоколыг соёрхон баталж болно.

3. Батламж жуух бичгийг энэхүү протоколоор эх хадгалагчаар томилогдсон Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар, эсхүл Олон улсын иргэний нисэхийн байгууллагад хадгалуулна.

6 дугаар зүйл

1. Гарын үсэг зурагч улсуудын арав нь энэхүү протоколыг соёрхон батласан тухай батламж жуух бичгээ хадгалуулмагц энэхүү протокол нь арав дахь батламж жуух

бичгийг хадгалуулсан өдрөөс хойш 30 дахь өдрөөс тэдгээрийн хооронд хүчин төгөлдөр болно. Энэ өдрөөс хойш энэхүү протокол нь батламж жуух бичгээ хадгалуулсан улс тус бүрийн хувьд батламж жуух бичгээ тийнхүү хадгалуулснаас хойш 30 дахь өдрөөс хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү протоколыг хүчин төгөлдөр болмогц хадгалагч нар Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн 102 дугаар зүйл болон Олон улсын иргэний нисэхийн тухай конвенц (Чикаго, 1944 он)-ийн 83 дугаар зүйлийн дагуу бүртгэнэ.

7 дугаар зүйл

1. Энэхүү протокол хүчин төгөлдөр болсныхоо дараа гарын үсэг зурагч бус аливаа улс нэгдэн ороход нээлттэй байна.

2. Конвенцийн хэлэлцэн тохирогч бус аливаа улс Конвенцийг түүний 15 дугаар зүйлийн дагуу соёрхон батлах буюу түүнд нэгдэн орохдоо энэхүү протоколд нэгдэн орж болно.

3. Нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалагч нарт хадгалуулах бөгөөд нэгдэн орсон нь тийнхүү хадгалуулснаас хойш 30 дахь хоногт хүчин төгөлдөр болно.

8 дугаар зүйл

1. Энэхүү протоколын аливаа тал эх хадгалагч нарт бичгээр мэдэгдэх замаар энэхүү протоколыг цуцалж болно.

2. Цуцлах тухай мэдэгдлийг эх хадгалагч нар хүлээн авсан өдрөөс хойш зургаан сарын дараа цуцлалт хүчин төгөлдөр болно.

3. Энэхүү протоколыг цуцалсан нь Конвенцийг цуцалсан болохгүй.

4. Энэхүү нэмэлт протокол бүхий Конвенцийг уг конвенцийн хэлэлцэн тохирогч улс цуцласнаар энэхүү протоколыг нэгэн адил цуцалсан болно.

9 дүгээр зүйл

1. Эх хадгалагч нар энэхүү протоколд гарын үсэг зурагч болон нэгдэн орсон бүх улс, түүнчлэн Конвенцид гарын үсэг зурагч болон нэгдэн орсон бүх улсад дараахь зүйлийг даруй мэдээлнэ:

(а) энэхүү протоколд гарын үсэг зурсан өдөр болон түүнийг соёрхон батласан тухай батламж жуух бичиг буюу түүнд нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулсан өдрийн тухай;

(б) энэхүү протоколыг цуцлах тухай аливаа мэдэгдлийг хүлээж авсан тухай болон уг мэдэгдэл өгсөн өдрийн тухай.

2. Эх хадгалагч нар энэхүү протоколыг 6 дугаар зүйлийн дагуу хүчин төгөлдөр болсон өдрийн тухай 1 дэх хэсэгт заасан улсуудад мөн мэдэгдэнэ.

Дээр дурдсаныг нотолж зохих ёсоор засгийн газраасаа бүрэн эрх олгогдсон дор гарын үсэг зурагсад энэхүү протоколд гарын үсэг зурав.

Нэг мянга есөн зуун наян найман оны 2 дугаар сарын хорин дөрөвний өдөр Мөнреаль хотноо тус бүр нь адил хүчинтэй англи, испани, орос, франц хэлээр дөрвөн эх хувь үйлдэв.

79. ХУВАНЦАР ТЭСРЭХ БОДИС ИЛРҮҮЛЭХ ЗОРИЛГООР ТЭМДЭГ ТАВИХ ТУХАЙ КОНВЕНЦ

*1991 оны 3 дугаар сарын 1-ний өдөр баталж,
1998 оны 6 дугаар сарын 21-ний өдөр хүчин төгөлдөр болсон**

Энэхүү конвенцид оролцогч улсууд,

олон улсын аюулгүй байдалд террорист үйлдлээс үүсэх үр дагаврыг ухамсарлаж,

агаарын хөлөг, тээврийн бусад хэрэгсэл болон бусад объектыг устгахад чиглэсэн террорист үйлдлийн талаар сэтгэл гүнээ түгшиж буйгаа илэрхийлж,

террорист ийм үйлдэлд хуванцар тэсрэх бодис ашиглаж байгаад сэтгэл зовниж,

тэсрэх ийм бодисыг илрүүлэх зорилгоор тэмдэг тавих нь хууль бус ийм үйлдлээс урьдчилан сэргийлэхэд үлэмж хувь нэмэр оруулна гэж үзэж,

хууль бус ийм үйлдлийг таслан зогсоох зорилгоор хуванцар тэсрэх бодист зохих ёсоор тэмдэг тавих явдлыг хангах талаар зохих арга хэмжээ авахыг улсуудад үүрэг болгосон олон улсын баримт бичиг батлах тулгамдсан хэрэгцээ байгааг хүлээн зөвшөөрч,

хуванцар буюу хуудсан тэсрэх бодисыг илрүүлэх зорилгоор тэмдэг тавих талаар олон улсын дэглэм бий болгох ажлыг эрчимжүүлэхийг Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас шаардсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөлийн 1989 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 635 тоот, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1989 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 44/29 тоот тогтоолыг харгалзаж,

хуванцар болон хуудсан тэсрэх бодисыг илрүүлэх зорилгоор тэмдэг тавих талаар олон улсын шинэ баримт бичиг боловсруулахыг эн тэргүүнд нэн чухлаар тавихыг Олон улсын иргэний нисэхийн байгууллагын чуулганы 27 дугаар хуралдаанаас санал нэгтгэйгээр батласан А27-8 дугаар тогтоолыг анхааралдаа авч,

Олон улсын иргэний нисэхийн байгууллагын зөвлөлийн Конвенцийг боловсруулахад гүйцэтгэсэн үүрэг болон түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон чиг үүргийг өөртөө хүлээхийг хүсэж байгааг сэтгэл хангалуун тэмдэглэж,

* Монгол Улс 1999.09.22-нд нэгдэн орсон

дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

1 дүгээр зүйл

Энэхүү конвенцийн зорилгод:

1. “Тэсрэх бодис” гэж энэхүү конвенцийн Техникийн хавсралтад тодорхойлсон “хуванцар тэсрэх бодис” гэсэн түгээмэл нэрээр хэрэглэгддэг тэсрэх бүтээгдэхүүнийг хэлэх бөгөөд үүнд уян буюу зөөлөн хуудсан хэлбэртэй тэсрэх бодис багтана.

2. “Илрүүлэх бодис” гэж тэсрэх бодисыг илрэхүйц шинж чанартай болгох зорилгоор түүнд оруулсан энэхүү конвенцийн Техникийн хавсралтад тодорхойлсон бодисыг хэлнэ.

3. “Тэмдэг тавих” гэж энэхүү конвенцийн Техникийн хавсралтад зааснаар тэсрэх бодист илрүүлэх бодис хийхийг хэлнэ.

4. “Үйлдвэрлэл” гэж тэсрэх бодисыг үйлдвэрлэх бүх үйл явц, түүний дотор дахин боловсруулахыг хэлнэ.

5. “Зохих ёсоор зөвшөөрөгдсөн байлдааны хэрэгсэл” гэж оролцогч холбогдох улсын хууль тогтоомжийн дагуу гагцхүү цэрэг буюу цагдаагийн зорилгоор үйлдвэрлэсэн хонгио, бөмбөг, сум, мин, пуужин, гар бөмбөг, өрөмдөгчийг хэлнэ.

6. “Үйлдвэрлэгч улс” гэж нутаг дэвсгэрт нь тэсрэх бодис үйлдвэрлэсэн аливаа улсыг хэлнэ.

2 дугаар зүйл

Оролцогч улс тус бүр тэмдэг тавиагүй тэсрэх бодисыг нутаг дэвсгэртээ үйлдвэрлэхийг хориглох, түүнээс урьдчилан сэргийлэх талаар шаардлагатай бөгөөд үр дүнтэй арга хэмжээ авна.

3 дугаар зүйл

1. Оролцогч улс бүр тэмдэг тавиагүй тэсрэх бодисыг нутаг дэвсгэртээ оруулах, гаргахыг хориглох, түүнээс урьдчилан сэргийлэх талаар шаардлагатай бөгөөд үр дүнтэй арга хэмжээ авна.

2. Өмнөх хэсгийг оролцогч аль нэг улсын цэрэг буюу цагдаагийн чиг үүрэг гүйцэтгэж байгаа эрх бүхий байгууллага тэмдэг тавиагүй тэсрэх бодисыг 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар тухайн улсын хяналтын дор энэхүү конвенцийн зорилгод харш биш зорилгоор гаргах, оруулахад хэрэглэхгүй.

4 дүгээр зүйл

1. Оролцогч улс бүр энэхүү конвенц тухайн улсын хувьд хүчин төгөлдөр болохоос өмнө нутаг дэвсгэрт нь үйлдвэрлэсэн буюу оруулж ирсэн тэмдэг тавиагүй тэсрэх бодисыг энэхүү конвенцийн зорилгоос өөрөөр буюу үл нийцэх байдлаар ашиглахаас урьдчилан сэргийлэхийн тулд тэдгээрийг эзэмших болон эзэмших эрхийг

шилжүүлэхэд хатуу бөгөөд үр дүнтэй хяналт тавих талаар шаардлагатай арга хэмжээ авна.

2. Оролцогч улс тус бүр цэрэг буюу цагдаагийн чиг үүрэг гүйцэтгэж байгаа эрх бүхий байгууллагад байгаагаас бусад энэ зүйлийн I дэх хэсэгт заасан тэсрэх бодисын бүх нөөцийг энэхүү конвенц тухайн улсын хувьд хүчин төгөлдөр болсноос хойш гурван жилийн хугацааны дотор устгах, энэхүү конвенцийн зорилгод харш биш зорилгоор ашиглаж дуусгах, тэмдэг тавих, эсхүл тэсрэх чанарыг нь алдагдуулах явдлыг хангах талаар шаардлагатай арга хэмжээ авна.

3. Оролцогч улс бүр цэрэг буюу цагдаагийн чиг үүрэг гүйцэтгэж байгаа эрх бүхий байгууллагад байгаа бөгөөд зохих ёсоор зөвшөөрөгдсөн байлдааны хэрэгслийн салшгүй хэсэг болоогүй энэ зүйлийн I дэх хэсэгт заасан тэсрэх бодисын бүх нөөцийг энэхүү конвенц тухайн улсын хувьд хүчин төгөлдөр болсноос хойш арван таван жилийн дотор устгах, энэхүү конвенцийн зорилгод харш биш зорилгоор ашиглаж дуусгах, тэмдэг тавих, эсхүл тэсрэх чанарыг нь алдагдуулах явдлыг хангах талаар шаардлагатай арга хэмжээ авна.

4. Оролцогч улс бүр энэхүү конвенц тухайн улсын хувьд хүчин төгөлдөр болох өдөр цэрэг буюу цагдаагийн чиг үүрэг гүйцэтгэж байгаа эрх бүхий байгууллагад байгаа бөгөөд зохих ёсоор зөвшөөрөгдсөн байлдааны хэрэгслийн салшгүй хэсэг болж буй тэмдэг тавиагүй тэсрэх бодисын нөөцөөс бусад нутаг дэвсгэрт нь олдсон бөгөөд энэ зүйлийн өмнөх хэсгүүдэд заагаагүй тэмдэг тавиагүй тэсрэх бодисыг нутаг дэвсгэртээ аль болох түргэн устгах явдлыг хангах талаар шаардлагатай арга хэмжээ авна.

5. Оролцогч улс тус бүр энэхүү конвенцийн Техникийн хавсралтын I дүгээр хэсгийн II хэсэгт заасан тэсрэх бодисыг энэхүү конвенцийн зорилгоос өөрөөр буюу үл нийцэх байдлаар ашиглахаас урьдчилан сэргийлэхийн тулд тэдгээрийг эзэмших болон эзэмших эрхийг шилжүүлэхэд хатуу бөгөөд үр дүнтэй хяналт тавих талаар шаардлагатай арга хэмжээ авна.

6. Оролцогч улс тус бүр энэхүү конвенц тухайн улсын хувьд хүчин төгөлдөр болсноос хойш үйлдвэрлэсэн бөгөөд энэхүү конвенцийн Техникийн хавсралтын I дүгээр хэсгийн II хэсгийн (d) дэд хэсэгт дурдсантай үл нийцэх тэмдэг тавиагүй тэсрэх бодис болон дээр дурдсан II хэсгийн бусад дэд хэсгийн хамрах хүрээнд хамаарахаа больсон тэмдэг тавиагүй тэсрэх бодисыг нутаг дэвсгэртээ аль болох түргэн устгах явдлыг хангах талаар шаардлагатай арга хэмжээ авна.

5 дугаар зүйл

1. Энэхүү конвенцийн оролцогч улсуудаас нэр дэвшүүлсэн хүмүүс дотроос Олон улсын иргэний нисэхийн байгууллагын зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх)-өөс томилсон арван таваас доошгүй, арван есөөс дээшгүй тооны гишүүнээс бүрдсэн Тэсрэх бодисын олон улсын техникийн комисс (цаашид “Комисс” гэх)-ыг энэхүү конвенцоор байгуулав.

2. Комиссын гишүүд нь тэсрэх бодис үйлдвэрлэх буюу илрүүлэх, эсхүл судлахтай холбогдсон асуудалтай шууд хамааралтай бөгөөд хангалттай туршлага бүхий мэргэжилтнүүд байна.

3. Комиссын гишүүдийн ажиллах хугацаа гурван жил байх бөгөөд тэднийг улируулан томилж болно.

4. Комиссын хуралдааныг Олон улсын иргэний нисэхийн байгууллагын төв байранд жилд наад зах нь нэг удаа, эсхүл Зөвлөлөөс товлосон буюу батласан газар болон цагт зарлан хуралдуулна.

5. Комисс нь үйл ажиллагааны журмаа баталж Зөвлөлөөр зөвшөөрүүлнэ.

6 дугаар зүйл

1. Комисс нь тэсрэх бодис үйлдвэрлэх, тэмдэг тавих, илрүүлэх талаар гарч байгаа техникийн дэвшилд үнэлэлт өгнө.

2. Комисс нь ажлынхаа үр дүнг Зөвлөлөөр дамжуулан оролцогч улсууд болон олон улсын холбогдох байгууллагад илтгэнэ.

3. Комисс нь шаардлага гарсан тухай бүр энэхүү конвенцийн Техникийн хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах талаар Зөвлөлд зөвлөмж гаргана. Комисс нь ийм зөвлөмж гаргах тухай шийдвэрийг нийтийн зөвшилцлөөр гаргах талаар хүчин чармайлт тавина. Нийтийн зөвшилцөлд хүрч чадахгүй тохиолдолд Комисс шийдвэрээ гишүүдийн гуравны хоёрын саналаар гаргана.

4. Зөвлөл нь Комиссын зөвлөмж болгосноор энэхүү конвенцийн Техникийн хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах талаар оролцогч улсуудад санал тавьж болно.

7 дугаар зүйл

1. Оролцогч аливаа улс энэхүү конвенцийн Техникийн хавсралтад оруулах нэмэлт өөрчлөлтийн талаар мэдэгдсэн өдрөөс хойш ер хоногийн дотор Зөвлөлд саналаа хүргүүлж болно. Зөвлөл эдгээр саналыг Комисст хэлэлцүүлэхээр аль болох түргэн дамжуулна. Зөвлөл нэмэлт өөрчлөлтийн талаар санал гаргасан буюу түүнээс татгалзсан аливаа оролцогч улсыг Комисстой зөвлөлдүүлэхээр урина.

2. Комисс өмнөх хэсэгт зааснаар оролцогч улсуудын илэрхийлсэн үзэл бодлыг хэлэлцэн Зөвлөлд илтгэнэ. Зөвлөл нь Комиссын илтгэлийг хэлэлцсэний дараа нэмэлт өөрчлөлт болон оролцогч улсууд, түүний дотор үйлдвэрлэгч улсын саналын шинж чанарыг харгалзан үзэж нэмэлт өөрчлөлтийг батлуулахаар оролцогч бүх улсад санал болгож болно.

3. Хэрэв санал болгосон нэмэлт өөрчлөлтийг оролцогч тав буюу түүнээс олон улс уг нэмэлт өөрчлөлтийн талаар Зөвлөлийн мэдэгдсэн өдрөөс хойш ер хоногийн дотор хүлээж авахгүй тухайгаа Зөвлөлд бичгээр мэдэгдээгүй бол түүнийг батласанд тооцож уг нэмэлт өөрчлөлт нь түүнээс хойш нэг зуун наян хоног, эсхүл санал болгосон нэмэлт өөрчлөлтөд заасан өөр хугацааны дараа түүнийг хүлээж авахгүй байх талаар шууд мэдэгдээгүй оролцогч улсын хувьд хүчин төгөлдөр болно.

4. Санал болгосон нэмэлт өөрчлөлтөөс шууд хүлээж авахгүй оролцогч улсууд уг нэмэлт өөрчлөлтийн заалтуудыг заавал биелүүлэх зөвшөөрлөө хүлээн зөвшөөрсөн буюу батласан тухай баримт бичгийг хадгалуулах журмаар хойшид илэрхийлж болно.

5. Хэрэв санал болгосон нэмэлт өөрчлөлтийг тав буюу түүнээс олон оролцогч улс хүлээж авахгүй бол Зөвлөл түүнийг үргэлжлүүлэн хэлэлцүүлэхээр Комисст шилжүүлнэ.

6. Санал болгосон нэмэлт өөрчлөлтийг энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар батлаагүй бол Зөвлөл оролцогч бүх улсын бага хурлыг зарлан хуралдуулж болно.

8 дугаар зүйл

1. Оролцогч улсууд боломжтой бол Комисст 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан чиг үүргээ биелүүлэхэд нь тус болох мэдээллийг шилжүүлнэ.

2. Оролцогч улсууд энэхүү конвенцийн заалтуудыг хэрэгжүүлэхээр авсан арга хэмжээнийхээ талаар Зөвлөлд мэдээлж байна. Зөвлөл ийм мэдээллийг оролцогч бүх улс болон холбогдох олон улсын байгууллагад дамжуулна.

9 дүгээр зүйл

Зөвлөл нь оролцогч улсууд болон олон улсын холбогдох байгууллагатай хамтран энэхүү конвенцийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх талаар зохих арга хэмжээ, үүний дотор техникийн туслалцаа үзүүлэх болон тэсрэх бодист тэмдэг тавих, түүнийг илрүүлэх талаар гарч байгаа техникийн дэвшилтэй холбогдох мэдээлэл солилцох арга хэмжээ авна.

10 дугаар зүйл

Энэхүү конвенцийн Техникийн хавсралт нь энэхүү конвенцийн салшгүй хэсэг байна.

11 дүгээр зүйл

1. Энэхүү конвенцийг тайлбарлах буюу хэрэглэх талаар хоёр буюу түүнээс дээш оролцогч улсын хооронд гарсан бөгөөд хэлэлцээний замаар шийдвэрлэж чадаагүй аливаа маргааныг тэдгээрийн аль нэгний хүсэлтээр арбитраг шилжүүлнэ. Хэрэв арбитраг хүсэлт гаргасан өдрөөс хойш зургаан сарын дотор талууд арбитраг зохион байгуулах талаар тохиролцож чадаагүй бол аль нэг талын хүсэлтээр маргааныг Олон улсын шүүхэд уг шүүхийн дүрмийн дагуу шилжүүлж болно.

2. Оролцогч улс бүр энэхүү конвенцид гарын үсэг зурах, буюу түүнийг соёрхон батлах, эсхүл түүнд нэгдэн орохдоо энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг заавал биелүүлэх үүрэг хүлээхгүй гэж үзэж байгаа талаар мэдэгдэж болно. Ийм тайлбар хийсэн оролцогч улсын хувьд оролцогч бусад улс нь энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг заавал биелүүлэх үүрэг хүлээхгүй.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу тайлбар хийсэн оролцогч аливаа улс эх хадгалагчид мэдэгдэх замаар тайлбараа хэдийд ч эгүүлэн авч болно.

12 дугаар зүйл

11 дүгээр зүйлд зааснаас бусад тохиолдолд энэхүү конвенцид тайлбар хийж болохгүй.

13 дугаар зүйл

1. Энэхүү конвенц 1991 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс 3 дугаар сарын 1-ний өдөр хүртэл Монреаль хотноо болсон Агаарын эрх зүйн талаархи олон улсын бага хуралд оролцогч улсуудын хувьд 1991 оны 3 дугаар сарын 1-ний өдөр гарын үсэг зурахад нээлттэй байна. 1991 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс хойш энэхүү конвенц нь энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар хүчин төгөлдөр болох хүртэл бүх улсын хувьд Монреаль хот дахь Олон улсын иргэний нисэхийн байгууллагын төв байранд гарын үсэг зурахад нээлттэй байна. Энэхүү конвенцид гарын үсэг зураагүй аливаа улс түүнд хэдийд ч нэгдэн орж болно.

2. Энэхүү конвенцийг улсууд соёрхон баталж, хүлээн зөвшөөрч, баталж, эсхүл түүнд нэгдэн орж болно. Соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн, батласан эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг энэхүү конвенцийн дагуу эх хадгалагчаар томилогдсон Олон улсын иргэний нисэхийн байгууллагад хадгалуулна. Соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн, батласан эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахдаа улс бүр үйлдвэрлэгч улс мөн эсэхээ мэдэгдэнэ.

3. Энэхүү конвенц нь гучин тав дахь соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн, батласан эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг эх хадгалагчид хадгалуулсан өдрөөс хойш жар дахь өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд чингэхдээ эдгээр улсын таваас доошгүй нь өөрийгөө үйлдвэрлэгч гэж энэ зүйлийн 2 дахь хэсгийн дагуу мэдэгдсэн байвал зохино. Ийм гучин таван баримт бичгийг үйлдвэрлэгч таван улс баримт бичгээ хадгалуулахаас өмнө хадгалуулсан тохиолдолд энэхүү конвенц нь тав дахь үйлдвэрлэгч улс соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн, батласан, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулсан өдрөөс хойш жар дахь өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4. Бусад улсын хувьд соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн, батласан, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулсан өдрөөс хойш жар дахь өдрөөс эхлэн энэхүү конвенц нь хүчин төгөлдөр болно.

5. Энэхүү конвенцийг хүчин төгөлдөр болмогц эх хадгалагч Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн 102 дугаар зүйл болон Олон улсын иргэний нисэхийн тухай конвенц (Чикаго, 1944 он)-ийн 83 дугаар зүйлийн дагуу бүртгэнэ.

14 дүгээр зүйл

Эх хадгалагч нь гарын үсэг зурагч болон оролцогч бүх улсад дараахь зүйлийг даруй мэдэгдэнэ:

1. энэхүү конвенцид гарын үсэг зурсан тухай болон гарын үсэг зурсан өдрийн тухай;

2. батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, батласан эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулсан тухай болон хадгалуулсан өдрийн тухай, чингэхдээ тухайн улс өөрийгөө үйлдвэрлэгч улс гэж тодорхойлсон эсэхийг онцгойлон заана;

3. энэхүү конвенц хүчин төгөлдөр болсон өдрийн тухай;

4. энэхүү конвенцид буюу түүний Техникийн хавсралтад оруулсан аливаа нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болох өдрийн тухай;
5. 15 дугаар зүйлд зааснаар конвенцийг цуцалсан тухай;
6. 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар хийсэн аливаа мэдэгдлийн тухай.

15 дугаар зүйл

1. Оролцогч аливаа улс эх хадгалагчид бичгээр мэдэгдэх замаар энэхүү конвенцийг цуцалж болно.

2. Цуцлах тухай мэдэгдлийг эх хадгалагч хүлээн авсан өдрөөс хойш нэг зуун наян хоногийн дараа цуцлалт хүчин төгөлдөр болно.

Дээр дурдсаныг нотолж засгийн газраасаа зохих ёсоор бүрэн эрх олгогдсон дор гарын үсэг зурагсад энэхүү конвенцид гарын үсэг зурцгаав.

Нэг мянга есөн зуун ерэн нэгэн оны гуравдугаар сарын нэгний өдөр Монреаль хотноо англи, араб, испани, орос, франц хэлээр адил хүчинтэй таван эх бичвэр бүхий нэг жинхэнэ эх хувь үйлдэв.

ТЕХНИКИЙН ХАВСРАЛТ

I ХЭСЭГ: ТЭСРЭХ БОДИСЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. Энэхүү конвенцийн I дүгээр зүйлийн I дэх хэсэгт заасан тэсрэх бодисуудад дараахь бодис хамрагдана:

- (a) урвалд ороогүй үедээ 25 С градусын температурт ууршилтын даралт нь 10-4 Па-гаас бага нэг буюу хэд хэдэн хүчтэй тэсрэх бодисын нэгдэл;
- (b) наах материал агуулсан нэгдэл;
- (c) тасалгааны ердийн температурт зөөлөн буюу уян хатан байх нэгдэл.

II. Дараахь тэсрэх бодисыг энэ хэсгийн I дэх хэсэгт заасан тэсрэх бодисын тодорхойлолтод тохирч байсан хэдий ч дор дурдсан зорилгоор үргэлжлүүлэн хадгалж байгаа буюу ашиглаж байгаа, эсхүл байлдааны хэрэгслийн салшгүй хэсэг болсон хэвээр байгаа тохиолдолд тэсрэх бодис гэж үзэхгүй, тухайлбал:

- (a) гагцхүү шинэ буюу өөрчилсөн тэсрэх бодисын зохих ёсоор зөвшөөрөгдсөн судалгаа, боловсруулалт, туршилтад ашиглахаар цөөн тоогоор үйлдвэрлэсэн буюу хадгалж байгаа;
- (b) гагцхүү зохих ёсоор зөвшөөрөгдсөн тэсрэх бодис илрүүлэх талаархи сургалтад болон/буюу тэсрэх бодис илрүүлэх тоног төхөөрөмжийн боловсруулалт буюу туршилтад ашиглахаар цөөн тоогоор үйлдвэрлэсэн буюу хадгалж байгаа;

(с) гагцхүү зохих ёсоор зөвшөөрөгдсөн шүүхийн шинжлэх ухааны зорилгод ашиглахаар цөөн тоогоор үйлдвэрлэсэн буюу хадгалж байгаа;

(d) үйлдвэрлэгч улсын хувьд энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш гурван жилийн дотор тухайн улсын нутаг дэвсгэрт зохих ёсоор зөвшөөрөгдсөн байлдааны хэрэгслийн салшгүй хэсэг болох зориулалт бүхий буюу тийм салшгүй хэсэг болсон. Дээрх гурван жилийн хугацаанд үйлдвэрлэсэн хэрэгслийг энэхүү конвенцийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн хүрээнд зохих ёсоор зөвшөөрөгдсөн байлдааны хэрэгсэл гэж үзнэ.

III. Энэ хэсэгт:

2 дахь хэсгийн (a), (b), (c) дэд хэсэгт “зохих ёсоор зөвшөөрөгдсөн” гэж холбогдох улсын хууль тогтоомжийн дагуу зөвшөөрснийг хэлнэ; түүнчлэн

“хүчтэй тэсрэх бодис” гэдэгт циклотетраметилентетранитрамин (HMX), тетранитрат пентаэритрит (PETN) болон циклотриметилентринитрамин (RDX) багтах боловч эдгээрээр хязгаарлахгүй.

II ХЭСЭГ: ИЛРҮҮЛЭХ БОДИС

Илрүүлэх бодис гэдэг нь дараахь хүснэгтэд заасан аль нэг бодис байна. Энэ хүснэгтэд заасан илрүүлэх бодисыг ууршилт илрүүлэх хэрэгслээр тэсрэх бодисын илрэхүйц чанарыг сайжруулахаар ашиглах зорилготой юм. Илрүүлэх бодисыг бэлэн бүтээгдэхүүнд ижил хэмжээтэй тархсан байхаар тэсрэх бодист тохиолдол тус бүрт хийнэ. Үйлдвэрлэсний дараа бэлэн бүтээгдэхүүнд байх илрүүлэх бодисын тунгийн доод хэмжээг дээр дурдсан хүснэгтэд заасан болно.

ХҮСНЭГТ

Илрүүлэх бодисын нэр	Молекулын томъёо	Молекулын жин	Тунгийн доод хэмжээ
Этиленгликольдинитрат (EGDN)	C ₂ H ₄ (NO ₃) ₂	152	массаар 0.2%
2,3 диметил – 2,3 динитробутан (DMNB)	C ₆ H ₁₂ (NO ₂) ₂	176	массаар 0.1%
пара-мононитротолуол (p-MNT)	C ₇ H ₇ NO ₂	137	массаар 0.5%
орто-мононитротолуол (o-MNT)	C ₇ H ₇ NO ₂	137	массаар 0.5%

Тэсрэх бодисыг ердийн байдлаар бэлтгэхэд түүнд байгаа дээр заасан аливаа илрүүлэх бодисын тун шаардлагатай доод хэмжээнд буюу түүнээс дээш байвал түүнд тэмдэг тавьсан гэж үзнэ.

80. ТЕРРОРИЗМЫН ЗОРИЛГООР БӨМБӨГ ХЭРЭГЛЭХИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦ

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей 1998 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр баталж, 2001 оны 5 дугаар сарын 23-нд хүчин төгөлдөр болсон*

Энэхүү конвенцийн оролцогч улсууд,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах болон улс хоорондын сайн хөршийн харилцаа, найрсаг харилцаа, хамтын ажиллагааг дэмжин хөгжүүлэх зорилго, зарчмыг санаж,

терроризмын үйлдэл бүх хэлбэр, илрэлээрээ дэлхий дахинд өргөжиж байгаад сэтгэл гүнээ зовниж,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын 1995 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн Тавин жилийн ойн тунхаглалыг эргэн санаж,

“Терроризмын бүх үйлдэл, арга, дадал, түүний дотор улс, ард түмэн хоорондын найрсаг харилцаанд занал учруулж, улсуудын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, аюулгүй байдалд заналхийлэх үйлдэл, арга, далдыг хаана, хэн үйлдсэнээс нь үл хамааран гэмт хэрэг бөгөөд зөвтгөх боломжгүй гэж шууд буруутгаж буйгаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн улсууд *inter alia* ёслол төгөлдөр дахин нотлосон” Ерөнхий Ассамблейн 1994 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 49/60 тоот тогтоолд хавсаргасан Олон улсын терроризмыг устгах арга хэмжээний тухай тунхаглалыг мөн эргэн санаж,

Олон улсын терроризмыг устгах арга хэмжээний тухай тунхаглалд терроризм, түүний бүх хэлбэр, илрэлээс урьдчилан сэргийлэх, шийтгэх, таслан зогсоох талаар үйлчилж буй олон улсын эрх зүйн хэм хэмжээг нэн даруй авч үзэх, эдгээр асуудлын бүх талыг хамарсан иж бүрэн эрх зүйн тогтолцоог боловсруулахад улсуудад дэмжлэг үзүүлсэн байдгийг тэмдэглэж,

Ерөнхий Ассамблейн 1996 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 51/210 тоот тогтоол болон түүнд хавсаргасан Олон улсын терроризмыг устгах арга хэмжээний тухай тунхаглалын нэмэлт тунхаглалыг цаашид эргэн санаж,

тэсэрч дэлбэрэх бодис болон амь насанд аюултай бусад төхөөрөмж хэрэглэн террорист халдлага хийх нь улам өргөн тархаж байгааг мөн тэмдэглэж,

эдгээр халдлагыг үйлчилж буй олон улсын эрх зүйн заалт зохих түвшинд хамарч чадахгүй байгааг цаашид тэмдэглэж,

* Монгол Улс 2000.08.31-нд соёрхон батласан

терроризмын ийм үйлдлээс урьдчилан сэргийлэх, түүнийг үйлдсэн этгээдийг мөрдөх, шийтгэх талаар үр дүнтэй, бодитой арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх талаар улс хоорондын олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэн хөгжүүлэх нэн шаардлагатай гэдэгт итгэл төгс байж,

ийм үйлдэл гарах нь олон улсын хамтын нийгэмлэгийн ноцтой сэтгэл зовних асуудал болохыг харгалзан үзэж,

улсуудын цэргийн хүчний үйл ажиллагаа энэхүү конвенцийн хүрээнээс гадуур олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж буйг, түүнчлэн тодорхой арга хэмжээг энэхүү конвенцийн хамрах хүрээнээс гаргаснаар хууль бус үйлдлийг ноцтой бус, эсхүл өөр байдлаар хууль ёсны болгохгүй бөгөөд бусад хуулийн дагуу мөрдөхөд саад болохгүйг тэмдэглэж,

дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

1 дүгээр зүйл

Энэхүү конвенцийн зорилгод:

1. “Төрийн буюу засгийн газрын объект” гэж өөрсдийн албан үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан төрийг төлөөлсөн албан тушаалтнууд, засгийн газрын гишүүд, хууль тогтоох болон шүүхийн байгууллагын төлөөлөгчид, төрийн бусад байгууллагуудын албан хаагчид, мөн засгийн газар хоорондын байгууллагуудын албан хаагчид, албан тушаалтнуудаас байнгын болон түр үндсэн дээр ашиглаж буй аливаа объект буюу тээврийн хэрэгслийг хэлнэ.

2. “Дэд бүтцийн объект” гэж цэвэр ус, бохир ус, эрчим хүч, түлш, харилцаа холбоо зэрэг үйлчилгээг нийтийн хэрэгцээнд хангах буюу түгээх улсын буюу хувийн өмчийн объектыг хэлнэ.

3. “Тэсрэх бодис болон амь насанд аюултай бусад төхөөрөмж” гэж:

(а) хүний амь нас хөнөөх, бие махбодид хүнд гэмтэл, эсхүл эд материалын үлэмж хохирол учруулах зориулалт бүхий, тийм чадвартай тэсрэх бодис болон галт зэвсэг буюу төхөөрөмж; эсхүл

(б) химийн хорт бодис, биологийн идэвхт бодис буюу токсин, эсхүл тэдгээртэй төсөөтэй бодис, радиац, цацраг идэвхт материал ялгаруулах, түгээх, нөлөөлөх замаар хүний амь нас хөнөөх, бие махбодид хүнд гэмтэл, эсхүл эд материалын үлэмж хохирол учруулах зориулалт бүхий, тийм чадвартай зэвсэг буюу төхөөрөмжийг хэлнэ.

4. “Төрийн цэргийн хүчин” гэж аль нэг улсын үндэсний батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах нэн тэргүүний зорилгоор дотоодын хуулийнх нь дагуу зохион байгуулагдаж, бэлтгэгдэж, тоноглогдсон зэвсэгт хүчин, түүнчлэн тэдгээрийн удирдлага, хяналт, хариуцлагын дор тэдгээр зэвсэгт хүчнийг дэмжих үүрэг гүйцэтгэгч этгээдүүдийг хэлнэ.

5. “Нийтийн хэрэглээний газар” гэж аливаа барилга, хэсэг газар, гудамж, усан зам буюу бусад газрын байнга, үе үе эсхүл зарим тохиолдолд олон нийтэд хүртээлтэй, эсхүл нээлттэй байдаг хэсгийг хэлэх бөгөөд үүнд худалдаа, бизнес, соёл, түүх, боловсрол, шашин, төрийн үйлчилгээ, цэнгээн, амралтын, эсхүл тэдгээртэй төсөөтэй олон нийтэд хүртээлтэй, эсхүл нээлттэй байдаг газрыг хамруулна.

6. “Нийтийн тээврийн тогтолцоо” гэж зорчигч болон ачаа тээвэрлэх нийтэд хүртээлтэй үйлчилгээнд хэрэглэдэг улсын буюу хувийн өмчийн бүх төрлийн объект, тээврийн хэрэгсэл, туслах хэрэгслийг хэлнэ.

2 дугаар зүйл

1. Хэрэв аливаа этгээд:

(a) хүний амь нас хөнөөх буюу бие махбодид хүнд гэмтэл учруулахыг зорин; эсхүл

(b) эдийн засгийн томоохон алдагдалд оруулах, эсхүл оруулж болзошгүй их хэмжээний сүйрлийг тухайн газар, объект, тогтолцоонд учруулахыг зорин

тэсрэх бодис буюу амь насанд аюултай бусад төхөөрөмжийг нийтийн хэрэглээний газар, төрийн буюу засгийн газрын объект, нийтийн тээврийн тогтолцоо, эсхүл дэд бүтцийн объект, тэдгээрийн эсрэг хууль бусаар, эсхүл санаатайгаар хүргүүлсэн, байрлуулсан, тэсэлсэн, дэлбэлсэн бол уг этгээдийг энэхүү конвенцийн үзэл санааны хүрээнд гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ.

2. Хэрэв аливаа этгээд 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдэхийг завдсан бол тухайн этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэж мөн үзнэ.

3. Хэрэв аливаа этгээд дараахь үйлдлийг хийсэн бол түүнийг гэмт хэрэг үйлдсэн гэж тооцно:

(a) 1 буюу 2 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт хамтран оролцсон;

(b) 1 буюу 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг үйлдэх зорилгоор бусдыг зохион байгуулсан буюу удирдсан;

(c) 1 буюу 2 дахь хэсэгт заасан нэг буюу хэд хэдэн гэмт хэргийг бүлэг этгээд ч нэг зорилготойгоор үйлдэхэд бусад аливаа өөр хэлбэрээр хувь нэмэр оруулсан, чингэхдээ уг хувь нэмрийг санаатайгаар бөгөөд ерөнхий гэмт үйл ажиллагаа буюу уг бүлгийн зорилгыг цааш нь дэмжих зорилгоор эсхүл тухайн бүлгийн уг гэмт хэрэг буюу гэмт хэргүүдийг үйлдэх чиг санааг мэдсэн атлаа оруулсан байх.

3 дугаар зүйл

Гэмт хэргийг зөвхөн нэг улсад үйлдсэн, сэжигтэн этгээд болон хохирогч нь тухайн улсын харьяат, сэжигтэн этгээдийг тухайн улсын нутаг дэвсгэрт олсон, түүнчлэн тухайн тохиолдолд энэхүү конвенцийн 10-аас 15 дугаар зүйлийн заалт зохих үед хэрэглэхээс бусад тохиолдолд энэхүү конвенцийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, эсхүл 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн дагуу хэргийн харьяаллаа хэрэгжүүлэх өөр улс байхгүй бол энэхүү конвенцийг хэрэглэхгүй.

4 дүгээр зүйл

Оролцогч улс бүр дараахь чиглэлээр шаардлагатай байж болох арга хэмжээг авна:

(a) энэхүү конвенцийн 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийг дотоодын хуульдаа эрүүгийн гэмт хэрэг гэж тогтоох;

(b) тэдгээр гэмт хэргийн ноцтой шинжийг харгалзан тохирох ял шийтгэлийг тогтоох.

5 дугаар зүйл

Энэхүү конвенцийн хамрах хүрээнд үйлдсэн гэмт үйлдэл нь, ялангуяа тэдгээр үйлдэл нь олон нийт, бүлэг этгээд, эсхүл тодорхой этгээдүүдийн дунд террорист байдал бий болгохыг зорьсон, эсхүл тийнхүү тооцоологдсон бол тэдгээр үйлдлийг улс төр, гүн ухаан, үзэл суртал, арьс үндэс, үндэс угсаа, шашин шүтлэг, эсхүл төсөөтэй бусад шалтгаанаар ямар ч нөхцөлд зөвтгөхгүй бөгөөд ноцтой шинжид нь тохирох ял шийтгэл ногдуулах явдлыг хангах талаар шаардлагатай байж болох арга хэмжээг оролцогч улс бүр авах бөгөөд түүний дотор зохих үед дотоодын хууль тогтоомжийг оролцуулан авна.

6 дугаар зүйл

1. Оролцогч улс бүр 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийг дараахь байдлаар үйлдсэн бол хэргийн харьяаллаа тогтооход шаардлагатай байж болох арга хэмжээг авна:

(a) тухайн улсын нутаг дэвсгэрт үйлдсэн;

(b) гэмт хэргийг үйлдэх үед тухайн улсын төрийн далбааг мандуулсан хөлөг онгоцны тавцан дээр буюу тухайн улсын хуулийн дагуу бүртгэгдсэн агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн;

(c) тухайн улсын харьяат үйлдсэн.

2. Оролцогч улс аливаа ийм гэмт хэргийг дараахь байдлаар үйлдсэн бол хэргийн харьяаллаа мөн тогтоож болно:

(a) тухайн улсын харьяатын эсрэг үйлдсэн;

(b) тухайн улсын төрийн буюу засгийн газрын хилийн чанад дахь объект, түүний дотор тухайн улсын элчин сайдын яам эсхүл дипломат буюу консулын төлөөлөгчийн газрын байрны эсрэг үйлдсэн; эсхүл

(c) тухайн улсын нутаг дэвсгэрт байнга оршин суудаг харьяалалгүй этгээд үйлдсэн;

(d) уг гэмт хэрэг нь тухайн улсаас ямарваа нэгэн арга хэмжээ авахуулах, эсхүл авахаас татгалзахыг тулган шаардах оролдлогын дагуу үйлдсэн; эсхүл

(e) гэмт хэргийг тухайн улсын засгийн газрын эзэмшлийн агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн.

3. Оролцогч улс бүр энэхүү конвенцийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах буюу нэгдэн орохдоо энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу өөрийн хэргийн харьяаллаа тогтоосон тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэнэ. Ямар нэгэн өөрчлөлт гарсан тохиолдолд оролцогч холбогдох улс нь энэ тухайгаа Ерөнхий нарийн бичгийн даргад нэн даруй мэдэгдэнэ.

4. Хэрэв 2 дугаар зүйлд дурдсан гэмт хэргийг үйлдсэн гэх сэжигтэн этгээд нь тухайн улсын нутаг дэвсгэрт байгаа бөгөөд түүнийг энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу хэргийн харьяаллаа тогтоосон оролцогч бусад улсад шилжүүлээгүй бол оролцогч тухайн улс уг гэмт хэргийн хувьд өөрийн хэргийн харьяаллыг тогтоох шаардлагатай байж болох арга хэмжээ авна.

5. Энэхүү конвенц нь оролцогч улсын дотоодын хуульдаа нийцүүлэн тогтоосон эрүүгийн хэргийн аливаа харьяаллыг хэрэгжүүлэх явдлыг үгүйсгэхгүй.

7 дугаар зүйл

1. 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийг үйлдсэн буюу үйлдсэн гэж сэжиглэгдсэн этгээд нь тухайн улсын нутаг дэвсгэрт байж болох тухай мэдээллийг хүлээн авмагц оролцогч холбогдох улс тэрхүү мэдээлэлд дурдсан баримтыг мөрдөн байцаах талаар өөрийн дотоодын хуулийн дагуу зохих арга хэмжээ авна.

2. Хэрэв оролцогч улс нөхцөл байдал тийнхүү шаардаж байна гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн буюу үйлдсэн гэж сэжиглэгдсэн этгээд нь түүний нутаг дэвсгэрт байгаа бол оролцогч тухайн улс уг этгээдийг шилжүүлэх, эсхүл яллагаанд байлцуулах явдлыг хангах зорилгоор өөрийн дотоодын хууль тогтоомжийн дагуу холбогдох арга хэмжээ авна.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан арга хэмжээ авахуулж буй аливаа этгээд дараахь эрхийг эдэлнэ:

(а) тухайн этгээдийг харьяалах, эсхүл түүний эрхийг ямар нэг хэлбэрээр хамгаалах эрх бүхий улсын хамгийн ойр байх холбогдох төлөөлөгчтэй, хэрэв тухайн этгээд харьяалалгүй бол нутаг дэвсгэрт нь байнга оршин суугаа газар нь байрлах улсын төлөөлөгчтэй саадгүйгээр холбоо барих;

(б) тухайн улсын төлөөлөгчтэй уулзах;

(с) (а) болон (б) дэд хэсгийн дагуу эдлэх тухайн этгээдийн эрхийн талаар мэдээлэл авах.

4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан эрхийг гэмт хэрэгтэн буюу сэжигтэн этгээд нутаг дэвсгэрт нь байгаа улсын хууль тогтоомжийн дагуу эдлүүлэх бөгөөд уг хууль тогтоомж нь энэ зүйлийн 3 дахь хэсгийн дагуу эрх олгож буй зорилгыг бүрэн хэрэгжүүлэхэд чиглэсэн байвал зохино.

5. Энэ зүйлийн 3, 4 дэх хэсгийн заалтууд нь 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (с) дэд хэсэг, эсхүл 2 дахь хэсгийн (с) дэд хэсгийн дагуу хэргийн харьяаллаа тогтоохыг хүссэн оролцогч аливаа улс Олон улсын улаан загалмайн нийгэмлэгийг сэжигтэн этгээдтэй холбоо барих, уулзалт хийхийг урих эрхийг хөндөхгүй.

6. Энэ зүйлийн дагуу аливаа этгээдийг цагдан хорьсон оролцогч улс нь 6 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу хэргийн харьяаллаа тогтоосон оролцогч улс, түүнчлэн, хэрэв шаардлагатай гэж үзвэл тухайн этгээдийг цагдан хорьсон тухай болон түүнийг тийнхүү хорих болсон үндэслэл болон нөхцөл байдлын тухай сонирхсон бусад оролцогч улсад шууд буюу Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргаар дамжуулан даруй мэдэгдэнэ. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан мөрдөн байцаалтыг явуулж буй улс нь дээрх улсуудад мөрдөн байцаалтын үр дүнгийн талаар даруй мэдээлж, хэргийн харьяаллаа хэрэгжүүлэх эсэх тухайгаа мэдэгдэнэ.

8 дугаар зүйл

1. Нутаг дэвсгэрт нь сэжигтэн этгээд байгаа оролцогч улс 6 дугаар зүйлийн заалтуудыг хэрэглэх тохиолдолд хэрэв тухайн этгээдийг шилжүүлэн өгөхгүй бол гэмт хэрэг нутаг дэвсгэрт нь үйлдэгдсэн эсэхээс үл хамаарч хэргийг тухайн улсын хууль тогтоомжийн дагуу байцаан шийтгэх ажиллагаа явуулж өөрийн эрх бүхий байгууллагад яллуулахаар шилжүүлэх үүргийг аливаа нөхцөлгүйгээр хүлээнэ. Эдгээр байгууллага шийдвэрээ тухайн улсын хууль тогтоомжийн дагуу ноцтой шинж бүхий ердийн гэмт хэргийг шийдвэрлэдгийн адилаар гаргана.

2. Хэрэв оролцогч улсын дотоодын хууль тогтоомжид шилжүүлж өгөх буюу хүлээлгэн өгөх өөрийн иргэнийг зөвхөн шүүх хурал буюу шүүх ажиллагааны дүнд оногдуулсан ялыг гагцхүү тухайн улсад эргүүлэн авчирч эдлүүлэх болзолтойгоор шилжүүлж өгөх буюу хүлээлгэн өгөхийг зөвшөөрсөн бөгөөд тухайн улс болон уг этгээдийг шилжүүлж авахыг хүссэн улсын аль аль нь энэ хувилбар болон шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөлийн талаар тохиролцоонд хүрсэн бол ийнхүү

нөхцөл болзолтойгоор шилжүүлэн өгөх буюу хүлээлгэн өгөх нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүргийг биелүүлэхэд хангалттай байх болно.

9 дүгээр зүйл

1. Энэхүү конвенцийн 2 дугаар зүйлд дурдсан гэмт хэрэг нь энэхүү конвенцийг хүчин төгөлдөр болохоос өмнө оролцогч улсуудын хооронд байгуулсан гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай аливаа гэрээний хувьд шилжүүлэн өгвөл зохих гэмт хэрэг гэж тусгагдсанд тооцно. Оролцогч улсууд ийм гэмт хэргийг гэмт хэрэгтнийг шилжүүлэх тухай өөр хоорондоо байгуулах гэрээ бүртээ шилжүүлбэл зохих гэмт хэрэгт багтаан тусгах үүрэг хүлээнэ.

2. Хэрэв гэмт хэрэгтнийг гэрээний үндсэн дээр шилжүүлэх нөхцөл тавьдаг оролцогч улс түүнтэй гэрээ байгуулаагүй оролцогч нөгөө улсаас гэмт хэрэгтэн шилжүүлэх тухай хүсэлт хүлээн авбал 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хувьд энэхүү конвенцийг гэмт хэрэгтнийг шилжүүлэх эрх зүйн үндэслэл гэж өөрийн үзэмжээр тооцож болно. Шилжүүлэх ажиллагааг хүсэлт хүлээн авагч улсын хуульд заасан бусад нөхцөлийн дагуу гүйцэтгэнэ.

3. Гэмт хэрэгтнийг гэрээний үндсэн дээр шилжүүлэх нөхцөл тавьдаггүй оролцогч улсууд 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийг хүсэлт хүлээн авагч улсын хуульд заасан нөхцлийн дагуу өөр хоорондоо шилжүүлбэл зохих гэмт хэрэг хэмээн хүлээн зөвшөөрнө.

4. Шаардлагатай бол 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийг тухайн гэмт хэрэг үйлдэгдсэн газар төдийгүй 6 дугаар зүйлийн 1 болон 2 дахь хэсгийн дагуу хэргийн харьяаллаа тогтоох ёстой улсын нутаг дэвсгэрт үйлдсэн гэж оролцогч улсуудын хооронд гэмт хэрэгтнийг шилжүүлэх зорилгын үүднээс үзнэ.

5. 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийн тухайд гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай оролцогч улсуудын хоорондын бүхий л гэрээ, тохиролцооны энэхүү конвенцтой харшилсан заалтуудыг конвенцийн заалтуудтай нийцэх байдлаар өөрчлөгдсөн гэж оролцогч улсуудын хооронд үзнэ.

10 дугаар зүйл

1. Оролцогч улсууд 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хувьд мөрдөн байцаалт эсхүл эрүүгийн байцаан шийтгэх буюу шилжүүлэн өгөх ажиллагаатай холбогдсон туслалцааг бие биедээ дээд зэргээр үзүүлнэ, түүний дотор тэдгээр ажиллагаанд шаардлагатай өөрийн мэдэлд байгаа нотлох баримтыг олж авахад нь туслана.

2. Оролцогч улсууд 2 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт эрүүгийн мөрдөн байцаах, эрүүгийн байцаан шийтгэх болон шилжүүлэх ажиллагаатай холбогдуулан байцаан шийтгэх ажиллагаанд шаардлагатай өөрсдийн мэдэлд байгаа бүх нотлох баримтыг гаргаж өгөх зэргээр бие биедээ бүрэн хэмжээгээр туслалцаа үзүүлнэ.

11 дүгээр зүйл

Гэмт этгээдийг шилжүүлэх, эсхүл эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх зорилгын хүрээнд 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийн алийг ч улс төрийн гэмт хэрэг, эсхүл улс төрийн гэмт хэрэгтэй холбогдол бүхий гэмт хэрэг, эсхүл улс төрийн сэдэлтээр үйлдсэн гэмт хэрэг гэж авч үзэж үл болно. Үүнтэй холбогдуулан, оролцогч улсууд нь гэмт этгээдийг шилжүүлэх, эсхүл эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хүсэлтийг улс төрийн гэмт хэрэг, эсхүл улс төрийн гэмт хэрэгтэй холбогдол бүхий гэмт хэрэг, эсхүл улс төрийн сэдэлтээр үйлдсэн гэмт хэрэгтэй холбогдсон хүсэлт байна гэсэн ганц үндэслэл зааж хүлээн авахаас татгалзаж болохгүй.

12 дугаар зүйл

2 дугаар зүйлд заасан гэмт хэрэгтэй холбогдуулан гэмт хэрэгтнийг шилжүүлэн өгөх тухай хүсэлт нь тухайн этгээдийн арьсны өнгө, шашин шүтлэг, иргэний харьяалал, үндэс угсаа, улс төрийн үзэл бодлын улмаас яллах, шийтгэх зорилгыг агуулсан гэж үзэх, эсхүл тийм хүсэлтийг биелүүлэхэд дээрх учир шалтгааны аль нэг нь тухайн этгээдийн байдалд сөргөөр нөлөөлнө гэж үзэх бодитой үндэслэл байгаа үед хүсэлт хүлээн авсан улс нь тухайн этгээдийг шилжүүлэн өгөх, эсхүл эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх үүрэгтэй гэсэн утгаар энэхүү конвенцийн аль ч хэсгийг тайлбарлаж болохгүй.

13 дугаар зүйл

1. Энэхүү конвенцийн 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийг мөрдөн байцаах, яллахтай холбогдуулан хэн болохыг нь тогтоох, мэдүүлэг авах буюу эд мөрийн баримт олж авахад бусад туслалцаа үзүүлэхийн тулд оролцогч нэг улсын нутаг дэвсгэрт цагдан хоригдож байгаа, эсхүл хорих ял эдэлж буй этгээдийг оролцогч нөгөө улсад авчрах шаардлагатай байгаа бол дараахь нөхцөлийг хангасан тохиолдолд түүнийг хүлээлгэн өгч болно:

(a) тухайн этгээд бүрэн мэдээлэл авсны үндсэн дээр өөрөө сайн дураараа зөвшөөрч байгаа бол;

(b) хоёр улсын эрх бүхий байгууллагууд зохистой гэж үзсэн тийм нөхцлүүдийн дагуу зөвшөөрсөн.

2. Энэ зүйлийн зорилгод:

(a) тухайн этгээдийг хүлээн авсан улс нь хүлээлгэн өгсөн улсын зүгээс өөрөөр хүсэлт гаргасан буюу зөвшөөрснөөс бусад тохиолдолд тухайн этгээдийг цагдан хорьж байх эрх болон үүрэгтэй;

(b) тухайн этгээдийг хүлээн авсан улс нь урьдчилан тохиролцсон ёсоор буюу өөр ямарваа нэгэн аргаар хоёр улсын эрх бүхий байгууллагуудын хооронд тохиролцсоны дагуу тухайн этгээдийг хүлээлгэн өгсөн улсад хойшлуулалгүйгээр буцааж өгөх үүргээ биелүүлэх ёстой;

(с) тухайн этгээдийг хүлээн авсан улс нь хүлээлгэн өгсөн улсаас түүнийг буцааж авахын тулд шилжүүлэн өгөх ажиллагаа эхлүүлэхийг шаардаж болохгүй;

(d) хүлээлгэн өгсөн улсад цагдан хоригдсон хугацааг хүлээн авсан улсад хорих ялаа биеэр эдэлж буй этгээдийн эдэлсэн ялын нийт хугацаанд оролцуулан тооцно.

3. Энэ зүйлд заасны дагуу тухайн этгээдийг хүлээлгэн өгөх болсон улс энэ тухай зөвшөөрснөөс бусад тохиолдолд тухайн этгээдийн харьяаллаас үл хамааран, хүлээлгэн өгөх улсын нутаг дэвсгэрээс гарахаас өмнө түүний үйлдсэн хэрэг, түүнд оноосон ял шийтгэлтэй холбогдуулан хүлээн авах улсын нутаг дэвсгэрт түүнийг яллах, цагдан хорих, эсхүл бусад ямар нэг хэлбэрээр түүний хувийн эрх чөлөөг хязгаарлаж болохгүй.

14 дүгээр зүйл

Энэхүү конвенцийн дагуу цагдан хоригдсон буюу бусад аливаа арга хэмжээ, байцаан шийтгэх ажиллагааг өөрт нь холбогдуулж авсан этгээдтэй шударга харьцах баталгаагаар хангах бөгөөд чингэхдээ тэрбээр оршин байгаа улсынхаа хууль тогтоомж, олон улсын эрх зүйн холбогдох заалтууд, түүний дотор олон улсын хүний эрхийн тухай хуулийн хүрээнд олгох бүхий л эрх, баталгааг эдэлнэ.

15 дугаар зүйл

Оролцогч улсууд 2 дугаар зүйлд заасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хамтран ажиллана. Тухайлбал:

(a) 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийг үйлдэхийг өөгшүүлэн дэмжих, өдөөн хатгах, зохион байгуулах, мэдсэн атлаа санхүүжүүлэх буюу оролцож буй этгээд, бүлэг этгээд, байгууллагуудын хууль бус үйл ажиллагааг нутаг дэвсгэртээ хориглох арга хэмжээ авах зэргээр тэдгээр гэмт хэргийг нутаг дэвсгэр дотор нь буюу гадна үйлдэхэд бэлтгэхээс тус тусын нутаг дэвсгэрт урьдчилан сэргийлэх, сөрөг арга хэмжээ авах талаар бодитой арга хэмжээ, түүний дотор шаардлагатай бол дотоодын хууль тогтоомжоо нийцүүлэх арга хэмжээ авах замаар;

(b) үндэсний хуулийнхаа дагуу үнэн зөв, баталгаат мэдээлэл солилцох болон 2 дугаар зүйлд заасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд зохимжтой захиргааны болон бусад арга хэмжээг уялдуулан зохицуулах;

(с) зохих тохиолдолд, хүний амь нас хөнөөх буюу бие махбодид гэмтэл учруулж болох тэсрэх бодис болон бусад аюултай бодисыг илрүүлэх аргыг судлаж, хөгжүүлэх, дэлбэрэлтийн дараахь мөрдөн байцаалтын явцад гарал үүслийг нь таньж тогтоохын тулд тэсрэх бодист гэмдэг тавих жишгийг боловсруулах талаар зөвлөлдөх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар мэдээлэл солилцох, түүнчлэн технологи, тоног төхөөрөмж болон холбогдох материалын талаар хамтран ажиллах болон тэдгээрийг шилжүүлэх замаар.

16 дугаар зүйл

Сэжигтэн этгээдийг яллаж буй оролцогч улс нь дотоодын хууль тогтоомж болон холбогдох журмын дагуу хэргийг байцаан шийдвэрлэсэн үр дүнгийн талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдээлж, тэрбээр энэхүү мэдээллийг оролцогч бусад улсад хүргүүлнэ.

17 дугаар зүйл

Оролцогч улс нь улсуудын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, бүрэн эрхт байдал болон бусад улсын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх зарчимд нийцүүлэн энэхүү конвенцийн дагуу хүлээх үүргээ биелүүлнэ.

18 дугаар зүйл

Улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу зөвхөн тухайн улсын эрх бүхий байгууллагад оногдуулсан хэргийн харьяалал, чиг үүргийг тухайн улсын нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх эрхийг нөгөө улсад олгосон ямар ч заалт энэ конвенцид байхгүй.

19 дүгээр зүйл

1. Энэхүү конвенцийн аль ч заалт улс болон хувь хүмүүсийн олон улсын эрх зүйн дагуу хүлээх хариуцлага, үүрэг, эдлэх эрх, түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм, олон улсын хүмүүнлэгийн эрх зүй, холбогдох бусад конвенцийн зорилгыг хөндөхгүй.

2. Зэвсэгт мөргөлдөөний үед зэвсэгт хүчний үйл ажиллагааг тэдгээрийг зохицуулдаг олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн дагуу тэдгээр нэр томъёог ойлгодог тэр байдлаар нь энэхүү конвенцоор зохицуулахгүй бөгөөд аль нэг улсын цэргийн хүчний албан үүргээ гүйцэтгэхдээ явуулж буй үйл ажиллагааг олон улсын эрх зүйн өөр хэм хэмжээгээр зохицуулдаг тул энэхүү конвенцоор зохицуулахгүй.

20 дугаар зүйл

1. Энэхүү конвенцийг тайлбарлах буюу хэрэглэх талаар хоёр буюу түүнээс дээш оролцогч улсын хооронд гарсан бөгөөд хэлэлцээний замаар боломжит хугацаанд зохицуулж чадаагүй аливаа маргааныг тэдгээрийн аль нэгний хүсэлтээр арбитраг шилжүүлнэ. Хэрэв арбитраг хүсэлт гаргасан өдрөөс хойш зургаан сарын дотор талууд арбитраг зохион байгуулах талаар тохиролцож чадаагүй бол аль нэг талын хүсэлтээр маргааныг Олон улсын шүүхэд уг шүүхийн дүрмийн дагуу шилжүүлж болно.

2. Улс бүр энэхүү конвенцид гарын үсэг зурах буюу түүнийг соёрхон батлах, эсхүл түүнд нэгдэн орохдоо 1 дэх хэсгийн заалтыг заавал биелүүлэх үүрэг хүлээхгүй гэж үзэж байгаага мэдэгдэж болно. Ийм тайлбар хийсэн оролцогч улсын хувьд бусад оролцогч улс нь 1 дэх хэсгийн заалтыг заавал биелүүлэх үүрэг хүлээхгүй.

3. 2 дахь хэсгийн дагуу тайлбар хийсэн аливаа улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэх замаар тайлбараа хэдийд ч эгүүлэн авч болно.

21 дүгээр зүйл

1. Энэхүү конвенц нь 1998 оны 1 дүгээр сарын 12-ны өдрөөс 1999 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл Нью-Йорк хот дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын төв байранд бүх улсын хувьд гарын үсэг зурахад нээлттэй байна.

2. Энэхүү конвенцийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх эсхүл батална. Батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн эсхүл батласан тухай баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

3. Энэхүү конвенц аль ч улсын хувьд нэгдэн ороход нээлттэй байна. Нэгдэн орсон тухай баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

22 дугаар зүйл

1. Энэхүү конвенц нь хорин хоёр дахь батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, батласан буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулсан өдрөөс хойш гуч дахь өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

2. Хорин хоёр дахь батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, батласан буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулсны дараа Конвенцийг соёрхон баталж, хүлээн зөвшөөрч, баталж, түүнд нэгдэн орж буй улс бүрийн хувьд Конвенц тухайн улс батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, батласан буюу нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулсан өдрөөс хойш гуч дахь өдрөөс хүчин төгөлдөр болно.

23 дугаар зүйл

1. Аливаа оролцогч улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад бичгээр мэдэгдэх замаар энэхүү конвенцийг цуцалж болно.

2. Цуцлах тухай мэдэгдлийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга хүлээн авсан өдрөөс хойш нэг жилийн дараа цуцлалт хүчин төгөлдөр болно.

24 дүгээр зүйл

Англи, араб, испани, орос, франц, хятад хэлээрх эх бичвэр нь адил хүчинтэй энэхүү конвенцийн жинхэнэ эхийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулах бөгөөд Ерөнхий нарийн бичгийн дарга нь түүний баталгаатай хуулбарыг бүх улсад илгээнэ.

Дээр дурдсаныг нотолж засгийн газраасаа зохих ёсоор бүрэн эрх олгогдсон дор гарын үсэг зурагсад 1998 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр Нью-Йорк хотноо гарын үсэг зурахад нээлттэй болсон энэхүү конвенцид гарын үсэг зурав.

81. ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦ

*Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей 1999 оны 12 дугаар сарын 9-ний өдөр баталж, 2002 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр хүчин төгөлдөр болсон**

Энэ конвенцид оролцогч улсууд,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэмд заасан олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хангах, улс хооронд сайн хөршийн болон найрсаг харилцаа, мөн хамтын ажиллагааг хөгжүүлэх зарчим, зорилгыг анхааралдаа авч,

дэлхий даяар террорист үйлдэл бүхий л хэлбэр, илрэлээр цар хүрээгээ эрс тэлж байгаад сэтгэл гүнээ зовниж,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас 1995 оны 10 дугаар сарын 24-нд 50/6 тоот тогтоолоор батласан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тавин жилийн ойн тунхаглалыг эргэн санаж,

“Терроризмын бүх үйлдэл, арга, дадал, түүний дотор улс, ард түмэн хоорондын найрсаг харилцаанд занал учруулж, улсуудын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, аюулгүй байдалд заналхийлэх үйлдэл, арга, дадлыг хаана, хэн үйлдсэнээс нь үл хамааран гэмт бөгөөд зөвтгөх боломжгүй гэж шууд буруутгаж буйгаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн улсууд *inter alia* ёслол төгөлдөр дахин нотлосон” Ерөнхий Ассамблейн 1994 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 49/60 тоот тогтоолд хавсаргасан Олон улсын терроризмыг устгах арга хэмжээний тухай тунхаглалыг мөн эргэн санаж,

Олон улсын терроризмыг устгах арга хэмжээний тухай тунхаглалд терроризм, түүний бүх хэлбэр, илрэлээс урьдчилан сэргийлэх, шийтгэх, таслан зогсоох талаар үйлчилж буй олон улсын эрх зүйн хэм хэмжээг нэн даруй авч үзэх, эдгээр асуудлын бүх талыг хамарсан иж бүрэн эрх зүйн тогтолцоог боловсруулахад улсуудад дэмжлэг үзүүлсэн байдгийг тэмдэглэж,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1996 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 51/210 тоот тогтоолын 3 дугаар зүйлийн (f) хэсэгт террорист этгээдүүд болон террорист байгууллагуудыг санхүүжүүлэх явдалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн дотоодын зохих арга хэмжээ авах, чингэхдээ ийм санхүүжилт нь шууд хийгдсэн, эсхүл буяны, нийгмийн болон соёлын зорилготой буюу тийм зорилготой гэгдэх буюу хууль бус зэвсгийн наймаа, хар тамхины худалдаа, дарамтлах, түүний дотор террорист ажиллагаа санхүүжүүлэх зорилгоор хүмүүсийг мөлжих зэрэг үйл ажиллагаа явуулдаг байгууллагаар дамжин шууд бусаар хийгдэж буйг үл хамааран, мөнгөн хуримтлалыг хууль ёсоор шилжүүлэх эрх чөлөөнд ямар нэг байдлаар саад хийхгүйгээр, террорист зориулалттай гэж сэжиглэхүйц мөнгөн

* Монгол Улс 2003.12.13-нд нэгдэн орсон

хуримтлал шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх, эсэргүүцэн тэмцэх талаар зохицуулалтын арга хэмжээг шаардлагатай үед батлан гаргах асуудлыг судалж үзэх, олон улсын хэмжээнд шилжүүлж буй тийм санхүүжүүлэлт, мэдээллийн солилцоог эрчимжүүлэхийг Ерөнхий Ассамблей дэлхийн бүх улсад хандаж уриалсныг эргэн санаж,

түүнчлэн Ерөнхий Ассамблейн 1996 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 51/210 тоот тогтоолын 3 дугаар зүйлийн (a) - (f) хэсэгт дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлыг авч үзэхийг гишүүн улсуудад уриалсан 1997 оны 12 дугаар сарын 15-ны 52/165 тоот тогтоолыг эргэн санаж,

үйлчилж буй олон улсын холбогдох баримт бичгүүдэд нэмж терроризмыг санхүүжүүлэхийг хориглох тухай олон улсын конвенцийн төслийг боловсруулах үүргийг Ерөнхий Ассамблейн 1996 оны 12 дугаар сарын 17-ны 51/210 тоот тогтоолоор байгуулсан Түр хороонд өгөхөөр шийдвэрлэсэн Ерөнхий Ассамблейн 1998 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 53/108 тоот тогтоолыг цаашид эргэн санаж,

терроризмыг санхүүжүүлэх нь олон улсын хамтын нийгэмлэгийг бүхэлд нь хамарсан сэтгэл гүнээ зовоож буй асуудал хэмээн үзэж,

олон улсын террорист ажиллагааны тоо хэмжээ, тийм үйлдлийн ноцтой байдал нь террорист этгээдүүдийн олж болох санхүүжилтээс хамааралтай болохыг тэмдэглэн,

үйлчилж буй олон талт эрх зүйн баримт бичгүүдэд уг санхүүжилтийн асуудлыг шууд зохицуулаагүй болохыг мөн тэмдэглэж,

олон улсын терроризмыг санхүүжүүлэх явдлаас урьдчилан сэргийлэх, түүнчлэн түүнийг үйлдэгчдийг байцаах, шийтгэх замаар уг явдлыг хориглох үр дүнтэй арга хэмжээг боловсруулж батлан гаргах үйлсэд улсуудын хамтын ажиллагааг нэн даруй бэхжүүлэх туйлын шаардлагатай хэмээн итгэж,

дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

1 дүгээр зүйл

Энэхүү конвенцийн зорилгод:

1. "Мөнгөн хуримтлал" гэж хэрхэн олж авснаас үл шалтгаалан биет болон биет бус, хөдлөх болон үл хөдлөх аливаа эд хөрөнгө, мөн банкны зээл, замын чек, банкны чек, мөнгөний шилжүүлэг, хувьцаа, үнэт цаас, бонд, вексель, аккредитив болон бусад баримт бичгийг оролцуулан эдгээрээр үл хязгаарлагдах хөрөнгийг өмчлөх буюу түүнийг олж авах эрхийг цахим буюу тоон хэлбэрээр илэрхийлсэн эрх зүйн буюу өөр бусад хэлбэрээр үйлдсэн баримт бичгийг хэлнэ.

2. "Төрийн буюу засгийн газрын объект" гэж өөрсдийн албан үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан төрийг төлөөлсөн албан тушаалтнууд, засгийн газрын гишүүд, хууль тогтоох болон шүүхийн байгууллагын төлөөлөгчид, төрийн бусад байгууллагуудын албан хаагчид, мөн засгийн газар хоорондын байгууллагуудын албан хаагчид, албан тушаалтнуудаас байнгын болон түр үндсэн дээр ашиглаж буй аливаа объект буюу тээврийн хэрэгслийг хэлнэ.

3. "Орлого" гэдэгт 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийг үйлдэх замаар шууд болон шууд бусаар олсон аливаа мөнгөн хуримтлалыг хэлнэ.

2 дугаар зүйл

1. Аливаа этгээд дараахь хэргийг үйлдэхэд бүрэн буюу хэсэгчлэн ашиглуулах зорилготойгоор, эсхүл тийнхүү ашиглагдахыг мэдсээр байж, мөнгөн хуримтлалыг аливаа байдлаар, шууд буюу шууд бус, хууль бусаар болон санаатайгаар олгосон буюу хуримтлуулсныг энэхүү конвенцийн хүрээнд гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ:

(а) Хавсралтад дурдсан гэрээний аль нэгний үйлчлэлд хамаарах бөгөөд түүний дагуу гэмт хэрэг хэмээн тодорхойлогдсон үйлдлийг хийсэн бол;

(б) Өөрийн шинж чанар, агуулгын хувьд аль нэг засгийн газар, олон улсын байгууллагаас тодорхой шийдвэр гаргуулах буюу гаргахаас татгалзуулахыг тулган шаардах болон олон нийтэд айдас төрүүлэхэд чиглэсэн, эсхүл зэвсэгт мөргөлдөөний үед байлдааны үйл ажиллагаанд идэвхтэй оролцоогүй энгийн иргэд болон аливаа бусад хүний амь насыг нь хөнөөх буюу бие махбодид нь ноцтой гэмтэл учруулах зорилготой аливаа бусад үйлдэл.

2. (а) Энэхүү конвенцийн хавсралтад дурдсан аль нэг гэрээнд оролцогч биш улс нь энэхүү конвенцийг соёрхон батласан батламж жуух бичиг буюу хүлээн зөвшөөрсөн, батласан, эсхүл нэгдэн орсон баримт бичгийг хадгалуулахаар өгсний дараа оролцогч тухайн улсын хувьд энэхүү конвенцийг хэрэглэхэд уг гэрээ 1 дэх хэсгийн (а) дэд хэсэгт дурдсан хавсралтад ороогүй хэмээн мэдэгдэж болно. Энэхүү мэдэгдэл нь оролцогч тухайн улс уг гэрээнд нэгдэн орсноор хүчингүй болох бөгөөд тухайн улс конвенцийн эх хадгалагчид энэ тухай мэдэгдэнэ;

(б) Оролцогч улс хавсралтад дурдсан аль нэг гэрээнээс гарах тохиолдолд тэрээр тухайн гэрээний хувьд энэ зүйлд заасны дагуу мэдэгдэл хийж болно.

3. Аливаа үйлдлийг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг хэмээн тодорхойлоход 1 дэх хэсгийн (а), (б) дэд хэсэгт дурдсан гэмт хэргийг үйлдэхэд мөнгөн хуримтлалыг бодитойгоор ашигласан байхыг шаардахгүй.

4. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдэхээр завдсан аливаа этгээдийг гэмт хэрэг үйлдсэнд тооцно.

5. Хэрэв аливаа этгээд дараахь үйлдэл хийсэн бол гэмт хэрэг мөн үйлдсэн гэж үзнэ:

(а) энэ зүйлийн 1, эсхүл 4 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт хамтран оролцсон бол;

(б) энэ зүйлийн 1, эсхүл 4 дэх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдэхээр зохион байгуулсан буюу удирдсан;

(с) нэгдмэл зорилготой бүлэг хүмүүс энэ зүйлийн 1 буюу 4 дэх хэсэгт заасан нэг буюу хэд хэдэн гэмт хэргийг үйлдэхэд дэмжлэг үзүүлсэн. Уг дэмжлэгийг санаатайгаар үзүүлсэн байх болон түүнийг:

- i) энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдэх зорилго агуулсан буюу үйл ажиллагааг явуулах бүлгийн гэмт зорилго болон үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд үйлдсэн;
- ii) энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдэх бүлгийн зорилгыг мэдсээр байж үйлдсэн.

3 дугаар зүйл

Гэмт хэрэг тодорхой нэг улсын нутаг дэвсгэрт үйлдэгдэж, сэжигтэн этгээд тухайн улсын иргэн болон тухайн улсын нутаг дэвсгэрт байгаа бол энэхүү конвенцийг хэрэглэхгүй бөгөөд ийм нөхцөлд өөр аливаа улс шаардлагатай гэж үзвэл 12-18 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд 7 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн дагуу хэргийн харьяаллаа хэрэгжүүлэх үндэсгүй.

4 дүгээр зүйл

Оролцогч улс бүр шаардлагатай байж болох дараахь арга хэмжээг авна:

(a) 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийг дотоодын хууль тогтоомжийн дагуу гэмт хэрэг гэж тооцох;

(b) тухайн гэмт хэргийн ноцтой шинжийг харгалзсан зохих ялаар шийтгэхээр тогтоох.

5 дугаар зүйл

1. Тухайн улсын нутаг дэвсгэр дээр байрладаг буюу түүний хууль тогтоомжийн дагуу байгуулсан хуулийн этгээдийг удирдаж байгаа буюу хяналтдаа байлгадаг этгээд албан ажиллагааныхаа хүрээнд нь 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийг үйлдсэн бол тухайн хуулийн этгээдэд хуулийн хариуцлага ногдуулах талаар шаардлагатай арга хэмжээг оролцогч улс бүр авна. Тэр нь эрүүгийн, иргэний, эсхүл захиргааны хариуцлага байж болно.

2. Уг хариуцлага нь тухайн гэмт хэрэг үйлдсэн хувь этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээс ангид байна.

3. Оролцогч улс бүр ялангуяа 1 дэх хэсэгт заасны дагуу шийтгэл хүлээлгэсэн хуулийн зохих этгээдэд үр нөлөөтэй, гэм бурууд нь тохирсон, цээрлүүлэх зорилгоо хангахуйц, иргэний болон захиргааны хариуцлагыг тогтооно. Ийм хариуцлага нь мөнгөн хэлбэртэй байж болно.

6 дугаар зүйл

Оролцогч улс бүр нь энэхүү конвенцийн хүрээнд хамаарах гэмт үйлдлийг ямар ч нөхцөлд улс төр, философ, үзэл суртал, арьсны өнгө, үндэс угсаа, шашин болон бусад адил шинж чанартай шалтгаанаар зөвтгөхгүй байх арга хэмжээг шаардлагатай бол авах бөгөөд зохистой гэж үзвэл дотоодын хууль тогтоомжид өөрчлөлт оруулна.

7 дугаар зүйл

1. Оролцогч улс бүр 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хувьд дараахь тохиолдолд өөрийн хэргийн харьяаллыг тогтоох талаар шаардлагатай арга хэмжээ авна:

(а) гэмт хэргийг тухайн улсын нутаг дэвсгэрт үйлдсэн бол;

(б) гэмт хэргийг үйлдэх үед тухайн улсын төрийн далбааг мандуулсан хөлөг онгоцонд, эсхүл тухайн улсын хуулийн дагуу бүртгэгдсэн агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн бол;

(с) гэмт хэргийг тухайн улсын иргэн үйлдсэн бол.

2. Оролцогч улс мөн дараахь тохиолдолд тэдгээр гэмт хэргийн тухайд хэргийн харьяаллаа тогтоож болно:

(а) уг гэмт хэрэг нь 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (а) буюу (б) дэд хэсэгт дурдсан гэмт хэргийг тухайн улсын нутаг дэвсгэрт буюу түүний харьяат иргэдийн эсрэг үйлдэхэд чиглэсэн буюу эдгээр гэмт хэргийг үйлдэхэд хүргэсэн бол;

(б) уг гэмт хэрэг нь 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (а) буюу (б) дэд хэсэгт дурдсан гэмт хэргийг тухайн улсын хилийн чанад дахь төрийн буюу засгийн газрын объект, түүний дотор тухайн улсын дипломат болон консулын төлөөлөгчийн газрын байрны эсрэг үйлдэхэд чиглэсэн буюу эдгээр гэмт хэргийг үйлдэхэд хүргэсэн бол;

(с) уг гэмт хэрэг нь тухайн улсаас ямарваа нэгэн арга хэмжээ авахуулах, эсхүл авахаас татгалзахыг тулган шаардахыг оролдсон 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (а) буюу (б) дэд хэсэгт дурдсан гэмт хэргийг үйлдэхэд чиглэсэн буюу эдгээр гэмт хэргийг үйлдэхэд хүргэсэн бол;

(д) уг гэмт хэргийг тухайн улсын нутаг дэвсгэрт байнга оршин суудаг харьяалалгүй этгээд үйлдсэн бол;

(е) гэмт хэргийг тухайн улсын засгийн газрын эзэмшдэг агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн бол.

3. Оролцогч улс бүр энэхүү конвенцийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах буюу нэгдэн орохдоо энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу өөрийн хэргийн харьяаллаа тогтоосон тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэнэ. Ямар нэгэн өөрчлөлт гарсан тохиолдолд оролцогч холбогдох улс нь энэ тухайгаа Ерөнхий нарийн бичгийн даргад нэн даруй мэдэгдэнэ.

4. Хэрэв 2 дугаар зүйлд дурдсан гэмт хэргийг үйлдсэн гэх сэжигтэн этгээд нь тухайн улсын нутаг дэвсгэрт байгаа бөгөөд түүнийг энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу хэргийн харьяаллаа тогтоосон оролцогч бусад улсад шилжүүлээгүй бол оролцогч тухайн улс уг гэмт хэргийн хувьд өөрийн хэргийн харьяаллыг тогтоох шаардлагатай байж болох арга хэмжээ авна.

5. Нэгээс илүү оролцогч улс 2 дугаар зүйлд дурдсан гэмт хэргийн хувьд өөрийн хэргийн харьяаллыг тогтоосон бол тийм улсууд нь гэмт хэргийг яллах нөхцөл байдал, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх талаар зохих хэлбэрээр үйл ажиллагаагаа зохицуулахыг эрмэлзэнэ.

6. Энэхүү конвенц нь олон улсын түгээмэл эрх зүйн хэм хэмжээг хөндөхгүйгээр оролцогч улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу тогтоосон аливаа эрүүгийн хэргийн харьяаллаа хэрэгжүүлэхийг үгүйсгэхгүй.

8 дугаар зүйл

1. Оролцогч улс бүр 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийг үйлдэхэд ашиглаж буй буюу ашиглахад зориулсан мөнгөн хуримтлал, мөн уг гэмт хэргийг үйлдэж олсон орлогыг хурааж болзошгүй нөхцлийг хангах зорилгоор өөрийн дотоодын хууль тогтоомжийн зарчмын дагуу олж тогтоох, илрүүлэх, битүүмжлэх, эсхүл хураан авах талаар шаардлагатай арга хэмжээ авна.

2. Оролцогч улс бүр өөрийн дотоодын хууль тогтоомжийн зарчмын дагуу 2 дугаар зүйлд дурдсан гэмт хэргийг үйлдэхэд ашиглаж буй буюу ашиглахад зориулсан мөнгөн хуримтлал, мөн тийм гэмт хэргийг үйлдэж олсон орлогыг хураах талаар шаардлагатай арга хэмжээ авна.

3. Оролцогч холбогдох улс бүр нь энэ зүйлийн дагуу хураасан мөнгөн хуримтлалыг оролцогч бусад улстай байнгын үндсэн дээр буюу тухайн тохиолдол бүрийг шийдвэрлэх үндсэн дээр хуваах тухай хэлэлцээр байгуулах асуудлыг авч үзэж болно.

4. Оролцогч улс бүр энэ зүйлийн дагуу хураагдсан мөнгөн хуримтлалаас 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (a), (b) дэд хэсэгт заасан гэмт хэргийн хохирогчид буюу тэдний гэр бүлийнхэнд нөхөн олговор олгоход зарцуулах механизмыг тогтоох асуудлыг авч үзнэ.

5. Энэ зүйлийн заалтуудыг шударга гуравдагч этгээдийн эрхэд хохирол учруулахгүйгээр хэрэгжүүлнэ.

9 дүгээр зүйл

1. 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийг үйлдсэн буюу үйлдсэн гэж сэжиглэгдсэн этгээд нь тухайн улсын нутаг дэвсгэрт байж болох тухай мэдээллийг хүлээн авмагц оролцогч холбогдох улс тэрхүү мэдээлэлд дурдсан баримтыг мөрдөн байцаах талаар өөрийн дотоодын хуулийн дагуу зохих арга хэмжээ авна.

2. Хэрэв оролцогч улс нөхцөл байдал тийнхүү шаардаж байна гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн буюу үйлдсэн гэж сэжиглэгдсэн этгээд нь түүний нутаг дэвсгэрт байгаа бол оролцогч тухайн улс уг этгээдийг шилжүүлэх, эсхүл яллагаанд байлцуулах явдлыг хангах зорилгоор өөрийн дотоодын хууль тогтоомжийн дагуу холбогдох арга хэмжээ авна.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан арга хэмжээ авахуулж буй аливаа этгээд дараахь эрхийг эдэлнэ:

(a) тухайн этгээдийг харьяалах, эсхүл түүний эрхийг ямар нэг хэлбэрээр хамгаалах эрх бүхий улсын хамгийн ойр байх холбогдох төлөөлөгчтэй, хэрэв тухайн этгээд харьяалалгүй бол нутаг дэвсгэрт нь байнга оршин суугаа газар нь байрлах улсын төлөөлөгчтэй саадгүйгээр холбоо барих;

(b) тухайн улсын төлөөлөгчтэй уулзах;

(с) (а) болон (b) дэд хэсэгт заасан өөрийн эрхийн талаар мэдээлэл авах.

4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан эрхийг гэмт хэрэгтэн буюу сэжигтэн этгээд нутаг дэвсгэрт нь байгаа улсын хууль тогтоомжийн дагуу эдлүүлэх бөгөөд уг хууль тогтоомж нь энэ зүйлийн 3 дахь хэсгийн дагуу эрх олгож буй зорилгыг бүрэн хэрэгжүүлэхэд чиглэсэн байвал зохино.

5. Энэ зүйлийн 3, 4 дэх хэсгийн заалтууд нь 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (b) дэд хэсгийн дагуу хэргийн харьяаллаа тогтоохыг хүссэн оролцогч аливаа улс Олон улсын улаан загалмайн нийгэмлэгийг сэжигтэн этгээдтэй холбоо барих, уулзалт хийхийг урих эрхийг хөндөхгүй.

6. Энэ зүйлийн дагуу аливаа этгээдийг цагдан хорьсон оролцогч улс нь 7 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу хэргийн харьяаллаа тогтоосон оролцогч улс, түүнчлэн, хэрэв шаардлагатай гэж үзвэл тухайн этгээдийг цагдан хорьсон тухай болон түүнийг тийнхүү хорих болсон үндэслэл болон нөхцөл байдлын тухай сонирхсон бусад оролцогч улсад шууд буюу Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргаар дамжуулан нэн даруй мэдэгдэнэ. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан мөрдөн байцаалтыг явуулж буй улс нь дээрх улсуудад мөрдөн байцаалтын үр дүнгийн талаар даруй мэдээлж, хэргийн харьяаллаа хэрэгжүүлэх эсэх тухайгаа мэдэгдэнэ.

10 дугаар зүйл

1. Нутаг дэвсгэрт нь сэжигтэн этгээд байгаа оролцогч улс 7 дугаар зүйлийн заалтуудыг хэрэглэх тохиолдолд хэрэв тухайн этгээдийг шилжүүлэн өгөхгүй бол гэмт хэрэг нутаг дэвсгэрт нь үйлдэгдсэн эсэхээс үл хамаарч хэргийг тухайн улсын хууль тогтоомжийн дагуу байцаан шийтгэх ажиллагаа явуулж өөрийн эрх бүхий байгууллагад яллуулахаар шилжүүлэх үүргийг аливаа нөхцөлгүйгээр хүлээнэ. Эдгээр байгууллага шийдвэрээ тухайн улсын хууль тогтоомжийн дагуу ноцтой шинж бүхий ердийн гэмт хэргийг шийдвэрлэдгийн адилаар гаргана.

2. Хэрэв оролцогч улсын дотоодын хууль тогтоомжид шилжүүлж өгөх буюу хүлээлгэн өгөх өөрийн иргэнийг зөвхөн шүүх хурал буюу шүүх ажиллагааны дүнд ногдуулсан ялыг гагцхүү тухайн улсад эргүүлэн авчирч эдлүүлэх болзолтойгоор шилжүүлж өгөх буюу хүлээлгэн өгөхийг зөвшөөрсөн бөгөөд тухайн улс болон уг этгээдийг шилжүүлж авахыг хүссэн улсын аль аль нь энэ хувилбар болон шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөлийн талаар тохиролцоонд хүрсэн бол ийнхүү нөхцөл болзолтойгоор шилжүүлэн өгөх буюу хүлээлгэн өгөх нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүргийг биелүүлэхэд хангалттай байх болно.

11 дүгээр зүйл

1. Энэхүү конвенцийн 2 дугаар зүйлд дурдсан гэмт хэрэг нь энэхүү конвенцийг хүчин төгөлдөр болохоос өмнө оролцогч улсуудын хооронд байгуулсан гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай аливаа гэрээний хувьд шилжүүлэн өгвөл зохих гэмт хэрэг гэж тусгагдсанд тооцно. Оролцогч улсууд ийм гэмт хэргийг гэмт хэрэгтнийг шилжүүлэх тухай өөр хоорондоо байгуулах гэрээ бүртээ шилжүүлбэл зохих гэмт хэрэгт багтаан тусгах үүрэг хүлээнэ.

2. Хэрэв гэмт хэрэгтнийг гэрээний үндсэн дээр шилжүүлэх нөхцөл тавьдаг оролцогч улс түүнтэй гэрээ байгуулаагүй оролцогч нөгөө улсаас гэмт хэрэгтэн шилжүүлэх тухай хүсэлт хүлээн авбал 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хувьд энэхүү

конвенцийг гэмт хэрэгтнийг шилжүүлэх эрх зүйн үндэслэл гэж өөрийн үзэмжээр тооцож болно. Шилжүүлэх ажиллагааг хүсэлт хүлээн авагч улсын хуульд заасан бусад нөхцөлийн дагуу гүйцэтгэнэ.

3. Гэмт хэрэгтнийг гэрээний үндсэн дээр шилжүүлэх нөхцөл тавьдаггүй оролцогч улсууд 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийг хүсэлт хүлээн авагч улсын хуульд заасан нөхцлийн дагуу өөр хоорондоо шилжүүлбэл зохих гэмт хэрэг хэмээн хүлээн зөвшөөрнө.

4. Шаардлагатай бол 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийг тухайн гэмт хэрэг үйлдэгдсэн газар төдийгүй 7 дугаар зүйлийн 1 болон 2 дахь хэсгийн дагуу хэргийн харьяаллаа тогтоох ёстой улсын нутаг дэвсгэрт үйлдсэн гэж оролцогч улсуудын хооронд гэмт хэрэгтнийг шилжүүлэх зорилгын үүднээс үзнэ.

5. 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийн тухайд гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай оролцогч улсуудын хоорондын бүхий л гэрээ, тохиролцооны энэхүү конвенцтой харшилсан заалтуудыг конвенцийн заалтуудтай нийцэх байдлаар өөрчлөгдсөн гэж оролцогч улсуудын хооронд үзнэ.

12 дугаар зүйл

1. Оролцогч улсууд 2 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт эрүүгийн мөрдөн байцаах, эрүүгийн байцаан шийтгэх болон шилжүүлэх ажиллагаатай холбогдуулан байцаан шийтгэх ажиллагаанд шаардлагатай өөрсдийн мэдэлд байгаа бүх нотлох баримтыг гаргаж өгөх зэргээр бие биедээ бүрэн хэмжээгээр туслалцаа үзүүлнэ.

2. Оролцогч улсууд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай хүсэлтийг банкны нууцлалын шалтгаанаар хүлээж авахаас татгалзаж болохгүй.

3. Хүсэлт гаргасан улс нь хүсэлт хүлээн авсан улсаас авсан мэдээлэл, нотлох баримтыг хүсэлтэд дурдсан мөрдөн байцаах, яллагаа болон байцаан шийтгэх ажиллагаанаас бусад өөр ажиллагаанд хүсэлт хүлээн авсан улсаас урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр ашиглаж үл болно.

4. Оролцогч улс бүр нь 5 дугаар зүйлд дурдсан эрүүгийн, иргэний болон захиргааны хариуцлагыг тогтооход шаардлагатай мэдээлэл, нотлох баримтыг солилцох, механизм бий болгох асуудлыг авч үзэж болно.

5. Оролцогч улсууд нь 1, 2 дахь хэсэгт заасан үүргээ өөр хоорондоо байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх болон мэдээлэл солилцох тухай гэрээ, бусад тохиролцооны дагуу биелүүлнэ. Тийм гэрээ буюу тохиролцоо байхгүй бол оролцогч улсууд нь дотоодынхоо хууль тогтоомжийн дагуу өөр хоорондоо туслалцаа үзүүлнэ.

13 дугаар зүйл

Гэмт этгээдийг шилжүүлэх, эсхүл эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх зорилгын хүрээнд энэхүү конвенцийн 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийн алийг ч татвартай холбогдсон гэмт хэрэг хэмээн авч үзэхгүй. Үүнтэй холбогдуулан, оролцогч улсууд нь гэмт этгээдийг шилжүүлэх, эсхүл эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хүсэлтийг татвартай холбогдсон гэмт хэргийн талаар хүсэлт байна гэсэн ганц үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж болохгүй.

14 дүгээр зүйл

Гэмт этгээдийг шилжүүлэх, эсхүл эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх зорилгын хүрээнд энэхүү конвенцийн 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийн алийг ч улс төрийн гэмт хэрэг, эсхүл улс төрийн гэмт хэрэгтэй холбогдол бүхий гэмт хэрэг, эсхүл улс төрийн сэдэлтээр үйлдсэн гэмт хэрэг гэж авч үзэж үл болно. Үүнтэй холбогдуулан, оролцогч улсууд нь гэмт этгээдийг шилжүүлэх, эсхүл эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хүсэлтийг улс төрийн гэмт хэрэг, эсхүл улс төрийн гэмт хэрэгтэй холбогдол бүхий гэмт хэрэг, эсхүл улс төрийн сэдэлтээр үйлдсэн гэмт хэрэгтэй холбогдсон хүсэлт байна гэсэн ганц үндэслэл зааж хүлээн авахаас татгалзаж болохгүй.

15 дугаар зүйл

Энэхүү конвенцийн 2 дугаар зүйлд заасан гэмт хэрэгтэй холбогдуулан гэмт хэрэгтнийг шилжүүлэн өгөх тухай хүсэлт нь тухайн этгээдийн арьсны өнгө, шашин шүтлэг, иргэний харьяалал, үндэс угсаа, улс төрийн үзэл бодлын улмаас яллах, шийтгэх зорилгыг агуулсан гэж үзэх, эсхүл тийм хүсэлтийг биелүүлэхэд дээрх учир шалтгааны аль нэг нь тухайн этгээдийн байдалд сөргөөр нөлөөлнө гэж үзэх бодитой үндэслэл байгаа үед хүсэлт хүлээн авсан улс нь тухайн этгээдийг шилжүүлэн өгөх, эсхүл эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх үүрэгтэй гэсэн утгаар энэхүү конвенцийн аль ч хэсгийг тайлбарлаж болохгүй.

16 дугаар зүйл

1. Энэхүү конвенцийн 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийг мөрдөн байцаах, яллахтай холбогдуулан хэн болохыг тогтоох, мэдүүлэг авах буюу эд мөрийн баримт олж авахад бусад туслалцаа үзүүлэхийн тулд оролцогч нэг улсын нутаг дэвсгэрт цагдан хоригдож байгаа, эсхүл хорих ял эдэлж буй этгээдийг оролцогч нөгөө улсад авчрах шаардлагатай байгаа бол дараахь нөхцөлийг хангасан тохиолдолд түүнийг хүлээлгэн өгч болно:

(a) тухайн этгээд бүрэн мэдээлэл авсны үндсэн дээр өөрөө сайн дураараа зөвшөөрч байгаа бол;

(b) хоёр улсын эрх бүхий байгууллага эдгээр улсын хувьд харилцан хүлээж авахуйц нөхцөлийн талаар тохиролцсон бол.

2. Энэ зүйлийн зорилгод:

(a) тухайн этгээдийг хүлээн авсан улс нь хүлээлгэн өгсөн улсын зүгээс өөрөөр хүсэлт гаргасан буюу зөвшөөрснөөс бусад тохиолдолд тухайн этгээдийг цагдан хорьж байх эрх болон үүрэгтэй.

(b) тухайн этгээдийг хүлээн авсан улс нь урьдчилан тохиролцсон ёсоор буюу өөр ямарваа нэгэн аргаар хоёр улсын эрх бүхий байгууллагуудын хооронд тохиролцсоны дагуу тухайн этгээдийг хүлээлгэн өгсөн улсад хойшлуулалгүйгээр буцааж өгөх үүргээ биелүүлэх ёстой.

(c) тухайн этгээдийг хүлээн авсан улс нь хүлээлгэн өгсөн улсаас түүнийг буцааж авахын тулд шилжүүлэн өгөх ажиллагаа эхлүүлэхийг шаардаж болохгүй.

(d) хүлээлгэн өгсөн улсад цагдан хоригдсон хугацааг хүлээн авсан улсад хорих ялаа биеэр эдэлж буй этгээдийн эдэлсэн ялын нийт хугацаанд оролцуулан тооцно.

3. Энэ зүйлд заасны дагуу тухайн этгээдийг хүлээлгэн өгөх болсон улс энэ тухай зөвшөөрснөөс бусад тохиолдолд тухайн этгээдийн харъяаллаас үл хамааран, хүлээлгэн өгөх улсын нутаг дэвсгэрээс гарахаас өмнө түүний үйлдсэн хэрэг, түүнд оноосон ял шийтгэлтэй холбогдуулан хүлээн авах улсын нутаг дэвсгэрт түүнийг яллах, цагдан хорих, эсхүл бусад ямар нэг хэлбэрээр түүний хувийн эрх чөлөөг хязгаарлаж болохгүй.

17 дугаар зүйл

Энэхүү конвенцийн дагуу цагдан хоригдсон буюу бусад аливаа арга хэмжээ, байцаан шийтгэх ажиллагааг өөрт нь холбогдуулж авсан этгээдтэй шударга харьцах баталгаагаар хангах бөгөөд чингэхдээ тэрбээр оршин байгаа улсынхаа хууль тогтоомж, олон улсын эрх зүйн холбогдох заалтууд, түүний дотор олон улсын хүний эрхийн тухай хуулийн хүрээнд олгох бүхий л эрх, баталгааг эдэлнэ.

18 дугаар зүйл

1. Оролцогч улсууд нь 2 дугаар зүйлд заасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд хэрэгжүүлж болох бүхий л арга хэмжээг авах замаар хамтран ажиллах бөгөөд түүний дотор өөрийн нутаг дэвсгэрт болон нутаг дэвсгэрээс гадна тухайн гэмт хэргийг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, түүний эсрэг тэмцэхийн тулд шаардлагатай бол дотоодынхоо хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах бөгөөд:

(a) 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийг санаатайгаар дэмжиж, өдөөн хатгаж, зохион байгуулж, үйлдэхэд нь оролцож буй хувь этгээд буюу байгууллагын хууль бус үйл ажиллагааг нутаг дэвсгэртээ хориглох;

(b) санхүүгийн байгууллагууд, санхүүгийн үйл ажиллагаанд оролцогч бусад байгууллагыг өөрсдийн тухайн болон тохиолдлын үйлчлүүлэгчид, нэр дээрээ данс нээлгэсэн буюу бусдын нэр дээр данс нээлгэж буй харилцагчдын нэр хаягийг тодорхойлоход хамгийн үр ашигтай арга хэмжээ авч хэрэгжүүлэх, онцлог буюу сэжигтэй аливаа гүйлгээнд онцгой анхаарал тавьж, гэмт үйл ажиллагаатай холбоотой байж болзошгүй гүйлгээний тухай мэдэгдэж байхыг шаардсан арга хэмжээ авах. Энэ зорилгоор оролцогч улсууд нь дараахь арга хэмжээг авах боломжийг судална:

- i) эзэн буюу ашиг хүртэгч нь тодорхойгүй буюу тогтоох боломжгүй данс нээхийг хориглосон журмыг батлан гаргах, түүнчлэн эдгээр байгууллага нь тухайн гүйлгээний жинхэнэ эздийг тогтоох талаар арга хэмжээ авах;
- ii) хуулийн этгээдийн нэр хаягийг тодруулахын хувьд санхүүгийн байгууллагуудаас шаардлагатай бол харилцагчдынхаа эрх зүйн байдал, бүтэц, зохион байгуулалтыг тогтоох үүднээс тухайн харилцагчийг хуулийн этгээдийн хувьд тодорхойлох нотолгоо, түүний дотор харилцагчийн нэр, эрх зүйн байдал, хаяг, удирдлага болон тухайн хуулийн этгээдийн нэрийн өмнөөс үүрэг хүлээх эрх мэдлийг зохицуулсан дүрмийн талаархи нотолгоог хуулийн этгээдийн бүртгэлийг хөтөлдөг улсын байгууллага болон харилцагчаас өөрөөс нь, эсхүл хоёулангаас гаргуулж авахыг шаардах;

- iii) санхүүгийн байгууллагад хандаж сэжиг бүхий үндэслэлээ сайн дураар илэрхийлсэн үедээ эдийн засгийн тодорхой болон хууль ёсны мэдэгдэхүйц шалтгаангүй бүхий л нарийн төвөгтэй, хэвийн бус их хэмжээний гүйлгээ, гүйлгээний хэвийн бус хэлбэр загварын тухай мэдээллийг эрх бүхий байгууллагуудад мэдээллийн нууцлалыг хадгалах тухай аливаа хязгаарлалтыг зөрчихөд хүлээлгэх эрүүгийн болон иргэний хариуцлагаас үл эмээж даруй мэдэгдэж байхыг үүрэг болгосон дүрэм батлах;
- iv) санхүүгийн байгууллагыг дотоод болон гадаад гүйлгээнийхээ талаар шаардлагатай хуулга баримтаа наад зах нь таваас доошгүй жилийн хугацаанд хадгалах шаардлага тавих зэрэг болно.

2. Оролцогч улсууд нь 2 дугаар зүйлд заасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хамтран ажиллах зорилгоор дараахь арга хэмжээг авна:

(a) мөнгөний шилжүүлэг, гуйвуулга хийдэг бүхий л байгууллагад лиценз олгох зэрэг хяналтын арга хэмжээ авах;

(b) мэдээллийн нууцлалыг чанд хадгалах шаардлагыг хангаж, хөрөнгийн шилжилт хөдөлгөөний эрх чөлөөнд ямар нэг хэлбэрээр саад бэрхшээл учруулалгүйгээр бэлэн мөнгө болон нэхэмжлэгчид бэлнээр олгох төлбөрийн хэрэгслийг хилээр нэвтрүүлэхийг илрүүлэх, хяналт тавих хэрэгжүүлж болохуйц арга хэмжээ авна.

3. Оролцогч улсууд нь 2 дугаар зүйлд заасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор дотоодын хууль тогтоомжийнхоо дагуу үнэн зөв, шалгагдсан мэдээллийг солилцох болон эдгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүднээс шаардлагатай үед авах захиргааны болон бусад арга хэмжээгээ зохицуулж, дараахь байдлаар хамтран ажиллана:

(a) 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийн бүх шинжийн талаархи мэдээллийг найдвартай бөгөөд шуурхай солилцох явдлыг хөнгөвчлөх зорилгоор өөр өөрсдийн эрх бүхий алба, байгууллагуудын хооронд мэдээллийн сувгийг бий болгох, тогтмолжуулах;

(b) 2 дугаар зүйлд заасан дор дурдсантай холбоотой гэмт хэргийг мөрдөн байцаах зорилгоор өөр хоорондоо хамтран ажиллах:

i) тухайн гэмт хэргийг үйлдэхэд хамаатай гэж үндэслэлтэйгээр сэжиглэгдэж байгаа этгээдийн нэр, хаяг, байгаа газар, эрхэлдэг үйл ажиллагааг тогтоох;

ii) тухайн гэмт хэрэг үйлдэхтэй холбоотой мөнгөн хуримтлалын гүйлгээний талаар мэдээлэл солилцох.

4. Оролцогч улсууд нь Олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллага (Интерпол)-аар дамжуулан мэдээлэл солилцож болно.

19 дүгээр зүйл

Сэжигтэн этгээдийг яллаж буй оролцогч улс нь дотоодын хууль тогтоомж болон холбогдох журмын дагуу хэргийг байцаан шийдвэрлэсэн үр дүнгийн талаар

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдээлж, тэрбээр энэхүү мэдээллийг оролцогч бусад улсад хүргүүлнэ.

20 дугаар зүйл

Оролцогч улс нь улсуудын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, бүрэн эрхт байдал болон бусад улсын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх зарчимд нийцүүлэн энэхүү конвенцийн дагуу хүлээх үүргээ биелүүлнэ.

21 дүгээр зүйл

Энэхүү конвенцийн аль ч заалт улс болон хувь хүмүүсийн олон улсын эрх зүйн дагуу хүлээх хариуцлага, үүрэг, эдлэх эрх, түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм, олон улсын хүмүүнлэгийн эрх зүй, холбогдох бусад конвенцийн зорилгыг хөндөхгүй.

22 дугаар зүйл

Улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу зөвхөн тухайн улсын эрх бүхий байгууллагад оногдуулсан хэргийн харьяалал, чиг үүргийг тухайн улсын газар нутагт хэрэгжүүлэх эрхийг нөгөө улсад олгосон утга энэхүү конвенцийн аль ч заалтад байхгүй.

23 дугаар зүйл

1. Дараахь гэрээнд өөрчлөлт оруулах замаар Хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулж болно:

(a) бүх улс оролцоход нээлттэй;

(b) хүчин төгөлдөр болсон;

(c) энэхүү конвенцид оролцогч хорин хоёроос доошгүй улс соёрхон батласан, батласан, хүлээн зөвшөөрсөн буюу нэгдэн орсон.

2. Энэхүү конвенцийг хүчин төгөлдөр болсны дараа оролцогч аль ч улс ийм нэмэлт өөрчлөлтийг санал болгож болно. Нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналыг уг конвенцийн эх хадгалагчид бичгээр мэдэгдэнэ. Эх хадгалагч нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангаж буй саналын тухай оролцогч бүх улсад мэдэгдэж нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналыг батлах асуудлаар тэдний байр суурийг тодруулна.

3. Санал болгосон нэмэлт өөрчлөлтийг тарааснаас хойш 180 хоногийн дараа оролцогч улсуудын гуравны нэгээс доошгүй хувь нь дэмжихгүй байгаа тухайгаа бичгээр мэдэгдээгүй бол нэмэлт өөрчлөлтийг батласанд тооцно.

4. Хавсралтад оруулах батлагдсан нэмэлт өөрчлөлтийг энэхүү конвенцид оролцогч хорин хоёр дахь улс батламж жуух бичиг буюу хүлээн зөвшөөрсөн, эсхүл батласан тухай баримт бичгийг хадгалуулахаар хүргүүлснээс хойш 30 хоногийн дараа уг нэмэлт өөрчлөлтийг хүчин төгөлдөр болсонд тооцно. Хорин хоёр дахь батламж жуух бичиг буюу хүлээн зөвшөөрсөн, эсхүл батласан тухай баримт бичгийг хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш нэмэлт өөрчлөлтийг соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн буюу батласан улсын хувьд батламж жуух бичиг буюу хүлээн зөвшөөрсөн,

эсхүл батласан тухай баримт бичгийг хадгалуулахаар хүргүүлснаас хойш гуч хоногийн дараа тухайн нэмэлт өөрчлөлт нь хүчин төгөлдөр болно.

24 дүгээр зүйл

1. Энэхүү конвенцийг тайлбарлах буюу хэрэглэх талаар хоёр буюу түүнээс дээш оролцогч улсын хооронд гарсан бөгөөд хэлэлцээний замаар зохицуулж чадаагүй аливаа маргааныг тэдгээрийн аль нэгний хүсэлтээр арбитраг шилжүүлнэ. Хэрэв арбитраг хүсэлт гаргасан өдрөөс хойш зургаан сарын дотор талууд арбитраг зохион байгуулах талаар тохиролцож чадаагүй бол аль нэг талын хүсэлтээр маргааныг Олон улсын шүүхэд уг шүүхийн дүрмийн дагуу шилжүүлж болно.

2. Улс бүр энэхүү конвенцид гарын үсэг зурах, буюу түүнийг соёрхон батлах, эсхүл батлах буюу хүлээн зөвшөөрөхдөө энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг заавал биелүүлэх үүрэг хүлээхгүй гэж үзэж байгаа талаар мэдэгдэж болно. Ийм тайлбар хийсэн оролцогч улсын хувьд оролцогч бусад улс нь энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг заавал биелүүлэх үүрэг хүлээхгүй.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу тайлбар хийсэн аливаа оролцогч улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэх замаар тайлбараа хэдийд ч эгүүлэн авч болно.

25 дугаар зүйл

1. Энэхүү конвенц нь 2000 оны 1 дүгээр сарын 10-наас 2001 оны 12 дугаар сарын 31-нийг хүртэл Нью Йорк дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын төв байранд гарын үсэг зурахад бүх улсад нээлттэй байна.

2. Энэхүү конвенцийг соёрхон батлах, батлах буюу хүлээн зөвшөөрнө. Батламж жуух бичиг буюу батласан, эсхүл хүлээн зөвшөөрсөн тухай баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

3. Энэхүү конвенц бүх улсад нэгдэн ороход нээлттэй байна. Нэгдэн орсон тухай баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

26 дугаар зүйл

1. Энэхүү конвенц нь түүнийг соёрхон батласан, батласан, хүлээн зөвшөөрсөн эсхүл нэгдэн орсон тухай хорин хоёр батламж жуух бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулснаас хойш гуч хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү конвенцийг соёрхон батласан, батласан, хүлээн зөвшөөрсөн эсхүл нэгдэн орсон хорин хоёр дахь батламж жуух бичгийг хадгалуулснаас хойш түүнийг соёрхон батласан, батласан, хүлээн зөвшөөрсөн эсхүл нэгдэн орсон улсын хувьд батламж жуух бичгээ хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш гуч дахь өдөр энэхүү конвенц тухайн улсын хувьд хүчин төгөлдөр болно.

27 дугаар зүйл

1. Аль ч улс энэхүү конвенцийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад бичгээр мэдэгдэн цуцалж болно.

2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдсэн өдрөөс хойш нэг жилийн дараа цуцлалт хүчин төгөлдөр болно.

28 дугаар зүйл

Араб, хятад, англи, франц, орос, испани хэл дээрх эх бичвэрүүд нь адил хүчинтэй энэхүү конвенцийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулах бөгөөд тэрбээр баталгаат хуулбарыг бүх улсад илгээнэ.

Дээр дурдсаныг нотолж зохих ёсоор засгийн газраасаааа бүрэн эрх олгогдсон дор гарын үсэг зурагсад 2000 оны 1 дүгээр сарын 10-нд Нью-Йорк хотноо гарын үсэг зурахад нээлттэй болсон энэхүү конвенцид гарын үсэг зурав.

Хавсралт

1. Гаага хотноо 1970 оны 12 дугаар сарын 16-ны өдөр батласан Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенц
2. Монреаль хотноо 1971 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр батласан Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай конвенц
3. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас 1973 оны 12 дугаар сарын 14-ний өдөр батласан Олон улсын хамгаалалтад байдаг хүмүүс, түүний дотор дипломат төлөөлөгчдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон шийтгэх тухай конвенц,
4. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас 1979 оны 12 дугаар сарын 17-ны өдөр батласан Хүн барьцаанд авахын эсрэг олон улсын конвенц
5. Вена хотноо 1980 оны 3 дугаар сарын 3-ны өдөр батласан Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенц
6. Монреаль хотноо 1988 оны 2 дугаар сарын 24-ний өдөр батласан Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай Монреаль хотноо 1971 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр үйлдсэн конвенцийн Олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудал дахь хүч хэрэглэсэн хууль бус үйлдлийг хориглох тухай нэмэлт протокол
7. Ром хотноо 1988 оны 3 дугаар сарын 10-ны өдөр батласан Далайн навигацын аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай конвенц
8. Ром хотноо 1988 оны 3 дугаар сарын 10-ны өдөр батласан Эх газрын хормойд байрлуулсан суурилуулах төхөөрөмжийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай протокол

9. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас 1997 оны 12 дугаар сарын 15-ны өдөр батласан Терроризмын зорилгоор бөмбөг хэрэглэхийг хориглох тухай олон улсын конвенц

Ес. БУСАД ГЭМТ ХЭРГИЙН ЭСРЭГ КОНВЕНЦУУД

82. БООЛЧЛОЛ, БООЛЫН ХУДАЛДААГ ХОРИГЛОХ ТУХАЙ КОНВЕНЦ

*1926 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр баталж,
1927 оны 3 дугаар сарын 9-ний өдөр хүчин төгөлдөр болсон
1953 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн протоколоор өөрчлөлт оруулж,
уг протокол нь 1955 оны 7 дугаар сарын 7-ны өдөр хүчин төгөлдөр болсон**

1889-90 оны Брюсселийн бага хурлын Ерөнхий актад гарын үсэг зурсан улс бүр Африкийн боолын худалдааг устгах бүрэн зорилготойгоо тунхаглан,

1919 оны Сан-Жерменийн конвенцид гарын үсэг зурсан улс болон 1885 оны Берлины ерөнхий акт, 1890 оны Брюсселийн ерөнхий акт болон Тунхаглалыг хянан өөрчлөхөд боолчлолын бүх хэлбэрийг бүрэн хориглох, газар болон далайгаар дамжсан боолын худалдааг зогсоохыг нотлохын зэрэгцээ,

1924 оны 6 дугаар сарын 12-ны өдөр Үндэстнүүдийн Холбооны Зөвлөлөөр томилсон Боолчлолын түр хорооны илтгэлийг анхааралдаа авч,

Сан-Жерменийн конвенцид гарын үсэг зурсан улсуудаас боолчлол, боолын худалдааны талаар гаргасан зорилтуудыг дэлхий даяар хэрэгжүүлэх үүднээс Брюсселийн актын дагуу хэрэгжүүлэх ажлыг дуусгавар болгон хэрэгжүүлэхийг эрмэлзэн, мөн энэхүү конвенцид тусгагдсан заалтуудаас илүү нарийвчилсан заалт бүхий хэлэлцээр байгуулах шаардлагатайг хүлээн зөвшөөрч,

түүнчлэн албадан хөдөлмөр хийлгэх явдал нь боолчлолтой ижил нөхцөл рүү хүргэж болзошгүй юм гэдгээс сэргийлэн,

конвенц байгуулахыг шийдэн, бүрэн эрхт төлөөлөгчдийг томилон:

(бүрэн эрхт 40 төлөөлөгчдийн нэрс),

тэдний бүрэн эрхийн хүрээнд дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

1 дүгээр зүйл

Энэхүү конвенцийн зорилгод дараахь нэр томъёог хэлэлцэн тохиров:

1. Боолчлол гэдэгт өмчлөх эрхэд хамаарах бүх, эсхүл зарим эрх мэдлийг хүн дээр хэрэгжүүлсэн байдал буюу нөхцлийг ойлгоно.

* Монгол Улс 1968.10.31-нд соёрхон батласан

2. Боолын худалдаа гэдэгт хүнийг боол болгох зорилгоор олзлох, олж авах буюу эрхэндээ оруулах бүх үйлдэл; боолыг худалдах буюу солих зорилгоор түүнийг олж авахтай холбогдсон бүх үйлдэл; худалдах буюу солих зорилгоор олж авсан боолыг худалдах буюу солих замаар эрхэндээ оруулах бүх үйлдэл, бүхэлдээ боолыг тээвэрлэх, эсхүл худалдах бүх үйлдэл хамаарна.

2 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд шаардлагатай алхмыг хийж амжаагүй бол өөрийн бүрэн эрхт байдал, хэргийн харьяалал, хамгаалал, эзэн эрхт буюу асрамжинд байгаа нутаг дэвсгэртээ дараахь арга хэмжээг авна:

(а) боолын худалдааг хориглох болон түүнээс урьдчилан сэргийлэх;

(б) боолчлолын бүх хэлбэрийг аль болох богино хугацаанд эрчимтэй бүрмөсөн устгах.

3 дугаар дүйл

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүр өөрийн нутгийн ус болон тэдгээрийн далбааг мандуулсан хөлөг онгоцоор боолыг ачих, буулгах, тээвэрлэх явдлыг устгах, урьдчилан сэргийлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авна.

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд боолын худалдаатай холбоотой ерөнхий конвенцийг аль болох богино хугацаанд хэлэлцэх үүргийг хүлээх бөгөөд Зэвсгийн олон улсын худалдааны тухай 1925 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн конвенцийн (12, 20, 21, 22, 23, 24 болон II дугаар хавсралтын II дугаар бүлгийн 3, 4, 5 дугаар хэсэг) заалттай ижил төрлийн эрх, үүрэг хүлээлгэх заалт тусгахаас гадна энэхүү ерөнхий конвенцид хэлэлцэн тохирогч эрхэм дээд аливаа талын хөлөг онгоцыг (бага тоннын даацтайг ч оруулна) хэлэлцэн тохирогч эрхэм дээд бусад талын хөлөг онгоцноос өөр нөхцөлд тавихгүй байх зарчмыг баримтална гэж үзэж тохирох заалтыг тусгана.

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд түүнчлэн энэхүү ерөнхий конвенцийг хүчин төгөлдөр болохын өмнө буюу дараа өмнөх хэсэгт дурдсан зарчмаас буцахгүйгээр тухайн нөхцөлд тохирсон боолын худалдааг аль болох богино хугацаанд бүрэн устгахад чиглэсэн тусгай хэлэлцээрийг хоорондоо байгуулж болно.

4 дүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд боолчлол болон боолын худалдааг устгах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор харилцан туслалцаа үзүүлнэ.

5 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд албадан буюу заавал хийлгэх хөдөлмөр нь ноцгой үр дагаварт хүргэж болохыг хүлээн зөвшөөрч улс бүр өөрийн бүрэн эрхт байдал, хэргийн харьяалал, хамгаалал, эзэн эрхт буюу асрамжинд байгаа нутаг дэвсгэрийнхээ хувьд албадан буюу заавал хийлгэх хөдөлмөр нь боолчлол уруу шилжихээс сэргийлэх шаардлагатай бүх арга хэмжээг авна.

Талууд дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

1. 2 дахь хэсэгт дор дурдсан шилжилтийн заалтын дагуу албадан буюу заавал хийлгэх хөдөлмөр нь зөвхөн олон нийтийн зорилгод нийцсэн байж болно.

2. Албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийг олон нийтийн зорилгоос бусад зорилгод ашиглаж байгаа нутаг дэвсгэрт хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд түүнийг аль болох богино хугацаанд устгах чиглэлээр ажиллана. Хэрэв албадан буюу заавал хийлгэх хөдөлмөр ашиглаж байгаа бол түүнийг зөвхөн онцгой тохиолдолд хэрэглэх бөгөөд чингэхдээ тохирсон шан харамжийг төлж, ажилчдыг байнга оршин суугаа нутаг дэвсгэрээс нь нүүлгэхгүй байх үүрэг хүлээнэ.

3. Ямар ч тохиолдолд албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийн хариуцлагыг тухайн нутаг дэвсгэрийн эрх бүхий төв байгууллага хүлээнэ.

6 дугаар зүйл

Хууль тогтоомждоо хууль зөрчсөн үйлдэлд хүлээлгэх хариуцлагыг тухайн үед энэхүү конвенцийн зорилгыг хангахуйцаар тусгаагүй байгаа хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал уг зөрчлийн хувьд хатуу шийтгэл оногдуулах талаар шаардлагатай арга хэмжээ авна.

7 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд энэхүү конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор батласан дотоодын хууль тогтоомжын талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад болон өөр хоорондоо харилцан мэдээлэх үүрэг хүлээнэ.

8 дугаар зүйл

Энэхүү конвенцийг тайлбарлах буюу хэрэглэхэд үүссэн маргааныг хэлэлцээний замаар шууд шийдвэрлэж чадаагүй бол түүнийг Олон улсын шүүхэд шилжүүлэх талаар хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд тохиролцоно. Хэрэв энэхүү маргаанд оролцогч улсууд буюу тэдгээрийн аль нэг нь Олон Улсын шүүхийн оролцогч биш бол уг маргааныг талуудын хүсэлтээр болон тал бүрийн үндэсний хууль тогтоомжийн дагуу Олон улсын шүүх, эсхүл Олон улсын маргааныг эв зүйгээр шийдвэрлэх тухай 1907 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн конвенцийн дагуу байгуулагдсан хөндлөнгийн шүүхэд, эсхүл бусад хөндлөнгийн шүүхэд шилжүүлнэ.

9 дүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд аливаа тал энэхүү конвенцид гарын үсэг зурах, эсхүл соёрхон батлах буюу нэгдэн орох үедээ энэхүү конвенцийг хүлээн зөвшөөрснөөр уг конвенцийг бүхэлд нь буюу түүний зарим хэсгийг тухайн улсын бүрэн эрхт байдал, хэргийн харьяалал, хамгаалал, эзэн эрхт буюу асрамжинд байгаа бүх нутаг дэвсгэр болон түүний зарим хэсэгт үйлчлэхгүй гэдгийг зарлан тунхаглаж болно; мөн цаашид эдгээр нутаг дэвсгэрийн аль нэгний нэрийн өмнөөс энэхүү конвенцид бүхэлд нь буюу хэсэгчилэн нэгдэн орж болно.

10 дугаар зүйл

Хэрэв хэлэлцэн тохирогч эрхэм дээд аль нэг тал энэхүү конвенцийг цуцлах хүсэлт гаргавал, уг хүсэлтээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн

бичгийн даргад бичгээр мэдэгдэх бөгөөд тэрбээр энэ мэдэгдлийн баталгаат хуулбарыг түүнийг хүлээж авсан өдрийн хамт хэлэлцэн тохирогч эрхэм дээд бүх талд мэдэгдэнэ.

Цуцлалт нь зөвхөн цуцлах тухай мэдэгдэл хийсэн улсын хувьд үйлчлэх бөгөөд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга уг мэдэгдлийг хүлээн авснаас нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно.

Цуцлалтыг тухайн улсын бүрэн эрхт байдал, хэргийн харьяалал, хамгаалал, эзэн эрхт буюу асрамжинд байгаа нутаг дэвсгэр бүрийн хувьд тусад нь мэдэгдэж болно.

11 дүгээр зүйл

Энэ өдрөөр дугаарласан энэхүү конвенцийн англи, франц хэлээрхи эх бичвэрүүд адил хүчинтэй бөгөөд Үндэстнүүдийн Холбооны улсуудад 1927 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл гарын үсэг зурахад нээлттэй байна.

Энэхүү конвенцид Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн бус болон бусад бүх улс нэгдэн ороход нээлттэй байх бөгөөд тэдгээр улсад Ерөнхий нарийн бичгийн дарга конвенцийн баталгаат хуулбарыг хүргүүлнэ.

Нэгдэн орсон тухай албан ёсны баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулахаар өгснөөр нэгдэн орох бөгөөд тэрбээр энэ тухай энэхүү конвенцид оролцогч бүх улс болон энэ зүйлд дурдсан улсуудад нэгдэн орсон баримт бичгийг хадгалуулахаар өгсөн тухай болон түүнийг хүлээн авсан өдрийн хамт мэдэгдэнэ.

12 дугаар зүйл

Энэхүү конвенцийг соёрхон батлах бөгөөд батламж жуух бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулах бөгөөд тэрбээр энэ тухай хэлэлцэн тохирогч эрхэм дээд бүх талд нэн даруй мэдэгдэнэ.

Энэхүү конвенц нь соёрхон батласан болон нэгдэн орсон баримт бичгээ хадгалуулахаар өгсөн өдрөөс тухайн улсын хувьд хүчин төгөлдөр болно.

Дээр дурдсаныг нотолж засгийн газраасаа зохих ёсоор бүрэн эрх олгогдсон дор гарын үсэг зурагсад энэхүү конвенцид гарын үсэг зурав.

Энэхүү конвенцийг Женев хотноо 1926 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр нэг эх хувь үйлдэв. Эх хувийг Үндэстнүүдийн Холбооны архивт хадгалах бөгөөд түүний баталгаат хуулбарыг конвенцид гарын үсэг зурсан улс бүрт зохих ёсоор хүргүүлнэ.

83. БООЛЧЛОЛ, БООЛЫН ХУДАЛДАА БОЛОН БООЛЧЛОЛТОЙ АДИЛТГАХ ЁС, ЗАНШЛЫГ УСТГАХ ТУХАЙ НЭМЭЛТ КОНВЕНЦ

*1956 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр баталж,
1957 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр хүчин төгөлдөр болсон**

Удиртгал

энэхүү конвенцид оролцогч улс,

эрх чөлөө бол хүн бүрт төрөхөөс заяагдсан эрх мөн гэж үзэж,

Нэгдсэн Үндэстний улс түмэн дүрэмдээ хүн төрөлхтний үнэ цэнэ, нэр төрд итгэх итгэлийг бататгасныг дурдаж,

бүх улс, үндэстэн ард түмний хүрвэл зохих нийтлэг стандарт болгож Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас зарлан тунхагласан Хүний эрхийн түгээмэл тунхаглалд боолчлол буюу эрх мэдэлгүй байдалд хэн ч нэрвэгдэх ёсгүй бөгөөд боолчлол, боолын худалдааг бүх хэлбэрээр нь хориглоно гэж заасныг анхааралдаа авч,

боолын худалдааг устгахад чиглэсэн Женев хотноо 1926 оны 9 дүгээр сарын 25-нд гарын үсэг зурсан Боолчлолын тухай конвенцийг байгуулснаас хойш энэ зорилгод хүрэх явцад цаашдын дэвшил гарсныг хүлээн зөвшөөрч,

Албадан хөдөлмөрийн тухай 1930 оны конвенц болон албадан буюу заавал хөдөлмөрийн талаар Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас авсан удаа дараагийн арга хэмжээг анхааралдаа авч,

гэвч боолчлол, боолын худалдаа болон боолчлолтой адилтгах ёс, заншил дэлхийн бүх хэсэгт хараахан устаагүй байгааг харгалзан,

иймээс боолчлол, боолын худалдаа болон боолчлолтой адилтгах ёс, заншлыг устгахад үндэсний, түүнчлэн олон улсын хамтын чармайлтыг эрчимтэй болгоход чиглэсэн нэмэлт конвенц байгуулснаар хүчин төгөлдөр хэвээр байх 1926 оны конвенцийг бүрэн гүйцэд болгоно гэж шийдээд,

дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

* Монгол Улс 1968.10.31-нд соёрхон батласан

I ХЭСЭГ

Боолчлолтой адилтгах ёс, заншил

1 дүгээр зүйл

Энэхүү конвенцид оролцогч улс гүрэн бүр Женев хотноо 1926 оны 9 дүгээр сарын 25-нд гарын үсэг зурсан Боолчлолын тухай конвенцийн I дүгээр зүйлд заасан боолчлолын тухай тодорхойлолтод туссан эсэхийг нь харгалзалгүйгээр хараахан устаагүй байгаа дараахь ёс болон заншлыг бүрэн халах буюу устгахыг аль болох богино хугацаанд амжилттай гүйцэтгэхийн тулд бүхий л хэрэгжихүйц болон шаардлагатай хуулийн болон бусад арга хэмжээ авна:

(a) Өрөнд баригдаж боолчлогдсон, өөрөөр хэлбэл өртэй хүн өөрийнхөө, эсхүл өөрөөсөө хараат хүний үйлчилгээгээр өрөө төлөх үүргээ биелүүлэхтэй холбоотойгоор үүссэн барьцааны байдал буюу нөхцөл, хэрэв тэрхүү үйлчилгээг зохих ёсоор үнэлсэн үнэлгээ нь уг өрийн төлөөсөнд тооцогдохгүй, эсхүл тэрхүү хөдөлмөрийн шинж чанар, үргэлжлэх хугацаа нь тодорхой бус бол;

(b) Хамжлага болох, өөрөөр хэлбэл, хууль, заншил, эсхүл гэрээний дагуу түрээслэгч өөр хүний эзэмшил газарт амьдарч шан харамжтай буюу түүнгүйгээр хөдөлмөр хийх болон тухайн хүнд тодорхой зарим үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээсэн нөхцөл, байдал болон уг байдлыг өөрчилж чадахааргүй бол;

(c) Дараахь үйлдлийг зөвшөөрсөн аливаа ёс, заншил:

(i) эмэгтэй хүнийг мөнгө болон биет эд зүйлийн оронд төлөх болзолтойгоор өөрийнх нь зүгээс татгалзах эрхгүйгээр түүний эцэг, эх асран хамгаалагч, гэр бүл, эсхүл бусад хүн, эсхүл бүлэг хүмүүсээс эхнэр болгож өгөхийг амласан эсхүл өгсөн;

(ii) эмэгтэйн нөхөр, түүний гэр бүл, эсхүл овгийнхон нь тухайн эмэгтэйг өөр хүнд үнэтэй эд зүйлсийн оронд буюу бусад хэлбэрээр шилжүүлэн өгөх эрх эдэлдэг байх;

(iii) нөхрийг нь нас барахад бэлбэсэн эхнэрийг бусдад өвлүүлэн өгөх.

(d) 18 нас хүрээгүй болон бага насны хүүхдүүдийг ашиглах буюу тэдний хөдөлмөрийг мөлжих зорилгоор эцэг эхийнх нь аль нэг, эсхүл хоёул, эсхүл асран хамгаалагч нь тэднийг шан харамжтай буюу түүнгүйгээр бусдад өгдөг аливаа ёс буюу заншил.

2 дугаар зүйл

Энэхүү конвенцийн I дүгээр зүйлийн "с" дэд хэсэгт дурдсан ёс, заншлыг эцэс болгохын тулд түүнд оролцогч улсууд шаардлагатай бол гэрлэх насны зохистой доод хэмжээг тогтоох, иргэний болон албан тушаалтан болон шашны төлөөлөгчид гэрлэгчдээс хүслээ чөлөөтэй илэрхийлдэг болон хоёр талын аль аль нь зөвшөөрсний үндсэн дээр гэрлэдэг нөхшийг хангасан журам тогтоох, түүнчлэн гэрлэлтийг бүртгэдэг байхыг хөхиүлэн дэмжих үүргийг хүлээнэ.

II ХЭСЭГ Боолын худалдаа

3 дугаар зүйл

1. Боолыг нэг улсаас нөгөө улсад тээврийн аль нэг хэрэгслээр тээвэрлэсэн буюу тээвэрлэхийг завдсан, эсхүл түүнд оролцсон үйлдлийг энэхүү конвенцид оролцогч улсууд хуулиар гэмт хэрэг гэж тооцон ийм гэмт хэрэг үйлдэгчдид маш хүнд ял оногдуулна.

2. (a) Энэхүү конвенцид оролцогч улсууд түүний төрийн далбааг хэрэглэх зөвшөөрөл бүхий хөлөг онгоц болон агаарын хөлгөөр боол тээвэрлэх, улсынхаа төрийн далбааг тийм зорилгод ашиглахаас урьдчилан сэргийлэх, ийм хэрэгт гэм буруутай этгээдийг шийтгэх талаар үр нөлөөтэй арга хэмжээ авна.

(b) Энэхүү конвенцид оролцогч улсууд боол тээвэрлэхэд боомт, нисэх буудал, далайн эргээ ашиглуулахгүй байх явдлыг хангах үр нөлөөтэй бүхий л арга хэмжээ авна.

3. Энэхүү конвенцид оролцогч улсууд боолын худалдааны эсрэг тэмцэх талаар авсан арга хэмжээг хэрэгжихүйцээр уялдуулан зохицуулах зорилгоор мэдээлэл солилцож байх, боолын худалдаа хийсэн тохиолдол бүрийн тухай болон тийм гэмт хэрэг үйлдэхийг завдсан оролдлого бүрийн тухай мэдэж байгаа болгоноо харилцан мэдээлж байна.

4 дүгээр зүйл

Энэхүү конвенцид оролцогч улсын хөлөг онгоцон дээр орогносон боол *ipso facto* эрх чөлөөтэй болно.

III ХЭСЭГ Боолчлол болон боолчлолтой адилтгах ёс, заншил

5 дугаар зүйл

Энэхүү конвенцийн 1 дүгээр зүйлд дурдсан боолчлол болон түүнтэй адилтгах ёс, заншлыг бүрэн халж устгаагүй улсад боол буюу эрх мэдэлгүй байдалд байгаа хүн мөн гэдгийг нь тэмдэглэх, эсхүл цээрлүүлэх буюу өөр ямар нэгэн зорилгоор тэднийг зэрэмдэглэх, тамгалах үйлдэл түүнчлэн үүнийг үйлдэхэд оролцсоныг энэхүү конвенцид оролцогч улсын хуулиар эрүүгийн гэмт хэрэг гэж үзэж ийм хэрэг үйлдэгчдийг шийтгэнэ.

6 дугаар зүйл

1. Хүнийг боол болгох, бусдад өөрийг нь буюу түүнээс хараат хүнийг нь боол болгохыг албадах буюу ийм үйлдэл хийхийг завдах буюу түүнд оролцох, мөн тэдгээр үйлдлийн аль нэгийг үйлдэхээр үгсэн тохиролцоход оролцсоныг энэхүү конвенцид оролцогч улсын хуулиар эрүүгийн гэмт хэрэг гэж үзэж, ийм хэрэг үйлдэгчдийг шийтгэнэ.

2. Энэхүү конвенцийн 1 дүгээр зүйлийн удиртгалын хэсгийн заалтыг мөрдлөг болгон өөрийг нь буюу түүнээс хараат хүнийг 1 дүгээр зүйлд дурдсан ёс, заншлын үр

дүнд бий болсон эрх мэдэлгүй байдалд татан оруулахаар аливаа этгээдийг ятгах үйлдэл болон ийм үйлдэл хийх гэсэн оролдлого, түүнд хамтран оролцсон зэрэг тохиолдолд энэ зүйлийн 1 дэх заалтыг мөн хэрэглэнэ.

IV ХЭСЭГ

Тодорхойлолт

7 дугаар зүйл

Энэхүү конвенцийн зорилгод:

(а) Боолчлолын тухай 1926 оны конвенцид тодорхойлсны нэгэн адилаар өмчлөх эрхэд хамаарах бүх, эсхүл зарим эрх мэдлийг хүнээр хэрэгжүүлсэн байдал буюу нөхцлийг “боолчлол”, мөн ийм байдал буюу нөхцөлд байгаа хүнийг “боол” гэж тус тус ойлгоно.

(б) Энэхүү конвенцийн 1 дүгээр зүйлд дурдсан ёс, заншлын үр дүнд бий болсон байдал буюу нөхцөлд байгаа хүнийг “эрх мэдэлгүй байдалд байгаа хүн” гэнэ.

(с) “Боолын худалдаа” гэдэг ойлголтод хүнийг боол болгох зорилгоор олзлох, олж авах буюу эрхэндээ оруулах бүх үйлдэл; боолыг худалдах буюу солих зорилгоор түүнийг олж авахтай холбогдсон бүх үйлдэл; худалдах буюу солих зорилгоор олж авсан боолыг худалдах буюу солих замаар эрхэндээ оруулах бүх үйлдэл, бүхэлдээ боолыг тээвэрлэх, эсхүл худалдах бүх үйлдэл хамаарна.

V ХЭСЭГ

Энэхүү конвенцид оролцогч улсуудын хоорондын хамтын ажиллагаа, мэдээлэл

8 дугаар зүйл

1. Дээр дурдсан заалтыг хэрэгжүүлэхэд энэхүү конвенцид оролцогч улсууд хоорондоо болон Нэгдсэн Үндэстний Байгууллагатай хамтран ажиллах үүргийг хүлээнэ.

2. Конвенцид оролцогчид энэхүү конвенцийн заалтыг биелүүлэхийн тулд батлан гаргаж хэрэгжүүлсэн бүх хууль тогтоомж, засаг захиргааны захирамжийн хуулбарыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хүргүүлэх үүрэг хүлээнэ.

3. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга энэ зүйлийн 1-д заасан ёсоор ирүүлсэн мэдээллийг энэхүү конвенцид оролцогч бусад улсад болон Эдийн засаг, нийгмийн зөвлөлд хүргүүлэх бөгөөд тэр нь энэхүү конвенцийн үндсэн зүйл болж байгаа боолчлол, боолын худалдаа буюу боолчлолтой адилтгах ёс, заншлыг устгах талаар Зөвлөлөөс цаашид боловсруулах зөвлөмжийг хэлэлцэх асуудлын талаархи баримт бичгийн нэг хэсэг байна.

VI ХЭСЭГ Төгсгөлийн заалт

9 дүгээр зүйл

Энэхүү конвенцид тайлбар хийж болохгүй.

10 дугаар зүйл

Энэхүү конвенцийг тайлбарлах буюу хэрэглэх талаар түүнд оролцогч улсуудын хооронд үүссэн бөгөөд хэлэлцээний замаар шийдвэрлээгүй маргааныг зохицуулах өөр аргагүйд хүрвэл маргаанд оролцогчдын аль нэгний хүсэлтээр уг маргааныг Олон улсын шүүхэд шилжүүлнэ.

11 дүгээр зүйл

1. Энэхүү конвенц Нэгдсэн Үндэстний Байгууллага болон түүний төрөлжсөн аль нэг байгууллагын гишүүн улсын хувьд гарын үсэг зурахад 1957 оны 7 дугаар сарын 1 хүртэл нээлттэй байна. Гарын үсэг зурсан улсууд энэхүү конвенцийг соёрхон батлах бөгөөд батламж жуух бичгээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулж, тэрбээр энэ тухай конвенцид гарын үсэг зурсан буюу нэгдэн орсон улс бүрт мэдэгдэнэ.

2. Нэгдсэн Үндэстний Байгууллага болон түүний төрөлжсөн аль нэг байгууллагын гишүүн улс буюу Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас нэгдэн орох тухай урилга хүлээн авсан өөр аль ч улс 1957 оны 7 дугаар сарын 1-ээс хойш энэхүү конвенцид нэгдэн ороход нээлттэй байна. Нэгдэн орсон тухай албан ёсны баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулах бөгөөд тэрбээр энэ тухай конвенцид гарын үсэг зурсан буюу нэгдэн орсон улс бүрт мэдэгдэнэ.

12 дугаар зүйл

1. Оролцогч улсын олон улсын харилцаанд хариуцлага хүлээдэг өөртөө засан тохиноогүй, асрамжинд байгаа колонийн болон эзэн улсын бүрэлдэхүүнд ордоггүй бүх нутаг дэвсгэрт энэхүү конвенцийг хэрэглэнэ. Тухайн улс энэ зүйлийн 2 дахь хэсгийн дагуу гарын үсэг зурах, соёрхон батлах буюу нэгдэн орох үедээ энэхүү конвенцид гарын үсэг зурах, соёрхон батлах буюу нэгдэн орсноор түүнийг *ipso facto* хэрэглэх болсон эзэн улсын бүрэлдэхүүнд ордоггүй аливаа нутаг дэвсгэр, эсхүл тэдгээр нутаг дэвсгэрийн аль нэгнийх нь талаар зарлан мэдэгдэнэ.

2. Конвенцид оролцогч улс буюу эзэн улсын бүрэлдэхүүнд ордоггүй нутаг дэвсгэрийн үндэсний хууль тогтоомж буюу дадал ёсоор тухайн нутаг дэвсгэрийн зөвшөөрлийг урьдчилан авах шаардлагатай бол тухайн улс энэхүү конвенцид гарын үсэг зурсан өдрөөс эхлэн арван хоёр сарын дотор эзэн улсын бүрэлдэхүүн ордоггүй нутаг дэвсгэрийн зөвшөөрлийг заавал авсан байхыг хангахын тулд хүчин чармайлт гаргах бөгөөд зөвшөөрөл авмагцаа Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэнэ. Мэдэгдэлд дурдсан нутаг дэвсгэр буюу нутаг дэвсгэрүүдийн хувьд Ерөнхий нарийн бичгийн дарга мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс энэхүү конвенцийг хэрэглэнэ.

3. Өмнөх хэсэгт заасан арван хоёр сарын хугацаа дуусмагц конвенцид оролцогч холбогдох улсууд олон улсын харилцаанд хариуцлага хүлээдэг, эзэн улсын бүрэлдэхүүнд ордоггүй болон энэхүү конвенцийг хэрэглэх тухай зөвшөөрлөө өгөөгүй нутаг дэвсгэрүүдтэй хийсэн зөвлөлдөөний үр дүнгийн тухай Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэнэ.

13 дугаар зүйл

1. Хоёр улс оролцогч болмогц энэхүү конвенц хүчин төгөлдөр болно.

2. Хожим нь энэхүү конвенц улс буюу нутаг дэвсгэр тус бүрийн хувьд тэдгээрийн багтамж жуух бичиг буюу нэгдэн орох тухай баримт бичгээ хадгалуулсан буюу тухайн нутаг дэвсгэрт энэхүү конвенцийг хэрэглэх тухай мэдэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

14 дүгээр зүйл

1. Энэхүү конвенцийг хэрэглэх нь дэс дараалсан гурван жилийн хугацаанд хуваагдах бөгөөд түүний эхнийх нь 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу энэхүү конвенцийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхэлнэ.

2. Энэхүү конвенцид оролцогч аль ч улс тухайн гурван жилийн хугацааг дуусахаас зургаан сарын өмнө Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэх замаар энэхүү конвенцийг цуцалж болно. Ерөнхий нарийн бичгийн дарга тухайн мэдэгдэл болон болон түүнийг хүлээн авсан өдрийн тухай конвенцид оролцогч бусад улсад мэдэгдэнэ.

3. Цуцлалт нь тухайн гурван жилийн хугацаа дуусмагц хүчин төгөлдөр болно.

4. 12 дугаар зүйлийн дагуу эзэн улсын бүрэлдэхүүнд ордоггүй энэхүү конвенцид оролцогч улсын нутаг дэвсгэрт энэхүү конвенцийг хэрэглэх болсон үед тухайн улс холбогдох нутаг дэвсгэрийн зөвшөөрлийг авсны дараа тэр нутаг дэвсгэрийн хувьд энэхүү конвенцийг цуцлах тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад аль ч үед мэдэгдэж болно. Ерөнхий нарийн бичгийн дарга уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш нэг жилийн дараа цуцлалт хүчин төгөлдөр болох бөгөөд тэрбээр мэдэгдэл болон түүнийг хүлээн авсан өдрийн тухай конвенцид оролцогч бусад бүх улсад мэдээлнэ.

15 дугаар зүйл

Англи, испани, хятад, орос, франц хэлээр үйлдсэн эх бичвэр нь адил хүчинтэй энэхүү конвенцийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын нарийн бичгийн дарга нарын газрын архивт хадгалуулна. Энэхүү конвенцид оролцогч улс Нэгдсэн Үндэстний Байгууллага болон түүний төрөлжсөн бусад байгууллагын гишүүн бүх улсад хүргүүлэх энэхүү конвенцийн баталгаат хуулбарыг Ерөнхий нарийн бичгийн дарга бэлтгэнэ.

Дээр дурдсаныг нотолж засгийн газраасаа зохих ёсоор бүрэн эрх олгогдсон дор гарын үсэг зурагсад энэхүү конвенцид тэдний гарын үсгийн эсрэг талд заасан өдөр гарын үсэг зурав.

Энэхүү конвенцийг Женев дэх Нэгдсэн Үндэстний Байгууллагын Европын салбарт 1956 оны 9 дүгээр сарын 7-нд үйлдэв.

84. МАНСУУРУУЛАХ ЭМИЙН ТУХАЙ НЭГДСЭН КОНВЕНЦ

*1961 оны 3 дугаар сарын 25-ны өдөр баталж,
1964 оны 12 дугаар сарын 13-ны өдөр хүчин төгөлдөр болсон
1972 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн протоколоор нэмэлт өөрчлөлт оруулж,
уг протокол нь 1975 оны 8 дугаар сарын 8-ны өдөр хүчин төгөлдөр болсон**

Удиртгал

Талууд

хүн төрөлхтөний эрүүл мэнд, сайн сайхны төлөө сэтгэл зовниж,

мансууруулах эмийг анагаах ухаанд хэрэглэх нь өвчин, зовлонг илааршуулахад зайлшгүй шаардлагатай байгааг, тийм зорилгоор мансууруулах эмийг хүртээлтэй байлгах явдлыг зохих хэмжээгээр хангах ёстойг хүлээн зөвшөөрч,

мансууруулах эмд донтох нь хувь хүнд ноцтой гай зовлон, хүн төрөлхтөнд нийгэм, эдийн засгийн аюул учруулахыг хүлээн зөвшөөрч,

энэ гай зовлонгоос урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх үүргээ ухамсарлаж,

мансууруулах эмийг урвуулан хэрэглэхийн эсрэг үр дүнтэй арга хэмжээ авахад уялдуулан зохицуулалт, бүх нийтийн үйл ажиллагаа шаардлагатай гэж үзэж,

бүх нийтийн ийм арга хэмжээ нь адил зарчмыг удирдлага болгосон нэгэн зорилтод чиглэсэн олон улсын хамтын ажиллагааг шаардаж байгааг ойлгож,

хар тамхинд хяналт тавих салбар дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын эрх хэмжээг хүлээн зөвшөөрч, олон улсын холбогдох байгууллагууд нь тэрхүү байгууллагын хүрээнд багтаж байх нь зүйтэй гэж үзэж,

мансууруулах эмийн талаархи одоо мөрдөж буй гэрээнүүдийг сольж, мансууруулах эмийг гагцхүү анагаах ухааны болон эрдэм шинжилгээний хэрэглээгээр хязгаарлаж, ийм зорилго, зорилтод хүрэхэд олон улсын байнгын хамтын ажиллагаа, хяналт тавих тухай заасан нийтээр хүлээн зөвшөөрөх олон улсын конвенц байгуулахыг эрмэлзэн,

дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

* Монгол Улс 1990.12.06-нд нэгдэн орсон

1 дүгээр зүйл

Тодорхойлолт

1. Хэрэв өөрөөр илэрхий заагаагүй буюу тодорхой тохиолдолд агуулгын хувьд өөр шаардлагагүй бол энэхүү конвенцид дараахь тодорхойлолтыг хэрэглэнэ:

а) “Хороо” гэж Хар тамхинд хяналт тавих олон улсын хороог хэлнэ.

б) “Каннабис” гэж ямар нэрээр тэмдэглэж болохоос үл хамааран давирхайг нь ялгаагүй цэцэг болон үртэйгээ (толгойноос ангид байх үр, навчнаас бусад) байгаа каннабис ургамлын толгой үзүүрийг хэлнэ.

с) “Каннабис ургамал” гэж каннабисын төрлийн аливаа ургамлыг хэлнэ.

д) “Каннабисын давирхай” гэж каннабисын ургамлаас авч ялгасан бохир буюу цэвэрлэсэн давирхайг хэлнэ.

е) “Кока бут” гэж эритроксилоны төрлийн аливаа зүйлийн ургамлыг хэлнэ.

ф) “Кока навч” гэж экгонин, кокаин болон экгониний аливаа бусад алколоидыг шавхаж авсан навчнаас бусад кока бутны навчийг хэлнэ.

г) “Комисс” гэж Зөвлөлийн Мансууруулах эмтэй тэмцэх комиссыг хэлнэ.

h) “Зөвлөл” гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эдийн засаг, нийгмийн зөвлөлийг хэлнэ.

и) “Тарималжуулах” гэж опиумын намуу, кока бут буюу каннабисын ургамлыг тарималжуулахыг хэлнэ.

j) “Мансууруулах эм” гэж I болон II жагсаалтад орсон байгалийн болон нийлэг бодисын аль нэгийг хэлнэ.

к) “Ерөнхий Ассамблей” гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейг хэлнэ.

l) “Хууль бус эргэлт” гэж энэхүү конвенцийн заалтыг зөрчиж мансууруулах эм тарималжуулах буюу эргэлтэд оруулахыг хэлнэ.

m) “импорт” болон “экспорт” гэж мансууруулах эмийг тухайн тохиолдолд нэг улсаас нөгөө улс уруу, эсхүл нэг улсын дотор нэг нутаг дэвсгэрээс нөгөө нутаг дэвсгэр рүү биет байдлаар шилжүүлэхийг хэлнэ.

n) “Бэлтгэх” гэж үйлдвэрлэхээс бусад мансууруулах эмийг гаргаж авах бүх үйл ажиллагааг хэлэх бөгөөд үүнд мансууруулах нэг эмийг мансууруулах нөгөө эм рүү шилжүүлэн хувиргах ажиллагаа багтана.

o) “Эмчилгээний опиум” гэж эмчилгээнд хэрэглэж болохуйцаар зохих боловсруулалтад орсон опиумыг хэлнэ.

p) “Опиум” гэж опиумын намууны бүлэгнэсэн шүүсийг хэлнэ.

- q) “Опиумын намуу” гэж *Papaverum somniferum L.* зүйлийн ургамлыг хэлнэ.
- г) “Намууны сүрэл” гэж хатсаны дараахь опиумын намууны (үрээс бусад) бүх хэсгийг хэлнэ.
- с) “Бэлдмэл” гэж мансууруулах эм агуулсан хатуу буюу шингэн холимгийг хэлнэ.
- т) “Үйлдвэрлэх” гэж кока навч, каннабис болон каннабисын давирхайг, тэдгээрийг гаргаж авсан ургамлаас нь салгахыг хэлнэ.
- у) “I жагсаалт”, “II жагсаалт”, “III жагсаалт”, “IV жагсаалт” гэж 3 дугаар зүйлд нийцүүлэн тухай бүр нэмэлт, өөрчлөлт оруулсан, энэхүү конвенцид хавсаргасан мансууруулах эм буюу бэлдмэлийн зохих ёсоор дугаарласан жагсаалтыг хэлнэ.
- v) “Ерөнхий нарийн бичгийн дарга” гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргыг хэлнэ.
- w) “Тусгай нөөц” гэж Засгийн газрын тусгай зориулалт болон онцгой нөхцөлд байдалд хэрэглэхээр аль нэг орон буюу нутаг дэвсгэрт байгаа тухайн орон буюу нутаг дэвсгэрийн засгийн газрын мэдэлд байгаа мансууруулах эмийн хэмжээг хэлэх бөгөөд “тусгай зориулалт” гэдэг нэр томъёог ийнхүү ойлгоно.
- x) “Нөөц” гэж аль нэг орон буюу нутаг дэвсгэрт байгаа дор дурдсан зориулалт бүхий мансууруулах эмийн хэмжээг хэлнэ:
- (i) Анагаах ухааны болон эрдэм шинжилгээний зорилгоор тухайн орон буюу нутаг дэвсгэрт хэрэглэх;
 - (ii) Мансууруулах эм болон бусад бодис бэлтгэхээр тухайн орон буюу нутаг дэвсгэрт ашиглах;
 - (iii) Экспортлох, тухайн орон буюу нутаг дэвсгэрт байгаа мансууруулах эмийн хэмжээг үүнд үл оролцуулна;
 - (iv) Жижиглэн худалдаалах эмийн санч, зөвшөөрөл бүхий бусад жижиглэн худалдаа эрхлэгч, түүнчлэн эмчилгээний болон эрдэм шинжилгээний зохих ёсоор зөвшөөрөл аван чиг үүргээ хэрэгжүүлж буй мэргэшсэн этгээдүүдэд байгаа;
 - (v) “Тусгай нөөцийн” байдлаар байгаа.
- y) “Нутаг дэвсгэр” гэж 31 дүгээр зүйлд заасны дагуу импортын гэрчилгээ, экспортын зөвшөөрлийн тогтолцоог хэрэглэх зорилгоор тусгай нэгж гэж үзэж буй аль нэг улсын хэсгийг хэлнэ. Энэ тодорхойлолтыг 42, 46 дугаар зүйлд хэрэглэсэн “нутаг дэвсгэр” хэмээх нэр томъёонд хэрэглэхгүй.

2. Энэхүү конвенцийн зорилгоор мансууруулах эмийг аливаа этгээд буюу байгууллагад жижиглэн худалдаа, эмнэлгийн хэрэглээ буюу эрдэм шинжилгээний судалгааны зориулалтаар нийлүүлсэн бол түүнийг “хэрэглэгдсэн” гэж үзэх бөгөөд “хэрэглээ” гэдэг нэр томъёог ийнхүү ойлгоно.

2 дугаар зүйл

Хяналтад хамрагдах бодис

1. Тодорхой мансууруулах эмээр хязгаарласан хяналтын арга хэмжээнээс бусад тохиолдолд I жагсаалтад орсон мансууруулах эм нь энэхүү конвенцийн дагуу мансууруулах эмийн хувьд хэрэглэх хяналтын бүх арга хэмжээ, ялангуяа 4 дэх хэсгийн (с) дэд хэсэг, 19, 20, 21, 29, 30, 31, 32, 33, 34, 37 дугаар зүйлд заасан арга хэмжээнд хамрагдана.

2. II жагсаалтад заасан мансууруулах эм нь жижиглэн худалдаалах талаар 30 дугаар зүйлийн 2 болон 5 дахь хэсэгт заасан арга хэмжээнээс бусад I жагсаалтад орсон мансууруулах эмийн адил хяналтын арга хэмжээнд хамрагдана.

3. III жагсаалтад орсноос бусад бэлдмэл нь тэдгээрт орсон мансууруулах эмийн адил хяналтын арга хэмжээнд хамрагдах боловч эдгээр мансууруулах эмийн тооцоо, дүн бүртгэлээс ялгаатай тооцоо (19 дүгээр зүйл), дүн бүртгэл (20 дугаар зүйл)-ийн ийм бэлдмэлийн хувьд шаардахгүй бөгөөд 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн (с) дэд хэсэг, 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (b) (ii) дэд хэсгийг хэрэглэхгүй.

4. III жагсаалтад заасан бэлдмэлүүд нь II жагсаалтад орсон мансууруулах эм агуулсан бэлдмэлийн адил хяналтын арга хэмжээнд хамрагдана. Харин үүнд 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн (b) дэд хэсэг болон 3-15 дахь хэсэг, түүнчлэн тэдгээрийг олж авах болон жижиглэн худалдаалахын хувьд 34 дүгээр зүйлийн (b) хэсгийг хэрэглэх хэрэггүй бөгөөд шаардлагатай мэдээллийг ийм бэлдмэл бэлтгэхэд хэрэглэсэн мансууруулах эмийн хэмжээгээр тооцоо (19 дүгээр зүйл) болон дүн бүртгэл (20 дугаар зүйл)-ийн зорилгоор хязгаарлана.

5. IV жагсаалтад орсон мансууруулах эмийг I жагсаалтад мөн оруулж тэдгээрт I жагсаалтад орсон мансууруулах эмийн хувьд хэрэглэдгийн адил хяналтын бүх арга хэмжээнд хамруулах бөгөөд үүний зэрэгцээ:

а) Аль нэг тал тийнхүү оруулсан мансууруулах эмийн онцгой аюултай шинж чанарыг харгалзан шаардлагатай гэж үзэж байгаа хяналтын тусгай арга хэмжээгээ авна;

б) Аль нэг тал өөрийн оронд буй нөхцөл байдал олон нийтийн эрүүл мэнд, сайн сайхныг хамгаалах хамгийн тохиромжтой арга хэрэгслээр хангаж байгаа гэж үзвэл зөвхөн анагаах ухааны болон эрдэм шинжилгээний судалгаа, түүний дотор шаардлагатай байж болох хэмжээнээс бусад мансууруулах эмийг үйлдвэрлэх, бэлтгэх, экспортлох, импортлох, худалдаалах, эзэмших, эсхүл хэрэглэхийг хориглоно.

6. I жагсаалтад орсон бүх мансууруулах эмд хэрэглэх хяналтын арга хэмжээний зэрэгцээ опиум нь 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн (i) дэд хэсэг болон 21 bis, 23, 24 дүгээр зүйлийн заалт, кока навч нь 26, 27 дугаар зүйлийн заалт, каннабис нь 28 дугаар зүйлийн заалтад хамрагдана.

7. Опиумын намуу, кока бут, каннабисын ургамал, намууны сүрэл, каннабисын навч нь 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн (e) дэд хэсэг, 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (g) дэд хэсэг, 21 bis зүйл болон 22-24 дүгээр зүйл, 22, 26 болон 27 дугаар зүйл, 22 ба 28 дугаар зүйл, 25 дугаар зүйл, 28 дугаар зүйлд заасан хяналтын арга хэмжээнд тус тус хамрагдана.

8. Энэхүү конвенцид хамрагдаагүй боловч мансууруулах эм хууль бусаар бэлтгэхэд ашиглаж болох бодисын хувьд талууд амьдралд хэрэгжүүлэх боломжтой хяналтын арга хэмжээг хэрэглэх талаар бүхий л хүчин чармайлтаа гаргана.

9. Талууд анагаах ухааны болон эрдэм шинжилгээнээс бусад зорилгоор үйлдвэрт өргөн ашиглаж буй мансууруулах эмийн хувьд доор заасан нөхцөлд энэхүү конвенцийн заалтыг хэрэглэх шаардлагагүй:

а) Бүр мөсөн хувиргах зохистой арга буюу бусад арга хэрэглэн тийнхүү хэрэглэж буй мансууруулах эмийг урвуулан хэрэглэхгүй буюу хортой үр дагавар (3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг) үүсгэхэд хүргэхгүй бөгөөд амьдралд хорт бодис гаргаж авах боломжгүй байх явдлыг талууд хангасан байна, түүнчлэн;

б) Тийнхүү ашигласан мансууруулах эм бүрийн хэмжээг тэд дүн бүртгэлийн мэдээлэл (20 дугаар зүйл)-д мөн тусгана.

3 дугаар зүйл

Хяналт тавих хүрээнд дэх өөрчлөлт

1. Аль нэг тал буюу Дэлхийн эрүүл мэндийн байгууллагад түүний үзэж байгаагаар Жагсаалтуудын аль нэгэнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байж болох мэдээлэл байгаа бол Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэж, тухайн мэдэгдлийг батлах мэдээллийг хүргүүлнэ.

2. Ерөнхий нарийн бичгийн дарга тийм мэдэгдэл болон холбогдолтой гэж үзсэн аливаа мэдээллийг талууд болон комисст, түүнчлэн мэдэгдлийг аль нэг тал өгсөн тохиолдолд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагад дамжуулна.

3. Мэдэгдэл нь I жагсаал буюу II жагсаалтад ороогүй бодист хамааралтай бол:

(i) Талууд I жагсаалтад орсон мансууруулах эмийн хувьд хэрэглэдэг хяналтын арга хэмжээг тухайн эмийн хувьд түр хэрэглэх боломжийг байгаа мэдээллийн хүрээнд судална;

(ii) Энэ хэсгийн (iii) дахь дэд хэсэгт заасан шийдвэр гарах хүртэл I жагсаалтад орсон мансууруулах эмийн хувьд хэрэглэх хяналтын бүх арга хэмжээг тухайн бодисын хувьд талууд түр хэрэглэх тухай шийдвэрийг комисс гаргаж болно. Талууд ийм арга хэмжээг зөвхөн тухайн бодисын хувьд түр хэрэглэнэ.

(iii) Хэрэв Дэлхийн эрүүл мэндийн байгууллага тухайн бодис нь I ба II жагсаалтад орсон мансууруулах эмийн адил урвуулан хэрэглэх болон адил хортой үр дагавар үүсгэхэд хүргэнэ эсхүл мансууруулах бодис болгон хувиргаж болно гэж олж тогтоовол энэ тухай Комисст мэдэгдэх бөгөөд Комисс нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжид нийцүүлэн уг бодисыг I жагсаалт буюу II жагсаалтад нэмэхээр шийдвэрлэж болно.

4. Хэрэв аль нэг бэлдмэлд агуулагдсан бодисоос шалтгаалан түүнийг урвуулан хэрэглэх болон хортой үр дагаварт хүргэх боломжгүй (3 дахь хэсэг), түүнчлэн түүнд байгаа мансууруулах эм хялбар аргаар гаргах боломжгүй гэж Дэлхийн эрүүл мэндийн

байгууллага олж тогтоовол Комисс Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжид нийцүүлэн уг бэлдмэлийг III жагсаалтад нэмж болно.

5. I жагсаалтад орсон аль нэг мансууруулах эм нь түүнийг урвуулан хэрэглэх, хортой үр дагаварт онцгой хүргэнэ (3 дахь хэсэг) бөгөөд энэ байдал нь IV жагсаалтад орсон мансууруулах эмээс өөр бодист байхгүй эмчилгээний үлэмж давуу талаар орлогдохгүй гэж Дэлхийн эрүүл мэндийн байгууллага олж тогтоовол Комисс нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжөөр тухайн мансууруулах эмийг IV жагсаалтад оруулна.

6. I жагсаалт буюу II жагсаалтад орсон мансууруулах эм буюу III жагсаалтад орсон бэлдмэлд хамаарах бол Комисс нь 5 дахь хэсэгт заасан арга хэмжээнээс гадна Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжид нийцүүлэн Жагсаалтуудын аль нэгд дараахь замаар нэмэлт, өөрчлөлт оруулж болно:

а) Мансууруулах эмийг I жагсаалтаас II жагсаалтад шилжүүлэх буюу II жагсаалтаас I жагсаалтад шилжүүлэх; эсхүл

б) Тухайн тохиолдлоос хамааран мансууруулах эм буюу бэлдмэлийг Жагсаалтаас хасах.

7. Энэ зүйлийн дагуу гаргасан Комиссын шийдвэрийг Ерөнхий нарийн бичгийн дарга Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн бүх улс, гишүүн бус энэхүү конвенцийн оролцогч улс, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон Хороонд мэдэгдэнэ. Уг шийдвэр нь тал бүрийн хувьд тийм мэдэгдэл хүлээн авсан өдөр хүчин төгөлдөр болж, талууд энэхүү конвенцийн дагуу шаардагдаж болох авах арга хэмжээг авна.

8. а) Жагсаалтуудын аль нэгд нэмэлт, өөрчлөлт оруулж буй Комиссын шийдвэрийг тухайн шийдвэрийн талаархи мэдэгдлийг хүлээн авснаас хойш ерэн хоногийн дотор гаргасан аль нэг талын хүсэлтээр хянан үзнэ. Хянан үзэх хүсэлтийг түүний үндэслэл болох холбогдох бүх мэдээллийн хамт Ерөнхий нарийн бичгийн даргад илгээнэ.

б) Ерөнхий нарийн бичгийн дарга хянан үзэх тухай хүсэлтийн хуулбар болон холбогдох мэдээллийг Комисс, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон бүх талд дамжуулж саналаа ерэн хоногийн дотор өгөхийг санал болгоно. Хүлээн авсан бүх саналыг хэлэлцүүлэхээр Зөвлөлд өгнө.

с) Зөвлөл нь Комиссын шийдвэрийг баталж, өөрчилж эсхүл цуцалж болох бөгөөд Зөвлөлийн шийдвэр эцсийн байна. Зөвлөлийн шийдвэрийн тухай мэдэгдлийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн бүх улс, гишүүн бус энэхүү конвенцийн оролцогч улсууд, Комисс, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон Хороонд дамжуулна.

д) Хянан үзэх хүртэл Комиссын анхны шийдвэр хүчин төгөлдөр хэвээр байна.

9. Энэ зүйлд нийцүүлэн гаргасан Комиссын шийдвэр 7 дугаар зүйлд заасан хянан үзэх ажиллагаанд хамрагдахгүй.

4 дүгээр зүйл

Ерөнхий үүрэг

Талууд дараахь зорилгоор шаардлагатай байж болох дараахь хууль тогтоох болон захиргааны арга хэмжээ авна:

а) Энэхүү конвенцийн заалтыг өөрийн нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр болгож, хэрэгжүүлэх;

б) Энэхүү конвенцийн заалтыг гүйцэтгэхэд бусад улстай хамтран ажиллах; буюу

с) Энэхүү конвенцийн заалтыг мөрдөхийн хамт мансууруулах эм үйлдвэрлэх, бэлтгэх, экспортлох, импортлох, түгээх, худалдаалах, ашиглах болон эзэмшихийг гагцхүү анагаах ухааны болон эрдэм шинжилгээний зорилгоор хязгаарлах.

5 дугаар зүйл

Олон улсын хяналтын байгууллага

Талууд мансууруулах эмийн олон улсын хяналт тавих талаархи Нэгдсэн Үндэстний Байгууллагын эрх хэмжээг хүлээн зөвшөөрч энэхүү конвенцоор тус тус олгосон чиг үүргийг Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн Мансууруулах эмд хяналт тавих олон улсын хороонд хариуцуулахыг зөвшөөрч байна.

6 дугаар зүйл

Олон улсын хяналтын байгууллагын зардал

Комисс болон Хорооноос гарах зардлыг Ерөнхий Ассамблейгаас шийдвэрлэсэн байдлаар Нэгдсэн Үндэстний Байгууллага хариуцна. Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн бус талууд Ерөнхий Ассамблейгаас шударга гэж үзэж, тэдгээр талын засгийн газруудтай тухай бүр зөвлөлдөн үнэлж байх хэмжээгээр эдгээр зардалд хувь нэмэр оруулна.

7 дугаар зүйл

Комиссын шийдвэр болон зөвлөмжийг хянан үзэх

Энэхүү конвенцийн заалтын дагуу Комиссоос 3 дугаар зүйлийн дагуу гаргасан шийдвэрээс бусад шийдвэр буюу зөвлөмж бүрийг Комиссын бусад шийдвэр буюу зөвлөмжийн адилаар Зөвлөл буюу Ерөнхий Ассамблейгаар батлах буюу өөрчилнө.

8 дугаар зүйл

Комиссын чиг үүрэг

Комисс нь энэхүү конвенцийн зорилгод хамаарах бүх асуудлыг авч үзэх бүрэн эрхтэй, тухайлбал:

а) 3 дугаар зүйлд нийцүүлэн Жагсаалтуудад өөрчлөлт оруулах;

b) Хорооны чиг үүрэгт холбогдож болох аливаа асуудалд Хорооны анхаарлыг хандуулах;

c) Эрдэм шинжилгээний судалгааны хөтөлбөр, түүнчлэн шинжлэх ухаан буюу техникийн чанартай мэдээлэл солилцохыг оролцуулан энэхүү конвенцийн зорилго, заалтыг хэрэгжүүлэх талаар зөвлөмж гаргах;

d) Энэхүү конвенцийн дагуу өөрийн гаргасан шийдвэр, зөвлөмжид нийцүүлэн арга хэмжээ авах асуудлыг авч хэрэгжүүлэх зорилгоор тал бус улсын анхаарлыг тэдгээрт хандуулна.

9 дүгээр зүйл

Хорооны бүрэлдэхүүн болон чиг үүрэг

1. Хороо нь дараахь байдлаар Зөвлөлөөс сонгох арван гурван гишүүнээс бүрдэнэ:

a) Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас нэр дэвшүүлсэн наад зах нь таван хүний жагсаалтаас анагаах ухаан, эм зүй, эм судлалын туршлагатай гурван гишүүн;

b) Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн бус талуудын нэр дэвшүүлсэн хүний жагсаалтаас арван гишүүн.

2. Хорооны гишүүд нь өөрийн мэдлэг чадвар, хараат бус, өрөөсгөлгүй байдлаараа бүх нийтийн итгэл хүлээх хүмүүс байна. Тэдгээр нь алба хаших хугацаандаа чиг үүргээ хараат бусаар хэрэгжүүлэхэд нөлөөлж болох ямарваа албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах ёсгүй. Зөвлөл нь Хороотой зөвлөлдөж Хороо чиг үүргээ гүйцэтгэхдээ техникийн хувьд бүрэн хараат бус байлгахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авна.

3. Зөвлөл нь газар зүйн шударга төлөөллийн зарчмыг зохих ёсоор сахиж, Хорооны бүрэлдэхүүнд мансууруулах эм үйлдвэрлэдэг, бэлтгэдэг болон хэрэглэдэг орнууд дахь мансууруулах эмийн байдлын талаархи мэдлэг бүхий, тийм орнуудтай холбоотой хүнийг тооны шударга харьцаагаар оруулахын чухлыг анхаарна.

4. Хороо нь мансууруулах эм тарималжуулах, үйлдвэрлэх, бэлтгэх болон ашиглахыг анагаах ухааны болон эрдэм шинжилгээний зорилгоор шаардлагатай хангалттай хэмжээнд хязгаарлах, ийм зорилгод мансууруулах эм байлгах явдлыг хангах, мансууруулах эм хууль бусаар тарималжуулах, үйлдвэрлэх, бэлтгэх, хууль бус эргэлтэд оруулах, ашиглахаас урьдчилан сэргийлэхийг засгийн газруудтай хамтран энэхүү конвенцийн нөхцөлийг мөрдөхийн хамт эрмэлзэнэ.

5. Энэхүү конвенцийн дагуу Хорооноос авч буй бүх арга хэмжээ нь засгийн газрууд Хороотой хамтран ажиллахыг хөгжүүлэх, энэхүү конвенцийн зорилгод хүрэхэд чиглэсэн үндэстний үр дүнтэй арга хэмжээг авч явуулахад тус дөхөм, түлхэц болохуйцаар засгийн газрууд болон Хорооны хооронд яриа хэлэлцээг үргэлжлүүлэн явуулж байх механизмыг хангах зорилготой хамгийн нийцсэн арга хэмжээ байна.

10 дугаар зүйл

Хорооны гишүүдийн алба хаших хугацаа болон урамшуулал

1. Хорооны гишүүд нь энэ албан тушаалыг таван жилийн хугацаатай хаших бөгөөд дахин сонгогдож болно.
2. Хорооны гишүүн бүрийн алба хаших хугацаа нь түүний оронд сонгогдсон гишүүн оролцох эрхтэй Хорооны анхдугаар хуралдаан дуусахад дуусна.
3. Дараалсан гурван чуулганд оролцоогүй Хорооны гишүүнийг огцорсонд тооцно.
4. Зөвлөл нь 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт гишүүнчлэлийн талаар шаардлагатай нөхцлийг хангаж чадахаа больсон хорооны гишүүнийг Хорооны зөвлөмжийн дагуу албан тушаалаас нь чөлөөлж болно. Ийм зөвлөмжийг Хорооны өсөн гишүүн саналаа өгч үйлдэнэ.
5. Хэрэв аль нэг гишүүний алба хаших хугацаанд Хороонд гишүүний орон тоо гарвал Зөвлөл орон тоонд аль болох богино хугацаанд 9 дүгээр зүйлийн заалтын дагуу үлдэж байгаа хугацаанд өөр гишүүн сонгоно.
6. Хорооны гишүүд Ерөнхий Ассамблейгаас тогтоосон зохих урамшуулал авна.

11 дүгээр зүйл

Хорооны ажиллах горим

1. Хороо нь өөрийн дарга болон шаардлагатай гэж үзэж болох бусад албан тушаалтанг сонгож, ажиллах горимоо батлана.
2. Хороо нь чиг үүргээ зохих ёсоор биелүүлэхэд шаардлагатай гэж үзэх аль болох тогтмол хуралдах боловч хуанлийн жил бүр хоёроос доошгүй удаа чуулна.
3. Хорооны хуралд шаардлагатай ирцийг найман гишүүн бүрдүүлнэ.

12 дугаар зүйл

Тооцооллын систем хэрэглэх

1. Хороо нь 19 дүгээр зүйлд заасны дагуу тооцоо гаргаж өгсөн байх хугацаа, гаргах журмыг тогтоож, энэ зорилгоор маягт тогтооно.
2. Энэхүү конвенцийг үл хэрэглэх улс болон нутаг дэвсгэрийн хувьд энэхүү конвенцийн заалтын дагуу тооцоо гаргаж өгөхийг сонирхогч засгийн газраас Хороо хүснэ.
3. Хэрэв аливаа улс тогтоосон хугацаанд аль нэг нутаг дэвсгэрийнхээ хувьд тооцоо гаргаж өгөхгүй бол Хороо тооцоог бололцооны хэмжээнд гаргана. Ийм тооцоо гаргахдаа Хороо нь сонирхогч засгийн газартай боломжийн хэмжээнд хамтран ажиллана.

4. Хороо нь тооцоо, түүний дотор нэмэлт тооцоог шалган үзэх бөгөөд тусгай зорилгоор шаардагдахаас бусад тохиолдолд нэрийн нь өмнөөс тооцоо ирсэн аливаа улс буюу нутаг дэвсгэрийн хувьд шаардлагатай гэж үзсэн мэдээллийг тооцоо дуусгах, эсхүл түүнд байгаа аливаа мэдэгдлийг тайлбарлахын тулд шаардаж болно.

5. Хороо нь мансууруулах эмийн ашиглалт, түгээлтийг анагаах ухааны болон эрдэм шинжилгээний зорилгод шаардлагатай хангалттай хэмжээгээр хязгаарлах, эсхүл ийм зорилгоор тэдгээрийг хангах үүднээс засгийн газар болон Хорооны хооронд санал зөрсөн тохиолдолд Хороо нь өөрийн тооцоо, түүний дотор нэмэлт тооцоог гаргах, мэдэгдэх, нийтлэх эрхтэй байна.

6. 15 дугаар зүйлд заасан илтгэлийн зэрэгцээ Хороо нь тогтоосон хугацаандаа, гэхдээ наад зах нь жил бүр тооцоотой холбогдсон түүний үзэж байгаагаар энэхүү конвенцийн биелэлтийг хөнгөвчлөх мэдээллийг гаргана.

13 дугаар зүйл

Дүн бүртгэлийн мэдээний тогтолцоог хэрэглэх

1. Хороо нь 20 дугаар зүйлийн дагуу дүн бүртгэлийн мэдээ гаргаж өгөх арга, хэлбэрийг тогтоож энэ зорилгоор маягт боловсруулна.

2. Хороо нь аль нэг тал, эсхүл аливаа өөр улс нь энэхүү конвенцийн заалтыг баримталсан эсэхийг тогтоох үүднээс уг мэдээг шалгаж үзнэ.

3. Хороо нь дүн бүртгэлийн мэдээнд байгаа мэдээллийг баяжуулах, эсхүл тайлбарлахад шаардлагатай гэж үзсэн нэмэлт мэдээллийг шаардаж болно.

4. Тусгай зорилгоор шаардагдах мансууруулах эмтэй холбоотой дүн бүртгэлийн мэдээний талаар асуулт асуух буюу санал илэрхийлэх нь Хорооны эрх хэмжээнд үл хамаарна.

14 дүгээр зүйл

Конвенцийн заалтыг гүйцэтгэлийг хангах талаар Хорооноос авах арга хэмжээ

1. а) Хэрэв энэхүү конвенцийн заалтын дагуу засгийн газрууд Хороонд ирүүлсэн мэдээлэл, эсхүл Нэгдсэн Үндэстний Байгууллагын алба буюу төрөлжсөн байгууллага, эсхүл Хорооны зөвлөмжийн дагуу Комиссоос батласан бэл тухайн үндсэн асуудлын хувьд шууд эрх хэмжээтэй бөгөөд Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн 71 дүгээр зүйлийн дагуу Эдийн засаг, нийгмийн зөвлөлтэй зөвлөлдөх эрх бүхий засгийн газар хоорондын бусад байгууллага буюу засгийн газрын бус олон улсын байгууллагаас өгсөн мэдээллийг хянасны үндсэн дээр Хороо нь аливаа нэг тал, орон буюу нутаг дэвсгэр, энэхүү конвенцийн заалтыг биелүүлээгүйгээс шалтгаалан энэхүү конвенцийн зорилгыг хэрэгжүүлэхэд ноцтой аюул учирч байна гэж итгэх бодит шалтгаан Хороонд байвал Хороо нь сонирхогч засгийн газарт зөвлөлдөөн эхлэх санал тавих буюу тайлбар гаргахыг хүсэх эрхтэй байна. Хэрэв энэхүү конвенцийн заалтыг хэрэгжүүлж байгаа аливаа тал, эсхүл орон буюу нутаг дэвсгэрт мансууруулах эм хууль бусаар тарималжуулах, үйлдвэрлэх буюу бэлтгэх, эсхүл эргэлтэд оруулах буюу хэрэглэх чухал төв болсон буюу болж болох ноцтой эрсдэл байгаа тухай нотолгоо байвал Хороо сонирхогч засгийн газарт зөвлөлдөөн эхлэхийг санал болгох эрхтэй байна. Талууд,

Зөвлөл, Комиссын анхаарлыг дор (d) дэд хэсэгт дурдсан асуудалд хандуулах Хорооны эрхийг хэрэгжүүлэхийн хамт Хороо нь тухайн засгийн газрын мэдээлэл авах хүсэлт, тайлбар, эсхүл зөвлөлдөх тухай санал буюу энэ дэд хэсгийн дагуу Засгийн газартай хийж байгаа зөвлөлдөөнийг нууц гэж үзнэ.

б) Дээрх (а) дэд хэсгийн дагуу арга хэмжээ авсны дараа Хороо нь хэрэв шаардлагатай гэж үзвэл энэхүү конвенцийн заалтыг тухайн нөхцөл байдалд гүйцэтгэхэд шаардлагатай байж болох арга хэмжээ авахыг сонирхогч засгийн газарт уриална.

с) Хороо нь хэрэв энэ хэсгийн (а) дэд хэсэгт заасан асуудлуудыг үнэлэх зорилгоор тийм арга хэмжээ авах шаардлагатай гэж үзвэл сонирхогч засгийн газарт уг асуудлын судалгааг өөрийн нутаг дэвсгэрт засгийн газрын тохиромжтой гэж үзсэн арга хэрэгслээр явуулахыг санал болгож болно. Хэрэв сонирхогч засгийн газар энэ судалгааг явуулахаар шийдвэрлэвэл тэрээр Хорооноос судалгаа явуулахад тухайн засгийн газарт туслалцаа үзүүлэхэд шаардлагатай нэг буюу түүнээс олон эрх бүхий этгээдээс дүн шинжилгээ хийлгэх, нарийн мэргэшлийн үйлчилгээ үзүүлэхийг хүсэж болно. Хорооноос явуулах тухайн этгээд буюу этгээдүүдийг тухайн засгийн газраас сайшаан зөвшөөрсөн байвал зохино. Судалгаа явуулах нөхцөл, судалгаа дуусгах хугацааг засгийн газар болон Хороо хоорондоо зөвлөлдөж болно. Засгийн газар судалгааны үр дүнгийн талаар Хороонд мэдэгдэж, авах шаардлагатай гэж үзсэн засах арга хэмжээг заана.

д) Хэрэв сонирхогч засгийн газар дээрх (а) дэд хэсгийн дагуу уриалга авсан боловч хангалттай тайлбар өгөөгүй, эсхүл дээрх (b) дэд хэсгийн дагуу уриалга авсан боловч үүнийг засах арга хэмжээг аваагүй, эсхүл олон улсын хэмжээнд хамтран ажиллах шаардлага бүхий ноцтой байдал байна гэж олж тогтоовол уг асуудалд талуудын, Зөвлөлийн болон Комиссын анхаарлыг Хороо хандуулж болно. Энэхүү конвенцийн зорилгыг хэрэгжүүлэхэд ноцтой аюул учрахаар байгаа, эсхүл уг асуудлыг аливаа өөр замаар хангалттай шийдвэрлэх боломжгүй болсон бол Хороо ийнхүү ажиллана. Хороо нь тухайн ноцтой байдлыг засахад олон улсын хэмжээнд хамтран ажиллах шаардлагатай ноцтой байдал бий болсон бөгөөд түүний талаар талууд, Зөвлөл болон Комисст мэдэгдэх нь ийм хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд дөхөм үзүүлэх хамгийн тохиромжтой арга гэж олж тогтоовол мөн ийнхүү ажиллана; Хороо тухайн асуудлаархи Комиссын илтгэлийг авч үзсэний дараа Зөвлөл нь энэ асуудалд Ерөнхий Ассамблейн анхаарлыг хандуулж болно.

2. Хороо нь талууд, Зөвлөл болон Комиссын анхаарлыг дээрх 1 дэх хэсгийн (d) дэд хэсгийн дагуу аливаа асуудалд хандуулахдаа хэрэв энэ нь шаардлагатай гэж үзвэл мансууруулах эмийг тухайн орон буюу нутаг дэвсгэрт, эсхүл орон буюу нутаг дэвсгэрээс импортлох, экспортлох, эсхүл аль алиныг нь заасан хугацаанд, эсхүл тухайн орон буюу нутаг дэвсгэр дэх байдлыг хангалттай сайжирсан гэж Хороог үзэх хүртэл зогсоохыг талуудад зөвлөмж болгож болно. Сонирхогч улс уг асуудлыг Зөвлөлд толилуулж болно.

3. Хороо нь энэ зүйлийн дагуу авч үзсэн аливаа асуудлаар илтгэл нийтлүүлж Зөвлөлд өгөх эрхтэй бөгөөд Зөвлөл илтгэлийг бүх талд дамжуулна. Хэрэв Хороо нь энэ зүйлийн дагуу гаргасан шийдвэр, эсхүл түүнд хамаарах аливаа мэдээллийг энэ илтгэлд нийтэлж байгаа бөгөөд сонирхогч засгийн газар хүсвэл тухайн засгийн газрын үзэл бодлыг мөн нийтэлнэ.

4. Хэрэв энэ зүйлийн дагуу нийтэлсэн Хорооны шийдвэрийг аливаа тохиолдолд санал нэгтгэйгээр гаргаагүй бол цөөнхийн үзэл бодлыг тусгана.

5. Тухайн улсад шууд хамааралтай асуудлыг энэ зүйлийн дагуу хэлэлцэж Хорооны хуралдаанд аливаа улсыг төлөөлөгчөө илгээхээр урьж болно.

6. Энэ зүйлийн дагуу Хорооны гаргах шийдвэрийг Хорооны нийт гишүүдийн тооны олонхи болох гуравны хоёрын саналаар гаргана.

14 bis зүйл

Техникийн болон санхүүгийн тусламж

Хороо нь зохистой гэж үзсэн тохиолдолд 14 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан арга хэмжээнд нэмэлт болгон буюу түүний оронд нь сонирхогч засгийн газрын зөвшөөрснөөр тухайн газраас энэхүү конвенцоор хүлээсэн үүргээ, түүний дотор 2, 35, 38 болон 38 bis зүйлд заасан буюу дурдсан үүргийг биелүүлэхэд чиглэсэн хүчин чармайлтыг дэмжихийн тулд уг засгийн газарт техникийн, эсхүл санхүүгийн тусламж, эсхүл аль аль тусламжийг үзүүлэх талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын эрх бүхий байгууллага болон төрөлжсөн байгууллагад зөвлөмж болгож болно.

15 дугаар зүйл

Хорооны илтгэл

1. Хороо нь мөн өөрийн мэдэлд байгаа тооцоо болон дүн бүртгэлийн мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ, зохих тохиолдолд засгийн газруудаас өгсөн, эсхүл шаардсан тайлбар байвал тийм тайлбар бүхий өөрийн ажлын жил бүрийн илтгэл, түүнчлэн шаардлагатай гэж үзсэн нэмэлт илтгэлийг Хорооноос хүссэн аливаа тэмдэглэл, зөвлөмжийн хамт бэлтгэнэ. Эдгээр илтгэлийг Комиссоор дамжуулан Зөвлөлд өргөн барих бөгөөд Комисс нь тохиромжтой гэж үзсэн тэмдэглэлийг хийж болно.

2. Эдгээр илтгэлийг талуудад тарааж, дараа нь Ерөнхий нарийн бичгийн дарга нийтлүүлнэ. Талууд илтгэлийг үл хязгаарлагдсан байдлаар тараахыг зөвшөөрнө.

16 дугаар зүйл

Нарийн бичгийн дарга нарын газар

Комисс болон Хорооны нарийн бичгийн дарга нарын албаны ажлыг Ерөнхий нарийн бичгийн дарга хариуцна. Тухайлбал, Хорооны нарийн бичгийн даргыг Хороотой зөвлөлдөж Ерөнхий нарийн бичгийн дарга томилно.

17 дугаар зүйл

Захиргааны тусгай нэгж

Энэхүү конвенцийн заалтыг хэрэглэх зорилгоор талууд захиргааны тусгай нэгж ажиллуулна.

18 дугаар зүйл

Талуудаас Ерөнхий нарийн бичгийн даргад өгөх мэдээлэл

1. Талууд өөрийн чиг үүргээ биелүүлэхэд шаардлагатай гэж Комиссоос хүсэж болох дараахь мэдээллийг Ерөнхий нарийн бичгийн даргад өгнө, тухайлбал:

- a) Конвенц нутаг дэвсгэр бүрт хэрэгжиж байгаа тухай жил бүрийн илтгэл;
- b) Энэхүү конвенцийг биелүүлэх талаар тухай бүр гарсан бүх хууль, журмын эх бичвэр;
- c) Хууль бус эргэлтийн тохиолдлын талаар Комиссоос тогтоох мэдээ баримт, түүний дотор хууль бус эргэлтэд оруулахаар мансууруулах эмийг олж авсан эх сурвалжийг зааж байгаа, эсхүл мансууруулах эмийн хэмжээ буюу хууль бус эргэлтэд оруулагчдын хэрэглэж байгаа аргаас шалтгаалан хууль бус эргэлтийн чухал байж болох тохиолдол бүрийн талаарх мэдээ баримт;
- d) Экспорт болон импортын зөвшөөрөл буюу гэрчилгээ олгох эрх бүхий засгийн газрын байгууллагын нэр, хаягийг өгнө.

2. Талууд дээрх дурдсан мэдээллийг Комиссоос хүсэж болох хэлбэр, хугацаанд өгч, Комиссоос хүсэлт болгосон маягтыг хэрэглэнэ.

19 дүгээр зүйл

Мансууруулах эмийн шаардлагыг тооцоолох

1. Талууд өөрийн нутаг дэвсгэр бүрийн хувьд Хорооноос тогтоосон арга, хэлбэрээр түүнээс ирүүлсэн маягтаар дараахь асуудлаар тооцоо гаргаж Хороонд өгнө:

- a) Анагаах ухааны болон эрдэм шинжилгээний зорилгоор хэрэглэсэн мансууруулах эмийн хэмжээ;
- b) Бусад мансууруулах эм, III жагсаалтад орсон бэлдмэл болон энэхүү конвенцид хамрагдаагүй бодис бэлтгэхэд ашигласан мансууруулах эмийн хэмжээ;
- c) Тухайн тооцооны хамаарч байгаа жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх мансууруулах эмийн нөөц;
- d) Тусгай нөөцийг сэлбэхэд шаардлагатай мансууруулах эмийн хэмжээ;
- e) Опиумын намуу тарималжуулахад ашиглаж буй газрын талбай (гектараар) болон газар зүйн байрлал;
- f) Үйлдвэрлэх опиумын барагцаалсан хэмжээ;
- g) Нийлэг мансууруулах эм бэлтгэх үйлдвэрийн газрын тоо;
- h) Өмнөх дэд хэсэгт дурдсан үйлдвэрийн газар бүрийн бэлтгэх нийлэг мансууруулах эмийн хэмжээ.

2. а) 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт дурдсанаар хасалт хийхийн хамт, нутаг дэвсгэр бүрийн опиум болон нийлэг мансууруулах бодисоос бусад мансууруулах эм бүрийн тооцооны нийт дүн нь энэ зүйлийн 1 дэх хэсгийн (а), (b), (d) дэд хэсгийн дагуу заасан хэмжээний нийлбэр дүн дээр өмнөх оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх бодит нөөцийг 1 дэх хэсгийн (с) дэд хэсгийн дагуу тооцоолсон хэмжээнд хүргэхэд шаардлагатай аливаа хэмжээг нэмснээс бүрдэнэ.

б) 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт дурдсанаар импортын талаар 21 bis зүйлийн 2 дахь хэсэгт дурдсанаар хасалт хийхийн хамт, нутаг дэвсгэр бүрийн опиумын тооцооны нийт дүн нь энэ зүйлийн 1 дэх хэсгийн (а), (b) болон (d) дэд хэсгийн дагуу заасан хэмжээний нийлбэр дээр өмнөх оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх бодит нөөцийг 1 дэх хэсгийн (с) дэд хэсгийн дагуу заасан хэмжээ хоёрын аль илүүг нь нэмснээс бүрдэнэ.

с) 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт дурдсанаар хасалт хийхийн хамт, нутаг дэвсгэр бүрийн нийлэг мансууруулах эмийн тооцооны нийт дүн нь энэ зүйлийн 1 дэх хэсгийн (а), (b) болон (d) дэд хэсэгт заасан нийлбэр дээр өмнөх оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх бодит нөөцийг 1 дэх хэсгийн (с) дэд хэсэгт заасны дагуу тооцоолсон хэмжээнд хүргэхэд шаардлагатай аливаа хэмжээ болон энэ зүйлийн 1 дэх хэсгийн (h) дэд хэсгийн дагуу заасан хэмжээ хоёрын аль илүүг нь нэмснээс бүрдэнэ.

д) Түр хурааж хууль ёсоор ашиглахаар чөлөөлсөн аливаа хэмжээ, түүнчлэн тусгай нөөцөөс иргэдийн хэрэгцээг хангахаар авсан аливаа хэмжээг харгалзан энэ хэсгийн өмнөх дэд хэсгүүдийн дагуу өгсөн тооцоог зохих ёсоор өөрчилнө.

3. Аливаа улс жилийн туршид нэмэлт тооцоог түүнийг гаргах шаардлагыг нөхцөлдүүлсэн байдлын тайлбарын хамт өгч болно.

4. Талууд тооцоонд заасан хэмжээг тодорхойлоход хэрэглэдэг арга, уг аргад гарсан аливаа өөрчлөлтийг Хороонд мэдэгдэнэ.

5. 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт дурдсанаар хасалт хийхийн хамт, 21 bis зүйлийн заалтыг зохимжтой үед харгалзан тооцоо нь хэмжээ хэтэрсэн байж үл болно.

20 дугаар зүйл

Хороонд өгөх дүн бүртгэлийн мэдээ

1. Талууд өөрийн нутаг дэвсгэр бүрийн хувьд Хорооноос тогтоосон арга, хэлбэрээр түүнээс ирүүлсэн маягтаар дараахь асуудлаар дүн бүртгэлийн мэдээ гаргаж Хороонд өгнө:

а) Мансууруулах эм үйлдвэрлэх буюу бэлтгэх;

б) Бусад мансууруулах эм, III жагсаалтад орсон бэлдмэл, энэхүү конвенцид хамрагдаагүй бодис бэлтгэхэд мансууруулах эм ашиглах, түүнчлэн мансууруулах эм бэлтгэхэд намууны сүрэл ашиглах;

с) Мансууруулах эм хэрэглэх;

д) Мансууруулах эм болон намууны сүрэл импортлох болон экспортлох;

- e) Мансууруулах эмийг түр хураах болон захиран зарцуулах;
- f) Тухайн мэдээ хамаарах оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар байгаа мансууруулах эмийн нөөц;
- g) Опиумын намуу тарималжуулахад зориулан тогтоож тодорхойлж болох талбай.

2. а) 1 дэх хэсгийн (d) дэд хэсгээс бусад 1 дэх хэсэгт дурдсан асуудлын талаархи дүн бүртгэлийн мэдээг жил бүр бэлтгэж, тухайн мэдээний хамаарах оны дараахь оны 6 дугаар сарын 30-аас оройтуулахгүйгээр Хороонд хүргүүлнэ.

б) 1 дэх хэсгийн (d) дэд хэсэгт дурдсан асуудлын талаархи дүн бүртгэлийн мэдээг улирал бүр бэлтгэж, тухайн мэдээний хамаарах улирал дуссанаас хойш нэг сарын дотор Хороонд хүргүүлнэ.

3. Тусгай нөөцийн талаар дүн бүртгэлийн мэдээ гаргаж өгөхийг талуудаас шаардахгүй боловч тусгай зорилгоор тухайн орон буюу нутаг дэвсгэрт импортлосон, эсхүл олж авсан мансууруулах эмийн талаар, түүнчлэн иргэдийн хэрэгцээг хангахаар тусгай нөөцөөс авсан мансууруулах эмийн хэмжээний талаархи мэдээг тус тусад нь хүргүүлнэ.

21 дүгээр зүйл

Бэлтгэх болон импортлохыг хязгаарлах

1. Аливаа орон буюу нутаг дэвсгэрийн нэг жилд бэлтгэсэн болон импортлосон мансууруулах эм бүрийн нийт хэмжээ нь дараахь хэмжээний нийлбэр дүнгээс хэтэрч үл болно:

а) Анагаах ухааны болон эрдэм шинжилгээний зорилгоор холбогдох тооцооны хүрээнд хэрэглэсэн хэмжээ;

б) Бусад мансууруулах эм, III жагсаалтад орсон бэлдмэл болон энэхүү конвенцид хамрагдаагүй бодис бэлтгэхээр холбогдох тооцооны хүрээнд ашигласан хэмжээ;

с) Экспортлосон хэмжээ;

д) Уг нөөцийг холбогдох тооцоонд заасан түвшинд хүргэхээр түүнд нэмсэн хэмжээ; болон

е) Тусгай зорилгоор холбогдох тооцооны хүрээнд олж авсан хэмжээ.

2. Түр хурааж хууль ёсоор ашиглахаар чөлөөлсөн аливаа хэмжээ, түүнчлэн тусгай нөөцөөс иргэдийн хэрэгцээнд зориулан авсан аливаа хэмжээг 1 дэх хэсэгт заасан хэмжээний нийлбэр дүнгээс хасна.

3. Аливаа нэг жилд бэлтгэсэн болон импортлосон хэмжээ 1 дэх хэсэгт заасан хэмжээний энэ зүйлийн 2 дахь хэсгийн дагуу шаардлагатай хасалтыг хийсэн нийлбэр дүнгээс илүү болохыг болохыг Хороо олж тогтоовол бэлтгэх буюу импортлох хэмжээ болон 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт тодорхойлсон тооцооны нийт дүнгээс тийнхүү тогтоосон болон оны эцэст үлдэж буй илүү хэмжээг дараагийн онд хасна.

4. а) Аливаа орон буюу нутаг дэвсгэрт экспортлосон хэмжээ 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт тодорхойлсон тухайн орон буюу нутаг дэвсгэрийн тооцооны нийт дүн дээр экспортлосон гэж заасан хэмжээг нэмж, энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу тогтоосон аливаа илүү хэмжээг хассаны дараа уг нийт дүнгээс хэтэрч буй нь импорт буюу экспортын дүн бүртгэлийн мэдээнээс (20 дугаар зүйл) харагдаж байвал Хороо нь түүний үзэж байгаагаар энэ тухай мэдэх нь зүйтэй гэсэн улсуудад мэдэгдэж болно.

б) Ийм мэдэгдэл хүлээн авсан талууд дор дурдсанаас бусад тохиолдолд тухайн жилд тухай орон буюу нутаг дэвсгэрт тухайн мансууруулах эмийг цаашид экспортлохыг зөвшөөрөхгүй:

(i) Тухайн орон, нутаг дэвсгэрийн хувьд хэтрүүлж импортлосон болон нэмэлт шаардлагатай хэмжээний талаар нэмэлт тооцоо өгч буй тохиолдол; эсхүл

(ii) Тухайн экспортлогч орны засгийн газрын үзэж байгаагаар экспорт нь өвчтөнг эмчлэхэд зайлшгүй шаардлагатай онцгой тохиолдол.

21 bis зүйл

Опиум үйлдвэрлэхийг хязгаарлах

1. Аливаа орон буюу нутаг дэвсгэр дэх опиумын үйлдвэрлэх аливаа нэг жилд үйлдвэрлэсэн хэмжээ 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн (f) дэд хэсгийн дагуу тогтоосноор үйлдвэрлэх опиумын тооцооноос хэтрэхгүй байх явдлыг аль болох хангахаар зохион байгуулж хянана.

2. Хэрэв энэхүү конвенцийн заалтад нийцүүлэн өөрийн мэдэлд байгаа мэдээлэлд үндэслэн Хороо нь 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн (f) дэд хэсгийн дагуу тооцоо гаргаж өгсөн тал холбогдох тооцоод нийцүүлэн өөрийн хил хязгаарын хүрээнд хууль ёсны зорилгоор үйлдвэрлэсэн опиумыг хязгаарлаагүй бөгөөд хууль ёсны буюу хууль бусаас үл хамааран тухайн талын хил хязгаарын хүрээнд үйлдвэрлэсэн үлэмж хэмжээний опиум нь хууль бус эргэлтэд орсон гэж олж тогтоовол ийнхүү олж тогтоосныг мэдэгдсэний дараа нэг сарын дотор холбогдох талын өгсөн тайлбарыг судалсны дараа ийм хэмжээг бүхэлд нь, эсхүл хэсгийг нь үйлдвэрлэх тоо хэмжээнээс, түүнчлэн жилийн улирал болон опиум экспортлох гэрээг үүргийг харгалзан ийм хасалтыг техникийн хувьд гүйцэтгэх боломжтой дараагийн онд 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн (b) дэд хэсэгт тодорхойлсон тооцооны нийт дүнгээс тухай оны улирал болон опиумын экспортын талаар хасахаар шийдвэрлэх болно. Энэ шийдвэр нь түүнийг сонирхогч талд мэдэгдсэнээс хойш ер хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

3. Хасах талаар дээрх 2 дахь хэсгийн дагуу гаргасан шийдвэрийг сонирхогч талд мэдэгдсэний дараа Хороо нь байдлыг хангалттай шийдвэрлэхийн тулд тухайн талтай зөвлөлдөнө.

4. Хэрэв нөхцөл байдлыг хангалттай шийдвэрлээгүй бол Хороо нь 14 дүгээр зүйлийн заалтыг зохимжтой үед ашиглаж болно.

5. Дээрх 2 дахь хэсгийн дагуу хийх хасалтын талаархи шийдвэр гаргахдаа Хороо нь холбогдох бүх нөхцөл байдал, түүний дотор дээрх 2 дахь хэсэгт дурдсан хууль бус

эргэлтийн асуудлыг үүсгэж буй нөхцөл байдал төдийгүй тухайн талаас авсан байж болох хяналтын аливаа холбогдох шинэ арга хэмжээг ч харгалзан үзнэ.

22 дугаар зүйл

Тарималжуулалтад хэрэглэх тусгай заалт

1. Аль нэг талын орон буюу нутаг дэвсгэр нөхцөл байдалд нь опиумын намуу, кока бут буюу каннабисын ургамал тарималжуулахыг хориглох нь түүний үзэж байгаагаар олон нийтийн эрүүл мэнд, сайн сайхныг хамгаалах болон мансууруулах эмийг хууль бус эргэлтэд оруулахаас урьдчилан сэргийлэх хамгийн зохистой арга хэмжээ болж байвал тухайн тал нь тарималжуулахыг хориглоно.

2. Опиумын намуу буюу каннабисын ургамлыг тарималжуулахыг хориглож буй тал нь тухайн талд эрдэм шинжилгээ буюу судалгааны зорилгоор шаардлагатай бага тоо хэмжээнээс бусад хууль бусаар тарималжуулсан аливаа ургамлыг түр хурааж авч, устгах талаар зохих арга хэмжээ авна.

23 дугаар зүйл

Опиумын асуудал эрхлэх үндэсний агентлаг

1. Опиум үйлдвэрлэхийн тулд опиумын намуу тарималжуулахыг зөвшөөрсөн тал нь хэрэв энэ зүйлийн дагуу шаардлагатай чиг үүргийг биелүүлэх засгийн газрын нэг буюу хэд хэдэн агентлаг (цаашид “Агентлаг” гэнэ) байгуулаагүй бол байгуулж, ажиллуулна.

2. Тухайн тал бүр нь опиум үйлдвэрлэхээр опиумын намуу тарималжуулахад, түүнчлэн опиумд дараахь заалтуудыг хэрэглэнэ:

а) Агентлаг нь опиум үйлдвэрлэх зорилгоор опиумын намуу тарималжуулахыг зөвшөөрөх талбай болон газрын хэсгийг заана.

б) Зөвхөн Агентлагаас тусгай зөвшөөрөл авсан этгээдэд тарималжуулах үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрнө.

в) Тарималжуулах үйл ажиллагааг зөвшөөрсөн газрын хэмжээг тусгай зөвшөөрөл бүрт заана.

д) Опиумын намуу тарималжуулж байгаа этгээдээс хураасан нийт опиумаа Агентлагт тушаахыг шаардана. Агентлаг нь хураасан опиумыг аль болохоор түргэн, ургац хурааснаас хойш дөрвөн сараас оройтуулахгүйгээр худалдан авч, түүний бодит эзэмшигч болно.

е) Опиумын хувьд опиумын алкалоид, эмчилгээний опиум буюу опиумын бэлдмэл бэлтгэгчдэд байгаа нөөцөөс бусдыг импортлох, экспортлох, бөөнөөр худалдаалах болон хадгалах талаар Агентлаг онцгой эрх эдэлнэ. Талууд онцгой энэ эрхээ эмчилгээний опиум ба опиумын бэлдмэлд хэрэглэх хэрэггүй.

3. Холбогдох талын Үндсэн хуулиар зөвшөөрсөн бол 2 дахь хэсэгт дурдсан засгийн газрын чиг үүргийг засгийн газрын нэг агентлаг хэрэгжүүлнэ.

24 дүгээр зүйл

Олон улсын худалдаанд зориулан опиум үйлдвэрлэлтийг хязгаарлах

1. а) Хэрэв аль нэг тал опиумын үйлдвэрлэл эхлэх буюу үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх чиг санаатай бол тухайн талын опиумын үйлдвэрлэл нь дэлхий дахинд опиумын үйлдвэрлэлийн хэмжээг хэтрүүлэхэд хүргэхгүйн тулд Хорооноос нийтлүүлсэн тооцоонд нийцүүлэн дэлхий дахины опиумын хэрэгцээг харгалзана.

б) Хэрэв аль нэг талын үзэж байгаагаар түүний нутаг дэвсгэрт опиумын үйлдвэрлэл эхлэх буюу үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх нь опиумын хууль бус эргэлтэд хүргэж болох бол үйлдвэрлэл эхлэх буюу үйлдвэрлэлээ нэмэгдүүлэхийг үл зөвшөөрнө.

2. а) 1 дэх хэсгийг мөрдөхийн хамт, хэрэв аль нэг тал 1961 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар экспортонд зориулж опиум үйлдвэрлэдэггүй тал үйлдвэрлэж буй опиумаа жил бүр таван тонноос хэтрэхгүй хэмжээгээр экспортлохыг хүсвэл Хороонд мэдэгдэж дараахь зүйлийн талаархи мэдээллийг агуулсан мэдэгдэл өгнө:

(i) Үйлдвэрлэх болон экспортлох опиумын талаар тавих энэхүү конвенцоор шаардагдсан үйлчилж буй хяналт;

(ii) Опиум экспортлогдох орон буюу орнуудын нэр.

Хороо нь ийм мэдэгдлийг зөвшөөрөх буюу экспортонд зориулж опиум үйлдвэрлэхгүй байхыг тухайн талд зөвлөмж болгоно.

б) 3 дахь хэсэгт дурдсанаас өөр тал жил бүр таван тонноос илүү опиум экспортонд зориулж үйлдвэрлэхийг хүсвэл Зөвлөлд мэдэгдэж дараахь зүйлийн талаархи мэдээллийг агуулсан мэдэгдэл өгнө:

(i) Экспортонд зориулж үйлдвэрлэх тооцолсон хэмжээ;

(ii) Үйлдвэрлэх опиумын талаар тавьж байгаа буюу санал болгосон хяналт;

(iii) Опиум экспортлогдох орон буюу орнуудын нэр.

Зөвлөл нь мэдэгдлийг зөвшөөрөх буюу экспортонд зориулж опиум үйлдвэрлэхгүй байхыг тухайн талд зөвлөмж болгоно.

3. Үйлдвэрлэсэн опиумаа 1961 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнөх арван жилийн туршид экспортлосон тал нь үйлдвэрлэж буй опиумаа 2 дахь хэсгийн (а) болон (б) дэд хэсгийн заалтыг үл харгалзан экспортлож болно.

4. а) Аль нэг тал дараахь талын нутаг дэвсгэрт үйлдвэрлэснээс бусад аливаа орон буюу нутаг дэвсгэрээс опиум импортлохгүй:

(i) 3 дахь хэсэгт дурдсан тал;

(ii) 2 дахь хэсгийн (а) дэд хэсэгт заасны дагуу Хороонд мэдэгдсэн тал;
эсхүл

(iii) 2 дахь хэсгийн (b) дэд хэсэгт зааснаар Зөвлөлөөс зөвшөөрөр авсан тал.

b) Аль нэг тал энэ хэсгийн (a) дэд хэсэгт заасныг үл харгалзан 1961 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнөх арван жилийн туршид опиум үйлдвэрлэж экспортлож байсан аливаа орны үйлдвэрлэсэн опиумыг хэрэв тухайн орон 23 дугаар зүйлийн зорилгоор үндэсний хяналтын байгууллага буюу агентлаг байгуулан ажиллуулж байгаа бөгөөд түүний үйлдвэрлэж буй опиум хууль бус эргэлтэд орохгүй байхыг хангах үр дүнтэй хүчин төгөлдөр арга хэрэгсэлтэй бол импортлож болно.

5. Энэ зүйлийн заалт нь дараахь тохиолдолд аль ч талд хориг болохгүй:

a) Өөрийн хэрэгцээнд хүрэлцэхүйцээр опиум үйлдвэрлэх; эсхүл

b) Энэхүү конвенцийн шаардлагад нийцүүлэн хууль бусаар эргэлтэд оруулсан учир түр хураагдсан опиумыг өөр талд экспортлох.

25 дугаар зүйл

Намууны сүрэлд тавих хяналт

1. Опиум үйлдвэрлэхээс өөр зорилгоор опиумын намуу тарималжуулахыг зөвшөөрдөг тал нь дараахь зүйлийг хангахад шаардлагатай бүх арга хэмжээг авна:

a) Опиумыг уг опиумын намуунаас үйлдвэрлэхгүй байх; эсхүл

b) Намууны сүрлээс мансууруулах эм бэлтгэхийг зохих ёсоор хянаж байх.

2. Талууд нь намууны сүрлийн хувьд 31 дүгээр зүйлийн 4-15 дахь хэсэгт зааснаар импортын гэрчилгээ болон экспортын зөвшөөрлийн системийг хэрэглэнэ.

3. Талууд 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (d) дэд хэсэг, 2 дахь хэсгийн (b) дэд хэсгийн дагуу мансууруулах эмд шаардсанаар намууны сүрлийн импорт болон экспортын тухай дүн бүртгэлийн мэдээлэл өгнө.

26 дугаар зүйл

Кока бут болон кока навч

1. Хэрэв аль нэг тал кока бут тарималжуулахыг зөвшөөрвөл түүнд болон кока навчинд опиумын намуунд тавих хяналтын талаар 23 дугаар зүйлд зааснаар хяналтын тогтолцоог хэрэглэх бөгөөд тэр зүйлийн 2 дахь хэсгийн (d) дэд хэсгийн хувьд түүнд дурдсан Агентлагт тавих шаардлага нь ургац хураасны дараа аль болох түргэн ургацыг эзэмшилдээ авсан байхад оршино.

2. Талууд зэрэглээгээр ургасан бүх кока бутыг боломжийн хэрээр түүх арга хэмжээ авна. Кока бутыг хууль бусаар тарималжуулсан бол талууд түүнийг устгана.

27 дугаар зүйл

Кока навчинд хамаарах нэмэлт заалт

1. Талууд аливаа алкалоид агуулаагүй амт оруулагч бодис бэлтгэхэд кока навч ашиглахыг зөвшөөрч болох бөгөөд ийнхүү ашиглахад шаардлагатай хэмжээний хүрээнд эдгээр навчийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, худалдаалах болон эзэмшихийг зөвшөөрч болно.

2. Талууд тухайн кока навчийг алкалоид болон амт оруулагч бодис гаргаж авахад ашиглаж энэ талаар тооцоо, дүн бүртгэлийн мэдээлэлд тайлбарласнаас бусад тохиолдолд амт оруулагч бодис бэлтгэхэд зориулсан кока навчны талаар тусдаа тооцоо (19 дүгээр зүйл), дүн бүртгэлийн мэдээлэл (20 дугаар зүйл) гарган өгнө.

28 дугаар зүйл

Каннабист тавих хяналт

1. Хэрэв аль нэг тал каннабис буюу каннабисын давирхай үйлдвэрлэхээр каннабисын ургамал тарималжуулахыг зөвшөөрдөг бол тухайн тал опиумын намуунд тавих хяналтын талаар 23 дугаар зүйлд зааснаар хяналтын тогтолцоог түүнд хэрэглэнэ.

2. Энэхүү конвенцийг гагцхүү үйлдвэрийн (ширхэг болон үр) болон цэцэрлэгжүүлэлтийн зорилгоор тарималжуулах каннабисын ургамлын хувьд хэрэглэхгүй.

3. Талууд каннабисын ургамлын навчийг зүй бусаар хэрэглэх, хууль бус эргэлтэд оруулахаас урьдчилан сэргийлэхэд шаардлагатай байж болох арга хэмжээ авна.

29 дүгээр зүйл

Бэлтгэх

1. Талууд мансууруулах эм бэлтгэх үйл ажиллагааг улсын байгууллага, эсхүл улсын байгууллагууд гүйцэтгэхээс бусад тохиолдолд тусгай зөвшөөрлийн дагуу явуулахыг шаардана.

2. Талууд:

а) Мансууруулах эм бэлтгэдэг буюу бэлтгэхэд оролцдог бүх этгээд болон байгууллагыг хяналтад байлгана;

б) Ийнхүү бэлтгэж болох байгууллага, байрыг тусгай зөвшөөрлийн дагуу хяналтад байлгана;

в) Тусгай зөвшөөрөл бүхий мансууруулах эм бэлтгэгчид бэлтгэх эрхтэй мансууруулах эмийн төрөл болон хэмжээг заасан зөвшөөрлийг үе үе авч байхыг шаардана. Гэхдээ тогтмол зөвшөөрлийг бэлдмэлд авах хэрэггүй.

3. Мансууруулах эм бэлтгэгчдийн эзэмшилд буй үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардлагатай мансууруулах эм болон намууны сүрлийг зах зээлийн нөхцлийг харгалзан хэмжээнээс илүүгээр хуримтлуулахаас урьдчилан сэргийлнэ.

30 дугаар зүйл

Худалдаа болон түгээлт

1. а) Талууд мансууруулах эм худалдаалах болон түгээхийг улсын байгууллага, эсхүл улсын байгууллагууд гүйцэтгэхээс бусад тохиолдолд түүнийг тусгай зөвшөөрлийн дагуу явуулахыг шаардана.

б) Талууд:

(i) Мансууруулах эм худалдаалах болон түгээдэг буюу худалдаалах болон түгээхэд оролцдог бүх этгээд болон байгууллагыг хяналтад байлгана;

(ii) Ийнхүү худалдаалах болон түгээж болох байгууллага, байрыг тусгай зөвшөөрлийн дагуу хяналтад байлгана. Гэхдээ бэлдмэлд зөвшөөрөл авах хэрэггүй.

с) Эмчилгээний болон шинжлэх ухааны чиг үүргийг хэрэгжүүлэхээр зохих ёсоор зөвшөөрөл авсан этгээдүүд уг чиг үүргээ хэрэгжүүлэх үед (а), (б) дэд хэсгийн тусгай зөвшөөрлийн талаархи заалтыг хэрэглэхгүй.

2. Талууд түүнчлэн:

а) Мансууруулах эм худалдаачид, түгээгч, улсын байгууллага болон дээр дурдсан эрх бүхий этгээдийн эзэмшилд буй үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардлагатай мансууруулах эм болон намууны сүрлийг зах зээлийн нөхцлийг харгалзан хэмжээнээс илүүгээр хуримтлуулахаас урьдчилан сэргийлнэ.

б) (i) Хувь хүмүүст мансууруулах эм нийлүүлэх буюу олгохдоо эмчийн жор шаардана. Энэ шаардлагыг эмчилгээний чиг үүрэгтэйгээ холбоотойгоор хувь хүмүүс зохих ёсоор хууль ёсоор олж авах, хэрэглэх, тэдэнд олгох буюу хангаж болох мансууруулах эмд хэрэглэх шаардлагагүй.

(ii) Хэрэв талууд ийм арга хэмжээг шаардлагатай, эсхүл хүсүүштэй гэж үзвэл I жагсаалтад орсон мансууруулах эмийн жорыг засгийн газрын эрх бүхий байгууллага, эсхүл эрх бүхий мэргэжлийн холбооноос бяцхан товхимол хэлбэрээр гаргасан албан ёсны маягт дээр бичихийг шаардана.

3. Олон улсын хэмжээнд нэр нь бүртгэгдээгүй мансууруулах эмд хамаарах болон арилжааны зорилгоор ашиглаж буй мансууруулах эмийг бүх төрлийн зар сурталчилгаа, тайлбар бүхий ном зохиолд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас санал болгосны дагуу мансууруулах эм бүхий савны доторхи боодол, түүнчлэн мансууруулах эмийг худалдахаар санал болгож буй шошгыг бичмэл буюу хэвлэмэл хэлбэрээр илэрхийлэхийг талууд шаардлага болгохыг эрмэлзэнэ.

4. Хэрэв аль нэг тал тийм арга хэмжээг шаардлагатай буюу хүсүүштэй гэж үзвэл мансууруулах эм бүхий доторхи сав буюу боодол дээр илт ялгаран харагдах хос улаан зураас тавихыг шаардана. Мансууруулах ийм бодис агуулсан савны гаднах боодол дээр хос улаан зураас тавихгүй.

5. Аль нэг тал мансууруулах эмийг худалдаанд гаргах шошгонд түүнд орсон мансууруулах эмийн жин болон хувь хэмжээгээр яг тодорхой заасан байхыг

шаардана. Шошгон дахь мэдэгдлийн энэ шаардлагыг хувь хүнд эмчийн жороор олгосон мансууруулах эмд хэрэглэх хэрэггүй.

6. 2 болон 5 дахь хэсгийн заалтыг II жагсаалтад орсон мансууруулах эмийг жижиглэн худалдаалах буюу жижиглэн түгээхэд хэрэглэх хэрэггүй.

31 дүгээр зүйл

Олон улсын худалдаанд хамаарах тусгай заалтууд

1. Талууд дараахь нөхцлөөр зөвшөөрөхөөс бусад тохиолдолд аливаа орон буюу нутаг дэвсгэр рүү мансууруулах эм экспортолохыг зөвшөөрөхгүй:

а) Тухайн орон буюу нутаг дэвсгэрийн хууль, журамд нийцүүлсэн;

б) 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт тодорхойлсноор тухайн орон буюу нутаг дэвсгэрийн тооцооны нийт дүн дээр реэкспортонд зориулж хэмжээг дахин нэмсэн.

2. Талууд чөлөөт боомт болон бүсэд өөрийн нутаг дэвсгэрийн бусад хэсэгт тавьдгийн нэгэн адил хяналт, шалгалт явуулах бөгөөд чингэхдээ түүнээс хатуу арга хэмжээ авч болно.

3. Талууд нь: а) Улсын үйлдвэрийн газар буюу үйлдвэрийн газруудаас хэрэгжүүлж байгаагаас бусад тохиолдолд мансууруулах эмийн импорт болон экспортод тусгай зөвшөөрлийн дагуу хяналт тавина;

б) Ийм импорт буюу экспорт хийж байгаа буюу үйл ажиллагаа эрхэлж байгаа бүх этгээд болон үйлдвэрийн газарт хяналт тавина.

4. а) Мансууруулах эмийн импорт буюу экспортыг зөвшөөрч байгаа тал бүр нь нэг буюу хэдэн мансууруулах эм хамаарснаас үл хамааран импорт буюу экспорт тус бүрт тус тусад нь импорт буюу экспортын зөвшөөрөл авахыг шаардана.

б) Ийм зөвшөөрөлд мансууруулах эмийн нэр, олон улсын бүртгэгдээгүй нэр байгаа бол тухайн нэр, импортлох буюу экспортлох тоо хэмжээ, импортлогч болон экспортлогчийн нэр, хаяг, түүнчлэн импортлосон буюу экспортлосон байх ёстой хугацааг заана.

с) Экспортын зөвшөөрөлд мөн импортын гэрчилгээ (5 дахь хэсэг)-ний дугаар, он, сар, өдөр, түүнчлэн түүнийг олгосон эрх бүхий байгууллагыг заана.

д) Импортын зөвшөөрлөөр нэгээс илүү ачилтаар импортлохыг зөвшөөрч болно.

5. Экспортын зөвшөөрөл олгохын өмнө талууд импортлогч орон буюу нутаг дэвсгэрийн эрх бүхий байгууллагаас олгосон импортын гэрчилгээ шаардах бөгөөд уг гэрчилгээ нь түүнд дурдсан мансууруулах эм буюу эмүүдийг импортлохыг зөвшөөрснийг гэрчилж, ийм гэрчилгээг экспортын зөвшөөрөл хүсэж буй этгээд буюу байгууллага гаргаж өгнө.

6. Ачаа бүрийг экспортын зөвшөөрлийн хуулбар дагалдах бөгөөд экспортын зөвшөөрөл олгосон засгийн газар нэг хуулбарыг импортлогч орон буюу нутаг дэвсгэрийн засгийн газарт илгээнэ.

7. а) Импорт хиймэгц эсхүл импорт хийхээр тогтоосон хугацаа дуусмагц импортлогч орон буюу нутаг дэвсгэрийн засгийн газар экспортын зөвшөөрлийн энэ талаархи тэмдэглэл хийж экспортлогч орон буюу нутаг дэвсгэрийн засгийн газарт буцаана.

б) Тэр мэдэгдэлд бодит импортын хэмжээг заана.

с) Хэрэв экспортын хэмжээ нь экспортын зөвшөөрөлд зааснаас бага байвал экспортын зөвшөөрөлд болон түүний албан ёсны аливаа хуулбарт эрх мэдэл бүхий байгууллага бодит экспортын хэмжээг заана.

8. Экспортын зөвшөөрөлд нэрлэснээс өөр талын шуудангийн хайрцаг, эсхүл банкны дансанд ачаа экспортлохыг хориглоно.

9. Импортлогч орны засгийн газар экспортын зөвшөөрөл хүссэн этгээд буюу байгууллагын гэрчилгээнд баталгаат агуулахад байрлуулах зорилгоор импортлохыг зөвшөөрснөө гэрчлээгүй тохиолдолд ачааг баталгаат агуулах уруу экспортлохыг хориглоно. Ийм тохиолдолд экспортын зөвшөөрөлд тухайн ачааг ийм зорилгоор экспортлож байгааг заана. Баталгаат агуулахаас ачааг гаргах бүрд тухайн агуулах харьяалагдах эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авахыг шаардах бөгөөд гадаадад ачуулах тохиолдолд ийнхүү гаргахыг энэхүү конвенцийн утга агуулгаар шинэ экспорт гэж үзнэ.

10. Аль нэг талын нутаг дэвсгэрт орж буй буюу нутаг дэвсгэрээс гарч буй мансууруулах эмийн ачаанд экспортын зөвшөөрөл дагалдуулаагүй бол ийм ачааг эрх бүхий байгууллага саатуулна.

11. Тухайн талын эрх бүхий байгууллагад тухайн ачааны экспортын зөвшөөрлийн хуулбарыг гаргаж өгөөгүй тохиолдолд аль нэг тал өөр улсад ачуулсан аливаа мансууруулах эмийг өөрийн нутаг дэвсгэрээр өнгөрүүлэхийг түүнийг ачсан тээврийн хэрэгслээс буулгасан эсэхийг үл харгалзан зөвшөөрөхгүй.

12. Ачаа өнгөрч буй орон буюу нутаг дэвсгэрийн засгийн газар тийнхүү чиглэлээ өөрчлөхийг зөвшөөрөөгүй бол мансууруулах эм бүхий ачааг өнгөрүүлэхийг зөвшөөрсөн аливаа орон буюу нутаг дэвсгэрийн эрх бүхий байгууллага ачааг дагалдуулсан экспортын зөвшөөрлийн хуулбарт нэрлэсэн чиглэлээс өөр чиглэлд ачуулахгүй байхаас урьдчилан сэргийлэхийн тулд зохих бүх арга хэмжээг авна. Дамжин өнгөрүүлэх орон буюу нутаг дэвсгэрийн засгийн газар чиглэлээ өөрчлөх талаархи аливаа хүсэлтийг авч үзэхдээ тийнхүү чиглэл өөрчлөхийг тухайн дамжин өнгөрүүлэх орон буюу нутаг дэвсгэрээс шинэ чиглэлийн орон буюу бүс нутаг руу экспортлож байгаа мэтээр үзнэ. Хэрэв тийнхүү чиглэл өөрчлөхийг зөвшөөрсөн бол 7 дахь хэсгийн (а), (б) дэд хэсгийн заалтыг дамжин өнгөрүүлэх орон буюу нутаг дэвсгэр болон ачааг анх экспортлосон орон буюу нутаг дэвсгэрийн хооронд мөн хэрэглэнэ.

13. Мансууруулах эм бүхий ямар ч ачааг дамжин өнгөрүүлэх явцад, эсхүл баталгаат агуулахад хадгалах хооронд тухайн мансууруулах эмийн мөн чанарыг өөрчлөх ямарваа үйлдэл хийж болохгүй. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр савлагааг өөрчилж болохгүй.

14. Мансууруулах эмийг аль нэг талын нутаг дэвсгэрээр өнгөрүүлэхэд хамаарах 11-ээс 13 дахь хэсгийн заалтыг тухайн ачааг дамжин өнгөрүүлэх орон буюу нутаг дэвсгэрт буулт хийхгүй байх агаарын хөлгөөр тээвэрлэж буй тохиолдолд хэрэглэхгүй.

Хэрэв агаарын хөлөг ийм орон буюу нутаг дэвсгэрт буулт хийвэл тэдгээр заалтыг тухайн нөхцөл байдал шаардсны дагуу хэрэглэнэ.

15. Энэ хэсгийн заалт дамжин өнгөрч буй мансууруулах эмд талуудын аль нэг нь хэрэгжүүлж болох хяналтыг хязгаарлаж буй олон улсын аливаа хэлэлцээрийн заалтыг хөндөхгүй.

16. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн (а) дэд хэсэг болон 2 дахь хэсгээс бусад аль ч заалтыг III жагсаалтад орсон бэлдмэлүүдийн тохиолдолд хэрэглэхгүй.

32 дугаар зүйл

Олон улсын тээврийн хөлөг онгоц, эсхүл агаарын хөлөгт эмнэлгийн анхны тусламжийн зорилгоор мансууруулах эмийг авч явах талаархи тусгай заалтууд

1. Эмнэлгийн анхны тусламжийн зорилгоор, эсхүл яаралтай тохиолдолд хэрэглэх мансууруулах эмийн аяллын явцад хэрэгтэй байж болох хязгаарлагдмал тоо хэмжээг хөлөг онгоц, эсхүл агаарын хөлөгт олон улсад тээвэрлэхийг энэхүү конвенцийн утга агуулгаар импорт, экспорт, эсхүл аль нэг орноор дамжин өнгөрөх үйлдэл гэж үзэхгүй.

2. 1 дэх хэсэгт дурдсан мансууруулах эмийг зүй бусаар хэрэглэх, эсхүл хууль бус зорилгоор чиглэлийг нь өөрчлөхөөс урьдчилан сэргийлэх хамгаалалтын зохих арга хэмжээг бүртгэлийн орон авна. Комисс нь олон улсын зохих байгууллагуудтай зөвлөлдөж хамгаалалтын ийм арга хэмжээг зөвлөмж болгоно.

3. 1 дэх хэсгийн дагуу хөлөг онгоц, эсхүл агаарын хөлөгт авч явж буй мансууруулах эмийн хувьд бүртгэлийн орны хууль, журам, зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийг мөрдөх бөгөөд хөлөг онгоц, эсхүл агаарын хөлөгт шалгалт, хяналт шалгалт болон хяналтын бусад арга хэмжээ авч явуулах дотоодын эрх бүхий байгууллагын эрхийг хөндөхгүй. Яаралтай тохиолдолд ийм мансууруулах эмийг хэрэглэх нь 30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн (b) дэд хэсгийн шаардлагыг зөрчсөн гэж үзэхгүй.

33 дугаар зүйл

Мансууруулах эм эзэмших

Талууд хууль ёсоор зөвшөөрснөөс бусад тохиолдолд мансууруулах эм эзэмшихийг үл зөвшөөрнө.

34 дүгээр зүйл

Хянах болон шалгах арга хэмжээ

Талууд:

а) Энэхүү конвенцид нийцүүлэн зааснаар тусгай зөвшөөрөл авсан, эсхүл энэхүү конвенцид нийцүүлэн байгуулсан улсын үйлдвэрийн газарт удирдах буюу хянан шалгах албан тушаал эрхэлж байгаа бүх этгээд энэ зорилгоор гаргасан хууль, журмын заалтыг үр дүнтэй, хэлбэрэлтгүй гүйцэтгэх хангалттай мэдлэг чадвартай байх;

б) Засгийн газрын эрх бүхий байгууллага, үйлдвэрлэгч, худалдаачин, эрдэмтэн, эрдэм шинжилгээний байгууллага болон эмнэлгүүд бэлтгэсэн мансууруулах эмийн болон мансууруулах эм авсан болон захиран зарцуулсан тохиолдол бүрийн хэмжээг харуулсан бүртгэл хөтөлж байхыг шаардана. Ийм бүртгэлийг хоёр жилээс доошгүй хугацаагаар тус тус хадгална. Албан ёсны жор бичих товхимол хэлбэрээр гаргасан дэвтэр (30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн (b) дэд хэсэг) хэрэглэж байгаа бол товхимол хэлбэрээр гаргасан ийм дэвтрийг мөн хоёр жилээс доошгүй хугацаагаар хадгална.

35 дугаар зүйл

Хууль бус эргэлтийн эсрэг арга хэмжээ

Талууд өөрийн үндэсний хууль тогтоомж, эрх зүй болон захиргааны тогтолцоог зохих ёсоор харгалзан:

а) Хууль бус эргэлтийн эсрэг урьдчилан сэргийлэх болон шийтгэх арга хэмжээнүүдийг уялдуулан зохицуулахад чиглэсэн арга хэмжээг үндэсний хэмжээнд авна; энэ зорилгоор тэд тийнхүү уялдуулан зохицуулах асуудлыг хариуцсан зохих байгууллагыг тухайн ажилд ашиг тустайгаар томилж болно;

б) Мансууруулах эмийн хууль бус эргэлтийн эсрэг кампанит ажил явуулахад бие биедээ туслана;

в) Хууль бус эргэлтийн эсрэг уялдуулан зохицуулсан кампанит ажил явуулах үүднээс бие биетэйгээ болон гишүүн нь болох олон улсын эрх бүхий байгууллагатай нягт хамтран ажиллана;

д) Зохих байгууллагуудын хоорондын олон улсын хамтын ажиллагааг шуурхай хэрэгжүүлэх явдлыг хангана;

е) Мөрдөх ажиллагаа явуулах зорилгоор хууль зүйн баримт бичгийг олон улсын хэмжээнд дамжуулж байгаа тохиолдолд талуудын томилсон байгууллагуудад шуурхай дамжуулах явдлыг хангана; энэ шаардлага нь хууль зүйн баримт бичгийг дипломат шугамаар илгээхийг шаардах аль нэг талын эрхийг хөндөхгүй.

ф) 18 дугаар зүйлээр шаардсан мэдээлэлд нэмэлт болгож өөрийн хил хязгаарын доторхи мансууруулах эмтэй холбоотой хууль бус үйл ажиллагаанд хамаарах мэдээлэл, түүний дотор мансууруулах эмийг хууль бусаар тарималжуулах, үйлдвэрлэх, бэлтгэх, хэрэглэх, түүнчлэн хууль бусаар эргэлтэд оруулах тухай мэдээллийг Ерөнхий нарийн бичгийн даргаар дамжуулан Хороо болон Комисст зохистой гэж үзвэл өгнө.

г) Өмнөх хэсэгт дурдсан мэдээллийг Хорооноос хүсэж болох арга хэлбэр, хугацаанд аль болох өгнө; аль нэг тал хүсвэл Хороо нь мэдээлэл өгөх болон тухайн талын хил хязгаарын доторхи мансууруулах эмтэй холбоотой хууль бус үйл ажиллагааг багасгахыг эрмэлзэхэд нь зөвлөлгөө өгөхийг санал болгож болно.

36 дугаар зүйл

Шийтгэлийн тухай заалт

1. а) Тал бүр энэхүү конвенцийн заалтуудыг зөрчиж мансууруулах эм тарималжуулах, үйлдвэрлэх, бэлтгэх, гаргаж авах, бэлдэх, эзэмших, санал болгох, худалдахаар санал болгох, түгээх, худалдан авах, худалдах, аливаа нөхцлөөр хүргүүлэх,

зуучлах, илгээх, дамжин өнгөрүүлэн илгээх, тээвэрлэх, импортлох болон экспортлох, түүнчлэн тухайн талын үзэж байгаагаар энэхүү конвенцид харш байж болох аливаа бусад үйлдлийг санаатайгаар үйлдсэн бол шийтгэвэл зохих гэмт хэрэг гэж үзэх, мөн ноцтой гэмт хэрэгт тохирох шийтгэл, тухайлбал хорих буюу эрх чөлөөг нь хасах бусад шийтгэл хүлээлгэх явдлыг хангах арга хэмжээг өөрийн үндсэн хуулийн хязгаарлалтыг харгалзан авна.

б) Мансууруулах эм урвуулан хэрэглэгчид тийм гэмт хэрэг үйлдсэн бол талууд дээрх хэсгийг үл харгалзан шийтгэл буюу ялын оронд, эсхүл нэмэлт болгож тэднийг эмчлэх, хүмүүжүүлэх, эмнэлгийн дараахь эмчилгээ хийх, нөхөн сэргээх, нийгмийн амьдралд эргүүлэн оруулах арга хэмжээнд 38 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт нийцүүлэн хамруулахаар зааж болно.

2. Аль нэг талын үндсэн хуулийн хязгаарлалт, эрх зүйн тогтолцоо, дотоодын хуулийг харгалзан:

а) i) 1 дэх хэсэгт жагсаасан гэмт хэрэг бүрийг хэд хэдэн оронд үйлдсэн бол тусдаа гэмт хэрэг гэж үзнэ;

ii) тэдгээр гэмт хэргийн аль нэгийг үйлдэхэд санаатайгаар хамтран оролцох, үйлдэхээр үгсэн тохиролцох, завдах, түүнчлэн энэ зүйлд дурдсан гэмт хэрэгт холбогдуулан бэлтгэх үйлдэл хийх болон санхүүгийн үйл ажиллагаа явуулах нь 1 дэх хэсэгт заасны дагуу шийтгэвэл зохих гэмт хэрэг болно;

iii) тийм гэмт хэргийн төлөө гадаад улсад оногдуулсан шийтгэлийг рецидив гэмт хэрэгтнээр тогтоох зорилгоор харгалзан үзнэ;

iv) тухайн гэмт хэрэг нутаг дэвсгэрт нь үйлдэгдсэн тал, эсхүл хүсэлт гаргасан талын хуулиар шилжүүлэн өгөхийг хүлээж авдаггүй бөгөөд уг гэмт этгээд өмнө нь яллагдаж, шүүхээр шийтгэгдээгүй бол уг гэмт этгээдийг нутаг дэвсгэрт нь олж тогтоосон тал тухайн улсын харьяат эсхүл гадаад улсын харьяат үйлдсэн дээр дурдсан ноцтой гэмт хэргийг мөрдөн шалгана.

б) i) Энэ зүйлийн 1 болон 2 дахь хэсгийн (а) (ii) дэд хэсэгт заасан гэмт хэрэг бүрийг талуудын хооронд байгуулсан шилжүүлэн өгөх тухай аливаа гэрээнд шилжүүлэн өгөх гэмт хэрэгт оруулсан гэж үзнэ. Талууд өөр хоорондоо хойшид байгуулах шилжүүлэн өгөх тухай гэрээ бүрт тийм гэмт хэргийг шилжүүлэн өгөх гэмт хэрэг гэж оруулах үүрэг хүлээнэ;

ii) Гэрээний үндсэн дээр шилжүүлэн өгөх нөхцөл тавьдаг тал шилжүүлэн өгөх тухай гэрээ байгуулаагүй өөр нэг талаас шилжүүлэн өгөх тухай хүсэлт хүлээн авбал өөрийн үзэмжээр энэхүү конвенцийг энэ зүйлийн 1 болон 2 (а) (ii) дэд хэсэгт жагсаасан гэмт хэргийн хувьд шилжүүлэн өгөх эрх зүйн үндэс гэж үзэж болно. Шилжүүлэн өгөхөд хүсэлт хүлээн авагч улсын хуульд заасан бусад нөхцлийг мөрдөнө;

iii) Гэрээний үндсэн дээр шилжүүлэн өгөх нөхцөл тавьдаггүй талууд энэ зүйлийн 1 дэх хэсэг болон 2 дахь хэсгийн (а)(ii) дэд хэсэгт жагсаасан гэмт хэргийг шилжүүлэн өгөх гэмт хэрэг гэж өөр хоорондоо үзэж, хүсэлт хүлээн авагч улсын хуульд заасан бусад нөхцлийг мөрдөнө;

iv) Шилжүүлэн өгөхийг хүсэлт хүлээн авагч талын хуульд нийцүүлэн зөвшөөрөх бөгөөд энэ хэсгийн (b)(i), (ii) болон (iii) дэд хэсгийг үл харгалзан

тухайн гэмт хэргийг эрх бүхий байгууллагаас хангалттай ноцтой биш гэж үзсэн тохиолдолд шилжүүлэн өгөхийг зөвшөөрөхөөс тухайн тал татгалзах эрхтэй.

3. Харьяаллын асуудлын хувьд тухайн талын эрүүгийн хуулийн заалт энэ зүйлийн заалтаас давуу хүчинтэй байна.

4. Энэ зүйлийн аль ч заалт нь түүнд дурдсан гэмт хэргийг аль нэг талын дотоодын хуульд нийцүүлэн тогтоож, мөрдөн шалгаж, шийтгэх зарчмыг хөндөхгүй.

37 дугаар зүйл

Түр болон бүрмөсөн хураах

36 дугаар зүйлд дурдсан гэмт хэргүүдийн аль нэгийг үйлдэхэд ашигласан буюу зориулсан аливаа мансууруулах эм, бодис болон тоног төхөөрөмжийг түр хураах болон бүрмөсөн хураана.

38 дугаар зүйл

Мансууруулах эм урвуулан хэрэглэхийн эсрэг арга хэмжээ

1. Талууд мансууруулах эм урвуулан хэрэглэхээс урьдчилан сэргийлэх, холбогдох этгээдийг эрт таньж тогтоох, эмчлэх, хүмүүжүүлэх, эмнэлгийн дараахь эмчилгээ хийх, нөхөн сэргээх, нийгмийн амьдралд эргүүлэн оруулах талаар онцгой анхаарч, боломжтой бүх арга хэмжээг авах бөгөөд энэ зорилгод хүрэх хүчин чармайлтаа уялдуулан зохицуулна.

2. Талууд мансууруулах эм урвуулан хэрэглэгчдийг эмчлэх, эмнэлгийн дараахь эмчилгээ хийх, нөхөн сэргээх, нийгмийн амьдралд эргүүлэн оруулах боловсон хүчний сургалтыг бололцооны хэрээр дэмжинэ.

3. Талууд сэтгэцэд нөлөөлөх бодис урвуулан хэрэглэхийн бэрхшээлтэй асуудал, түүнээс урьдчилан сэргийлэх асуудлыг ойлгохыг ажил нь шаарддаг этгээдүүдэд туслах талаар боломжтой бүх арга хэмжээ авч, мөн мансууруулах эм урвуулан хэрэглэх явдал өргөн дэлгэрэх эрсдэл байгаа бол ийм ойлголтыг олон нийтэд түгээхийг дэмжинэ.

38 bis зүйл

Бүсчилсэн төвийн тухай хэлэлцээр

Хэрэв аль нэг тал мансууруулах эм хууль бусаар ашиглах болон эргэлтэд оруулахаас үүсэж буй асуудалтай тэмцэх бүсийн эрдэм шинжилгээ, боловсролын төв бий болгох тухай хэлэлцээр байгуулахыг мансууруулах эмийг хууль бус эргэлтэд оруулахын эсрэг чиглэсэн арга хэмжээнийхээ нэг хэсэг болгон явуулах нь зүйтэй гэж өөрийн үндэсний хууль, эрх зүй, захиргааны тогтолцоог зохих ёсоор харгалзсаны үндсэн дээр Хороо буюу төрөлжсөн байгууллагын техник зөвлөгөөнд түшиглэн тийнхүү хүсэж байгаа бол тухайн бүс нутгийн бусад сонирхогч талтай зөвлөлдсөний үндсэн дээр тийм хэлэлцээр байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

39 дугаар зүйл

**Энэхүү конвенцид шаардсан үндэсний хяналтын арга
хэмжээнээс илүү чанга арга хэмжээ хэрэглэх**

Энэхүү конвенцид орсон аль ч заалтыг үл харгалзан, аль нэг тал энэхүү конвенцид зааснаас илүү чанга буюу хатуу хяналтын арга хэмжээ авахад, ялангуяа III жагсаалтад орсон бэлдмэл буюу II жагсаалтад орсон мансууруулах эмд I жагсаалтад орсон мансууруулах эмд хэрэглэх хяналтын бүх, эсхүл түүний үзэж байгаагаар олон нийтийн эрүүл мэнд, сайн сайхныг хамгаалахад шаардлагатай, эсхүл хүсүүштэй арга хэмжээг авахыг шаардахад саад болохгүй буюу саад болно гэж үзэхгүй.

40 дүгээр зүйл

Конвенцийн хэл, гарын үсэг зурах, соёрхон батлах, нэгдэн орох журам

1. Англи, испани, орос, франц, хятад хэлээрх эх бичвэр нь адил хүчинтэй энэхүү конвенц нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын аливаа гишүүн, гишүүн бус боловч Олон улсын шүүхийн дүрмийн оролцогч буюу Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагын гишүүн аливаа улс, түүнчлэн тал болохыг Зөвлөлөөс урьсан аливаа бусад улсын нэрийн өмнөөс гарын үсэг зурахад 1961 оны 8 дугаар сарын 1-ний өдөр хүртэл нээлттэй байна.

2. Энэхүү конвенцийг соёрхон батлана. Батламж жуух бичгийг Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

3. Энэхүү конвенц нь 1961 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн дараа 1 дэх хэсэгт дурдсан улсууд нэгдэн ороход нээлттэй байна. Нэгдэн орсон тухай баримт бичгийг Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

41 дүгээр зүйл

Хүчин төгөлдөр болох

1. Дөч дэх батламж жуух бичиг, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг 40 дүгээр зүйлд нийцүүлэн хадгалуулсан өдрөөс хойш гуч дахь хоногт энэхүү конвенц хүчин төгөлдөр болно.

2. Дээр дурдсан дөч дэх баримт бичгийг хадгалуулсны дараа батламж жуух бичиг, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулж буй өөр аливаа улсын хувьд энэхүү конвенц батламж жуух бичиг, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгээ тухайн улс хадгалуулснаас хойш гуч дахь хоногт хүчин төгөлдөр болно.

42 дугаар зүйл

Хамаарах нутаг дэвсгэр

Аль нэг тал олон улсын харилцааг нь хариуцаж буй харьяа бус бүх нутаг дэвсгэрт тийм нутаг дэвсгэрээс урьдчилан зөвшөөрөл авсан байхыг тухайн тал буюу нутаг дэвсгэрийн Үндсэн хуулиар, эсхүл зан заншлаар шаардсанаас бусад тохиолдолд энэхүү конвенцийг хэрэглэнэ. Тийм тохиолдолд тухайн тал аль болох богино хугацаанд тухайн нутаг дэвсгэрээс шаардлагатай зөвшөөрлийг авахыг эрмэлзэх бөгөөд зөвшөөрлийг авмагц Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэнэ. Ерөнхий нарийн

бичгийн дарга мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс эхлэн Конвенцийг тухайн мэдэгдэлд нэрлэсэн нутаг дэвсгэр буюу нутаг дэвсгэрүүдэд хэрэглэнэ. Харьяа бус нутаг дэвсгэрээс урьдчилан зөвшөөрөл авах шаардлагагүй тохиолдолд сонирхогч тал гарын үсэг зурах, соёрхон батлах, эсхүл нэгдэн орохдоо энэхүү конвенцийг хэрэглэх харьяа бус нутаг дэвсгэр буюу нутаг дэвсгэрүүдийг зарлана.

43 дугаар зүйл

19, 20, 21 болон 31 дүгээр зүйлийн зорилгоорх нутаг дэвсгэр

1. 19, 20, 21 болон 31 дүгээр зүйлийн зорилгод аль нэг тал нутаг дэвсгэрийн аль нэг нь хоёр буюу хэд хэдэн нутаг дэвсгэрт хуваагдсан, эсхүл хоёр болон хэд хэдэн нутаг дэвсгэр нь нэг нутаг дэвсгэр болон нэгдсэн тухай Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэж болно.

2. Хоёр буюу хэд хэдэн тал хоорондоо гаалийн холбоо байгуулсны үр дүнд тэдгээр тал нь 19, 20, 21 болон 31 дүгээр зүйлийн зорилгод нэг нутаг дэвсгэр болж буй тухайгаа Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэж болно.

3. Дээрх 1, эсхүл 2 дахь хэсгийн дагуу хийсэн аливаа мэдэгдэл түүнийг хийсэн жилийн дараагийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болно.

44 дүгээр зүйл

Олон улсын өмнөх гэрээнүүд дуусгавар болох

1. Энэхүү конвенц хүчин төгөлдөр болмогц түүний заалтууд энэхүү конвенцийн талуудын хоорондын дараахь гэрээний заалтуудыг дуусгавар болгож, тэдгээрийг орлоно:

а) Гаага хотноо 1912 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр гарын үсэг зурсан Опиумын тухай олон улсын конвенц;

б) Женев хотноо 1925 оны 2 дугаар сарын 11-ний өдөр гарын үсэг зурсан Бэлэн опиум бэлтгэх, дотоодод худалдаалах, ашиглах талаархи хэлэлцээр;

в) Женев хотноо 1925 оны 2 дугаар сарын 19-ний өдөр гарын үсэг зурсан Опиумын тухай олон улсын конвенц;

г) Женев хотноо 1931 оны 7 дугаар сарын 13-ны өдөр гарын үсэг зурсан Мансууруулах эм бэлтгэхийг хязгаарлах болон түгээхийг зохицуулах конвенц;

д) Бангкок хотноо 1931 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр гарын үсэг зурсан Алс Дорнодод опиум татах явдалд хяналт тавих хэлэлцээр;

е) Гаага хотноо 1912 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр, Женев хотноо 1925 оны 2 дугаар сарын 11-ний өдөр, 1925 оны 2 дугаар сарын 19-ний өдөр, 1931 оны 7 дугаар сарын 13-ны өдөр, Бангкок хотноо 1931 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр, Женев хотноо 1936 оны 6 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан Мансууруулах эмийн тухай хэлэлцээр, конвенц, протоколд нэмэлт өөрчлөлт оруулсан Лейк Саксесст 1946 оны 12 дугаар сарын 11-ний өдөр гарын үсэг зурсан протокол, гэхдээ нэрлэсэн конвенцуудын сүүлчийнхэд нөлөөлөхөөс бусад тохиолдолд;

g) (f) дэд хэсэгт дурдсан 1946 оны протоколоор нэмэлт өөрчлөлт оруулсан (a)-(e) дэд хэсэгт дурдсан конвенц, хэлэлцээрүүд;

h) Лейк Саксест 1946 оны 12 дугаар сарын 11-ний өдөр гарын үсэг зурсан протоколоор нэмэлт өөрчлөлт оруулсан Мансууруулах эм бэлтгэхийг хязгаарлах болон түгээхийг зохицуулах 1931 оны 7 дугаар сарын 13-ны өдрийн конвенцийн хамрах хүрээнээс гадуурх мансууруулах эмийг олон улсын хяналтад оруулах Парис хотноо 1948 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр гарын үсэг зурсан протокол;

i) Нью-Йорк хотноо 1953 оны 6 дугаар сарын 23-ны өдөр гарын үсэг зурсан Намуу ургамлыг тарималжуулахыг, опиум үйлдвэрлэх, олон улсад болон бөөнөөр худалдаалах, ашиглахыг хязгаарлах болон зохицуулах протокол хүчин төгөлдөр болсон бол тэрхүү протокол.

2. Энэхүү конвенц хүчин төгөлдөр болмогц Женев хотноо 1936 оны 6 дугаар сарын 26-ны өдөр гарын үсэг зурсан Аюултай мансууруулах эмийн хууль бус эргэлттэй тэмцэх конвенцийн 9 дүгээр зүйл нь мөн энэхүү конвенцийн тал болох тэрхүү конвенцийн талуудын хооронд дуусгавар болж уг зүйлийг энэхүү конвенцийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн (b) дэд хэсэг орлоно; чингэхдээ тухайн тал Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэх замаар дээр дурдсан 9 дүгээр зүйлийг хүчин төгөлдөр хэвээр үлдээж болно.

45 дугаар зүйл

Шилжилтийн заалт

1. 9 дүгээр зүйлд заасан Хорооны чиг үүргийг 44 дүгээр зүйлийн (c) дэд хэсэгт дурдсан бөгөөд нэмэлт өөрчлөлт оруулсан Конвенцийн IV бүлгийн дагуу байгуулсан Байнгын төв хороо, 44 дүгээр зүйлийн (d) дэд хэсэгт дурдсан бөгөөд нэмэлт өөрчлөлт оруулсан Конвенцийн II бүлгийн дагуу байгуулсан Хянан шалгах байгууллага энэхүү конвенц хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн (41 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг) тэдгээр чиг үүргийн тус тусын шаардлагад нийцүүлэн түр гүйцэтгэнэ.

2. Зөвлөл нь 9 дүгээр зүйлд дурдсан шинэ хороо үүргээ биелүүлж эхлэх он, сар, өдрийг товлон. Тэр өдрөөс эхлэн Хороо нь энэхүү конвенцийн тал бус боловч 44 дүгээр зүйлд жагсаасан гэрээнд оролцогч улсуудын хувьд 1 дэх хэсэгт дурдсан Байнгын төв хороо болон Хянан шалгах байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлнэ.

46 дугаар зүйл

Цуцлах

1. Энэхүү конвенц (41 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг) хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш хоёр жил өнгөрсний дараа аливаа тал өөрийн нэрийн өмнөөс, эсхүл тухайн тал өмнөөс нь олон улсын хариуцлага хүлээсэн бөгөөд 42 дугаар зүйлд нийцүүлэн өгсөн зөвшөөрлөө буцаан авсан нутаг дэвсгэрийн нэрийн өмнөөс энэхүү конвенцийг бичгээр үйлдсэн баримт бичгээр цуцалж, Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулж болно.

2. Хэрэв цуцалсан тухайн баримт бичгийг Ерөнхий нарийн бичгийн дарга аливаа жилийн 7 дугаар сарын эхний өдөр буюу түүнээс өмнө хүлээн авсан бол цуцлалт дараа жилийн 1 дүгээр сарын эхний өдөр хүчин төгөлдөр болох бөгөөд хэрэв цуцалсан тухайн баримт бичгийг 7 дугаар сарын эхний өдрөөс хойш хүлээн авсан бол

түүнийг дараа жилийн 7 дугаар сарын эхний өдөр буюу түүнээс өмнө хүлээн авсантай адилаар цуцлалт хүчин төгөлдөр болно.

3. Хэрэв энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хийсэн цуцлалтын үр дүнд 41 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан ёсоор конвенц хүчин төгөлдөр болох нөхцөл үгүй болбол энэхүү конвенц дуусгавар болно.

47 дугаар зүйл

Нэмэлт өөрчлөлт

1. Аливаа тал энэхүү конвенцид нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргаж болно. Аливаа тийм нэмэлт өөрчлөлтийн эх бичвэр болон үндэслэлийг Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэх бөгөөд Ерөнхий нарийн бичгийн дарга нь талууд болон Зөвлөлд мэдэгдэнэ. Зөвлөл дор дурдсан шийдвэрийн аль нэгийг гаргаж болно:

а) Санал болгосон нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэхээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн 62 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт нийцүүлэн бага хурал зарлан хуралдуулах;

б) Санал болгосон нэмэлт өөрчлөлтийг хүлээн авах эсэх талаар талуудын саналыг авч, мөн нэмэлт өөрчлөлттэй холбогдсон аливаа саналаа Зөвлөлд ирүүлэхийг тэднээс хүсэх.

2. Хэрэв санал болгосон нэмэлт өөрчлөлтийг энэ зүйлийн 1 дэх хэсгийн (б) дэд хэсгийн дагуу тарааснаас хойш арван найман сарын дотор түүнээс талууд татгалзаагүй бол тухайн нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болно. Хэрэв санал болгосон нэмэлт өөрчлөлтөөс аливаа тал татгалзсан бол Зөвлөл талуудаас хүлээж авсан саналыг харгалзан тухайн нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэхээр бага хурал хуралдуулах эсэхийг шийдвэрлэж болно.

48 дугаар зүйл

Маргаан

1. Хэрэв энэхүү конвенцийг тайлбарлах буюу хэрэглэх талаар хоёр буюу хэд хэдэн талын хооронд маргаан үүсвэл талууд хэлэлцээ хийх, мөрдөн шалгах, гуравдагч этгээд оролцуулах, эвлэрэх, арбитраар хэлэлцүүлэх, бүс нутгийн байгууллагад хандах, шүүхээр шийдвэрлүүлэх буюу өөрийн сонгож авсан бусад эв зүйгээр маргааныг зохицуулах зорилгоор зөвлөлдөнө.

2. Дээр зааснаар зохицуулж чадаагүй аливаа ийм маргааныг шийдвэрлүүлэхээр Олон улсын шүүхэд шилжүүлж болно.

49 дүгээр зүйл

Шилжилтийн тайлбар

1. Гарын үсэг зурах, соёрхон батлах буюу нэгдэн орох үед аль нэг тал нутаг дэвсгэрүүдийнхээ аль нэгэнд дараахь үйлдлийг түр зөвшөөрөх эрхээ хадгалж тайлбар хийж болно:

а) Опиумыг хагас анагаах ухааны зорилгоор хэрэглэх;

b) Опиум татах;

c) Кока навч зажлах;

d) Каннабис, каннабисын давирхай, каннабисын ханд буюу буйлуулмалыг анагаах ухааны бус зорилгоор хэрэглэх;

e) (a)-(d) дэд хэсгийн дагуу дурдсан мансууруулах эмийг тэдгээр дэд хэсэгт дурдсан зорилгоор үйлдвэрлэх, бэлтгэх болон худалдаалах.

2. 1 дэх хэсгийн дагуу хийсэн тайлбарт дараахь хязгаарлалт тавина:

a) 1 дэх хэсэгт дурдсан үйл ажиллагааг зөвхөн ийм үйл ажиллагаа нь тайлбар хийсэн нутаг дэвсгэрт заншсан бөгөөд 1961 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр зөвшөөрөгдсөн байсан хэмжээнд зөвшөөрч болно.

b) 1 дэх хэсэгт дурдсан мансууруулах эмийг уг дэд хэсэгт дурдсан зорилгоор энэхүү конвенцийн тал бус улс буюу 42 дугаар зүйлийн дагуу энэхүү конвенц хэрэглэгддэггүй нутаг дэвсгэрт экспортлохыг үл зөвшөөрнө.

c) Зөвхөн 1964 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр эрх бүхий байгууллагад бүртгэгдсэн байсан этгээдэд опиум татахыг зөвшөөрнө.

d) Опиумыг хагас анагаах ухааны зорилгоор хэрэглэхийг 41 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш 15 жилийн дотор устгах ёстой.

e) Кока навч зажлахыг 41 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш хорин таван жилийн дотор устгах ёстой.

f) Каннабисыг анагаах ухааны болон эрдэм шинжилгээнийхээс бусад зорилгоор хэрэглэхийг аль болох түргэн зогсоох ёстой, гэхдээ ямар ч тохиолдолд 41 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш хорин таван жилийн дотор устгах ёстой.

g) 1 дэх хэсэгт дурдсан мансууруулах эмийг уг хэсэгт дурдсан зорилгоор үйлдвэрлэх, бэлтгэх болон худалдаалахыг багасгаж, эцэст нь тийнхүү хэрэглэхийг багасгах болон устгахтай нэгэн зэрэг устгах ёстой.

3. 1 дэх хэсгийн дагуу тайлбар хийж буй тал:

a) 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (a) дэд хэсэгт нийцүүлэн Ерөнхий нарийн бичгийн даргад өгөх жил бүрийн илтгэлдээ 1 дэх хэсгийн дагуу дурдсан хэрэглэх, үйлдвэрлэх, бэлтгэх буюу худалдаалахыг устгах чиглэлээр өнгөрсөн онд хүрсэн амжилтын тухай тайланг оруулна;

b) Тайлбар хийсэн үйл ажиллагааны талаар тооцоо (19 дүгээр зүйл) болон дүн бүртгэлийн мэдээ (20 дугаар зүйл)-г тус тусад нь Хорооноос тогтоосон арга, хэлбэрээр Хороонд гаргаж өгнө.

4. a) Хэрэв 1 дэх хэсгийн дагуу тайлбар хийж буй тал:

(i) 3 дахь хэсгийн (a) дэд хэсэгт дурдсан илтгэлийг тухайн мэдээлэл хамаарах жил дууссаны дараа зургаан сарын дотор;

(ii) 3 дахь хэсгийн (b) дэд хэсэгт дурдсан тооцоог 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт нийцүүлэн тэрхүү зорилгоор Хорооноос тогтоосон өдрийн дараа гурван сарын дотор;

(iii) 3 дахь хэсгийн (b) дэд хэсэгт дурдсан дүн бүртгэлийг 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт өгвөл зохих өдрийн дараа гурван сарын дотор

гаргаж өгөөгүй бол тухайн тохиолдлоос хамааран Хороо буюу Ерөнхий нарийн бичгийн дарга тухайн талд хугацаа хожимдсон тухай мэдэгдэл илгээж, уг мэдээллийг тухайн мэдэгдлийг хүлээн авсны дараа гурван сарын дотор өгөхийг хүснэ.

b) Хэрэв тухайн тал нь Хороо буюу Ерөнхий нарийн бичгийн даргын хүсэлтийг энэ хугацаанд биелүүлэхгүй бол 1 дэх хэсгийн дагуу хийсэн тайлбар хүчингүй болно.

5. Тайлбар хийсэн улс тайлбараа хэдийд ч бүхэлд нь буюу хэсэгчлэн эгүүлэн авч болно.

50 дугаар зүйл

Бусад тайлбар

1. 49 дүгээр зүйл эсхүл дараахь хэсгүүдэд нийцүүлэн хийснээс бусад тайлбарыг үл зөвшөөрнө.

2. Гарын үсэг зурах, соёрхон батлах, нэгдэн орох үед аливаа улс энэхүү конвенцийн дор дурдсан заалтуудын хувьд тайлбар хийж болно:

12 дугаар зүйлийн 2 болон 3 дахь хэсэг; 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг; 14 дүгээр зүйлийн 1 болон 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн (b) дэд хэсэг болон 48 дугаар зүйл.

3. Тал болохыг хүссэн боловч энэ зүйлийн 2 дахь хэсэг эсхүл 49 дүгээр зүлд нийцүүлэн хийснээс өөр тайлбар хийх хүсэлтэй улс ийм чиг санаагаа Ерөнхий нарийн бичгийн даргад мэдээлж болно. Хэрэв тухайн тайлбарын тухай Ерөнхий нарийн бичгийн дарга мэдэгдсэнээс хойш арван хоёр сар өнгөрөхөд энэхүү конвенцийг соёрхон батласан буюу нэгдэн орсон улсуудын гуравны нэг уг тайлбараас татгалзаагүй бол түүнийг зөвшөөрсөн гэж үзнэ. Харин тайлбараас татгалзсан улсууд уг тайлбараар хөндөгдсөн энэхүү конвенцийн дагуу хүлээх аливаа үүргийг тайлбар хийсэн улсын хувьд хүлээх шаардлагагүй гэж ойлгоно.

4. Тайлбар хийсэн улс тайлбараа хэдийд ч бүхэлд нь буюу хэсэгчлэн эгүүлэн авч болно.

51 дүгээр зүйл

Мэдэгдэл

Ерөнхий нарийн бичгийн дарга нь энэхүү конвенцийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан бүх улсад дараахь зүйлийг мэдэгдэнэ:

а) 40 дүгээр зүйлд нийцүүлэн конвенцид гарын үсэг зурсан, соёрхон батласан болон нэгдэн орсон тухай;

б) 41 дүгээр зүйлд нийцүүлэн энэхүү конвенц хүчин төгөлдөр болох он, сар, өдрийн тухай;

с) 46 дугаар зүйлд нийцүүлэн цуцласан тухай;

д) 42, 43, 47, 49 болон 50 дугаар зүйлийн дагуу мэдэгдэл хийсэн тухай.

ЖАГСААЛТУУД

(1990 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн байдлаар Мансууруулах эмтэй тэмцэх комиссын оруулсан бүх нэмэлт, өөрчлөлтийг тусгасан)

I ЖАГСААЛТАД ОРСОН МАНСУУРУУЛАХ ЭМ

Acetorphine	3- <i>O</i> -acetyltetrahydro-7- <i>alpha</i> -(1-hydroxy-1-methylbutyl)-6,14- <i>endo</i> ethenopipavine
Acetyl- <i>alpha</i> -methylfentanyl	<i>N</i> -[1-(<i>alpha</i> -methylphenethyl)-4-piperidyl]acetanilide
Acetylmethadol	3-acetoxy-6-dimethylamino-4,4-diphenylheptane
Alfentanil	<i>N</i> -[1-[2-(4-ethyl-4,5-dihydro-5-oxo-1 <i>H</i> -tetrazol-1-yl)ethyl]-4-(methoxymethyl)-4-piperidinyl]- <i>N</i> -phenylpropanamide
Allylprodine	3-allyl-1-methyl-4-phenyl-4-propionoxypiperidine
Alphacetylmethadol	<i>alpha</i> -3-acetoxy-6-dimethylamino-4,4-diphenylheptane
Alphameprodine	<i>alpha</i> -3-ethyl-1-methyl-4-phenyl-4-propionoxypiperidine
Alphamethadol	<i>alpha</i> -6-dimethylamino-4,4-diphenyl-3-heptanol
<i>Alpha</i> -methylfentanyl	<i>N</i> -[1(<i>alpha</i> -methylphenethyl)-4-piperidyl]propionanilide
<i>Alpha</i> -methylthiofentanyl	<i>N</i> -[1-[1-methyl-2-(2-thienyl)ethyl]-4-piperidyl]propionanilide
Alphaprodine	<i>alpha</i> -1,3-dimethyl-4-phenyl-4-propionoxypiperidine
Anileridine	1- <i>para</i> -aminophenethyl-4-phenylpiperidine-4-carboxylic acid ethyl ester
Benzethidine	1-(2-benzyloxyethyl)-4-phenylpiperidine-4-carboxylic acid ethyl ester
Benzylmorphine	3- <i>O</i> -benzylmorphine
Betacetylmethadol	<i>beta</i> -3-acetoxy-6-dimethylamino-4,4-diphenylheptane
Beta-hydroxyfentanyl	<i>N</i> -[1-(<i>beta</i> -hydroxyphenethyl)-4-

	piperidyl]propionanilide
Beta-hydroxy-3-methylfentanyl	<i>N</i> -[1-(<i>beta</i> -hydroxyphenethyl)-3-methyl-4-piperidyl]propionanilide
Betameprodine	<i>beta</i> -3-ethyl-1-methyl-4-phenyl-4-propionoxypiperidine
Betamethadol	<i>beta</i> -6-dimethylamino-4,4-diphenyl-3-heptanol
Betaprodine	<i>beta</i> -1,3-dimethyl-4-phenyl-4-propionoxypiperidine
Bezitramide	1-(3- <i>cyano</i> -3,3-diphenylpropyl)-4-(2- <i>oxo</i> -3-propionyl-1-benzimidazoliny)-piperidine
Каннабис болон Каннабисын давирхай	Болон КАННАБИСЫН ХАНД болон БУЙЛУУЛМАЛ
Clonitazene	2- <i>para</i> -chlorbenzyl-1-diethylaminoethyl-5-nitrobenzimidazole
Кока навчны кокаин	methyl ester of benzoylecgonine
Codoxime	dihydrocodeinone-6-carboxymethyloxime
Concentrate of poppy straw	the material arising when poppy straw has entered into a process for the concentration of its alkaloids when such material is made available in trade
Desomorphine	dihydrodeoxymorphine
Dextromoramide	(+)-4-[2-methyl-4- <i>oxo</i> -3,3-diphenyl-4-(1-pyrrolidinyl)butyl]-morpholine
Diampromide	<i>N</i> -[2-(methylphenethylamino)-propyl]propionanilide
Diethylthiambutene	3-diethylamino-1,1-di-(2,,-thienyl)-1-butene
Difenoxin	1-(3- <i>cyano</i> -3,3-diphenylpropyl)-4-phenylisonipectic acid
Dihydromorphine Dimenoxadol	2-dimethylaminoethyl-1-ethoxy-1,1-diphenylacetate
Dimepheptanol	6-dimethylamino-4,4-diphenyl-3-heptanol
Dimethylthiambutene	3-dimethylamino-1,1-di-(2'-thienyl)-1-butene
Dioxaphetyl butyrate	ethyl-4-morpholino-2,2-diphenylbutyrate
Diphenoxylate	1-(3- <i>cyano</i> -3,3-diphenylpropyl)-4-phenylpiperidine-4-carboxylic acid ethyl ester
Dipipanone	4,4-diphenyl-6-piperidine-3-heptanone
Drotebanol	3,4-dimethoxy-17-methylmorphinan-6- <i>beta</i> ,14-diol
Ecgonine	its esters and derivatives which are convertible to ecgonine and cocaine
Ethylmethylthiambutene	3-ethylmethylamino-1,1-di-(2,,-thienyl)-1-butene
Etonitazene	1-diethylaminoethyl-2- <i>para</i> -ethoxybenzyl-5-nitrobenzimidazole

Etorphine	tetrahydro-7- <i>alpha</i> -(1-hydroxy-1-methylbutyl)-6,14- <i>endoetheno</i> -oripavine
Etoxeridine	1-[2-(2-hydroxyethoxy)-ethyl]-4-phenylpiperidine-4-carboxylic acid ethyl ester
Fentanyl	1-phenethyl-4- <i>N</i> -propionylanilinopiperidine
Furethidine	1-(2-tetrahydrofurfuryloxyethyl)-4-phenylpiperidine-4-carboxylic acid ethyl ester
Heroin	diacetylmorphine
Hydrocodone	dihydrocodeinone
Hydromorhinol	14-hydroxydihydromorphine
Hydromorphone	dihydromorphinone
Hydroxypethidine	4- <i>meta</i> -hydroxyphenyl-1-methylpiperidine-4-carboxylic acid ethyl ester
Isomethadone	6-dimethylamino-5-methyl-4,4-diphenyl-3-hexanone
Ketobemidone	4- <i>meta</i> -hydroxyphenyl-1-methyl-4-propionylpiperidine
Levomethorphan	*(-)-3-methoxy- <i>N</i> -methylmorphinan
Levomoramide	(-)-4-[2-methyl-4-oxo-3,3-diphenyl-4-(1-pyrrolidinyl)-butyl]morpholine
Levophenacymorphan	(1)-3-hydroxy- <i>N</i> -phenacymorphinan
Levorphanol	*(-)-3-hydroxy- <i>N</i> -methylmorphinan
Metazocine	2'-hydroxy-2,5,9-trimethyl-6,7-benzomorphan
Methadone	6-dimethylamino-4,4-diphenyl-3-heptanone
Methadone intermediate	4-cyano-2-dimethylamino-4,4-diphenylbutane
Methyldesorphine	6-methyl- <i>delta</i> -6-deoxymorphine
Methyldihydromorphine	6-methyldihydromorphine
3-methylfentanyl	<i>N</i> -(3-methyl-1-phenethyl-4-piperidyl)propionanilide
3-methylthiofentanyl	<i>N</i> -[3-methyl-1-[2-(2-thienyl)ethyl]-4-piperidyl]propionanilide
Metopon	5-methyldihydromorphinone
Moramide intermediate	2-methyl-3-morpholino-1,1-diphenylpropane carboxylic acid
Morpheridine	1-(2-morpholinoethyl)-4-phenylpiperidine-4-carboxylic acid ethyl ester
Morphine Morphine methobromide	and other pentavalent nitrogen morphine derivatives, including in particular the morphine- <i>N</i> -oxide derivatives, one of which is codeine- <i>N</i> -oxide
Morphine- <i>N</i> -oxide MPPP	1-methyl-4-phenyl-4-piperidinol propionate (ester)
Myrophine	myristylbenzylmorphine

Nicomorphine	3,6-dinicotinylmorphine
Noracymethadol	(<i>l</i>)- <i>alpha</i> -3-acetoxy-6-methylamino-4,4-diphenylheptane
Norlevorphanol	(-)-3-hydroxymorphinan
Normethadone	6-dimethylamino-4,4-diphenyl-3-hexanone
Normorphine	demethylmorphine or <i>N</i> -demethylated morphine
Norpipanone	4,4-diphenyl-6-piperidino-3-hexanone
Opium Oxycodone	14-hydroxydihydrocodeinone
Oxymorphone	14-hydroxydihydromorphinone
<i>Para</i> -fluorofentanyl	4'-fluoro- <i>N</i> -(1-phenethyl-4-piperidyl)propionanilide
PEPAP	1-phenethyl-4-phenyl-4-piperidinol acetate (ester)
Pethidine	1-methyl-4-phenylpiperidine-4-carboxylic acid ethyl ester
Pethidine intermediate A	4-cyano-1-methyl-4-phenylpiperidine
Pethidine intermediate B	4-phenylpiperidine-4-carboxylic acid ethyl ester
Pethidine intermediate C	1-methyl-4-phenylpiperidine-4-carboxylic acid
Phenadoxone	6-morpholino-4,4-diphenyl-3-heptanone
Phenampramide	<i>N</i> -(1-methyl-2-piperidinoethyl)-propionanilide
Phenazocine	2'-hydroxy-5,9-dimethyl-2-phenethyl-6,7-benzomorphan
Phenomorphane	3-hydroxy- <i>N</i> -phenethylmorphinan
Phenoperidine	1-(3-hydroxy-3-phenylpropyl)-4-phenylpiperidine-4-carboxylic acid ethyl ester
Piminodine	4-phenyl-1-(3-phenylaminopropyl)-piperidine-4-carboxylic acid ethyl ester
Piritramide	1-(3-cyano-3,3-diphenylpropyl)-4-(1-piperidino)-piperidine-4-carboxylic acid amide
Proheptazine	1,3-dimethyl-4-phenyl-4-propionoxyazacycloheptane
Properidine	1-methyl-4-phenylpiperidine-4-carboxylic acid isopropyl ester
Racemethorphan	(<i>l</i>)-3-methoxy- <i>N</i> -methylmorphinan
Racemoramide	(<i>l</i>)-4-[2-methyl-4-oxo-3,3-diphenyl-4-(1-pyrrolidinyl)-butyl]-morpholine
Racemorphan	(<i>l</i>)-3-hydroxy- <i>N</i> -methylmorphinan
Sufentanil	<i>N</i> -[4-(methoxymethyl)-1-[2-(2-thienyl)-ethyl]-4-piperidyl]propionanilide
Thebacon	acetyldihydrocodeinone
Thebaine Thiofentanyl	<i>N</i> -[1-[2-(2-thienyl)ethyl]-4-piperidyl]propionanilide
Tilidine	(<i>l</i>)-ethyl- <i>trans</i> -2-(dimethylamino)-1-

	phenyl-3-cyclohexene-1-carboxylate
Trimeperidine	1,2,5-trimethyl-4-phenyl-4-propionoxypiperidine; and

Энэ жагсаалтад орсон мансууруулах эмийн изомер тусгай химийн зориулалтын хүрээнд байж болох тохиолдолд түүнийг энэ жагсаалтаас тусгайлан хасаагүй бол энэ жагсаалтад орсон мансууруулах эмийн изомер;

Өөр жагсаалтад ороогүй бол энэ жагсаалтын мансууруулах эмийн эфир болон хүнд эфир байж болох тохиолдолд тийм эфир болон хүнд эфир;

Дээр заасанчлан эфир буюу хүнд эфир болон изомерын давсууд байж болох тохиолдолд тэдгээрийг оролцуулан энэ жагсаалтад орсон мансууруулах эмийн давсууд, * Dextromethorphan ((+)-3-methoxy-N-methylmorphinan) болон dextrorphan ((+)-3-hydroxy-N-methylmorphinan) энэ Жагсаалтаас тусгайлан хассан болно.

II ЖАГСААЛТАД ОРСОН МАНСУУРУУЛАХ ЭМ

Acetyldihydrocodeine Codeine	3- <i>O</i> -methylmorphine
Dextropropoxyphene	<i>alpha</i> -(+)-4-dimethylamino-1,2-diphenyl-3-methyl-2-butanol propionate
Dihydrocodeine Ethylmorphine	3- <i>O</i> -ethylmorphine
Nicocodine	6-nicotinylcodeine
Nicodicodine	6-nicotinyldihydrocodeine
Norcodeine	<i>N</i> -demethylcodeine
Pholcodine	morpholinylethylmorphine
Propiram	<i>N</i> -(1-methyl-2-piperidinoethyl)- <i>N</i> -2-pyridylpropionamide; болон

Энэ жагсаалтад орсон мансууруулах эмийн изомер тусгай химийн зориулалтын хүрээнд байж болох тохиолдолд түүнийг энэ жагсаалтаас тусгайлан хасаагүй бол энэ жагсаалтад орсон мансууруулах эмийн изомер;

Дээр заасанчлан изомерын давсууд байж болох тохиолдолд тэдгээрийг оролцуулан энэ жагсаалтад орсон мансууруулах эмийн давсууд.

III ЖАГСААЛТАД ОРСОН БЭЛДМЭЛ

1. Acetyldihydrocodeine-ийн бэлдмэл,

Бусад нэг буюу түнээс илүү зүйлтэй нийлүүлсэн нэг тундаа 100 мг. илүүгүй мансууруулах эм агуулсан бөгөөд ангижруулаагүй бэлдмэлийн 2.5 хувиас илүүгүй концентраци бүхий

Codeine,
Dihydrocodeine,
Ethylmorphine,
Nicodicodine,
Norcodeine, and

Pholcodine

2. Нэг тундаа 100 мг. илүүгүй *propiram* агуулсан бөгөөд наад зах нь мөн хэмжээний *methylcellulose*-той нийлүүлсэн пропирамын бэлдмэл.

3. Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай 1971 оны конвенцоор зохицуулагддаг аливаа бодис агуулаагүй байх тохиолдолд нэг тундаа 135 мг. илүүгүй *dextropropoxyphene*-ийн суурь агуулсан шүдний эмчилгээнд хэрэглэх, эсхүл салгаагүй бэлдмэлд 2.5 хувиас илүүгүй концентраци бүхий *dextropropoxyphene*-ийн бэлдмэл.

4. Кокаины суурь гэж тогтоосон 0.1 хувиас илүүгүй кокаин агуулсан кокаины бэлдмэл болон *anhydrous* морфины суурь гэж тогтоосон 0.2 хувиас илүүгүй морфин агуулсан, түүнчлэн хялбар хэрэглэж болохуйц аргаар буюу олон нийтэд аюул учруулахуйц ургацад буцаж мансууруулах эм болгох боломжгүй нэг буюу түүнээс илүү бусад зүйлтэй нийлүүлсэн опиумын эсхүл морфины бэлдмэл.

5. Нэг тундаа 0.5 мг. илүүгүй *difenoxin* бөгөөд *difenoxin*-ийн нэг тунгийн наад зах нь 5 хувьтай тэмцэх *atropine sulfate* агуулсан *difenoxin*-ийн бэлдмэл

6. Нэг тундаа суурь гэж тогтоосон 2.5 мг. илүүгүй *diphenoxylate* болон *diphenoxylate*-ийн тунгийн наад зах нь 1 хувьтай тэнцэх *atropine sulfate* агуулсан *diphenoxylate*-ийн бэлдмэл.

7. *Pulvis ipescacuanhae et opii compositus*-ийн бэлдмэл

10 хувь нунтаг опиум

Мансууруулах болис агуулаагүй 80 хувь аливаа нунтаг зүйлтэй сайтар холисон 10 хувь нунтаг *ipescacuanha* үндэс

8. Энэ жагсаалтад орсон томъёонд нийцсэн бэлдмэлүүд болон мансууруулах бодис агуулаагүй аливаа материалтай холисон ийм бэлдмэлүүдийн холимог.

IV ЖАГСААЛТАД ОРСОН МАНСУУРУУЛАХ ЭМ

Acetorphine	3- <i>O</i> -acetyltetrahydro-7- α -(1-hydroxy-1-methylbutyl)-6,14-endoethenopipavine
Acetyl- α -methylfentanyl	<i>N</i> -[1-(α -methylphenethyl)-4-piperidyl]acetanilide
α -methylfentanyl	<i>N</i> -[1-(α -methylphenethyl)-4-piperidyl]propionanilide
α -methylthiofentanyl	<i>N</i> -[1-[1-methyl-2-(2-thienyl)ethyl]-4-piperidyl]propionanilide
β -hydroxy-3-methylfentanyl	<i>N</i> -[1-(β -hydroxyphenethyl)-3-methyl-4-piperidyl]propionanilide
β -hydroxyfentanyl	<i>N</i> -[1-(β -hydroxyphenethyl)-4-piperidyl]propionanilide
Каннабис болон каннабисын давирхайн Desomorphine	dihydrodeoxymorphine
Etorphine	tetrahydro-7- α -(1-hydroxy-1-

	methylbutyl)-6,14-endoetheno-orphavine
Heroin	diacetylmorphine
Ketobemidone	4- meta-hydroxyphenyl-1-methyl-4-propionylpiperidine
3-methylfentanyl	N-(3-methyl-1-phenethyl-4-piperidyl)propionanilide; cis-N-[3-methyl-1(2-phenylethyl)-4-piperidyl]propionanilide; trans-N-[3-methyl-1-(2-phenylethyl)-4-piperidyl]propionanilide
3-methylthiofentanyl	N-(3-methyl-1-[2-(2-thienyl)ethyl]-4-piperidyl)propionanilide
MPPP	1-methyl-4-phenyl-4-piperidinol propionate (ester)
Para-fluorofentanyl	4'-fluoro-N-(1-phenethyl-4-piperidyl)propionanilide
PEPAP	1-phenethyl-4-phenyl-4-piperidinol acetate (ester)
Thiofentanyl	N-[1-[2-(thienyl)ethyl]-4-piperidyl]propionanilide; and

Энэ жагсаалтад орсон давсууд байж болох тохиолдолд тийм давс.

85. СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛСИЙН ХУУЛЬ БУС ЭКСПОРТ, ИМПОРТ, ТҮҮНЧЛЭН ӨМЧЛӨХ ЭРХИЙГ ШИЛЖҮҮЛЭХИЙГ ХОРИГЛОХ, ТЭДГЭЭРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ КОНВЕНЦ

*Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага 1970 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Парис хотноо баталж, 1972 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр хүчин төгөлдөр болсон**

Удиртгал

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий бага хурал Парис хотноо 1970 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөс 11 дүгээр сарын 14-ний өдрүүдэд болсон арван зургаадугаар чуулганаараа,

Ерөнхий бага хурлаас арван дөрөвдүгээр чуулганаараа батласан Олон улсын соёлын хамтын ажиллагааны зарчмуудын тунхаглалд тусгасан заалтууд чухал болохыг эргэн санаж,

шинжлэх ухаан, соёл, боловсролын зорилгод үндэстэн хоорондын соёлын үнэт зүйлсийн солилцоо нь хүн төрөлхтний иргэншлийн тухай мэдлэгийг нэмэгдүүлэх, бүх

* Монгол Улс 1991.01.04-нд соёрхон батласан

ард түмний соёлын амьдралын баяжуулах, үндэстэн хоорондын харилцан хүндэтгэл, талархлыг төлөвшүүлнэ гэж үзэж,

соёлын үнэт зүйлс нь иргэншил, үндэсний соёлын үндсэн бүрэлдэхүүн хэсэг болдог бөгөөд түүний жинхэнэ үнэ цэнийг зөвхөн түүний үүсэл, түүх болон уламжлалт орчны талаархи бүрэн мэдээлэлтэй холбогдуулан гаргаж болно гэж үзэж,

улс бүр өөрийн нутаг дэвсгэрт буй соёлын үнэт зүйлсийг хулгай, нууцаар ухаж авах болон хууль бус экспортын аюулаас хамгаалах үүрэгтэй гэж үзэж,

эдгээр аюулыг таслан зогсооход улс бүр өөрийн болон бүх үндэстний соёлын өвийг хүндэтгэх ёс суртахууны үүргийг ухамсарлах шаардлагатай гэж үзэж,

соёлын байгууллага болох музей, номын сан болон архивт байгаа цуглуулга нь бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахууны зарчмын дагуу цуглуулагдсан байх явдлыг хангах ёстой гэж үзэж,

соёлын үнэт зүйлсийн хууль бус импорт, экспорт болон өмчлөх эрхийг шилжүүлэх нь ЮНЕСКО-оос зөвлөмж болгох замаар дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий олон улсын холбогдох конвенцуудын оролцогч сонирхогч улсуудын үндэстэн хоорондын ойлголцолд саад учруулж байна гэж үзэж,

соёлын үнэт өвийг хамгаалах нь гагцхүү хоёр талын болон олон улсын хооронд нягт хамтын ажиллагааг зохион байгуулах тохиолдолд үр дүнтэй байж чадна гэж үзэж,

энэ зорилгоор ЮНЕСКО-ийн Ерөнхий бага хурлаас 1964 онд гаргасан зөвлөмжийг анхааралдаа авч,

соёлын үнэт зүйлсийн хууль бус экспорт, импорт, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай чуулганы хэлэлцэх хэргийн 19 дэх асуудал болох цаашдын саналыг хүлээн авч,

15 дугаар чуулганаар энэ асуудал нь олон улсын конвенцоор зохицуулах асуудал болно гэж шийдвэрлэж,

1970 оны 11 дүгээр сарын арван дөрөвний өдөр энэхүү конвенцийг батлав.

1 дүгээр зүйл

Энэхүү конвенцийн зорилгод “Соёлын үнэт зүйлс” гэдэгт археологи, түүхийн өмнөх үе, түүх, утга зохиол, урлаг, шинжлэх ухааны ач холбогдолтой гэж улс бүр үзэж байгаа шашны буюу шашны бус шинж чанартай бөгөөд дор дурдсан ангилалд хамаарагдах үнэт зүйлсийг ойлгоно:

а) ургамал, амьтан, эрдэс, анатомын ховор дээжис, цуглуулга болон палеонтологийн ач холбогдолтой үнэт зүйлс;

б) түүхийн үнэт зүйлс, тухайлбал, шинжлэх ухаан болон техникийн түүх, дайн болон нийгмийн түүх, түүнчлэн үндэсний нэрт зүтгэлтэн, сэтгэгчид, эрдэмтэд, жүжигчид болон үндэсний томоохон үйл явдалд холбоотой үнэт зүйлс;

с) археологийн (ердийн болон нуугдмал) олдворууд буюу археологийн нээлтүүд;

d) урлагийн болон түүхийн хөшөө дурсгал, археологийн ач холбогдол бүхий газрын бүрэлдэхүүн хэсгүүд;

e) 100 жилээс өмнөх үеийн бичээс, цутгамал, зоос, тамга тэмдэг зэрэг хуучны эд юмс;

f) угсаатны зүйн материалууд;

g) урлагийн дараахь үнэт зүйлс:

(i) аливаа эд зүйл дээр юугаар үйлдсэнийг үл харгалзан бүхэлд нь гараар үйлдсэн бүх төрлийн зураг, уран зураг, зураасан зураг (барааны тэмдэг болон гараар үйлдсэн үйлдвэрийн бүтээгдэхүүнийг оруулахгүй);

(ii) аливаа эдээр хийсэн баримал, уран баримлын эх бүтээлүүд;

(iii) сийлбэр, бар, цутгамлын эх бүтээлүүд;

(iv) аливаа эдээр хийсэн уран сайхны сонгомж, эвлүүлэг.

h) ховор гар бичмэлүүд, хэвлэмэл зүйлс, эртний ном судар, баримт бичиг болон (түүх, уран сайхан, шинжлэх ухаан, уран зохиол зэрэг) онцгой сонирхол татаж байгаа дангаараа буюу цуглуулгаараа байгаа хэвлэмэл бүтээл;

i) дангаараа буюу цуглуулгаараа байгаа шуудангийн марк, татварын буюу түүнтэй адилтгах марк;

j) дууны бичлэг, гэрэл зураг болон киноны архивуудыг оролцуулан бусад төрлийн архив;

k) 100 жилээс өмнөх үеийн эртний модон тавилга болон хөгжмийн эртний зэмсгүүд.

2 дугаар зүйл

1. Энэхүү конвенцид оролцогч улсууд соёлын үнэт зүйлсийн хууль бус импорт, экспорт, түүнийг өмчлөх эрхийг хууль бусаар шилжүүлэх нь уг үнэт зүйлсийн гарлын улсын соёлын өвийг ядууралд хүргэдэг гол хүчин зүйлсүүдийн нэг болон соёлынхоо үнэт зүйлсийг дээрхтэй холбоотой бүх аюулаас хамгаалах хамгийн үр нөлөөтэй аргуудын нэг нь олон улсын хамтын ажиллагаа гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

2. Энэ зорилгоор оролцогч улсууд дээрх үйлдлийг таслан зогсоох, шалтгааныг нь арилгах, шаардлагатай бол хохирлыг барагдуулахад туслалцаа үзүүлэх зэрэг арга хэмжээг өөрсдийнхөө бололцооны хэрээр авах үүрэг хүлээнэ.

3 дугаар зүйл

Энэхүү конвенцийн дагуу оролцогч улсуудаас батласан журмыг зөрчин соёлын үнэт зүйлсийг импортлох, экспортлох, өмчлөх эрхийг шилжүүлэхийг хууль бус гэж үзнэ.

4 дүгээр зүйл

Энэхүү конвенцийн зорилгын дагуу дор дурдсан зүйлс нь улс бүрийн соёлын үнэт зүйлсэд хамаарна гэж энэхүү конвенцид оролцогч улсууд хүлээн зөвшөөрөв:

а) тухайн улсын харьяат этгээдийн дангаараа буюу бусад этгээдтэй хамтран бүтээсэн соёлын үнэт зүйлс, мөн тухайн улсын нутаг дэвсгэрт оршин суугаа гадаадын иргэд буюу харьяалалгүй хүмүүсийн хийж бүтээсэн тухайн улсад чухал ач холбогдолтой соёлын үнэт зүйлс;

б) үндэсний нутаг дэвсгэрт олдсон соёлын үнэт зүйлс;

в) соёлын үнэт зүйлсийн гарлын улсын эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр археологи, угсаатны зүй, байгалийн шинжлэх ухааны экспедицүүдийн олсон соёлын үнэт зүйлс;

д) сайн дурын солилцоогоор олж авсан соёлын үнэт зүйлс;

е) соёлын үнэт зүйлсийн гарлын улсын эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр бэлгэнд, эсхүл хууль ёсоор худалдан авсан соёлын үнэт зүйлс.

5 дугаар зүйл

Энэхүү конвенцид оролцогч улсууд соёлынхоо үнэт зүйлсийг хууль бусаар импортлох, экспортлох, өмчлөх эрхийг шилжүүлэхээс хамгаалах байгууллагагүй бол дор дурдсан үүргийг үр нөлөөтэй биелүүлэхэд шаардлагатай тооны мэргэшсэн хүмүүсээс бүрдсэн соёлын өвийг хамгаалах үндэсний нэг буюу хэд хэдэн байгууллагыг өөрийн нөхцөлдөө тохируулан байгуулах үүрэг хүлээнэ:

а) соёлын өвийг хамгаалах, ялангуяа соёлын чухал үнэт зүйлсийг хууль бусаар импортлох, экспортлох, өмчлөх эрхийг шилжүүлэхийг таслан зогсооход чиглэсэн хууль, журмын төслийг боловсруулахад туслалцаа үзүүлэх;

б) экспортлосноос үүдэж үндэсний соёлын өвд их хэмжээгээр хохирол учруулах улсын болон хувийн эзэмшлийн соёлын чухал үнэт зүйлсийн жагсаалтыг үндэсний хамгаалагдах өвийн бүртгэлийг үндэслэн гаргах болон шинэчлэх;

в) соёлын үнэт зүйлсийг хадгалах, сурталчилахад шаардлагатай шинжлэх ухаан болон техникийн байгууллагууд (музей, номын сан, архив, лаборатори, урлан гэх мэт)-ыг байгуулах, хөгжүүлэхэд туслалцаа үзүүлэх;

д) археологийн малталтад тавих хяналтыг зохион байгуулах, *in situ* (газар дээр нь) үлдээсэн соёлын тодорхой үнэт зүйлсийг болон ирээдүйд археологийн малталт хийхээр үлдээсэн газрыг хамгаалах;

е) энэхүү конвенцоор тодорхойлсон ёс суртахууны зарчимд нийцсэн дүрмийг сонирхогч этгээдүүдэд (хадгалагчид, цуглуулагчид эртний эдлэл цуглуулагчид гэх мэт) зориулж тогтоох, биелэлтийг хянах;

ф) бүх улсын соёлын өвийг хүндэтгэх үзлийг бий болгох, бэхжүүлэх, энэхүү конвенцийн заалтуудыг сурталчилах зорилгоор хүмүүжлийн үйл ажиллагаа явуулах;

г) соёлын үнэт зүйлс үрэгдэх бүхий л тохиолдолд зохих журмаар зарлагдаж байгаа эсэхэд хяналт тавих.

6 дугаар зүйл

Энэхүү конвенцид оролцогч улсууд дараахь үүрэг хүлээнэ:

а) экспортлогч улс соёлын нэг буюу хэд хэдэн үнэт зүйлийг экспортлох зөвшөөрөл олгосноо батлах гэрчилгээ бий болгох. Уг гэрчилгээг журмын дагуу экспортлогдож буй нэг буюу соёлын хэд хэдэн үнэд зүйлд хавсаргана;

б) дээр дурдсан экспортын гэрчилгээг хавсаргаагүй соёлын үнэт зүйлсийг өөрийнхөө нутгаас экспортлохыг хориглох;

с) олон нийтэд, ялангуяа соёлын үнэт зүйлсийг экспортлох, импортлох боломжтой хүмүүст энэхүү хоригийг зохих хэлбэрээр танилцуулсан байх.

7 дугаар зүйл

Энэхүү конвенцид оролцогч улсууд дараахь үүрэг хүлээнэ:

а) энэхүү конвенцийг хүчин төгөлдөр болсноос хойш энэхүү конвенцид оролцогч нөгөө улсаас гаралтай, хууль бусаар экспортлогдсон соёлын үнэт зүйлсийг өөрийн нутаг дээр байгаа музей болон түүнтэй адил төстэй байгууллагууд сандаа авахаас урьдчилан сэргийлэх бололцоотой бүх арга хэмжээг үндэснийхээ хууль тогтоомжийн дагуу авах. Холбогдох хоёр улсын хувьд энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш энэхүү конвенцид оролцогч болох гарлын улсын нутаг дэвсгэрээс соёлынх нь үнэт зүйлсийг хууль бусаар экспортлосон тохиолдолд түүнийг буцааж авах хүсэлтийн талаар боломжтой гэж үзвэл мэдэгдэх;

б) (i) холбогдох улсуудын хувьд энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш энэхүү конвенцид оролцогч улсын музей, шашин шүтлэгийн болон иргэний түүхийн дурсгал, эсхүл түүнтэй адил төст байгууллагаас алдагдсан бөгөөд үнэт зүйлс уг байгууллагын эд юмсын бүртгэлд байгаа тохиолдолд тэдгээрийг импортлохыг хориглох;

(ii) тухайн хоёр улсын хувьд энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш нутагт нь импортлосон соёлын үнэт зүйлсийг илрүүлэх болон эгүүлэн өгөхөд чиглэсэн зохих арга хэмжээг оролцогч нөгөө улсын хүсэлтээр авах бөгөөд чингэхийн тулд уг хүсэлт гаргагч улс тус үнэт зүйлсийг шударгаар худалдан авсан буюу түүнийг эзэмших эрх бүхий этгээдэд зохих төлбөрийг төлсөн байвал зохино. Үнэт зүйлсийг эрэн сурвалжилах болон эгүүлэн өгөх тухай хүсэлтийг дипломат шугамаар дамжуулна. Үнэт зүйлсийг эрэн сурвалжлах, эгүүлэн өгөхийг шаардах эрхийг нь тогтооход шаардлагатай баримт бичиг болон бусад баталгааг хүсэлт гаргасан тал өөрийнхөө зардлаар хариуцна. Энэ зүйлийн дагуу буцаагдаж байгаа соёлын үнэт зүйлст талууд гаалийн болон бусад ямар нэг хураамж ногдуулахгүй. Дээр дурдсан нэг буюу хэд хэдэн соёлын үнэт зүйлийг буцаахтай холбогдсон бүх зардлыг хүсэлт гаргасан тал хариуцна.

8 дугаар зүйл

Энэхүү конвенцид оролцогч улсууд конвенцийн 6 (b) болон 7(b)-д заасан хоригийг зөрчсөн аливаа этгээдэд эрүүгийн, эсхүл захиргааны хариуцлага хүлээлгэх үүрэг хүлээнэ.

9 дүгээр зүйл

Археологийн болон угсаатны зүйн материалыг хулгайлснаас үүдэж соёлын сан хөмрөг нь аюулд учирсан энэхүү конвенцид оролцогч аливаа улс холбогдох бусад оролцогч улсад хандаж болно. Энэ тохиолдолд конвенцид оролцогч улсууд шаардлагатай арга хэмжээг тодорхойлж хэрэгжүүлэх, түүний дотор соёлын үнэт зүйлсээр худалдаа хийх, тэдгээрийг импортлох, экспортлоход хяналт тавих зэрэг олон улсын харилцан зохицуулсан үйл ажиллагаанд оролцох үүрэгтэй. Тийнхүү харилцан тохиролцох хүртэл холбогдох улс бүр хүсэлт гаргагч улсын соёлын өвд нөхөшгүй хохирол учрахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг бололцооныхоо хэрээр авна.

10 дугаар зүйл

Энэхүү конвенцид оролцогч улсууд дараахь үүрэг хүлээнэ:

а) мэдлэг олгох, мэдээлэл өгөх, сэрэмжлүүлэх замаар энэхүү конвенцид оролцогч аливаа улсаас хууль бусаар гаргасан соёлын үнэт зүйлсийн хөдөлгөөнийг хязгаарлах, улс бүр зохих ёсоор эртний эдлэлийн худалдаачдад эрүүгийн болон захиргааны хуулийн дагуу соёлын үнэт зүйл тус бүрийн гарал үүсэл, түүнийг өгсөн этгээдийн нэр болон хаяг, худалдсан эдлэл тус бүрийн төрх байдал, үнэ өртгийг тэмдэглэсэн бүртгэл хөтлөх, түүнчлэн соёлын үнэт зүйл худалдан авагчдад тухайн үнэт зүйлсийг экспортлохыг хориглож болзошгүйг сануулж байх үүрэг хүлээнэ;

б) соёлын үнэт зүйлсийн ач холбогдол, түүнчлэн тэдгээрийг хулгайлах, нууцаар малталт хийх, хууль бусаар экспортлох нь соёлын өвд аюултайг олон нийтэд сурганы хэрэгслээр ухамсарлуулан ойлгуулах.

11 дүгээр зүйл

Аливаа улсыг гадаад улс эзлэн түрэмгийлсний шууд буюу шууд бус уршгаар соёлын үнэт зүйлсийг хууль бусаар экспортолж, түүнийг өмчлөх эрхийг хүчээр шилжүүлсэн бол тэдгээр үйлдлийг мөн хууль бус гэж үзнэ.

12 дугаар зүйл

Энэхүү конвенцид оролцогч улсууд олон улсын харилцаанд хариуцах нутаг дэвсгэртээ соёлын өвийг хүндэтгэж, тэдгээрийг хууль бусаар импортлох, экспортлох, өмчлөх эрхийг нь шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн шаардлагатай арга хэмжээ авна.

13 дугаар зүйл

Энэхүү конвенцид оролцогч улсууд хууль тогтоомжийнхоо дагуу дараахь арга хэмжээ авах үүрэг хүлээнэ:

а) соёлын үнэт зүйлсийг хууль бусаар импортлох буюу экспортлоход хүргэх уг үнэт зүйлсийн өмчлөлийн эрхийг шилжүүлэх явдлаас зохих бүхий л аргаар урьдчилан сэргийлэх;

б) хууль бусаар экспортлосон соёлын үнэт зүйлсийг аль болох богино хугацаанд хууль ёсных нь өмчлөгчдөд буцааж өгөхийн тулд өөрсдийнн эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагааг хангах;

с) алдагдсан буюу хулгайлагдсан соёлын үнэт зүйлсийг эгүүлэн өгүүлэх талаар хууль ёсны өмчлөгч болон түүний нэрийн өмнөөс зарга мэдүүлэх эрхийг зөвшөөрөх;

д) энэхүү конвенцид оролцогч улс бүр соёлын үнэт зүйлсийнхээ заримыг бусдад шилжүүлэхгүй гэж ангилан зарлаж, *ipso facto* экспортлохгүй байх салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх бөгөөд хэрэв соёлын тийм үнэт зүйлс өмнө нь экспортлогдсон бол тэдгээрийг холбогдох улсуудад буцааж өгөхөд туслалцаа үзүүлнэ.

14 дүгээр зүйл

Соёлын үнэт зүйлсийг хууль бусаар экспортлохоос урьдчилан сэргийлэх болон энэхүү конвенцийг хэрэгжүүлэхтэй холбоотой үүргээ биелүүлэхийн тулд энэхүү конвенцид оролцогч улс бүр соёлын өвийг хамгаалах үндэснийхээ байгууллагад бололцооныхоо хэрээр хангалттай хөрөнгө олгох ёстой бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх зорилгоор сан байгуулж болно.

15 дугаар зүйл

Энэхүү конвенцийг хүчин төгөлдөр болохоос өмнө түүнд оролцогч улсууд гарлын нутаг дэвсгээрээсээ ямар нэгэн шалтгаанаар гарсан соёлын үнэт зүйлсийг буцааж авах талаар тусгай хэлэлцээр байгуулах буюу өмнө байгуулсан хэлэлцээрээ үргэлжлүүлэн хэрэгжүүлэхэд энэхүү конвенцийн аль ч заалт саад болохгүй.

16 дугаар зүйл

Энэхүү конвенцид оролцогч улсууд уг конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор батлан гаргасан хууль тогтоомж болон авсан бусад арга хэмжээ, түүнчлэн энэ салбарт хуримтлуулсан туршлагынхаа тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий бага хуралд зохих хугацаа, журмын дагуу тогтмол ирүүлдэг илтгэлдээ мэдээлж байна.

17 дугаар зүйл

1. Энэхүү конвенцид оролцогч улсууд ялангуяа дараахь асуудлаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагаас техникийн туслалцаа хүсч болно:

- а) мэдээлэл болон боловсрол;
- б) зөвлөлгөө болон мэргэжилтний туслалцаа авах;
- с) зохион байгуулалтын болон сайн санааны үйлчилгээ хүртэх.

2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага өөрийн санаачлагаар соёлын үнэт зүйлсийг хууль бусаар дамжуулж байгаа асуудлаар судалгаа хийж, эрдэм шинжилгээний бүтээл гаргаж болно.

3. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага дээрх зорилгоор төрийн бус эрх бүхий аль ч байгууллагатай хамтран ажиллаж болно.

4. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага энэхүү конвенцийг хэрэгжүүлэх талаар оролцогч улсуудад хандаж өөрийн санаачлагаар санал гаргаж болно.

5. Энэхүү конвенцид оролцогч хоёроос доошгүй улсын хооронд түүнийг хэрэгжүүлэх талаар санал зөрөлдвөл тэдгээрийн хүсэлтээр тохиролцоонд хүрэхэд ЮНЕСКО сайн санааны үйлчилгээ үзүүлэх талаар санал тавьж болно.

18 дугаар зүйл

Энэхүү конвенцийг эх бичвэр нь адил хүчинтэй байх англи, испани, орос, франц хэлээр дөрвөн эх хувь үйлдэв.

19 дүгээр зүйл

1. Энэхүү конвенцийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын гишүүн улсууд өөрсдийн хууль тогтоомжийн дагуу соёрхон батлах буюу хүлээн зөвшөөрнө.

2. Батламж жуух бичиг буюу хүлээн зөвшөөрсөн тухай баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захиралд хадгалуулна.

20 дугаар зүйл

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Гүйцэтгэх зөвлөлөөс энэхүү конвенцид нэгдэн орох урилга хүлээн авсан уг байгууллагын гишүүн бус аль ч улсын хувьд энэхүү конвенцид нэгдэн ороход нээлттэй байна.

2. Нэгдэн орох тухай баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захиралд хадгалуулснаар энэхүү конвенцид нэгдэн орсон гэж үзнэ.

21 дүгээр зүйл

Энэхүү конвенц нь гурав дахь батламж жуух бичиг буюу хүлээн зөвшөөрсөн, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар өгснөөс хойш гурван сарын дараа зөвхөн батламж жуух бичиг буюу хүлээн зөвшөөрсөн, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгээ тухайн өдөр буюу түүнээс өмнө хадгалуулахаар өгсөн улсуудын хувьд хүчин төгөлдөр болно. Бусад аль ч улс батламж жуух бичиг буюу хүлээн зөвшөөрсөн, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгснөөс хойш гурван сарын дараа энэхүү конвенц тэдний хувьд хүчин төгөлдөр болно.

22 дугаар зүйл

Энэхүү конвенцид оролцогч улсууд энэхүү конвенц нь тэдгээрийн эзэмшлийн нутаг дэвсгэрт байдаг төдийгүй олон улсын харилцаанд хариуцдаг нутаг дэвсгэрт нэгэн адил үйлчлэхийг хүлээн зөвшөөрнө. Энэхүү конвенцийг дээрх нутаг дэвсгэрт хэрэгжүүлэхийн тулд шаардлагатай бол түүнийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх буюу нэгдэн орох үедээ, эсхүл түүнээс өмнө эдгээр нутаг дэвсгэрийн засгийн газар болон эрх бүхий бусад байгууллагатай зөвлөлдөх бөгөөд энэхүү конвенцийн үйлчлэх нутаг дэвсгэрийн талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захиралд мэдэгдэх үүрэг хүлээнэ. Мэдэгдэл нь түүнийг хүлээж авснаас хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

23 дугаар зүйл

1. Энэхүү конвенцид оролцогч улс бүр өөрийнхөө нэрийн өмнөөс буюу олон улсын харилцаанд хариуцдаг нутаг дэвсгэрийн нэрийн өмнөөс энэхүү конвенцийг цуцалж болно.

2. Цуцалсан тухайгаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захиралд бичгээр мэдэгдэнэ.

3. Цуцалсан тухай баримт бичгийг хүлээн авснаас хойш арван хоёр сарын дараа цуцлалт нь хүчин төгөлдөр болно.

24 дүгээр зүйл

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захирал энэхүү конвенцийн 19, 20 дугаар зүйлүүдэд дурдсан соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн буюу нэгдэн орсон тухай бүх баримт бичиг, түүнчлэн 22, 23 дугаар зүйлүүдэд заасан цуцалсан тухай мэдэгдлийг хадгалуулахаар хүргүүлсэн тухай Байгууллагын гишүүд улсууд, 20 дугаар зүйлд дурдсан гишүүн бус улсууд, түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагад мэдээлнэ.

25 дугаар зүйл

1. Энэхүү конвенцийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий бага хурлаар өөрчилж болно. Гэхдээ конвенцийн өөрчлөгдсөн эх хувь гагцхүү өөрчлөлт оруулсан конвенцийн оролцогч тал болсон улсуудад үүрэг хүлээлгэнэ.

2. Ерөнхий бага хурал энэхүү конвенцийг бүхэлд нь буюу хэсэгчилэн өөрчилж шинэ конвенц батласан тохиолдолд шинэ конвенцид өөрөөр заагаагүй бол өөрчилсөн эх бичвэр бүхий шинэ конвенцийг хүчин төгөлдөр болсон өдрөөс энэхүү конвенц соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх буюу нэгдэн ороход хаалттай болно.

26 дугаар зүйл

Энэхүү конвенцийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн 102 дугаар зүйлийн дагуу Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захирлын хүсэлтээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын нарийн бичгийн дарга нарын газарт бүртгүүлнэ.

86. СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛӨХ БОДИСЫН ТУХАЙ КОНВЕНЦ

*1971 оны 2 дугаар сарын 21-ний өдөр баталж,
1976 оны 8 дугаар сарын 16-ны өдөр хүчин төгөлдөр болсон**

Удиртгал

Талууд,

хүн төрөлхтний эрүүл мэнд, сайн сайхны төлөө сэтгэл зовниж,

сэтгэцэд нөлөөлөх зарим бодисыг урвуулан хэрэглэсний улмаас үүсэж байгаа олон нийтийн эрүүл мэнд, нийгмийн асуудлыг сэтгэл зовнин тэмдэглэж,

тийм бодисыг урвуулан хэрэглэх, түүнээс үүсдэг хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх шийдвэр төгс байж,

тийм бодисыг хууль ёсны зорилгоор ашиглахыг хязгаарлахын тулд хатуу арга хэмжээ шаардлагатай гэж үзэж,

сэтгэцэд нөлөөлөх бодисыг анагаах ухааны болон эрдэм шинжилгээний зорилгоор ашиглах нь зайлшгүй бөгөөд тийм зорилгоор ашиглах боломжийг зүй бусаар хязгаарлах ёсгүй гэдгийг хүлээн зөвшөөрч,

тийм бодисыг урвуулан хэрэглэхийн эсрэг үр дүнтэй арга хэмжээ авахад уялдуулан зохицуулалт, бүх нийтийн үйл ажиллагаа шаардлагатай гэдэгт итгэж,

сэтгэцэд нөлөөлөх бодист хяналт тавих салбар дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын эрх хэмжээг хүлээн зөвшөөрч олон улсын холбогдох байгууллагууд нь тэрхүү байгууллагын хүрээнд багтаж байх нь зүйтэй гэж хүсэж,

эдгээр зорилгод хүрэхэд олон улсын конвенц шаардлагатайг хүлээн зөвшөөрч,

дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

1 дүгээр зүйл

Нэр томъёог хэрэглэх

Хэрэв өөрөөр илэрхий заагаагүй буюу тодорхой тохиолдолд агуулгын хувьд өөр утга шаардлагагүй бол энэхүү конвенц дахь дараахь нэр томъёонууд дор дурдсан утгатай байна:

а) “Зөвлөл” гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эдийн засаг, нийгмийн зөвлөлийг хэлнэ.

б) ”Комисс” гэж Зөвлөлийн Мансууруулах эмтэй тэмцэх комиссыг хэлнэ.

* Монгол Улс 1999.04.22-нд соёрхон баталсан

- с) “Хороо” гэж Мансууруулах эмийн тухай 1961 оны нэгдсэн конвенцид заасан Хар тамхинд хяналт тавих олон улсын хороог хэлнэ.
- д) “Ерөнхий нарийн бичгийн дарга” гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргыг хэлнэ.
- е) “Сэтгэцэд нөлөөлөх бодис” гэж I, II, III, IV жагсаалтад орсон байгалийн буюу нийлэг аливаа бодис, эсхүл байгалийн аливаа материалыг хэлнэ.
- f) “Бэлдмэл” гэж :
- i) сэтгэцэд нөлөөлөх нэг буюу хэд хэдэн бодис агуулж байгаа физикийн ямар ч байдалд байгаа аливаа уусмал буюу холимогийг; эсхүл
 - ii) тунгийн хэлбэрт байгаа сэтгэцэд нөлөөлөх нэг буюу хэд хэдэн бодисыг хэлнэ.
- g) “I жагсаалт, II жагсаалт, III жагсаалт, IV жагсаалт” гэж 2 дугаар зүйлд нийцүүлэн өөрчлөлт оруулж болох бөгөөд энэхүү конвенцид хавсаргасан сэтгэцэд нөлөөлөх бодисын зохих ёсоор дугаарласан жагсаалтыг хэлнэ.
- h) “Экспорт” болон “импорт” гэж сэтгэцэд нөлөөлөх бодисыг тухайн тохиолдолд нэг улсаас нөгөө улс руу биет байдлаар шилжүүлэхийг хэлнэ.
- i) “Бэлтгэх” гэж сэтгэцэд нөлөөлөх бодисыг гаргаж авах бүх үйл ажиллагааг хэлэх бөгөөд үүнд цэвэрлэх болон сэтгэцэд нөлөөлөх нэг бодисыг сэтгэцэд нөлөөлөх нөгөө бодис руу шилжүүлэн хувиргах ажиллагаа багтана. Уг нэр томъёонд эмийн санд жороор найруулснаас бусад бэлдмэлийг бэлтгэх ажиллагаа мөн багтана.
- j) “Хууль бус эргэлт” гэж энэхүү конвенцийн заалтыг зөрчиж сэтгэцэд нөлөөлөх бодис бэлтгэх, эсхүл эргэлтэд оруулахыг хэлнэ.
- к) “Бүс нутаг” гэж 28 дугаар зүйлийн дагуу энэхүү конвенцийн зорилгоор тусгай нэгж гэж үзэж буй аль нэг улсын аливаа хэсгийг хэлнэ.
- l) “Байр” гэж барилга буюу түүний хэсэг, түүний дотор тэдгээрийн байрлаж буй газрыг хэлнэ.

2 дугаар зүйл

Бодист хяналт тавих хүрээ

1. Хэрэв олон улсын хяналтад хараахан хамрагдаагүй боловч энэхүү конвенцийн Жагсаалтуудад нэмж оруулах шаардлагатай гэж үзэж байгаа аливаа бодист хамаарах мэдээлэл аль нэг тал, эсхүл Дэлхийн эрүүл мэндийн байгууллагад байгаа бол энэ тухай Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэж, тухайн мэдэгдлийг батлах мэдээллийг хүргүүлнэ. Аль нэг тал, эсхүл Дэлхийн эрүүл мэндийн байгууллагад аль нэг бодисыг тэдгээр жагсаалт дотор нэг Жагсаалтаас нөгөөд шилжүүлэх буюу аль нэг бодисыг Жагсаалтаас хасах нь зүйтэйг батласан мэдээлэл байгаа тохиолдолд дээрх журмыг мөн хэрэглэнэ.

2. Ерөнхий нарийн бичгийн дарга тийм мэдэгдэл болон холбогдолтой гэж үзсэн мэдээллийг талууд болон Комисст, түүнчлэн мэдэгдлийг аль нэг тал өгсөн тохиолдолд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагад дамжуулна.

3. Хэрэв тийм мэдэгдлийн хамт дамжуулсан мэдээлэлд тухайн бодисыг 4 дэх хэсгийн дагуу I жагсаалт эсхүл II жагсаалтад оруулахад тохирно гэж заасан бол талууд дурдсан I жагсаалт эсхүл II жагсаалтад орсон бодист хамаарч байгаа хяналтын бүхий л арга хэмжээг зохимжтой бол түр хэрэглэх боломжийг өөрт байгаа мэдээллийг ашиглан судална.

4. Хэрэв Дэлхийн эрүүл мэндийн байгууллага:

а) Тухайн бодис нь:

i) 1) хараат байдлыг үүсгэх чадвартай бөгөөд
2) төв мэдрэлийн тогтолцоог сэргээх буюу дарангуйлах нөлөө үзүүлж, үр дүнд нь хий үзэгдэл харахад хүргэх, эсхүл хөдөлгөөний үйл ажиллагаа, сэтгэхүй, мэдрэхүй, зан авирыг саатуулан хямраах чадвартай; эсхүл

ii) I, II, III, IV жагсаалтад орсон аль нэг бодисын адил урвуулан хэрэглэхэд хүргэх буюу хортой үр дагавар үүсгэх чадвартай; эсхүл

б) Олон нийтийн эрүүл мэнд болон нийгэмд бэрхшээл учруулж, улмаар тухайн бодисыг олон улсын хяналтад оруулах үндэслэл болохуйцаар уг бодисыг урвуулан хэрэглэж байгаа, эсхүл хэрэглэх магадлалтай гэж үзэх хангалттай нотолгоо байгааг

олж тогтоовол Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас тухайн бодисын үнэлгээг, түүний дотор урвуулан хэрэглэх хэмжээ буюу магадлал, олон нийтийн эрүүл мэнд болон нийгэмд учруулах бэрхшээлийн ноцтой байдлын зэрэглэл, тухайн бодисыг анагаах ухааны эмчилгээнд хэрэглэхийн ашигтай талын зэрэглэлийн тухай, хэрэв үнэлгээний үүднээс зохимжтой байж болох хяналтын арга хэмжээний талаар зөвлөмж байгаа бол тэдгээр зөвлөмжийн хамт, Комисст мэдэгдэнэ.

5. Комисс нь үнэлгээ нь анагаах ухааны болон эрдэм шинжилгээний асуудалд шийдвэрлэх үүрэгтэй Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдэгдлийг харгалзан үзэж, уг асуудалд холбогдолтой гэж үзэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүй, захиргааны болон бусад хүчин зүйлийг харгалзан уг бодисыг I, II, III эсхүл IV жагсаалтад нэмж болно. Комисс нэмэлт мэдээлэл авахын тулд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага буюу холбогдох бусад эх сурвалжид хандаж болно.

6. Хэрэв I дэх хэсгийн дагуу өгсөн мэдэгдэл нь Жагсаалтуудын аль нэгэнд орсон бодист хамаарах бол Дэлхийн эрүүл мэндийн байгууллага олж тогтоосон аливаа шинэ зүйл, тухайн бодисын талаар 4 дэх хэсгийн дагуу гаргаж болох аливаа шинэ үнэлгээ, үнэлгээний үүднээс зохимжтой гэж үзэж болох хяналтын арга хэмжээний талаархи аливаа шинэ зөвлөмжийн тухай Комисст мэдэгдэнэ. Комисс 5 дахь хэсгийн дагуу Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдэгдлийг харгалзан үзэж, уг хэсэгт дурдсан хүчин зүйлийг харгалзан уг бодисыг нэг Жагсаалтаас нөгөөд шилжүүлэх буюу Жагсаалтуудаас хасахаар шийдвэрлэж болно.

7. Энэ зүйлд заасны дагуу Комиссоос гаргасан аливаа шийдвэрийн тухай Ерөнхий нарийн бичгийн дарга Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн бүх улс, гишүүн, бус энэхүү конвенцийн оролцогч улс, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон Хороонд мэдэгдэнэ. Уг шийдвэр нь тийнхүү мэдэгдсэн өдрөөс хойш 180

хоногийн дараа тал бүрийн хувьд бүрэн хүчин төгөлдөр болох боловч аль нэг бодисыг аль нэг Жагсаалтад нэмэх шийдвэртэй холбогдуулан аливаа тал тухайн жагсаалтад орсон бодисуудад хэрэглэгдэх Конвенцийн бүх заалтыг онцгой нөхцөл байдлын улмаас тэрхүү бодисын хувьд хүчин төгөлдөр болгох боломжгүй гэдгээ Ерөнхий нарийн бичгийн даргад дээрх хугацааны дотор бичгээр мэдэгдсэн бол энэ заалт уг талд хамаарахгүй. Ийм мэдэгдэлд энэхүү онцгой арга хэмжээ авах шалтгааныг заана. Тал бүр өөрийн мэдэгдлээс үл хамааран наад зах нь дор дурдсан хяналтын арга хэмжээг хэрэгжүүлнэ:

а) Урьд нь хяналтад хамрагдаагүй байсан бөгөөд I жагсаалтад нэмсэн бодисын талаар ийм мэдэгдэл өгсөн тал 7 дугаар зүйлд жагсаасан хяналтын тусгай арга хэмжээг боломжийн хэрээр харгалзан үзэж, тухайн бодистой холбогдуулан:

i) II жагсаалтад орсон бодисын хувьд бэлтгэх, худалдах, түгээхэд 8 дугаар зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрөл шаардана;

ii) II жагсаалтад орсон бодисыг хувьд нийлүүлэх буюу олгоход 9 дүгээр зүйлд заасны дагуу эмчийн жор шаардана;

iii) тухайн бодисын талаар тийм мэдэгдэл өгсөн талаас бусад талын хувьд 12 дугаар зүйлд заасан экспорт болон импортод хамаарах үүргийг биелүүлнэ;

iv) экспорт болон импортыг хориглох болон хязгаарлахтай холбогдуулан II жагсаалтад орсон бодисын хувьд 13 дугаар зүйлд заасан үүргийг биелүүлнэ;

v) 16 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн (а) дэд хэсгийн дагуу дүн бүртгэлийн илтгэлийг Хороонд өгнө;

vi) дээр дурдсан үүргийг биелүүлэхтэй холбогдуулан батласан хууль буюу журамд харш үйлдлийг зогсоох арга хэмжээг 22 дугаар зүйлийн дагуу авна.

б) Урьд нь хяналтад хамрагдаагүй байсан бөгөөд II жагсаалтад нэмсэн бодисын талаар ийм мэдэгдэл өгсөн тал тухайн бодистой холбогдуулан:

i) бэлтгэх, худалдах, түгээхэд 8 дугаар зүйлд нийцүүлэн тусгай зөвшөөрөл шаардана;

ii) нийлүүлэх буюу олгоход 9 дүгээр зүйлд нийцүүлэн эмчийн жор шаардана;

iii) тухайн бодисын талаар тийм мэдэгдэл өгсөн талаас бусад талын хувьд 12 дугаар зүйлд заасан экспорт болон импортод хамаарах үүргийг биелүүлнэ;

iv) экспорт болон импортыг хориглох болон хязгаарлахтай холбогдуулан 13 дугаар зүйлийн үүргийг биелүүлнэ;

v) 16 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн (а), (с), (d) дэд хэсгийн дагуу дүн бүртгэлийн илтгэлийг Хороонд өгнө;

vi) дээр дурдсан үүргийг биелүүлэхтэй холбогдуулан батласан хууль буюу журамд харш үйлдлийг зогсоох арга хэмжээг 22 дугаар зүйлийн дагуу авна.

с) Урьд нь хяналтад хамрагдаагүй байсан бөгөөд III жагсаалтад нэмсэн бодисын талаар ийм мэдэгдэл өгсөн тал тухайн бодистой холбогдуулан:

i) бэлтгэх, худалдах, түгээхэд 8 дугаар зүйлд нийцүүлэн тусгай зөвшөөрөл шаардана;

ii) нийлүүлэх буюу олгоход 9 дүгээр зүйлд нийцүүлэн эмчийн жор шаардана;

iii) тухайн бодисын талаар тийм мэдэгдэл өгсөн талаас бусад талын хувьд 12 дугаар зүйлд заасан экспортод хамаарах үүргийг биелүүлнэ;

iv) экспорт болон импортыг хориглох болон хязгаарлахтай холбогдуулан 13 дугаар зүйлийн үүргийг биелүүлнэ;

v) дээр дурдсан үүргийг биелүүлэхтэй холбогдуулан батласан хууль буюу журамд харш үйлдлийг зогсоох арга хэмжээг 22 дугаар зүйлийн дагуу авна.

д) Урьд нь хяналтад хамрагдаагүй байсан бөгөөд IV жагсаалтад нэмсэн бодисын талаар ийм мэдэгдэл өгсөн тал тухайн бодистой холбогдуулан:

i) бэлтгэх, худалдах, түгээхэд 8 дугаар зүйлд нийцүүлэн тусгай зөвшөөрөл шаардана;

ii) экспорт болон импортыг хориглох болон хязгаарлахтай холбогдуулан 13 дугаар зүйлийн үүргийг биелүүлнэ;

iii) дээр дурдсан үүргийг биелүүлэхтэй холбогдуулан батласан хууль буюу журамд харш үйлдлийг зогсоох арга хэмжээг 22 дугаар зүйлийн дагуу авна.

е) Илүү чанга хяналт болон үүргийг заасан Жагсаалт руу шилжүүлсэн аль нэг бодисын талаар ийм мэдэгдэл өгсөн тал энэхүү конвенцийн уг бодисын урьд нь орсон байсан Жагсаалтад хэрэглэгдэх бүх заалтыг наад зах нь хэрэглэнэ.

8. а) Энэ зүйлийн дагуу гаргасан Комиссын шийдвэрийг тухайн шийдвэрийн талаархи мэдэгдлийг хүлээн авснаас хойш 180 хоногийн дотор гаргасан аль нэг талын хүсэлтээр Зөвлөл хянан үзнэ. Хянан үзэх тухай хүсэлтийг түүний үндэслэл болох холбогдох бүх мэдээллийн хамт Ерөнхий нарийн бичгийн даргад илгээнэ.

б) Ерөнхий нарийн бичгийн дарга хянан үзэх тухай хүсэлтийн хуулбар болон холбогдох мэдээллийг Комисс, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон бүх талд дамжуулж саналаа ер хоногийн дотор өгөхийг санал болгоно. Хүлээн авсан бүх саналыг хэлэлцүүлэхээр Зөвлөлд өгнө.

с) Зөвлөл нь Комиссын шийдвэрийг батлаж, өөрчилж эсхүл цуцалж болно. Зөвлөлийн шийдвэрийн тухай мэдэгдлийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн бүх улс, гишүүн бус энэхүү конвенцийн оролцогч улс, Комисс, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон Хороонд дамжуулна.

д) Хянан үзэх хүртэл Комиссын анхны шийдвэр 7 дахь хэсгийг мөрдөхийн хамт хүчин төгөлдөр хэвээр байна.

9. Энэхүү конвенцид үл хамаарагдах боловч сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар бэлтгэхэд ашиглаж болох бодисын хувьд талууд амьдралд хэрэгжүүлэх боломжтой хяналтын арга хэмжээг хэрэглэх талаар бүхий л хүчин чармайлтаа гаргана.

3 дугаар зүйл

Бэлдмэлийн хяналтад хамаарах тусгай заалтууд

1. Энэ зүйлийн дор дурдсан хэсгүүдэд зааснаас бусад тохиолдолд бэлдмэлийг түүний найрлагад орсон сэтгэцэд нөлөөлөх бодисын адил хяналтын арга хэмжээнд хамруулах бөгөөд хэрэв найрлагад нь нэгээс илүү тийм бодис орсон бол хамгийн чанга хяналтан дор байдаг бодист хэрэглэгдэх арга хэмжээг хэрэглэнэ.

2. Хэрэв I жагсаалтад орсон бодисоос бусад сэтгэцэд нөлөөлөх бодис агуулсан бэлдмэл нь түүнийг урвуулан хэрэглэх эрсдэлгүй эсхүл ялимгүй эрсдэлтэй бөгөөд тэрхүү бодисыг урвуулан хэрэглэх боломжтой хэмжээгээр хялбар аргаар гаргаж авах бололцоогүй, улмаар уг бэлдмэл нь олон нийтийн эрүүл мэнд болон нийгэмд бэрхшээл учруулахгүй байдлаар найруулагдсан бол 3 дахь хэсэгт нийцүүлэн тухайн бэлдмэлийг энэхүү конвенцид заасан хяналтын зарим арга хэмжээнээс чөлөөлж болно.

3. Хэрэв аль нэг тал бэлдмэлийн талаар өмнөх хэсгийн дагуу аливаа зүйл олж тогтоосон бол уг бэлдмэлийг өөрийн оронд буюу бүс нутгуудынхаа аль нэгэнд энэхүү конвенцид заасан хяналтын аливаа эсхүл бүх арга хэмжээнээс дор дурдсан шаардлагуудаас бусад тохиолдолд чөлөөлөхөөр шийдвэрлэж болно:

- a) 8 дугаар зүйл (тусгай зөвшөөрөл)-ийн бэлтгэхэд хамаарах заалт;
- b) 11 дүгээр зүйл (бүртгэл)-ийн чөлөөлөгдсөн бэлдмэлд хамаарах заалт;
- c) 13 дугаар зүйл (экспорт болон импортыг хориглох болон хязгаарлах);
- d) 15 дугаар зүйл (хяналт шалгалт)-ийн бэлтгэхэд хамаарах заалт;
- e) 16 дугаар зүйл (талуудын өгөх илтгэл)-ийн чөлөөлөгдсөн бэлдмэлд хамаарах заалт;
- f) 22 дугаар зүйл (шийтгэлийн тухай заалт)-ийн дээр дурдсан үүргийг биелүүлэхтэй холбогдуулан батласан хууль буюу журамд харш үйлдлийг зогсооход шаардлагатай хэмжээнд.

Аль нэг тал аливаа ийм мэдэгдэл, чөлөөлөгдсөн бэлдмэлийн нэр болон найрлагын тухай, түүнчлэн хяналтын ямар арга хэмжээнээс чөлөөлсөн тухайгаа Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэнэ. Ерөнхий нарийн бичгийн дарга мэдэгдлийг бусад тал, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон Хороонд дамжуулна.

4. Хэрэв аль нэг тал, эсхүл Дэлхийн эрүүл мэндийн байгууллага 3 дахь хэсгийн дагуу чөлөөлөгдсөн бэлдмэлийн талаар тийнхүү чөлөөлснийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хүчингүй болгохыг шаардахуйц гэж үзэх мэдээлэлтэй бол энэ тухайгаа Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэж, мэдэгдлийг батлах мэдээллийг түүнд өгнө. Ерөнхий нарийн бичгийн дарга тийм мэдэгдэл болон холбогдолтой гэж үзсэн мэдээллийг талууд болон Комисст, түүнчлэн мэдэгдлийг аль нэг тал өгсөн тохиолдолд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагад дамжуулна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

2 дахь хэсэгт заасан асуудалтай холбогдуулан уг бэлдмэлийн үнэлгээг хэрэв тухайн бэлдмэл чөлөөлөгдөхөө болих нь зүйтэй хяналтын арга хэмжээ байгаа бол тийм арга хэмжээний тухай зөвлөмжийн хамт Комисст мэдэгдэнэ. Комисс нь үнэлгээ нь анагаах ухааны болон эрдэм шинжилгээний асуудалд шийдвэрлэх үүрэгтэй Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдэгдлийг харгалзан үзэж, уг асуудалд холбогдолтой гэж үзэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүй, захиргааны болон бусад хүчин зүйлийг харгалзан уг бодисыг хяналтын аливаа, эсхүл бүх арга хэмжээнээс чөлөөлөхийг зогсоохоор шийдвэрлэж болно. Энэ хэсгийн дагуу Комиссоос гаргасан аливаа шийдвэрийн тухай Ерөнхий нарийн бичгийн дарга Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн бүх улс, гишүүн бус энэхүү конвенцийн оролцогч улс, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон Хороонд мэдэгдэнэ. Бүх тал хяналтын тухайн арга хэмжээ буюу арга хэмжээнүүдээс чөлөөлснийг зогсоох арга хэмжээг Ерөнхий нарийн бичгийн даргын мэдэгдлийн өдрөөс эхлэн 180 хоногийн дотор авна.

4 дүгээр зүйл

Хяналт тавих хүрээтэй холбогдох бусад тусгай заалт

I жагсаалтад орсноос бусад сэтгэцэд нөлөөлөх бодисын хувьд талууд дараахь зүйлийг зөвшөөрч болно:

а) Олон улсын аялал хийж буй хүмүүс хувийн хэрэглээндээ зориулан бага хэмжээний бэлдмэл авч явах; харин эдгээр бэлдмэлийг хууль ёсоор олж авсан талаар тал бүр нотлуулах эрхтэй;

б) Сэтгэцэд үл нөлөөлөх бодис буюу бүтээгдэхүүн бэлтгэхийн тулд аж үйлдвэрт хэрэглэх, чингэхдээ ийм бодисыг энэхүү конвенцоор шаардсан хяналтын арга хэмжээг хэрэглэхийн хамт, сэтгэцэд нөлөөлөх тухайн бодисыг амьдралд урвуулан хэрэглэх буюу гаргаж авах байдалд хүртэл хэрэглэх;

в) Ан амьтан барих зорилгоор ийм бодис хэрэглэхийг эрх бүхий байгууллагаас тусгайлан зөвшөөрөгдсөн этгээд уг бодисыг ийм зорилгоор энэхүү конвенцоор шаардсан хяналтын арга хэмжээг хэрэглэхийн хамт хэрэглэх.

5 дугаар зүйл

Анагаах ухааны болон эрдэм шинжилгээний зорилгоор хэрэглэхээр хязгаарлах

1. Тал бүр I жагсаалтад орсон бодисын хэрэглээг энэхүү конвенцийн 7 дугаар зүйлд заасны дагуу хязгаарлана.

2. Тал бүр 4 дүгээр зүйлд зааснаас бусад тохиолдолд II, III, IV жагсаалтад орсон бодисыг анагаах ухааны болон эрдэм шинжилгээний зорилгоор бэлтгэх, экспортлох, импортлох, түгээх, нөөцлөх, худалдаалах, ашиглах болон эзэмшихийг өөрийн зохимжтой гэж үзсэн арга хэмжээгээр хязгаарлана.

3. II, III, IV жагсаалтад орсон бодисыг эзэмшихийг хууль ёсоор зөвшөөрөл олгосноос бусад тохиолдолд талууд аль болох зөвшөөрөхгүй байвал зохино.

6 дугаар зүйл

Захиргааны тусгай нэгж

Энэхүү конвенцийн заалтуудыг хэрэглэх зорилгоор тал бүр захиргааны тусгай нэгжийг аль болох байгуулж, ажиллуулбал зохих бөгөөд ийм нэгж нь мансууруулах эмийн хяналтын тухай конвенцуудын заалтын дагуу байгуулагдсан захиргааны тусгай нэгжтэй адил байж, ингэснээрээ давуу байдалтай байж, эсхүл түүнтэй нягт хамтран ажиллаж болно.

7 дугаар зүйл

I жагсаалтад орсон бодисын талаархи тусгай заалтууд

I жагсаалтад орсон бодисуудын хувьд талууд:

а) Өөрийн засгийн газрын шууд хяналтан дор, эсхүл түүнээс тусгайлан зөвшөөрсөн анагаах ухааны болон эрдэм шинжилгээний байгууллагуудад зохих ёсоор зөвшөөрөл авсан этгээд эрдэм шинжилгээний, эсхүл анагаах ухааны маш хязгаарагдмал зорилгоор хэрэглэхээс бусад тохиолдолд бүх хэрэглээг хориглоно;

б) Бэлтгэх, худалдаалах, түгээх, эзэмшихийг тусгай зөвшөөрөл эсхүл урьдчилан авсан зөвшөөрлийн дагуу хэрэгжүүлэхийг шаардана;

с) (а), (б) хэсэгт дурдсан үйл ажиллагаа, үйлдэлд нарийн нягт хяналт тавина;

д) Зохих ёсоор зөвшөөрөгдсөн этгээдэд нийлүүлэх хэмжээг түүний зөвшөөрөгдсөн зорилгод шаардлагатай тоо хэмжээгээр хязгаарлан олгоно;

е) Бодисыг олж авсан болон тэдгээрийн хэрэглээг дэлгэрэнгүй тусгасан бүртгэл хөтлөж байхыг анагаах ухааны болон эрдэм шинжилгээний чиг үүрэг гүйцэтгэж байгаа этгээдүүдээс шаардах бөгөөд тэрхүү бүртгэлийг түүнд бүртгэгдсэн хамгийн сүүлчийн хэрэглээнээс хойш наад зах нь хоёр жил хадгална;

ф) Экспортлогч болон импортлогч нь хоёулаа тус тус экспортлогч болон импортлогч орон буюу бүс нутгийн эрх бүхий байгууллага, эсхүл энэ зорилгоор тэдгээр орон буюу бүс нутгийн эрх бүхий байгууллагаас тусгайлан зөвшөөрөгдсөн бусад этгээд буюу байгууллага байхаас бусад тохиолдолд экспортлох болон импортлохыг хориглоно. II жагсаалтад орсон бодисуудад экспорт болон импортын зөвшөөрөл олгох тухай 12 дугаар зүйлийн I дэх хэсгийн шаардлагыг I жагсаалтад орсон бодисуудад мөн хэрэглэнэ.

8 дугаар зүйл

Тусгай зөвшөөрөл

1. Талууд II, III, IV жагсаалтад орсон бодисуудыг бэлтгэх, худалдаалах (үүнд экспорт болон импортын худалдаа багтана), түгээхийг тусгай зөвшөөрөл, эсхүл хяналтын төсөөтэй өөр арга хэмжээний дагуу хэрэгжүүлэхийг шаардана.

2. Талууд:

а) I дэх хэсэгт дурдсан бодисыг бэлтгэх, худалдаалах (үүнд экспорт болон импортын худалдаа багтана), эсхүл түгээх үйл ажиллагаа явуулж буюу эрхэлж байгаа зохих ёсоор зөвшөөрөгдсөн бүх этгээд болон байгууллагыг хянана;

б) Тийнхүү бэлтгэх, худалдаалах, эсхүл түгээх үйл ажиллагаа явагдаж болох байгууллага болон байрыг тусгай зөвшөөрөл, эсхүл хяналтын төсөөтэй өөр арга хэмжээний дагуу хянана;

с) Нөөц хулгайлах буюу өөрөөр алдагдахаас урьдчилан сэргийлэхийн тулд тэдгээр байгууллага болон байрны хувьд аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авна.

3. Энэ зүйлийн 1 болон 2 дахь хэсгийн тусгай зөвшөөрөл олгох болон хяналтын төсөөтэй өөр арга хэмжээнд хамаарах заалтуудыг эмчилгээний буюу эрдэм шинжилгээний чиг үүрэг гүйцэтгэхийг зохих ёсоор зөвшөөрөгдсөн этгээдүүдэд уг чиг үүргээ гүйцэтгэж байхад нь хэрэглэхгүй.

4. Талууд энэхүү конвенцид нийцүүлэн тусгай зөвшөөрөл авсан эсхүл энэ зүйлийн 1 дэх хэсэг эсхүл 7 дугаар зүйлийн (b) дэд хэсгийн дагуу өөрөөр зөвшөөрөгдсөн бүх этгээд энэхүү конвенцийг хэрэгжүүлэх үүднээс гаргасан хууль, журмын заалтыг үр дүнтэй, ягштал гүйцэтгэх хангалттай мэдлэг, чадвартай байхыг шаардана.

9 дүгээр зүйл

Жор

1. Хувь хүмүүс зохих ёсоор зөвшөөрөл авсны дагуу эмчилгээний буюу эрдэм шинжилгээний чиг үүргийг хэрэгжүүлэхээр II, III, IV жагсаалтад орсон бодисыг хууль ёсоор олж авах, хэрэглэх, олгох буюу хангаж болохоос бусад тохиолдолд эдгээр бодисыг зөвхөн эмчийн жороор хувь хүмүүсийн хэрэглээнд нийлүүлэх буюу олгохыг талууд шаардана.

2. Талууд II, III, IV жагсаалтад орсон бодисын жорыг эмнэлгийн тогтсон дадалд нийцүүлэн олон нийтийн эрүүл мэнд, сайн сайхан байдлыг хамгаалах журам, тухайлбал тэдгээрийг давтан хэрэглэж болох тоо, үйлчлэх хугацааны талаархи журмын дагуу олгох явдлыг хангах арга хэмжээг авна.

3. I дэх хэсгийн заалтыг үл харгалзан аль нэг тал, хэрэв түүний үзэж байгаагаар орон нутгийн нөхцөл байдал тийнхүү шаардаж байвал, түүнчлэн өөрийн зааж болох нөхцлийн дагуу, түүний дотор бүртгэл хөтлөх нөхцлийн дагуу онцгой тохиолдолд хувь хүмүүст эмнэлгийн зорилгоор хэрэглэхэд нь зориулан III болон IV жагсаалтад орсон бодисыг талуудын тохиролцсон хязгаарлалтын хүрээнд бага хэмжээгээр өөрийн үзэмжээр, жоргүйгээр олгохыг өөрийн орны буюу түүний зарим хэсэгт олон нийтийн эрүүл мэндийг хариуцдаг эрх бүхий байгууллагаас томилсон тусгай зөвшөөрөл бүхий эмийн санч буюу жижиглэн худалдаа эрхлэгч бусад этгээдэд зөвшөөрч болно.

10 дугаар зүйл

Сав боодлын сануулах бичээс болон сурталчилгаа

1. Тал бүр Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын журам буюу зөвлөмжийг харгалзан үзэж, сэтгэцэд нөлөөлөх бодисын жижиглэн худалдах сав боодлын

боломжтой бол шошгон дээр, мөн ямар ч тохиолдолд дагалдах хуудсан дээр түүний үзэж байгаагаар хэрэглэгчийн аюулгүй байдалд шаардлагатай хэрэглэх заавар, түүний дотор сэрэмжлүүлэг болон сануулга байхыг шаардана.

2. Тал бүр өөрийн үндсэн хуулийн заалтыг зохих ёсоор харгалзан ийм бодисыг олон нийтэд сурталчлахыг хориглоно.

II дүгээр зүйл

Бүртгэл

1. Талууд I жагсаалтад орсон бодисуудын хувьд бэлтгэсэн тоо хэмжээ болон нөөцийн тоо хэмжээний талаар, түүнчлэн олж авсан, олгосон тохиолдол бүрт тоо хэмжээ, он, сар, өдөр, нийлүүлэгч болон хүлээн авагчийн талаар дэлгэрэнгүй тусгасан бүртгэлийг тал бүрийн тогтоосон журмаар хөтлөж байхыг 7 дугаар зүйлийн дагуу тэдгээр бодисыг худалдаалах болон түгээх зөвшөөрөл авсан бэлтгэгч болон бусад бүх этгээдээс шаардана.

2. Талууд II болон III жагсаалтад орсон бодисын хувьд бэлтгэсэн тоо хэмжээний талаар, түүнчлэн олж авсан, олгосон тохиолдол бүрт тоо хэмжээ, он, сар, өдөр, нийлүүлэгч болон хүлээн авагчийн талаар дэлгэрэнгүй тусгасан бүртгэлийг тал бүрийн тогтоосон журмаар хөтлөж байхыг бэлтгэгч, бөөний худалдаа эрхлэгч, экспортлогч болон импортлогчоос шаардана.

3. Талууд II жагсаалтад орсон бодисын хувьд олж авсан, олгосон тохиолдол бүрт тоо хэмжээ, он, сар, өдөр, нийлүүлэгч болон хүлээн авагчийн талаар дэлгэрэнгүй тусгасан бүртгэлийг тал бүрийн тогтоосон журмаар хөтлөж байхыг жижиглэн худалдаа эрхлэгч, эмнэлэг, сувилал болон эрдэм шинжилгээний байгууллагуудаас шаардана.

4. Талууд III жагсаалтад орсон бодисыг жижиглэн түгээгч, эмнэлэг, сувилал болон эрдэм шинжилгээний байгууллагуудын олж авсан, олгосон талаархи мэдээлэл хялбар хүртээлтэй байх явдлыг зохих аргаар өөрийн орны мэргэжлийн болон худалдааны дадлыг харгалзан үзэж хангана.

5. Талууд IV жагсаалтад орсон бодисын хувьд бэлтгэсэн, экспортлосон болон импортлосон тоо хэмжээний талаар дэлгэрэнгүй тусгасан бүртгэлийг тал бүрийн тогтоосон журмаар хөтлөж байхыг бэлтгэгч, экспортлогч болон импортлогчоос шаардана.

6. Талууд чөлөөлөгдсөн бэлдмэлийг бэлтгэхэд хэрэглэсэн сэтгэцэд нөлөөлөх бодис бүрийн тоо хэмжээ, түүнчлэн түүнээс бэлтгэсэн чөлөөлөгдсөн бэлдмэлийн мөн чанар, нийт тоо хэмжээ болон анхны олголтын талаар бүртгэл хөтлөж байхыг 3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн дагуу чөлөөлөгдсөн бэлдмэлийг бэлтгэгчээс шаардана.

7. Талууд 16 дугаар зүйлийн дагуу илтгэл өгөх зорилгод шаардлагатай энэ зүйлд дурдсан бүртгэл болон мэдээллийг наад зах нь хоёр жил хадгалах явдлыг хангана.

12 дугаар зүйл

Олон улсын худалдаанд хамаарах заалтууд

1. а) I, эсхүл II жагсаалтад орсон бодисын экспорт буюу импортыг зөвшөөрч байгаа тал бүр тухайн экспорт буюу импорт тус бүрт тэр нь нэг буюу хэд хэдэн бодисыг хамарснаас үл хамааран Комиссоос тогтоох маягтаар тус тусд нь импорт буюу экспортын зөвшөөрөл авахыг шаардана.

б) Ийм зөвшөөрөлд олон улсын бүртгэгдээгүй буюу ийм нэр байхгүй тохиолдолд тухайн бодисын Жагсаалтад заасан нэр, экспортлох буюу импортлох тоо хэмжээ, эмийн хэлбэр, экспортлогч болон импортлогчийн нэр, хаяг, тэрчлэн экспорт буюу импортыг хийсэн байх ёстой хугацааг заана. Хэрэв тухайн бодисыг бэлдмэлийн хэлбэрээр экспортлож, эсхүл импортлож байгаа бөгөөд тухайн бэлдмэл нь нэртэй бол нэрийг нь нэмж өгнө. Экспортын зөвшөөрөлд импортын зөвшөөрлийн дугаар, он, сар, өдөр, зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагын хаягийг мөн заана.

с) Экспортын зөвшөөрөл олгохын өмнө талууд импортлогч орон буюу бүс нутгийн эрх бүхий байгууллагаас олгосон импортын зөвшөөрлийг шаардах бөгөөд уг зөвшөөрөл нь түүнд дурдсан бодис буюу бодисуудыг импортлохыг зөвшөөрснийг гэрчилж, ийм зөвшөөрлийг экспортын зөвшөөрөл хүсэж буй этгээд буюу байгууллага гаргаж өгнө.

д) Ачаа бүрийг экспортын зөвшөөрлийн хуулбар дагалдах бөгөөд экспортын зөвшөөрөл олгосон засгийн газар нэг хуулбарыг импортлогч орон буюу бүс нутгийн засгийн газарт илгээнэ.

е) Импортлосны дараа импортлогч орон буюу бүс нутгийн засгийн газар экспортын зөвшөөрлийг бодит импортын хэмжээг гэрчилсэн тэмдэглэл хийж экспортлогч орон буюу бүс нутгийн засгийн газарт буцаана.

2. а) Талууд нь III жагсаалтад орсон бодисын экспорт тус бүрт Комиссоос тогтоох маягтаар дараахь мэдээллийг агуулсан мэдэгдлийг гурван хувь бичихийг экспортлогчдоос шаардана:

i) Экспортлогч болон импортлогчийн нэр, хаяг;

ii) Олон улсын бүртгэлд ороогүй нэр буюу ийм нэр байхгүй тохиолдолд тухайн бодисын Жагсаалтад заасан нэр;

iii) Экспортлож буй бодисын тоо хэмжээ, эмийн хэлбэр, түүнчлэн хэрэв бэлдмэл хэлбэртэй бөгөөд тухайн бэлдмэл нь нэртэй бол түүний нэр;

iv) Ачуулсан он, сар, өдөр.

б) Экспортлогчид нь мэдэгдлийн хоёр хуулбарыг өөрийн орон буюу бүс нутгийн эрх бүхий байгууллагад өгнө. Гурав дахь хуулбарыг ачаанд дагалдуулна.

с) III жагсаалтад орсон бодис нутаг дэвсгэрээс нь экспортлогдож буй тал нь аль болох богино хугацаанд, гэхдээ ачуулсан өдрөөс хойш ерэн хоногоос хэтрүүлэхгүйгээр импортлогч орон буюу бүс нутгийн эрх бүхий байгууллагад экспортлогчоос хүлээж авсан мэдэгдлийн нэг хуулбарыг түүнийг хүлээж авсныг баталгаажуулахыг хүссэн хүсэлтийн хамт баталгаат шуудангаар илгээнэ.

d) Ачааг хүлээн авмагц ачааг дагалдуулсан бөгөөд хүлээж авсан тоо хэмжээ, он, сар, өдрийг зохих ёсоор тэмдэглэсэн хуулбарыг өөрийн орон буюу бүс нутгийн эрх бүхий байгууллагад дамжуулахыг талууд нь импортлогчоос шаардаж болно.

3. I, II жагсаалтад орсон бодисын хувьд дараахь нэмэлт заалтыг хэрэглэнэ:

a) Талууд нь чөлөөт боомт болон бүсэд өөрийн нутаг дэвсгэрийн бусад хэсэгт мөрддөг хяналт, шалгалтыг хэрэгжүүлж болох бөгөөд чингэхдээ илүү чанга арга хэмжээг хэрэглэж болно.

b) Экспортын зөвшөөрөлд нэрлэснээс өөр этгээдийн шуудангийн хайрцаг, эсхүл банкны дансанд ачаа экспортлохыг хориглоно.

c) I жагсаалтад орсон бодисыг баталгаат агуулах руу экспортлохыг хориглоно. Импортлогч орны засгийн газар экспортын зөвшөөрөл хүссэн этгээд буюу байгууллагын гаргаж өгсөн импортын зөвшөөрөлд II жагсаалтад орсон бодис агуулсан ачааг баталгаат агуулахад байрлуулах зорилгоор импортлохыг зөвшөөрснөө гэрчлээгүй тохиолдолд тухайн ачааг баталгаат агуулахад экспортлохыг хориглоно. Ийм тохиолдолд экспортын зөвшөөрөлд тухайн ачааг ийм зорилгоор экспортлож байгааг гэрчилнэ. Баталгаат агуулахаас ачааг гаргах бүрд тухайн агуулах харьяалагдах эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авахыг шаардах бөгөөд гадаадад ачуулах тохиолдолд ийнхүү гаргахыг энэхүү конвенцийн утга агуулгаар шинэ экспорт гэж үзнэ.

d) Аль нэг талын нутаг дэвсгэрт орж буй буюу нутаг дэвсгэрээс гарч буй ачаанд экспортын зөвшөөрөл дагалдуулаагүй бол ийм ачааг эрх бүхий байгууллага саатуулна.

e) Тухайн талын эрх бүхий байгууллагад тухайн ачааны экспортын зөвшөөрлийн хуулбарыг гаргаж өгөөгүй тохиолдолд аль нэг тал өөр улсад ачуулсан аливаа бодисыг өөрийн нутаг дэвсгэрээр өнгөрүүлэхийг түүнийг ачсан тээврийн хэрэгслээс буулгасан эсэхийг үл харгалзан зөвшөөрөхүй.

f) Ачаа өнгөрч буй орон буюу бүс нутгийн засгийн газар тийнхүү чиглэлээ өөрчлөхийг зөвшөөрөөгүй бол бодис бүхий ачааг өнгөрүүлэхийг зөвшөөрсөн аливаа орон буюу бүс нутгийн эрх бүхий байгууллага ачааг дагалдуулсан экспортын зөвшөөрлийн хуулбарт нэрлэсэн чиглэлээс өөр чиглэлд ачуулахгүй байхаас урьдчилан сэргийлэхийн тулд зохих бүх арга хэмжээг авна. Дамжин өнгөрүүлэгч орон буюу бүс нутгийн засгийн газар чиглэлээ өөрчлөх талаархи аливаа хүсэлтийг авч үзэхдээ тийнхүү чиглэл өөрчлөхийг тухайн дамжин өнгөрүүлэгч орон буюу бүс нутгаас шинэ чиглэлийн орон буюу бүс нутаг руу экспортлож байгаа мэтээр үзнэ. Хэрэв тийнхүү чиглэл өөрчлөхийг зөвшөөрсөн бол I дэх хэсгийн (e) дэд хэсгийн заалтыг дамжин өнгөрүүлэгч орон буюу бүс нутаг болон ачааг анх экспортлосон орон буюу бүс нутгийн хооронд мөн хэрэглэнэ.

g) Бодис бүхий ямар ч ачааг дамжин өнгөрүүлэх явцад эсхүл баталгаат агуулахад хадгалах хооронд тухайн бодисын мөн чанарыг өөрчлөх ямарваа үйлдэл хийж болохгүй. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр савлагааг өөрчилж болохгүй.

h) Бодисыг аль нэг талын нутаг дэвсгэрээр өнгөрүүлэхэд хамаарах (e)-гээс (g) хүртэлх дэд хэсгийн заалтыг тухайн ачааг дамжин өнгөрүүлэгч орон буюу бүс нутагт

газардахгүй агаарын хөлгөөр тээвэрлэж буй тохиолдолд хэрэглэхгүй. Хэрэв агаарын хөлөг ийм орон буюу бүс нутагт газардвал тэдгээр заалтыг тухайн нөхцөл байдал шаардсан хэмжээгээр хэрэглэнэ.

й) Энэ хэсгийн заалт дамжин өнгөрч буй ийм бодист талуудын аль нэг нь хэрэгжүүлж болох хяналтыг хязгаарлаж буй олон улсын аливаа хэлэлцээрийн заалтыг хөндөхгүй.

13 дугаар зүйл

Импорт буюу экспортыг хориглох болон хязгаарлах

1. Аль нэг тал нь Ерөнхий нарийн бичгийн даргаар дамжуулан II, III, эсхүл IV жагсаалтад орсон нэг буюу хэд хэдэн бодисыг өөрийн оронд буюу бүс нутгуудынхаа аль нэгэнд импортлохыг хориглож буйгаа бусад бүх талд мэдэгдэж болно. Ингэхдээ Жагсаалтыг мэдэгдэлдээ заана. Аливаа ийм мэдэгдэлд бодисын нэрийг II, III, эсхүл IV жагсаалтад заасан байдлаар нь заана.

2. Хэрэв аль нэг тал I дэх хэсгийн дагуу импортлохыг хориглож буй мэдэгдэл авмагц мэдэгдэлд заасан нэг ч бодисыг мэдэгдэл өгөгч талын орон буюу бүс нутгуудын аль нэгэнд экспортлохгүй байх явдлыг хангах арга хэмжээг авна.

3. Өмнөх хэсгүүдийн заалтыг үл харгалзан, I дэх хэсгийн дагуу мэдэгдэл өгсөн тал тухайн бодис, эсхүл ийм бодис агуулж буй бэлдмэлийн тодорхой тоо хэмжээг импортлохыг тохиолдол тус бүрт импортын тусгай зөвшөөрлөөр зөвшөөрч болно. Импортлогч орны тусгай зөвшөөрөл олгогч эрх бүхий байгууллага импортлогч болон экспортлогчийн нэр, хаягийг заасан импортын тусгай зөвшөөрлийн хоёр хуулбарыг экспортлогч орон буюу бүс нутгийн эрх бүхий байгууллагад илгээх бөгөөд дараа нь экспортлогч орон буюу бүс нутгийн эрх бүхий байгууллага нь ачилт хийхийг экспортлогчид зөвшөөрнө. Экспортлогч орон буюу бүс нутгийн эрх бүхий байгууллагаас зохих ёсоор батласан импортын тусгай зөвшөөрлийн нэг хуулбар нь ачилтыг дагалдана.

14 дүгээр зүйл

Олон улсын тээврийн хөлөг онгоц, агаарын хөлөг, эсхүл нийтийн тээврийн бусад хэрэгслээр эмнэлгийн анхны тусламжийн зорилгоор сэтгэцэд нөлөөлөх бодис тээвэрлэх талаархи тусгай заалтууд

1. Эмнэлгийн анхны тусламжийн зорилгоор эсхүл яаралтай тохиолдолд хэрэглэх II, III, эсхүл IV жагсаалтад орсон бодисын аяллын явцад хэрэгтэй байж болох хязгаарлагдмал тоо хэмжээг хөлөг онгоц, агаарын хөлөг, эсхүл олон улсын төмөр замын галт тэрэг болон автобус зэрэг олон улсын нийтийн тээврийн бусад хэлбэрт олон улсад авч явахыг энэхүү конвенцийн утга агуулгаар экспорт, импорт, эсхүл аль нэг орноор өнгөрөх үйлдэл гэж үзэхгүй.

2. I дэх хэсэгт дурдсан бодисыг зүй бусаар хэрэглэх, эсхүл хууль бус зорилгоор чиглэлийг нь өөрчлөхөөс урьдчилан сэргийлэх хамгаалалтын зохих арга хэмжээг бүртгэлийн орон авна. Комисс нь олон улсын зохих байгууллагуудтай зөвлөлдөж хамгаалалтын ийм арга хэмжээг зөвлөмж болгоно.

3. I дэх хэсгийн дагуу хөлөг онгоц, агаарын хөлөг, эсхүл олон улсын нийтийн тээврийн бусад хэлбэрт авч явж буй бодисын хувьд бүртгэлийн орны хууль, журам,

зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийг мөрдөх бөгөөд эдгээр тээврийн хэрэгсэл дээр шалгалт, хяналт шалгалт болон хяналтын бусад арга хэмжээ авч явуулах дотоодын эрх бүхий байгууллагын эрхийг хөндөхгүй. Яаралтай тохиолдолд ийм бодисыг хэрэглэх нь 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн шаардлагыг зөрчсөн гэж үзэхгүй.

15 дугаар зүйл

Хяналт шалгалт

Талууд сэтгэцэд нөлөөлөх бодисыг бэлтгэгч, экспортлогч, импортлогч болон бөөний болон жижиглэн худалдаа эрхлэгч, түүнчлэн ийм бодисыг хэрэглэдэг эмнэлгийн болон эрдэм шинжилгээний байгууллагыг хянан шалгах тогтолцоотой байна. Тэд шаардлагатай гэж үзсэн үедээ байр, нөөц, бүртгэлд хяналт шалгалт хийнэ.

16 дугаар зүйл

Талуудын өгөх илтгэл

1. Өөрийн чиг үүргийг биелүүлэхэд шаардлагатай гэж Комиссын хүсэж болох мэдээлэл, тухайлбал энэхүү конвенц нутаг дэвсгэрт нь хэрэгжиж байгаа талаархи дараахь мэдээллийг багтаасан жил бүрийн илтгэлийг талууд Ерөнхий нарийн бичгийн даргад өгнө:

а) Сэтгэцэд нөлөөлөх бодисын талаархи өөрийн хууль, журамд орсон чухал өөрчлөлт; болон

б) Нутаг дэвсгэрт нь сэтгэцэд нөлөөлөх бодисыг урвуулан хэрэглэх, хууль бус эргэлтэд оруулах талаар гарсан томоохон үйл явдал.

2. Талууд мөн 7 дугаар зүйлийн (f) дэд хэсэг, 12 дугаар зүйл болон 13 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт дурдсан засгийн газрын эрх бүхий байгууллагын нэр, хаягийг Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэнэ. Ийм мэдээллийг Ерөнхий нарийн бичгийн дарга талуудын сонорт хүргэнэ.

3. Талууд дараахь шалтгаанаар чухал гэж үзсэн сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлт, эсхүл хууль бус эргэлтийн зүйлийг хурааж авсан аливаа хэргийн талаар тухайн үйл явдал болсны дараа аль болох түргэн Ерөнхий нарийн бичгийн даргад илтгэл өгнө:

а) Шинээр илэрсэн хандлага;

б) Тухайн тоо хэмжээ;

в) Бодисыг олж авсан эх үүсвэрийг заах мэдээ баримт; эсхүл

г) Хууль бус эргэлт эрхлэгчдийн хэрэглэж буй арга.

Илтгэлийн хуулбарыг 21 дүгээр зүйлийн (b) дэд хэсгийн дагуу тараана.

4. Талууд дараахь зүйлийн талаар жил бүрийн дүн бүртгэлийн илтгэлийг Хорооноос бэлтгэсэн маягтаар гаргаж Хороонд өгнө:

а) I болон II жагсаалтад орсон бодис бүрийн хувьд, бэлтгэсэн, орон буюу бүс нутаг бүрт экспортлосон, орон буюу бүс нутаг бүрээс импортлосон тоо хэмжээ, түүнчлэн бэлтгэгчдэд байгаа нөөц;

б) III болон IV жагсаалтад орсон бодис бүрийн хувьд бэлтгэсэн тоо хэмжээ, түүнчлэн экспортлосон болон импортлосон нийт тоо хэмжээ;

в) II болон III жагсаалтад орсон бодис бүрийн хувьд чөлөөлөгдсөн бэлдмэлүүдийг бэлтгэхэд хэрэглэсэн тоо хэмжээ;

д) I жагсаалтад орсон бодисоос бусад бодис бүрийн хувьд 4 дүгээр зүйлийн (b) дэд хэсгийн дагуу аж үйлдвэрийн зорилгоор хэрэглэсэн тоо хэмжээ.

Энэ хэсгийн (a) болон (b) дэд хэсэгт дурдсан бэлтгэсэн бодисын тоо хэмжээнд бэлтгэсэн бэлдмэлийн тоо хэмжээ хамаарахгүй.

5. Аль нэг тал орон буюу бүс нутаг бүрт экспортлосон болон орон буюу бүс нутаг бүрээс импортлосон III, IV жагсаалтад орсон аливаа тухайлсан тодорхой бодисын тоо хэмжээний талаархи ирээдүйн хугацаанд хамаарах дүн бүртгэлийн нэмэлт мэдээллийг Хороонд хүсэлтээр нь өгнө. Мэдээлэл авах хүсэлт болон энэ хэсгийн дагуу өгсөн мэдээллийн аль алийг нууц гэж үзэхийг тухайн тал Хорооноос хүсэж болно.

6. Талууд 1 болон 4 дэх хэсэгт дурдсан мэдээллийг Комисс, эсхүл Хорооны хүсэж болох хэлбэрээр болон Комисс эсхүл Хорооны хүсэж болох хугацаанд өгнө.

17 дугаар зүйл

Комиссын чиг үүрэг

1. Комисс нь энэхүү конвенцийн зорилго, түүний заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой бүх асуудлыг авч үзэж, тэдгээрт хамаарах зөвлөмж өгч болно.

2. 2 болон 3 дугаар зүйлд заасан Комиссын шийдвэрийг Комиссын гишүүдийн гуравны хоёрын олонхийн саналаар гаргана.

18 дугаар зүйл

Хорооны илтгэл

1. Хороо нь өөрийн мэдэлд байгаа дүн бүртгэлийн мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ, зохих тохиолдолд засгийн газруудаас өгсөн эсхүл шаардсан тайлбар байвал тийм тайлбар бүхий өөрийн ажлын жил бүрийн илтгэлийг Хорооны гаргахыг хүсэх аливаа тэмдэглэл, зөвлөмжийн хамт бэлтгэнэ. Хороо шаардлагатай гэж үзсэн нэмэлт илтгэл хийж болно. Илтгэлийг Комиссоор дамжуулан Зөвлөлд өргөн барих бөгөөд Комисс нь тохиромжтой гэж үзсэн тэмдэглэлийг хийж болно.

2. Хорооны илтгэлийг талуудад тарааж, дараа нь Ерөнхий нарийн бичгийн дарга нийтлүүлнэ. Талууд эдгээр илтгэлийг хязгаарлалтгүйгээр тараахыг зөвшөөрнө.

19 дүгээр зүйл

**Конвенцийн заалтын гүйцэтгэлийг хангах талаар
Хорооны авах арга хэмжээ**

1. а) Хэрэв засгийн газруудаас Хороонд өргөн барьсан мэдээлэл эсхүл, Нэгдсэн Үндэстний Байгууллагын байгууллагуудаас өгсөн мэдээллийг шалган үзсэний үндсэн дээр аль нэг орон буюу бүс нутаг энэхүү конвенцийн заалтыг хэрэгжүүлээгүй шалтгаанаар энэхүү конвенцийн зорилгод хүрэхэд ноцтой аюул учраад байна гэж Хороо үзэх шалтгаан байвал Хороо нь тайлбар өгөхийг тухайн орон буюу бүс нутгийн засгийн газраас хүсэх эхтэй. Талууд, Зөвлөл болон Комиссын анхаарлыг доорх (с) дэд хэсэгт дурдсан асуудалд хандуулах эрхээ эдлэхийн хамт Хороо нь мэдээлэл авах хүсэлт болон энэ дэд хэсгийн дагуу аль нэг засгийн газрын өгсөн тайлбарыг нууц гэж үзнэ.

б) (а) дэд хэсгийн дагуу арга хэмжээ авсны дараа Хороо нь тийм арга хэмжээ авах шаардлагатай гэж үзвэл энэхүү конвенцийн заалтыг гүйцэтгэхэд тухайн нөхцөл байдалд шаардлагатай санагдах засах арга хэмжээ авахыг тухайн засгийн газарт уриалж болно.

с) Хэрэв тухайн засгийн газар (а) дэд хэсгийн дагуу хангалттай тайлбар өгөөгүй, эсхүл (б) дэд хэсгийн дагуу авахыг шаардсан засах арга хэмжээг аваагүй гэж Хороо үзвэл, талууд Зөвлөл болон Комиссын анхаарлыг тухайн асуудалд хандуулж болно.

2. Хороо нь талууд, Зөвлөл, Комиссын анхаарлыг I дэх хэсгийн (с) дэд хэсгийн дагуу аливаа асуудалд хандуулахдаа хэрэв энэ нь шаардлагатай гэж үзвэл сэтгэцэд нөлөөлөх бодисыг тухайн орон буюу бүс нутгаар экспортлох, эсхүл тухайн орон буюу бүс нутагт импортлохыг, эсхүл экспортлох болон импортлохын аль алийг заасан хугацаанд, эсхүл тухайн орон буюу бүс нутаг дахь байдлыг хангалттай сайжирсан гэж Хороо үзэх хүртэл зогсоохыг талуудад зөвлөмж болгож болно.

3. Хороо нь энэ зүйлийн заалтын дагуу авч үзсэн аливаа асуудлаар илтгэл нийтлүүлж Зөвлөлд өгөх эрхтэй бөгөөд Зөвлөл илтгэлийг бүх талд дамжуулна. Хэрэв Хороо нь энэ зүйлийн дагуу гаргасан шийдвэр, эсхүл түүнд хамаарах аливаа мэдээллийг энэ илтгэлд нийтэлж байгаа бол сонирхогч засгийн газрын үзэл бодлыг хэрэв тухайн засгийн газар хүсвэл мөн нийтлэнэ.

4. Хэрэв энэ зүйлийн дагуу нийтлэсэн Хорооны шийдвэрийг аливаа тохиолдолд санал нэгтгэйгээр гаргаагүй бол цөөнхийн үзэл бодлыг тусгана.

5. Тухайн улсад шууд хамааралтай асуудлыг энэ зүйлийн дагуу хэлэлцэж байгаа Хорооны хуралдаанд аливаа улсыг төлөөлөгчөө илгээхээр урина.

6. Энэ зүйлийн дагуу Хорооны гаргах шийдвэрийг Хорооны гишүүдийн нийт тооны гуравны хоёрын олонхийн саналаар гаргана.

7. 2 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн дагуу аль нэг талын гаргасан шийдвэрийн үр дүнд энэхүү конвенцийн зорилгод хүрэхэд ноцтой аюул учраад байна гэж Хороо үзэх шалтгаан байвал дээрх хэсгүүдийн заалтыг мөн хэрэглэнэ.

20 дугаар зүйл

**Сэтгэцэд нөлөөлөх бодис урвуулан
хэрэглэхийн эсрэг арга хэмжээ**

1. Талууд сэтгэцэд нөлөөлөх бодис урвуулан хэрэглэхээс урьдчилан сэргийлэх, тухайн хүнийг эрт таньж тогтоох, эмчлэх, хүмүүжүүлэх, эмнэлгийн дараахь эмчилгээ хийх, нөхөн сэргээх, нийгмийн амьдралд эргүүлэн оруулах талаар боломжтой бүх арга хэмжээг авч, энэ зорилгод хүрэх хүчин чармайлтаа уялдуулан зохицуулна.

2. Талууд сэтгэцэд нөлөөлөх бодис урвуулан хэрэглэгчдийг эмчлэх, эмнэлгийн дараахь эмчилгээ хийх, нөхөн сэргээх, нийгмийн амьдралд эргүүлэн оруулах боловсон хүчний сургалтыг бололцооны хэрээр дэмжинэ.

3. Талууд сэтгэцэд нөлөөлөх бодис урвуулан хэрэглэхийн бэрхшээлтэй асуудал, түүнээс урьдчилан сэргийлэх асуудлыг ойлгохыг ажил нь шаарддаг этгээдүүдэд туслаж, мөн ийм бодисыг урвуулан хэрэглэх явдал өргөн дэлгэрэх эрсдэл байгаа бол ийм ойлголтыг олон нийтэд түгээхийг дэмжинэ.

21 дүгээр зүйл

Хууль бус эргэлтийн эсрэг арга хэмжээ

Талууд өөрийн үндсэн хууль, эрх зүй болон захиргааны тогтолцоог зохих ёсоор харгалзан:

а) Хууль бус эргэлтийн эсрэг урьдчилан сэргийлэх болон цээрлүүлэх арга хэмжээнүүдийг уялдуулан зохицуулахад чиглэсэн арга хэмжээг үндэсний хэмжээнд авна; энэ зорилгоор тэд тийнхүү уялдуулан зохицуулах асуудлыг хариуцсан зохих байгууллагыг тухайн ажилд ашиг тустайгаар томилж болно;

б) Сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг кампанит ажил явуулахад бие биедээ тусалж, тухайлбал, хууль бус эргэлт, эсхүл хууль бус эргэлтийн зүйлийг хурааж авсан аливаа хэргийг илрүүлсэнтэй холбогдуулан 16 дугаар зүйлийн дагуу Ерөнхий нарийн бичгийн даргад хаягласан аливаа илтгэлийн хуулбарыг шууд холбогдогч бусад талд дипломат шугамаар, эсхүл энэ зорилгоор талуудын томилсон эрх бүхий байгууллагаар дамжуулан нэн даруй илгээнэ;

в) Хууль бус эргэлтийн эсрэг уялдуулан зохицуулсан кампанит ажил явуулах үүднээс бие биетэйгээ болон гишүүн нь болох олон улсын эрх бүхий байгууллагатай нягт хамтран ажиллана;

д) Зохих байгууллагуудын хоорондын олон улсын хамтын ажиллагааг шуурхай байлгах явдлыг хангана;

е) Шүүхийн ажиллагаа явуулах зорилгоор хууль зүйн баримт бичгийг олон улсын хэмжээнд дамжуулж байгаа тохиолдолд талуудын томилсон байгууллагуудад шуурхай дамжуулах явдлыг хангана; энэ шаардлага нь хууль зүйн баримт бичгийг дипломат шугамаар илгээхийг шаардах аль нэг талын эрхийг хөндөхгүй.

22 дугаар зүйл

Шийтгэлийн тухай заалт

1. а) Тал бүр энэхүү конвенцийн дагуу хүлээх үүргээ биелүүлэх үүднээс батласан хууль буюу журамд харш, санаатайгаар үйлдсэн аливаа үйлдлийг шийтгэвэл зохих гэмт хэрэг гэж үзэх бөгөөд ноцтой гэмт хэрэгт тохирох шийтгэл, тухайлбал хорих буюу эрх чөлөөг нь хасах бусад шийтгэл хүлээлгэх явдлыг өөрийн үндсэн хуулийн хязгаарлалтыг харгалзан хангана.

б) Сэтгэцэд нөлөөлөх бодис урвуулан хэрэглэдэгчид тийм гэмт хэрэг үйлдсэн бол талууд дээрх хэсгийг үл харгалзан шийтгэл буюу ялын оронд, эсхүл нэмэлт болгож тэднийг эмчлэх, хүмүүжүүлэх, эмнэлгийн дараахь эмчилгээ хийх, нөхөн сэргээх, нийгмийн амьдралд эргүүлэн оруулах арга хэмжээнд 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт нийцүүлэн хамруулахаар зааж болно.

2. Аль нэг талын үндсэн хуулийн хязгаарлалт, эрх зүйн тогтолцоо, дотоодын хуулийг харгалзан:

а) i) 1 дэх хэсгийн дагуу гэмт хэрэгт тооцогдох өөр хоорондоо холбоотой үйлдлийг хэд хэдэн оронд үйлдсэн бол үйлдэл бүрийг тусдаа гэмт хэрэг гэж үзнэ;

ii) тэдгээр гэмт хэргийн аль нэгийг үйлдэхэд санаатайгаар хамтран оролцох, үйлдэхээр үгсэн тохиролцох, завдах, түүнчлэн энэ зүйлд дурдсан гэмт хэрэгт холбогдуулан бэлтгэх үйлдэл хийх болон санхүүгийн үйл ажиллагаа явуулах нь 1 дэх хэсэгт заасны дагуу шийтгэвэл зохих гэмт хэрэг болно;

iii) тийм гэмт хэргийн төлөө гадаад улсад оногдуулсан шийтгэлийг рецидив байдлыг тогтоох зорилгоор харгалзан үзнэ;

iv) тухайн гэмт хэрэг нутаг дэвсгэрт нь үйлдэгдсэн тал, эсхүл хүсэлт гаргуулсан талын хуулиар шилжүүлэн өгөхийг хүлээж авдаггүй бөгөөд уг гэмт этгээд өмнө нь яллагдаж, шүүхээр шийтгэгдээгүй бол уг гэмт этгээдийг нутаг дэвсгэрт нь олж тогтоосон тал тухайн улсын харьяат, эсхүл гадаад улсын харьяат үйлдсэн дээр дурдсан ноцтой гэмт хэргийг мөрдөн шалгана.

б) 1 дэх хэсэг болон 2 дахь хэсгийн (а)(ii) дэд хэсэгт дурдсан гэмт хэргүүдийг аливаа талуудын хооронд байгуулсан болон үүнээс хойш байгуулах шилжүүлэн өгөх тухай аливаа гэрээнд шилжүүлэн өгвөл зохих гэмт хэрэг гэж тусгаж, гэрээ буюу харилцан адил байх зарчмын үндсэн дээр шилжүүлэн өгөх нөхцөл тавьдаггүй аливаа талуудын хооронд шилжүүлэн өгвөл зохих гэмт хэрэг гэж хүлээн зөвшөөрөх нь зүйтэй; чингэхдээ өргөдөл гаргуулсан талын хуульд нийцүүлэн шилжүүлэн өгөх бөгөөд эрх бүхий байгууллагууд нь уг гэмт хэргийг хангалттай ноцтой бус гэж үзсэн тохиолдолд тухайн тал гэмт этгээдийг баривчлах буюу шилжүүлэн өгөхөөс татгалзах эрхтэй.

3. 1, 2 дахь хэсэгт дурдсан гэмт хэргийг үйлдэхэд ашигласан, эсхүл зориулагдсан сэтгэцэд нөлөөлөх аливаа бодис, эсхүл өөр бодис, түүнчлэн аливаа тоног төхөөрөмжийг түр хураах буюу бүрмөсөн хураана.

4. Харьяаллын асуудлын хувьд тухайн талын дотоодын хуулийн заалт энэ зүйлийн заалтаас давуу хүчинтэй байна.

5. Энэ зүйлийн аль ч заалт нь түүнд дурдсан гэмт хэргийг аль нэг талын дотоодын хуульд нийцүүлэн тогтоож, мөрдөн шалгаж, шийтгэх зарчмыг хөндөхгүй.

23 дугаар зүйл

**Энэхүү конвенцид шаардсан хяналтын арга
хэмжээнээс илүү чанга арга хэмжээ хэрэглэх**

Энэхүү конвенцид шаардсан хяналтын арга хэмжээнээс илүү чанга буюу хатуу хяналтын арга хэмжээ авах нь олон нийтийн эрүүл мэнд, сайн сайхныг хамгаалахад хүсүүштэй, эсхүл шаардлагатай гэж аль нэг тал үзвэл тийм арга хэмжээ авч болно.

24 дүгээр зүйл

**Конвенцийн заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдон
олон улсын байгууллагаас гарах зардал**

Тус тусын чиг үүргээ энэхүү конвенцийн дагуу хэрэгжүүлэхэд нь Комисс болон Хорооноос гарах зардлыг Ерөнхий Ассамблейгаас шийдвэрлэсэн байдлаар Нэгдсэн Үндэстний Байгууллага хариуцна. Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн бус талууд Ерөнхий Ассамблейгаас шударга гэж үзэж, тэдгээр талын засгийн газруудтай тухай бүр зөвлөлдөн үнэлж байх хэмжээгээр эдгээр зардалд хувь нэмэр оруулна.

25 дугаар зүйл

**Хүлээн зөвшөөрөх, гарын үсэг зурах,
соёрхон батлах, нэгдэн орох журам**

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүд, Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн бус боловч Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн аль нэг байгууллагын эсхүл Олон улсын цөмийн эрчим хүчний байгууллагын гишүүн эсхүл Олон улсын шүүхийн дүрмийн тал эсхүл Зөвлөлийн урьсан аливаа бусад улс дараахь замаар энэхүү конвенцийн тал болж болно:

- a) түүнд гарын үсэг зурах; эсхүл
- b) соёрхон батлах нөхцөлтэйгээр гарын үсэг зурсны дараа соёрхон батлах; эсхүл
- c) түүнд нэгдэн орох.

2. Конвенц 1972 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг дуустал гарын үсэг зурахад нээлттэй байна. Түүнээс хойш түүнд нэгдэн ороход нээлттэй байна.

3. Батламж жуух бичиг, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

26 дугаар зүйл

Хүчин төгөлдөр болох

25 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан улсын дөч нь соёрхон батлах тайлбаргүйгээр гарын үсэг зурсан, эсхүл батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулснаас хойш ер дэх хоногт Конвенц хүчин төгөлдөр болно.

Өмнөх хэсэгт дурдсанаар сүүлчийн гарын үсэг зурсан, эсхүл хадгалуулсны дараа соёрхон батлах тайлбаргүйгээр гарын үсэг зурж буй, эсхүл батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулж буй аливаа бусад улсын хувьд Конвенц гарын үсэг зурсан өдөр, эсхүл батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулсан өдрөөс хойш ер дэх хоногт хүчин төгөлдөр болно.

27 дугаар зүйл

Хамаарах нутаг дэвсгэр

Аль нэг тал олон улсын харилцааг нь хариуцаж буй харьяа бус бүх нутаг дэвсгэрт тийм нутаг дэвсгэрээс урьдчилан зөвшөөрөл авсан байхыг тухайн тал буюу нутаг дэвсгэрийн Үндсэн хуулиар эсхүл зан заншлаар шаардсанаас бусад тохиолдолд Конвенцийг хэрэглэнэ. Тийм тохиолдолд тухайн тал аль болох богино хугацаанд тухайн нутаг дэвсгэрээс шаардлагатай зөвшөөрлийг авахыг эрмэлзэх бөгөөд зөвшөөрлийг авмагц Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэнэ. Ерөнхий нарийн бичгийн дарга мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс эхлэн Конвенцийг тухайн мэдэгдэлд нэрлэсэн нутаг дэвсгэр буюу нутаг дэвсгэрүүдэд хэрэглэнэ. Харьяа бус нутаг дэвсгэрээс урьдчилан зөвшөөрөл авах шаардлагагүй тохиолдолд сонирхогч тал гарын үсэг зурах, соёрхон батлах эсхүл нэгдэн орохдоо энэхүү конвенцийг хэрэглэх харьяа бус нутаг дэвсгэр буюу нутаг дэвсгэрүүдийг зарлана.

28 дугаар зүйл

Энэхүү конвенцийн зорилгоорх бүс нутаг

Энэхүү конвенцийн зорилгод аль нэг тал нутаг дэвсгэр нь хоёр буюу хэд хэдэн бүс нутагт хуваагдсан, эсхүл хоёр болон хэд хэдэн бүс нутаг нь нэг бүс нутаг болон нэгдсэн тухай Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэж болно.

Хоёр буюу хэд хэдэн тал хоорондоо гаалийн холбоо байгуулсны үр дүнд тэдгээр тал нь энэхүү конвенцийн зорилгод нэг бүс нутаг болж буй тухайгаа Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэж болно.

1, эсхүл 2 дахь хэсгийн дагуу хийсэн аливаа мэдэгдэл түүнийг хийсэн жилийн дараахь жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болно.

29 дүгээр зүйл

Цуцлах

Энэхүү конвенц хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш хоёр жил өнгөрсний дараа аливаа тал өөрийн нэрийн өмнөөс, эсхүл тухайн тал өмнөөс нь олон улсын хариуцлага хүлээсэн бөгөөд 27 дугаар зүйлд нийцүүлэн өгсөн зөвшөөрлөө буцаан

авсан нутаг дэвсгэрийн нэрийн өмнөөс энэхүү конвенцийг бичгээр үйлдсэн баримт бичгээр цуцалж, Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулж болно.

Хэрэв цуцалсан тухайн баримт бичгийг Ерөнхий нарийн бичгийн дарга аливаа жилийн 7 дугаар сарын эхний өдөр буюу түүнээс өмнө хүлээн авсан бол цуцлалт дараагийн жилийн 1 дүгээр сарын эхний өдөр хүчин төгөлдөр болох бөгөөд хэрэв цуцалсан тухайн баримт бичгийг 7 дугаар сарын эхний өдрөөс хойш хүлээн авсан бол түүнийг дараагийн жилийн 7 дугаар сарын эхний өдөр буюу түүнээс өмнө хүлээн авсантай адилаар цуцлалт хүчин төгөлдөр болно.

Хэрэв энэ зүйлийн 1 болон 2 дахь хэсэгт заасны дагуу хийсэн цуцлалтын үр дүнд 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Конвенц хүчин төгөлдөр болох нөхцөл үгүй болбол энэхүү конвенц дуусгавар болно.

30 дугаар зүйл

Нэмэлт өөрчлөлт

Аливаа тал энэхүү конвенцид нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргаж болно. Аливаа тийм нэмэлт өөрчлөлтийн эх бичвэр болон үндэслэлийг Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэх бөгөөд Ерөнхий нарийн бичгийн дарга нь талууд болон Зөвлөлд мэдэгдэнэ. Зөвлөлд дор дурдсан шийдвэрийн аль нэгийг гаргаж болно:

а) Санал болгосон нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэхээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн 62 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт нийцүүлэн бага хурал зарлан хуралдуулах;

б) Санал болгосон нэмэлт өөрчлөлтийг хүлээн авах эсэх талаар талуудын саналыг авч, мөн нэмэлт өөрчлөлттэй холбогдсон аливаа саналаа Зөвлөлд ирүүлэхийг гэднээс хүсэх.

2. Хэрэв санал болгосон нэмэлт өөрчлөлтийг энэ зүйлийн 1 дэх хэсгийн (б) дэд хэсгийн дагуу тарааснаас хойш арван найман сарын дотор түүнээс талууд татгалзаагүй бол тухайн нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болно. Хэрэв санал болгосон нэмэлт өөрчлөлтөөс аливаа тал татгалзсан бол Зөвлөлд талуудаас хүлээж авсан саналыг харгалзан тухайн нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэхээр бага хурал хуралдуулах эсэхийг шийдвэрлэж болно.

31 дүгээр зүйл

Маргаан

Хэрэв энэхүү конвенцийг тайлбарлах буюу хэрэглэх талаар хоёр буюу хэд хэдэн талын хооронд маргаан үүсвэл талууд хэлэлцээ хийх, мөрдөн шалгах, гуравдагч этгээд оролцуулах, эвлэрэх, арбитраар хэлэлцүүлэх, бүс нутгийн байгууллагад хандах, шүүхээр шийдвэрлүүлэх буюу өөрийн сонгож авсан бусад эв зүйн аргаар маргааныг зохицуулах зорилгоор зөвлөлдөнө.

Дээр зааснаар зохицуулж чадаагүй аливаа ийм маргааныг шийдвэрлүүлэхээр маргаанд оролцогч аль нэг талын хүсэлтээр Олон улсын шүүхэд шилжүүлж болно.

32 дугаар зүйл

Тайлбар

Энэ зүйлийн 2, 3, 4 дэх хэсэгт нийцүүлэн хийснээс бусад тайлбарыг үл зөвшөөрнө.

Конвенцид гарын үсэг зурах, соёрхон батлах, нэгдэн орох үед аливаа улс энэхүү конвенцийн дор дурдсан заалтуудын хувьд тайлбар хийж болно:

- a) 19 дүгээр зүйлийн 1, 2 дахь заалт;
- b) 27 дугаар зүйл;
- c) 31 дүгээр зүйл.

Тал болохыг хүссэн боловч 2, 3 дахь хэсэгт нийцүүлэн хийснээс өөр тайлбар хийх хүсэлтэй улс ийм чиг санаагаа Ерөнхий нарийн бичгийн даргад мэдээлж болно. Хэрэв тухайн тайлбарын тухай Ерөнхий нарийн бичгийн дарга мэдэгдсэнээс хойш арван хоёр сар өнгөрөхөд энэхүү конвенцид соёрхон батлах тайлбаргүйгээр гарын үсэг зурсан, соёрхон батласан буюу нэгдэн орсон улсуудын гуравны нэг уг тайлбараас татгалзаагүй бол түүнийг зөвшөөрсөн гэж үзнэ. Харин тайлбараас татгалзсан улсууд уг тайлбараар хөндөгдсөн энэхүү конвенцийн дагуу хүлээх аливаа үүргийг тайлбар хийсэн улсын хувьд хүлээх шаардлагагүй гэж ойлгоно.

Нутаг дэвсгэрт нь I жагсаалтад орсон сэтгэгцэд нөлөөлөх бодисыг агуулсан зэрлэг ургамал ургадаг бөгөөд түүнийг жижиг, тодорхой бүлэг хүмүүс нь ид шид болон шашны уламжлалт зан үйлд ашигладаг улс энэхүү конвенцид гарын үсэг зурах, соёрхон батлах буюу нэгдэн орох үедээ тэдгээр ургамлын талаар 7 дугаар зүйлийн олон улсын худалдаанд хамаарахаас бусад заалтын хувьд тайлбар хийж болно.

Тайлбар хийсэн улс Ерөнхий нарийн бичгийн даргад бичгээр мэдэгдэх замаар тайлбараа хэдийд ч бүхэлд нь буюу хэсэгчлэн эгүүлэн авч болно.

33 дугаар зүйл

Мэдэгдэл

Ерөнхий нарийн бичгийн дарга нь энэхүү конвенцийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан бүх улсад дараахь зүйлийг мэдэгдэнэ:

25 дугаар зүйлд нийцүүлэн конвенцид гарын үсэг зурсан, соёрхон батласан болон нэгдэн орсон тухай;

26 дугаар зүйлд нийцүүлэн энэхүү конвенц хүчин төгөлдөр болох он, сар, өдрийн тухай;

29 дүгээр зүйлд нийцүүлэн цуцласан тухай;

27, 28, 30, 32 дугаар зүйлийн дагуу мэдэгдэл хийсэн тухай.

Дээр дурдсаныг нотолж, зохих ёсоор олгосон эрх бүхий дор гарын үсэг зурагчид тус тусын засгийн газрын нэрийн өмнөөс энэхүү конвенцид гарын үсэг зурцгаав.

Вена хотноо нэг мянга есөн зуун далан нэгэн оны хоёрдугаар сарын хорин нэгний өдөр англи, испани, орос, франц, хятад хэлээр ганц хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Конвенцийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулах бөгөөд Ерөнхий нарийн бичгийн дарга түүний баталгаатай хуулбарыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн бүх улс болон 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан бусад улсад дамжуулна.

ЖАГСААЛТУУДАД ОРСОН БОДИСЫН ЖАГСААЛТ

I жагсаалтад орсон бодис

Олон улсын бүртгэгдээгүй нэр (INN)	Бүртгэгдээгүй бусад нэр	Химийн нэр
BROLAMFETAMINE	DOB	(±)-4-bromo-2,5-dimethoxy- <i>alpha</i> -methylphenethylamine
CATHINONE		(x)-(<i>S</i>)-2-aminopropiophenone
Байхгүй	DET	3-[2-(diethylamino)ethyl]indole
Байхгүй	DMA	(±)-2,5-dimethoxy- <i>alpha</i> -methylphenethylamine
Байхгүй	DMHP	3-(1,2-dimethylheptyl)-7,8,9,10-tetrahydro-6,6,9-trimethyl-6 <i>H</i> -dibenzo[<i>b,d</i>]pyran-1-olo
Байхгүй	DMT	3-[2-(dimethylamino)ethyl]indole
Байхгүй	DOET	(±)-4-ethyl-2,5-dimethoxy- <i>alpha</i> -phenethylamine
ETICYCLIDINE	PCE	<i>N</i> -ethyl-1-phenylcyclohexylamine
ETRYPTAMINE		3-(2-aminobutyl)indole
(+)-LYSERGIDE	LSD, LSD-25	9,10-didehydro- <i>N,N</i> -diethyl-6-methylergoline-8 <i>beta</i> -carboxamide
Байхгүй	MDMA	(±)- <i>N, alpha</i> -dimethyl-3,4-(methylenedioxy)phenethylamine
Байхгүй	mescaline	3,4,5-trimethoxyphenethylamine
	methcathinone	2-(methylamino)-1-phenylpropan-1-one
Байхгүй	4-methylaminorex	(±)- <i>cis</i> -2-amino-4-methyl-5-phenyl-2-oxazoline
Байхгүй	MMDA	2-methoxy- <i>alpha</i> -methyl-4,5-(methylenedioxy)phenethylamine
Байхгүй	<i>N</i> -ethyl MDA	(±)- <i>N</i> -ethyl- <i>alpha</i> -methyl-3,4-(methylenedioxy)phenethylamine
Байхгүй	<i>N</i> -hydroxy MDA	(±)- <i>N</i> -[<i>alpha</i> -methyl-3,4-(methylenedioxy)phenethyl]hydroxylamine
Байхгүй	parahexyl	3-hexyl-7,8,9,10-tetrahydro-6,6,9-trimethyl-6 <i>H</i> -dibenzo[<i>b,d</i>]pyran-1-ol

Байхгүй	PMA	<i>p</i> -methoxy- <i>alpha</i> -methylphenethylamine
Байхгүй	psilocine, psilotsin	3-[2-(dimethylamino)ethyl] indol-4-ol
PSILOCYBINE		3-[2-(dimethylamino)ethyl]indol-4-yl dihydrogen phosphate
ROLICYCLIDINE	PHP, PCPY	1-(1-phenylcyclohexyl)piperidine
Байхгүй	STP, DOM	2,5-dimethoxy- <i>alpha</i> ,4-dimethylphenethylamine
TENAMFETAMINE		MDA <i>alpha</i> -methyl-3,4-(methylenedioxy)phenethylamine
TENOCYCLIDINE	TCP	1-[1-(2-thienyl)cyclohexyl]piperidine
Байхгүй		tetrahydrocannabinol, дараахь изомер болон стерохимийн хувилбар: 7,8,9,10-tetrahydro-6,6,9-trimethyl-3-pentyl-6 <i>H</i> -dibenzo[<i>b,d</i>] pyran-1-ol (9 <i>R</i> ,10 <i>aR</i>)-8,9,10,10 <i>a</i> -tetrahydro-6,6,9-trimethyl-3-pentyl-6 <i>H</i> -dibenzo[<i>b,d</i>]pyran-1-ol (6 <i>aR</i> ,9 <i>R</i> ,10 <i>aR</i>)-6 <i>a</i> ,9,10,10 <i>a</i> -tetrahydro-6,6,9-trimethyl-3-pentyl-6 <i>H</i> -dibenzo[<i>b,d</i>]pyran-1-ol (6 <i>aR</i> ,10 <i>aR</i>)-6 <i>a</i> ,7,10,10 <i>a</i> -tetrahydro-6,6,9-trimethyl-3-pentyl-6 <i>H</i> -dibenzo[<i>b,d</i>]pyran-1-ol (6 <i>aR</i> ,10 <i>aR</i>)-6 <i>a</i> ,7,8,9-tetrahydro-6,6,9-trimethyl-3-pentyl-6 <i>H</i> -dibenzo[<i>b,d</i>] pyran-1-ol (6 <i>aR</i> ,10 <i>aR</i>)-6 <i>a</i> ,7,8,9,10,10 <i>a</i> -hexahydro-6,6-dimethyl-9-methylene-3-pentyl-6 <i>H</i> -dibenzo[<i>b,d</i>]pyran-1-ol
Байхгүй	TMA	(±)-3,4,5-trimethoxy- <i>alpha</i> -methylphenethylamine

Энэ жагсаалтад бодисын давсыг ийм давс байж болох бүх тохиолдолд оруулсан.*

II жагсаалтад орсон бодис

Олон улсын бүртгэгдээгүй нэр /INN/	Бүртгэгдээгүй бусад нэр	Химийн нэр
AMFETAMINE	amphetamine	(±)- <i>alpha</i> -methylphenethylamine
DEXAMFETAMINE	dexamphetamin e	(+)- <i>alpha</i> -methylphenethylamine
FENETYLLINE		7-[2-[(<i>alpha</i> -methylphenethyl)amino]ethyl]theophylline
LEVAMFETAMINE	levamphetamine	(x)-(<i>R</i>)- <i>alpha</i> -methylphenethylamine
	levomethamphetamine	(x)- <i>N, alpha</i> -dimethylphenethylamine
MECLOQUALONE		3-(<i>o</i> -chlorophenyl)-2-methyl-4(3 <i>H</i>)-quinazolinone
METAMFETAMINE	methamphetamine	(+)-(<i>S</i>)- <i>N, alpha</i> -dimethylphenethylamine
METAMFETAMINE RACEMATE	methamphetamine racemate	(±)- <i>N, alpha</i> -dimethylphenethylamine
METHAQUALONE		2-methyl-3- <i>o</i> -tolyl-4(3 <i>H</i>)-quinazolinone

METHYLPHENIDA TE		Methyl <i>alpha</i> -phenyl-2-piperidineacetate
PHENCYCLIDINE	PCP	1-(1-phenylcyclohexyl)piperidine
PHENMETRAZINE		3-methyl-2-phenylmorpholine
SECOBARBITAL		5-allyl-5-(1-methylbutyl)barbituric acid
<i>DRONABINOL</i> *	<i>delta</i> -9-tetrahydro- каннабинол болон түүний стерохимийн хувилбарууд	(6 <i>aR</i> ,10 <i>aR</i>)-6 <i>a</i> ,7,8,10 <i>a</i> -tetrahydro-6,6,9-trimethyl-3-pentyl-6 <i>H</i> -dibenzo[<i>b,d</i>]pyran-1-ol
ZIPEPROL		<i>alpha</i> -(<i>alpha</i> -methoxybenzyl)-4-(<i>beta</i> -methoxyphenethyl)-1-piperazineethanol

Энэ жагсаалтад бодисын давсыг ийм давс байж болох бүх тохиолдолд оруулсан.*

*Энэ INN нь *delta*-9-tetrahydrocannabinol, тухайлбал (-)- *trans*-*delta*-9-tetrahydrocannabinol-ын стереохимийн хувилбаруудын зөвхөн нэгийг л заана.

III жагсаалтад орсон бодис

Олон улсын бүртгэгдээгүй нэр /INN/	Бүртгэгдээгүй бусад нэр	Химийн нэр
AMOBARBITAL		5-ethyl-5-isopentylbarbituric acid
BUPRENORPHINE		21-cyclopropyl-7- <i>alpha</i> -[(<i>S</i>)-1-hydroxy-1,2,2-trimethylpropyl]-6,14-endo-ethano-6,7,8,14-tetrahydrooripavine
BUTALBITAL		5-allyl-5-isobutylbarbituric acid
CATHINE	(+)-norpseudo- ephedrine	(+)-(R)- <i>alpha</i> -[(R)-1-aminoethyl]benzyl alcohol
CYCLOBARBITAL		5-(1-cyclohexen-1-yl)-5-ethylbarbituric acid
FLUNITRAZEPAM		5-(<i>o</i> -fluorophenyl)-1,3-dihydro-1-methyl-7-nitro-2 <i>H</i> -1,4-benzodiazepin-2-one
GLUTETHIMIDE		2-ethyl-2-phenylglutarimide
PENTAZOCINE		(2 <i>R</i> *,6 <i>R</i> *,11 <i>R</i> *)-1,2,3,4,5,6-hexahydro-6,11-dimethyl-3-(3-methyl-2-butenyl)-2,6-methano-3-benzazocin-8-ol
PENTOBARBITAL		5-ethyl-5-(1-methylbutyl)barbituric acid

Энэ жагсаалтад бодисын давсыг ийм давс байж болох бүх тохиолдолд оруулсан.*

IV жагсаалтад орсон бодис

Олон улсын бүртгэгдээгүй нэр /INN/	Бүртгэгдээгүй бусад нэр	Химийн нэр
ALLOBARBITAL		5,5-diallylbarbituric acid
ALPRAZOLAM		8-chloro-1-methyl-6-phenyl-4 <i>H</i> -s-triazolo[4,3- <i>a</i>][1,4]benzodiazepine
AMFEPRAMONE	diethylpropion	2-(diethylamino)propiofenone
AMINOREX		2-amino-5-phenyl-2-oxazoline
BARBITAL		5,5-diethylbarbituric acid
BENZFETAMINE	benzphetamine	<i>N</i> -benzyl- <i>N</i> , <i>alpha</i> -dimethylphenethylamine
BROMAZEPAM		7-bromo-1,3-dihydro-5-(2-pyridyl)-2 <i>H</i> -1,4-benzodiazepin-2-one
Байхгүй	butobarbital	5-butyl-5-ethylbarbituric acid
BROTIZOLAM		2-bromo-4-(<i>o</i> -chlorophenyl)-9-methyl-6 <i>H</i> -thieno[3,2- <i>f</i>]-s-triazolo[4,3- <i>a</i>][1,4]diazepine
SAMAZEPAM		7-chloro-1,3-dihydro-3-hydroxy-1-methyl-5-phenyl-2 <i>H</i> -1,4 benzodiazepin-2-one dimethylcarbamate (ester)
CHLORDIAZEPOXIDE		7-chloro-2-(methylamino)-5-phenyl-3 <i>H</i> -1,4-benzodiazepine-4-oxide
CLOBAZAM		7-chloro-1-methyl-5-phenyl-1 <i>H</i> -1,5-benzodiazepine-2,4(3 <i>H</i> ,5 <i>H</i>)-dione
CLONAZEPAM		5-(<i>o</i> -chlorophenyl)-1,3-dihydro-7-nitro-2 <i>H</i> -1,4-benzodiazepin-2-one
CLORAZEPATE		7-chloro-2,3-dihydro-2-oxo-5-phenyl-1 <i>H</i> -1,4-benzodiazepine-3-carboxylic acid
CLOTIAZEPAM		5-(<i>o</i> -chlorophenyl)-7-ethyl-1,3-dihydro-1-methyl-2 <i>H</i> -thieno [2,3- <i>e</i>] -1,4-diazepin-2-one
CLOXAZOLAM		10-chloro-11b-(<i>o</i> -chlorophenyl)-2,3,7,11b-tetrahydro-oxazolo- [3,2- <i>d</i>][1,4]benzodiazepin-6(5 <i>H</i>)-one
DELORAZEPAM		7-chloro-5-(<i>o</i> -chlorophenyl)-1,3-dihydro-2 <i>H</i> -1,4-benzodiazepin-2-one
DIAZEPAM		7-chloro-1,3-dihydro-1-methyl-5-phenyl-2 <i>H</i> -1,4-benzodiazepin-2-one
ESTAZOLAM		8-chloro-6-phenyl-4 <i>H</i> -s-triazolo[4,3- <i>a</i>][1,4]benzodiazepine
ETHCHLORVYNO		1-chloro-3-ethyl-1-penten-4-yn-3-ol

L		
ETHINAMATE		1- ethynylcyclohexanolcarbamate
ETHYL LOFLAZEPATE		ethyl 7-chloro-5-(<i>o</i> -fluorophenyl)-2,3-dihydro-2-oxo-1 <i>H</i> -1,4-benzodiazepine-3-carboxylate
ETIL AMFETAMINE	<i>N</i> -ethylamphetamine	<i>N</i> -ethyl- <i>alpha</i> -methylphenethylamine
FENCAMFAMIN		<i>N</i> -ethyl-3-phenyl-2-norborananamine
FENPROPOREX		(±)-3-[(<i>alpha</i> -methylphenylethyl)amino]propionitrile
FLUDIAZEPAM		7-chloro-5-(<i>o</i> -fluorophenyl)-1,3-dihydro-1-methyl-2 <i>H</i> -1,4-benzodiazepin-2-one
FLURAZEPAM		7-chloro-1-[2-(diethylamino)ethyl]-5-(<i>o</i> -fluorophenyl)-1,3-dihydro-2 <i>H</i> -1,4-benzodiazepin-2-one
HALAZEPAM		7-chloro-1,3-dihydro-5-phenyl-1-(2,2,2-trifluoroethyl)-2 <i>H</i> -1,4-benzodiazepin-2-one
HALOXAZOLAM		10-bromo-11b-(<i>o</i> -fluorophenyl)-2,3,7,11b-tetrahydrooxazolo [3,2- <i>d</i>][1,4]benzodiazepin-6(5 <i>H</i>)-one
KETAZOLAM		11-chloro-8,12b-dihydro-2,8-dimethyl-12b-phenyl-4 <i>H</i> -[1,3]oxazino[3,2- <i>d</i>][1,4]benzodiazepine-4,7(6 <i>H</i>)-dione
LEFETAMINE	SPA	(<i>x</i>)- <i>N,N</i> -dimethyl-1,2-diphenylethylamine
LOPRAZOLAM		6-(<i>o</i> -chlorophenyl)-2,4-dihydro-2-[(4-methyl-1-piperazinyl) methylene]-8-nitro-1 <i>H</i> -imidazo[1,2- <i>a</i>][1,4]benzodiazepin-1-one
LORAZEPAM		7-chloro-5-(<i>o</i> -chlorophenyl)-1,3-dihydro-3-hydroxy-2 <i>H</i> -1,4-benzodiazepin-2-one
LORMETAZEPAM		7-chloro-5-(<i>o</i> -chlorophenyl)-1,3-dihydro-3-hydroxy-1-methyl-2 <i>H</i> -1,4-benzodiazepin-2-one
MAZINDOL		5-(<i>p</i> -chlorophenyl)-2,5-dihydro-3 <i>H</i> -imidazo[2,1- <i>a</i>]isoindol-5-ol
MEDAZEPAM		7-chloro-2,3-dihydro-1-methyl-5-phenyl-1 <i>H</i> -1,4-benzodiazepine
MEFENOREX		<i>N</i> -(3-chloropropyl)- <i>alpha</i> -methylphenethylamine
MEPROBAMATE		2-methyl-2-propyl-1,3-propanedioldicarbamate
MESOCARB		3-(<i>alpha</i> -methylphenethyl)- <i>N</i> -(phenylcarbamoyl)sydnone imine
METHYLPHENO BARBITAL		5-ethyl-1-methyl-5-phenylbarbituric acid

METHYPRYLON		3,3-diethyl-5-methyl-2,4-piperidine-dione
MIDAZOLAM		8-chloro-6-(<i>o</i> -fluorophenyl)-1-methyl-4 <i>H</i> -imidazo[1,5- <i>a</i>][1,4]benzodiazepine
NIMETAZEPAM		1,3-dihydro-1-methyl-7-nitro-5-phenyl-2 <i>H</i> -1,4-benzodiazepin-2-one
NITRAZEPAM		1,3-dihydro-7-nitro-5-phenyl-2 <i>H</i> -1,4-benzodiazepin-2-one
NORDAZEPAM		7-chloro-1,3-dihydro-5-phenyl-2 <i>H</i> -1,4-benzodiazepin-2-one
OXAZEPAM		7-chloro-1,3-dihydro-3-hydroxy-5-phenyl-2 <i>H</i> -1,4-benzodiazepin-2-one
OXAZOLAM		10-chloro-2,3,7,11b-tetrahydro-2-methyl-11b-phenyloxazolo [3,2- <i>d</i>][1,4]benzodiazepin-6(5 <i>H</i>)-one
PEMOLINE		2-amino-5-phenyl-2-oxazolin-4-one (=2-imino-5-phenyl-4-oxazolidinone)
PHENDIMETRAZINE		(+)-(2 <i>S</i> ,3 <i>S</i>)-3,4-dimethyl-2-phenylmorpholine
PHENOBARBITAL		5-ethyl-5-phenylbarbituric acid
PHENTERMINE		<i>alpha, alpha</i> -dimethylphenethylamine
PINAZEPAM		7-chloro-1,3-dihydro-5-phenyl-1-(2-propynyl)-2 <i>H</i> -1,4-benzodiazepin-2-one
PIPRADROL		1,1-diphenyl-1-(2-piperidyl)-methanol
PRAZEPAM		7-chloro-1-(cyclopropylmethyl)-1,3-dihydro-5-phenyl-2 <i>H</i> -1,4-benzodiazepin-2-one
PYROVALERONE		4'-methyl-2-(1,-pyrrolidinyl)valerophenone
SEC BUTABARBITAL		5- <i>sec</i> -butyl-5-ethylbarbituric acid
TEMAZEPAM		7-chloro-1,3-dihydro-3-hydroxy-1-methyl-5-phenyl-2 <i>H</i> -1,4-benzodiazepin-2-one
TETRAZEPAM		7-chloro-5-(1-cyclohexen-1-yl)-1,3-dihydro-1-methyl-2 <i>H</i> -1,4-benzodiazepin-2-one
TRIAZOLAM		8-chloro-6-(<i>o</i> -chlorophenyl)-1-methyl-4 <i>H</i> -s-triazolo[4,3- <i>a</i>][1,4]benzodiazepine
VINYLBITAL		5-(1-methylbutyl)-5-vinylbarbituric acid

Энэ жагсаалтад бодисын давсыг ийм давс байж болох бүх тохиолдолд оруулсан.

87. МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛӨХ БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТИЙН ЭСРЭГ НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН КОНВЕНЦ

*1988 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталж,
1990 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр хүчин төгөлдөр болсон**

Энэхүү конвенцийн талууд,

мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус үйлдвэрлэл, эрэлт, нийлүүлэлтийн хэмжээ өсөн нэмэгдэж байгаа нь хүний эрүүл мэнд, сайн сайханд ноцтой аюул занал учруулж нийгмийн улс төр, эдийн засаг, соёлын үндэст сөргөөр нөлөөлж буйд сэтгэл гүнээ зовниж,

мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлт нийгмийн янз бүрийн бүлгийн дунд улам гүнзгий тархаж, ялангуяа дэлхийн олон газарт хүүхдүүдийг хууль бус мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хэрэглэгчээр болон тэдгээрийн хууль бус үйлдвэрлэл болон эргэлтийн зорилгод ашиглаж байгаагийн үр дагавар нь тооцоолохын аргагүй аюулд хүргэж байгаад сэтгэл гүнээ зовниж,

улсуудын хууль ёсны эдийн засгийг сулруулж, тогтвортой байдал, аюулгүй байдал, бүрэн эрхт байдалд аюул учруулж буй хууль бус эргэлт болон түүнтэй холбоотой зохион байгуулалттай гэмт үйл ажиллагааны бусад хэлбэр нь харилцан холбоотойг хүлээн зөвшөөрч,

хууль бус эргэлт нь олон улсын шинж чанартай гэмт үйл ажиллагаа бөгөөд түүнийг таслан зогсоох явдал нь хойшлуулшгүй нэн тэргүүний анхаарал шаардаж буйг хүлээн зөвшөөрч,

хууль бус эргэлт нь санхүүгийн асар их ашиг, баялгаар хангаснаараа улс дамнасан гэмт хэргийн байгууллагуудад засгийн газрын байгууллагууд, хууль ёсны худалдаа, санхүүгийн үйл ажиллагаа болон нийгмийн бүх давхаргад нэвтрэх, тэдгээрийг бохирдуулах, ялзруулах боломж олгож байгааг хүлээн зөвшөөрч,

хууль бус эргэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээдүүдийг гэмт үйл ажиллагаанаас олж буй орлогоос нь салгаж, улмаар тийм үйл ажиллагаа эрхлэх гол хөшүүргийг нь арилгахад шийдэмгий байгаагаа илэрхийлж,

мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эрэлт, хууль бус эргэлтээс олсон асар их орлого зэрэг тийм эм, бодисыг урвуулан хэрэглэх үндсэн шалтгаануудыг арилгахыг эрмэлзэж,

олдоц нь элбэг байдаг нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын нууц үйлдвэрлэлийг өсгөхөд нөлөөлдөг зарим бодис, түүний дотор прекурсор, химийн бодис, уусгагч зэрэгт тавих хяналтын арга хэмжээ шаардлагатай гэж үзэж,

* Монгол Улс 2001.01.25-нд нэгдэн орсон

далай дахь хууль бус эргэлтийг таслан зогсоох олон улсын хамтын ажиллагааг сайжруулахыг эрмэлзэж,

хууль бус эргэлтийг устгах нь бүх улсын хамтын үүрэг бөгөөд энэ зорилгоор олон улсын хамтын ажиллагааны хүрээнд хүчин чармайлтыг уялдуулах шаардлагатайг хүлээн зөвшөөрч,

мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хянах салбар дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын эрх хэмжээг хүлээн зөвшөөрч, Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүрээнд тийм хяналт явуулдаг олон улсын байгууллагууд байлгахыг хүсч,

мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай олон улсын гэрээний удирдах зарчмууд болон тэдгээрт заасан хяналтын тогтолцоог дахин нотолж,

хууль бус эргэлтийн цар хүрээ, хэмжээ болон түүнээс үүдэн гарах ноцтой үр дагаврыг арилгах зорилгоор Мансууруулах эмийн тухай 1961 оны нэгдсэн конвенц болон Мансууруулах эмийн тухай 1961 оны нэгдсэн конвенцид нэмэлт өөрчлөлт оруулах тухай 1972 оны протоколоор оруулсан нэмэлт өөрчлөлт бүхий тэр конвенц болон Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай 1971 оны конвенцид заасан арга хэмжээг бэхжүүлэх, нэмэгдүүлэх шаардлагыг хүлээн зөвшөөрч,

олон улсын гэмт үйл ажиллагаа болох хууль бус эргэлтийг таслан зогсоох олон улсын эрх зүйн хамтын ажиллагааны эрх зүйн үр нөлөөтэй арга хэрэгслүүдийг бэхжүүлж, чангатгахын ач холбогдлыг мөн хүлээн зөвшөөрч,

хууль бус эргэлтийн эсрэг тухайлан чиглэгдсэн бөгөөд асуудлын янз бүрийн талыг ялангуяа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай хүчин төгөлдөр мөрдөгдөж буй олон улсын гэрээнд тусгагдаагүй зүйлүүдийг харгалзан боловсронгуй, үр өгөөжтэй, бодитойгоор хэрэгжих чадвартай олон улсын конвенц байгуулахыг эрмэлзэж,

дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

1 дүгээр зүйл

Нэр томъёо

Хэрэв өөрөөр илэрхий заагаагүй буюу тодорхой тохиолдолд агуулгын хувьд өөр утга шаардлагагүй бол энэхүү конвенцид дараахь тодорхойлолтыг хэрэглэнэ:

а) “Хороо” гэж Мансууруулах эмийн тухай 1961 оны нэгдсэн конвенц болон Мансууруулах эмийн тухай 1961 оны нэгдсэн конвенцид нэмэлт өөрчлөлт оруулах тухай 1972 оны протоколоор оруулсан нэмэлт өөрчлөлт бүхий тэр конвенцид заасан Хар тамхинд хяналт тавих олон улсын хороог хэлнэ;

б) “Каннабис” гэж олсны овгийн бүх төрлийн ургамлыг хэлнэ;

с) “Кока бут” гэж эритоксилонь төрлийн аливаа зүйлийн ургамлыг хэлнэ;

- d) “Арилжааны тээвэрлэгч” гэж аливаа урамшуулал, хөлс, бусад ашгийн төлөө хүн, бараа, шуудан тээвэрлэх ажиллагаанд оролцож буй аливаа хувь хүн, эсхүл олон нийтийн, хувийн бусад байгууллагыг хэлнэ;
- e) “Комисс” гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эдийн засаг, нийгмийн хорооны Мансууруулах эмтэй тэмцэх комиссыг хэлнэ;
- f) “Хураах” гэж шүүхийн буюу эрх бүхий бусад байгууллагын шийдвэрээр эд хөрөнгийг бүрмөсөн хураан авахыг хэлэх бөгөөд үүнд хөрөнгөөс салгахыг зохих тохиолдолд оруулна;
- g) “Хяналтан дор хүргүүлэх” гэж энэхүү конвенцид хавсаргасан I хүснэгт, II хүснэгтэд заасан хууль бус, эсхүл сэжигтэй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис болон тэдгээрийг орлох бодисыг энэхүү конвенцийн 3 дугаар зүйлийн I дэх хэсэгт дурдсан гэмт хэрэг үйлдэхэд оролцсон этгээдийг таньж тогтоох зорилгоор нэг буюу хэд хэдэн орны нутаг дэвсгэрээс гаргах, эсхүл түүгээр дамжуулах, эсхүл тэдгээрийн нутаг дэвсгэрт нэвтрүүлэхийг тэдгээр улсын эрх бүхий байгууллагын мэдэл, хяналтан доор зөвшөөрсөн аргачлалыг хэлнэ;
- h) “1961 оны конвенц” гэж Мансууруулах эмийн тухай 1961 оны нэгдсэн конвенцийг хэлнэ;
- i) “Өөрчлөн оруулсан 1961 оны конвенц” гэж Мансууруулах эмийн тухай 1961 оны нэгдсэн конвенцид өөрчлөлт оруулах тухай 1972 оны протоколоор нэмэлт өөрчлөлт оруулсан Мансууруулах эмийн тухай 1961 оны нэгдсэн конвенцийг хэлнэ;
- j) “1971 оны конвенц” гэж Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай 1971 оны конвенцийг хэлнэ;
- k) “Зөвлөл” гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эдийн засаг, нийгмийн зөвлөлийг хэлнэ;
- l) “Битүүмжлэх”, эсхүл “түр хураах” гэж шүүх болон эрх бүхий бусад байгууллагын шийдвэрээр эд хөрөнгийг шилжүүлэх, хэвиргах, захиран зарцуулах, хөдөлгөхийг түр хугацаагаар хориглох, эсхүл түр хугацаагаар хураах буюу хяналтад авахыг хэлнэ;
- m) “Хууль бус эргэлт” гэж энэхүү конвенцийн 3 дугаар зүйлийн I болон 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хэлнэ;
- n) “Мансууруулах эм” гэж Мансууруулах эмийн тухай 1961 оны нэгдсэн конвенц болон нэмэлт өөрчлөлт оруулсан уг конвенцийн I жагсаалт, II жагсаалтад орсон байгалийн болон нийлэг аливаа бодисыг хэлнэ;
- o) “Опиумын намуу” гэж *Papaver somniferum L* зүлийн ургамлыг хэлнэ;
- p) “Орлого” гэж 3 дугаар зүйлийн I дэх хэсэгт тодорхойлсон гэмт хэрэг үйлдсэний үр дүнд шууд болон шууд бусаар бий болсон буюу олж авсан аливаа хөрөнгийг хэлнэ;
- q) “Хөрөнгө” гэж материаллаг болон материаллаг бус, хөдлөх болон үл хөдлөх, (биет болон биет бус бүх төрлийн хөрөнгө, түүнчлэн тийм хөрөнгийг өмчлөх эрх

болон түүн дэх эрх, ашиг сонирхлыг гэрчлэх эрх зүйн баримт бичиг буюу актыг хэлнэ;

г) “Сэтгэцэд нөлөөлөх бодис” гэж 1971 оны конвенцийн I, II, III, IV жагсаалтад орсон байгалийн буюу нийлэг аливаа бодис эсхүл байгалийн аливаа материалыг хэлнэ;

с) “Ерөнхий нарийн бичгийн дарга” гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргыг хэлнэ;

т) “I хүснэгт”, “II хүснэгт” гэж 12 дугаар зүйлийн дагуу нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд энэхүү конвенцид хавсаргасан бодисын зохих ёсоор дугаарласан жагсаалтыг хэлнэ;

у) “Дамжин өнгөрүүлэгч улс” гэж хууль бус мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис болон энэхүү конвенцийн I хүснэгт, II хүснэгтэд заасан бодисын гарал үүслийн газар ч биш, эцсийн хүргэх газар ч биш бөгөөд тэдгээрийг нутаг дэвсгэрээр нь дамжин өнгөрүүлж байгаа улсыг хэлнэ.

2 дугаар зүйл

Конвенцийн хамрах хүрээ

1. Энэхүү конвенцийн зорилго нь олон улсын хэмжээний асуудал болж байгаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй холбоотой олон төрлийн асуудлыг үр өгөөжтэйгөөр шийдвэрлэх талуудын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино. Талууд энэхүү конвенцийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхдээ өөрийн дотоодын хууль тогтоомжийн тогтолцооны үндсэн зарчимд нийцүүлэн хуулийн болон захригааны шаардлагатай арга хэмжээ авна.

2. Талууд энэхүү конвенцийн дагуу хүлээсэн үүргээ бусад улсын бүрэн эрхт тэгш байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх болон дотоод хэрэгт хөндлөнгөөс үл оролцох зарчмыг баримтлан биелүүлнэ.

3. Аль нэг тал нь нөгөө талын нутаг дэвсгэрт хэргийн харьяалал тогтоож болохгүй бөгөөд тухайн талын дотоодын хуулийн дагуу зөвхөн түүний байгууллагуудын бүрэн эрхэд хамаарах чиг үүргийг хэрэгжүүлж болохгүй.

3 дугаар зүйл

Гэмт хэрэг, түүнд хүлээлгэх хариуцлага

1. Тал бүр санаатайгаар үйлдэгдсэн дараахь үйлдлийг дотоодынхоо хуулийн дагуу эрүүгийн гэмт хэрэг гэж тогтоох арга хэмжээ авна:

- а) i) 1961 оны конвенц, нэмэлт өөрчлөлт оруулсан уг конвенц болон 1971 оны конвенцийн заалтыг зөрчиж аливаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг үйлдвэрлэх, бэлтгэх, гаргаж авах, бэлдэх, санал болгох, худалдахаар санал болгох, түгээх, худалдах, ямар ч нөхцөлөөр хамаагүй хүргэх, зуучлах, илгээх, дамжуулан өнгөрүүлж илгээх, тээвэрлэх, экспортлох, импортлох;

ii) 1961 оны конвенц, нэмэлт, өөрчлөлт оруулсан уг конвенцийн заалтыг зөрчиж мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг үйлдвэрлэх зорилгоор опиумын намуу, кока бут, каннабис ургамлыг тарималжуулах;

iii) (i) дэд хэсэгт заасан аливаа үйл ажиллагааг явуулах зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хадгалах, худалдан авах;

iv) мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг тарималжуулах, үйлдвэрлэх эсхүл бэлтгэхэд зориулагдсаныг мэдсээр байж I хүснэгт, II хүснэгтэд заасан тоног төхөөрөмж, эд зүйлс, бодисыг бэлтгэх, тээвэрлэх, түгээх;

v) (i), (ii), (iii), (iv) дэд хэсэгт тодорхойлсон гэмт хэргийг удирдах, санхүүжүүлэх, зохион байгуулах.

(b) i) аливаа гэмт хэрэг болон энэ хэсгийн (a) дэд хэсгийн дагуу тогтоосон гэмт хэрэг үйлдсэний үр дүнд бий болсон, эсхүл дурдсан гэмт үйлдэлд оролцсоны үр дүнд бий болсон хөрөнгө гэдгийг мэдсээр байж хөрөнгийн хууль бус эх үүсвэрийг халхавчлах, нуун дарагдуулах болон гэмт хэрэг үйлдсэн аливаа этгээдэд гэмт үйлдлийнхээ эрх зүйн үр дагавраас зайлсхийхэд нь туслах зорилгоор уг хөрөнгийг хувиргах, шилжүүлэх;

ii) энэ хэсгийн (a) дэд хэсгийн дагуу тогтоосон гэмт хэрэг үйлдсэний үр дүнд бий болсон, эсхүл тийм гэмт хэрэг үйлдэхэд оролцсоны үр дүнд бий болсон хөрөнгө гэдгийг мэдсээр байж түүний жинхэнэ мөн чанар, эх үүсвэр, байрлал, захиран зарцуулах арга, хөдөлгөөн, хөрөнгөтэй холбоотой жинхэнэ эрх эсхүл эзэмшигчийг халхавчлах, нуун дарагдуулах;

(c) Үндэсний хууль тогтоомжийнхоо заалтууд, эрх зүйн тогтолцооныхоо гол зарчмуудыг баримтлан:

i) энэ хэсгийн (a) дэд хэсгийн дагуу тогтоосон гэмт хэрэг болон гэмт хэргүүд, эсхүл тухайн гэмт хэрэг болон гэмт хэргүүдэд оролцсон үйлдлийн улмаас бий болсон хөрөнгийг хүлээж авахдаа энэ тухай мэдсээр байж олж авсан, эзэмшсэн, хэрэглэсэн;

ii) I хүснэгт, II хүснэгтэд заасан тоног төхөөрөмж, эд зүйлс болон бодисыг аливаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар тарималжуулах, үйлдвэрлэхэд ашиглаж байгаа, эсхүл тийм зорилгоор ашиглахад зориулагдсан болохыг мэдсээр байж эзэмших;

iii) энэ зүйлийн дагуу тогтоосон аливаа гэмт хэргийг үйлдэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар хэрэглэхэд олон нийтийг аливаа хэлбэрээр өдөөн хатгах, уриалах;

iv) энэ зүйлээр тогтоосон аливаа гэмт хэргийг үйлдэхэд оролцсон, холбогдсон, үйлдэхээр үгсэн тохиролцсон, үйлдэхийг завдсан, түүнчлэн үйлдэх үед хамжсан, хатгасан, дэмжлэг үзүүлсэн эсхүл зөвлөгөө өгсөн.

2. Тал бүр Үндсэн хуулийнхаа заалтууд, эрх зүйн тогтолцооныхоо зарчмыг баримтлан 1961 оны конвенц, нэмэлт өөрчлөлт оруулсан 1961 оны конвенц, 1971 оны конвенцийг зөрчиж аливаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хувийн

ii) тухайн гэмт хэрэг нь гэмт хэрэг үйлдэх үед түүний төрийн далбааг мандуулсан хөлөг онгоцны тавцанд, эсхүл түүний хуулийн дагуу бүртгэгдсэн агаарын хөлгийн бүхээгт үйлдэгдсэн.

b) Дараахь тохиолдолд 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тогтоосон гэмт хэрэгт хэргийн харьяаллаа тогтоох талаар шаардлагатай байж болох арга хэмжээ авч болно:

i) тухайн улсын иргэн, эсхүл тухайн улсын нутаг дэвсгэрт байнга оршин суугч этгээд тухайн гэмт хэргийг үйлдсэн;

ii) тухайн тал хэргийн харьяаллаа зөвхөн энэ зүйлийн 4 болон 9 дэх хэсэгт дурдсан гэрээ болон тохиролцооны үндсэн дээр хэрэгжүүлэх нөхцөлөөр 17 дугаар зүйлд заасны дагуу зохих ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан хөлөг онгоцны тавцан дээр тухайн гэмт хэргийг үйлдсэн;

iii) 3 дугаар зүйлийн 1 дахь хэсгийн (c) (iv) дэд хэсэгт заасны дагуу тогтоосон гэмт хэрэг бөгөөд тухайн талын нутаг дэвсгэрээс гадна, 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тогтоосон гэмт хэргийг нутаг дэвсгэрт нь үйлдэх зорилгоор үйлдсэн.

2. Тал бүр:

a) сэжигтэн этгээд нутаг дэвсгэрт нь байгаа бөгөөд түүнийг дараахь үндэслэлээр нөгөө талд шилжүүлэн өгдөггүй тохиолдолд 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тухайн талын тогтоосон гэмт хэргийн хувьд хэргийн харьяаллаа тогтооход шаардлагатай байж болох арга хэмжээ авна:

i) тухайн гэмт хэргийг тухайн улсын нутаг дэвсгэрт, эсхүл гэмт хэрэг үйлдэх үед түүний төрийн далбааг мандуулсан хөлөг онгоцны тавцанд, эсхүл түүний хуулийн дагуу бүртгэгдсэн агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн.

ii) гэмт хэргийг тухайн орны иргэн үйлдсэн.

b) сэжигтэн этгээд нутаг дэвсгэрт нь байгаа бөгөөд түүнийг нөгөө талд шилжүүлэн өгдөггүй тохиолдолд 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тогтоосон гэмт хэрэгт хэргийн харьяаллаа тогтоох талаар шаардлагатай байж болох арга хэмжээ авч болно.

5 дугаар зүйл

Хураах

1. Тал бүр дараахь хөрөнгийг хураахад шаардлагатай байж болох арга хэмжээ авна:

a) 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тогтоосон гэмт хэргээс олсон орлого, тийм орлоготой тэнцэх үнэтэй хөрөнгө;

б) 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тогтоосон гэмт хэргийг үйлдэхэд ашигласан эсхүл ямар нэг байдлаар ашиглахад зориулсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис, материал, тоног төхөөрөмж, бусад хэрэгсэл.

2. Тал бүр энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан орлого, хөрөнгө, хэрэгсэл болон бусад зүйлийг хураах зорилгоор тодорхойлох, эрэн сурвалжлах, битүүмжлэх, түр хураах эрхийг өөрийн эрх бүхий байгууллагад олгоход шаардлагатай байж болох арга хэмжээ авна.

3. Тал бүр энэ зүйлд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор өөрийн шүүх болон бусад эрх бүхий байгууллагад банк, санхүү, арилжааны бичиг баримтуудыг шаардаж авах, эсхүл түр хураан авах шийдвэр гаргах эрх олгоно. Аль ч тал банкны нууцыг хадгалах шаардлагатай хэмээн энэ хэсэгт заасны дагуу арга арга хэмжээ авахаас татгалзаж болохгүй.

4. а) Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан орлого, хөрөнгө, хэрэгсэл болон аливаа бусад зүйл нутаг дэвсгэрт нь байгаа тал 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тогтоосон гэмт хэрэгт харьяаллаа тогтоосон нөгөө талаас энэ зүйлд үндэслэн гаргасан хүсэлтийг хүлээн авмагц:

i) хураах шийдвэрийг авах, тийм шийдвэрийг шилжүүлэн өгсөн тохиолдолд түүнийг хэрэгжүүлэх зорилгоор хүсэлтийг эрх бүхий байгууллагадаа шилжүүлнэ; эсхүл

ii) хүсэлт гаргагч талаас энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу гаргасан хураах тухай шийдвэрийг хүсэлтэд заасан хэмжээ болон хүлээн авагч талын нутаг дэвсгэрт байгаа 1 дэх хэсэгт заасан орлого, хөрөнгө, хэрэгсэл болон аливаа бусад зүйлд хамааралтай хэмжээнд биелүүлэх зорилгоор хүсэлтийг эрх бүхий байгууллагадаа шилжүүлнэ.

б) Хүсэлт хүлээн авагч тал 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тогтоосон гэмт хэрэгт харьяаллаа тогтоосон нөгөө талаас энэ зүйлд үндэслэн гаргасан хүсэлтийг хүлээн авмагц хүсэлт гаргагч талаас, эсхүл энэ хэсгийн (а) дэд хэсэгт заасны дагуу хүсэлт хүлээн авагч талаас гаргах хураах тухай шийдвэрээр дараа нь хураах зорилгоор энэ зүйлийн нэг дэх хэсэгт дурдсан орлого, хөрөнгө, хэрэгсэл эсхүл аливаа бусад зүйлийг тодорхойлох, эрэн сурвалжлах, битүүмжлэх, эсхүл түр хураан авах арга хэмжээ авна.

с) Хүсэлт хүлээн авагч тал энэ хэсгийн (а) (b) дэд хэсэгт заасан шийдвэр гаргах болон ажиллагаа явуулахдаа дотоодынхоо хууль тогтоомжид нийцүүлэх, мөрдлөг болгох, дотоодынхоо хуульд заасан байцаан шийтгэх ажиллагааны хэм хэмжээнд нийцүүлэх бөгөөд хүсэлт хүлээн авагч тал хүсэлт гаргагч талтай холбогдож болох хоёр болон олон талт аливаа гэрээ, хэлэлцээр, тохиролцоог баримтлана.

д) 7 дугаар зүйлийн 6-19 дэх хэсгийг *mutatis mutandis* хэрэглэнэ. Энэ зүйлийн дагуу гаргасан хүсэлтэд 7 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт заасан мэдээллээс гадна дараахь зүйлийг тусгана:

i) энэ зүйлийн (а) (i) дэд хэсэгт дурдсан хүсэлтэд хураавал зохих эд хөрөнгийн тодорхойлолт, хүсэлт гаргагч тал үндэслэл болгож буй болон хүсэлт хүлээн авагч тал дотоодынхоо хуулийн дагуу шийдвэр гаргах зорилгоор арга хэмжээ авахад хангалттай үндэслэл болж чадах үйл баримтыг тусгасан өргөдөл;

ii) (a) (ii) дэд хэсэгт дурдсан хүсэлтэд хүсэлтийн үндэслэл болж буй хөрөнгө хураах тухай хүсэлт гаргагч талын шийдвэрийн хууль ёсны хуулбар, үйл баримтыг тусгасан өргөдөл болон шийдвэрийн хүсэлт болгож буй гүйцэтгэлийн хэмжээний талаарх мэдээлэл;

iii) (b) дэд хэсэгт дурдсан хүсэлтэд хүсэлт гаргагч тал үндэслэл болгож буй үйл баримтыг тусгасан өргөдөл, санал болгож буй арга хэмжээний тодорхойлолт.

e) Тал бүр энэ хэсгийн заалтын хэрэгжилтийг хангаж буй аливаа хууль, дүрмийн эх бичвэр, түүнчлэн дурдсан хууль, журамд дараа нь орсон өөрчлөлтийн эх бичвэрийг Ерөнхий нарийн бичгийн даргад хүргүүлнэ.

f) Хэрэв аль нэг тал энэ хэсгийн (a) болон (b) дэд хэсэгт дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох гэрээтэй байх нөхцөл тавьж байгаа бол энэхүү конвенцийг шаардлагатай болон хангалттай эрх зүйн үндэс гэж үзнэ.

g) Талууд энэ зүйлийг хэрэгжүүлэх талаарх олон улсын хамтын ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор хоёр болон олон талт олон улсын гэрээ, хэлэлцээр, эсхүл тохиролцоо байгуулахыг эрмэлзэнэ.

5. a) Энэ зүйлийн 1 болон 4 дэх хэсэгт заасныг үндэслэн орлого болон хөрөнгийг хураасан тал тэдгээрийг дотоодынхоо хууль болон захиргааны журмын дагуу захиран зарцуулна.

b) Тал нь энэ зүйлд заасныг баримтлан нөгөө талын хүсэлтийн дагуу ажиллагаа явуулахдаа дараахь зүйлүүдийг тусгасан гэрээ байгуулах асуудлыг онцгойлон авч үзэж болно:

i) тийм орлого, хөрөнгийг худалдаж бий болсон орлого, хөрөнгө, мөнгөн хуримтлалыг, эсхүл тэдгээрийн томоохон хэсгийг нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг урвуулан хэрэглэх явдал болон тэдгээрийн хууль бус эргэлтийн эсрэг тэмцэх тусгайлсан чиг үүрэг бүхий засгийн газар хоорондын байгууллагуудад шилжүүлэн өгөх;

(i) тийм орлого, хөрөнгийг худалдаж бий болсон орлого, хөрөнгө, мөнгөн хуримтлалын зарим хэсгийг дотоодынхоо хууль, захиргааны журам, эсхүл энэ зорилгоор байгуулсан хоёр болон олон талт гэрээнд нийцүүлэн бусад талд нэг удаа эсхүл тогтмол шилжүүлэн өгөх;

6. a) Хэрэв орлогыг хөрөнгийн өөр хэлбэрт хувиргасан, эсхүл хөрвүүлсэн бол энэ зүйлд дурдсан арга хэмжээнүүдийг тухайн орлогод бус тэрхүү хөрөнгөд хамааруулан хэрэглэнэ.

b) Хэрэв орлогыг хууль ёсны эх сурвалжаас бий болсон хөрөнгөд нийлүүлсэн бол тийм хөрөнгийг түр хураах, битүүмжлэх аливаа эрхийг хязгаарлахгүйгээр нийлүүлсэн орлогын үнийн дүнгийн хэмжээгээр хураах ажиллагаа явуулна.

c)

i) Орлого;

ii) орлогыг хувиргаж болон хөрвүүлж бий болгосон хөрөнгө; эсхүл

iii) орлоготой нийлсэн хөрөнгөөс бий болсон орлого, бусад ашигт энэ зүйлд дурдсан арга хэмжээг орлоготой нэгэн адил хэмжээнд авч үзэж адил хэлбэрээр хэрэгжүүлнэ.

7. Тал бүр хураавал зохих сэжигтэй орлого буюу бусад хөрөнгийн хууль ёсны эх сурвалжтай холбогдсон нотлох дүүргийг дотоодынхоо хуулийн зарчим, шүүх болон байцаан шийтгэх бусад ажиллагааны шинж чанарт нийцсэн хэмжээнд хадгалан хэрэгжүүлэх боломжийг тооцож үзэж болно.

8. Энэ зүйлийн заалтуудыг гуравдагч талын *bonafide* эрхэд хохирол учруулахаар ойлгож хэрхэвч болохгүй.

9. Энэ зүйлийн аль ч хэсэг мөн зүйлд дурдсан арга хэмжээг холбогдох талын дотоодын хуульд нийцүүлэн тодорхойлох болон хэрэгжүүлэх зарчмыг хөндөхгүй.

6 дугаар зүйл

Шилжүүлэн өгөх

1. Энэ зүйлийг 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу талуудын хүлээн зөвшөөрсөн гэмт хэргүүдийн тухайд хэрэглэнэ.

2. Энэ зүйлд хамаарах гэмт хэрэг бүрийг талуудын хооронд байгуулсан шилжүүлэн өгөх тухай аливаа гэрээнд шилжүүлэн өгвөл зохих хэрэг гэж тусгах гэмт хэрэг гэж үзнэ. Талууд хоорондоо байгуулах шилжүүлэн өгөх тухай аливаа гэрээнд тийм гэмт хэргүүдийг шилжүүлэн өгвөл зохих гэмт хэрэг гэж тусгах үүрэг хүлээнэ.

3. Хэрэв гэрээний үндсэн дээр шилжүүлэн өгөх нөхцөл шаарддаг тал түүнтэй шилжүүлэн өгөх тухай гэрээ байгуулаагүй нөгөө талаас шилжүүлэн өгөх тухай хүсэлт хүлээж авсан бол энэ зүйлд хамаарах аль ч хэргийн хувьд энэхүү конвенцийг эрх зүйн үндэс хэмээн тооцож болно. Энэхүү конвенцийг шилжүүлэн өгөхөд эрх зүйн үндэс болгож хэрэглэхийн тулд нарийвчилсан хууль тогтоомж шаардлагатай гэж үзсэн тал тухайн шаардагдах хууль тогтоомжийг батлан гаргах асуудлыг авч үзнэ.

4. Шилжүүлэн өгөхөд гэрээ байгуулсан байх нөхцөл шаарддаггүй талууд энэ зүйлд хамаарах гэмт хэргүүдийг харилцан шилжүүлбэл зохих гэмт хэрэг гэж хүлээн зөвшөөрнө.

5. Шилжүүлэн өгөх ажиллагааг хүсэлт хүлээн авагч талын хууль тогтоомжид заасан нөхцөлийн дагуу, эсхүл шилжүүлэн өгөх тухай гэрээнд заасны дагуу хэрэгжүүлэх бөгөөд үүнд хүсэлт шилжүүлэн өгөхөөс татгалзах хүлээн авагч талын үндэслэлүүд ч мөн хамаарна.

6. Хүсэлт хүлээн авагч тал энэ зүйлийн дагуу хүлээн авсан хүсэлтийг хянан үзээд түүний шүүх болон бусад эрх бүхий байгууллага хүсэлтийг биелүүлснээр аливаа этгээдийг үндэс угсаа, шашин шүтлэг, иргэншил, эсхүл улс төрийн итгэл үнэмшлийг нь харгалзан яллах болон шийтгэхийг хөнгөвчилж эсхүл хүсэлтэд хамаарах аливаа этгээдэд тэдгээр шалтгааны алинаар нь ч хор хохирол учруулж болзошгүй гэж үзэх бодитой үндэслэл байвал уг хүсэлтийг биелүүлэхээс татгалзаж болно.

7. Талууд энэ зүйлд хамаарах аливаа гэмт хэргийн тухайд шилжүүлэн өгөх ажиллагааг шуурхай болгох, түүнтэй холбоотой нотлох баримт бүрдүүлэх шаардлагыг хялбаршуулах талаар хүчин чармайлт гаргана.

8. Хүсэлт хүлээн авагч тал дотоодынхоо хууль, шилжүүлэн өгөх тухай гэрээгээ баримтлан нөхцөл байдал чингэхийг шаардаж байгаа, мөн хойшлуулшгүй шинжтэй гэдэгт итгэлтэй байгаа бөгөөд нутаг дэвсгэрт нь байгаа, шилжүүлэн өгөхийг хүсэлт болгосон хүсэлт гаргагч талын хүсэлтээр цагдан хорих, эсхүл уг этгээдийг шилжүүлэн өгөхөд бэлэн байлгах явдлыг хангахад холбогдох бусад арга хэмжээг авч болно.

9. Сэжигтэн этгээд нутаг дэвсгэрт нь байгаа тал нь өөрийн дотоодын хууль тогтоомжоор тогтоосон аливаа эрүүгийн хэргийн харьяалалд хохирол учруулахгүйгээр дараахь үүрэг хүлээнэ:

а) хэрэв аль нэг тал нь 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тогтоосон сэжигтэн этгээдийг 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн (а) дэд хэсэгт заасан үндэслэлээр шилжүүлэн өгдөггүй бөгөөд хүсэлт гаргагч талтай өөрөөр харилцан тохиролцоогүй бол өөрийн улсын эрх бүхий байгууллагад эрүүгийн журмаар мөрдөх зорилгоор хэргийг шилжүүлнэ.

б) хэрэв сэжигтэн этгээдийг шилжүүлж өгдөггүй бөгөөд 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн (б) дэд хэсэгт заасны дагуу уг гэмт хэрэгт өөрийн хэргийн харьяаллыг тогтоосон бол хууль ёсны харьяаллаа хадгалах зорилгоор хүсэлт гаргагч тал өөр хүсэлт гаргаагүй бол, өөрийн улсын эрх бүхий байгууллагад эрүүгийн журмаар мөрдөх зорилгоор хэргийг шилжүүлнэ.

10. Эрэн сурвалжлагдаж буй этгээд нь хүсэлт хүлээн авагч талын иргэн гэсэн шалтгаанаар ял ногдуулсан шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор гаргасан шилжүүлэн авах хүсэлтэд татгалзсан хариу өгсөн бол хүсэлт хүлээн авагч тал ийнхүү шилжүүлэн өгөхийг хуулиар нь зөвшөөрч байвал түүнд нийцүүлэн хүсэлт гаргагч талын өргөдлийн дагуу хүсэлт гаргагч талын хуулиар ногдуулсан ялыг эсхүл түүний эдлээгүй үлдсэн хэсгийг эдлүүлэх асуудлыг авч үзнэ.

11. Талууд гэмт этгээдийг шилжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, түүний үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор хоёр болон олон талт хэлэлцээр байгуулахыг эрмэлзэнэ.

12. Талууд энэ зүйлд хамаарах гэмт хэрэг үйлдсэний улмаас хорих болон эрх чөлөөг нь хасах өөр төрлийн ялаар шийтгүүлсэн этгээдийн шийтгэлийн нь үлдсэн хугацааг эх оронд нь эдлүүлэх зорилгоор түүнийг тухайн улсад шилжүүлж өгөх асуудлаар хоёр болон олон талт ерөнхий болон *ad hoc* хэлэлцээр байгуулах боломжийг хэлэлцэн шийдвэрлэж болно.

7 дугаар зүйл

Эрх зүйн харилцан туслалцаа

1. Талууд 3 дугаар зүйлийн 1 дахь хэсэгт заасан гэмт хэргийг мөрдөн байцаах, эрүүгийн журмаар мөрдөх, шүүх ажиллагааны явцад эрх зүйн туслалцааг хамгийн өргөн хүрээгээр харилцан үзүүлнэ.

2. Дээрх зүйлд заасны дагуу үзүүлэх эрх зүйн харилцан туслалцааг дараахь зорилгоор хүсч болно:

- a) тодорхой этгээдээс нотлох баримт, мэдүүлэг авах;
- b) шүүн таслах ажиллагааны материалтай танилцах;
- c) нэгжих, хураах ажиллагаа явуулах;
- d) эд зүйл болон газар оронд үзлэг хийх;
- e) мэдээлэл болон нотолгооны зүйлээр хангах;
- f) банк, санхүү, корпораци, бизнесийн баримт бичиг, тэмдэглэл зэрэг холбогдох баримт бичгийн эх хувь болон хуулбарыг авах;
- g) нотлох зорилгоор орлого, хөрөнгө, хэрэгсэл, эсхүл бусад эд зүйлийг тодорхойлох, олж илрүүлэх.

3. Хүсэлт хүлээн авагч талын дотоодын хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад ямар ч төрлийн эрх зүйн туслалцааг талууд бие биедээ харилцан үзүүлж болно.

4. Талууд мөрдөн байцаалтад туслах, эсхүл мөрдөн байцаах ажиллагаанд оролцохыг зөвшөөрсөн хүмүүс, ялангуяа цагдан хоригдож буй этгээдийн оролцоо эсхүл хүрэлцээтэй байдлыг өөрийн дотоодын хуулиар болон практикт зөвшөөрөгдсөн хэмжээгээр хөнгөвчлөх болон түүнд дэмжлэг үзүүлнэ.

5. Тал нь банкны нууцыг хадгалах шалтгаар энэ зүйлийн дагуу эрх зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзах ёсгүй.

6. Энэ зүйлийн заалт нь эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх асуудлыг бүхэлд нь болон хэсэгчлэн зохицуулж буй, эсхүл зохицуулах аливаа бусад олон талт болон хоёр талт гэрээний дагуу хүлээх үүрэгт нөлөөлөхгүй.

7. Хэрэв холбогдох талууд эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай ямар нэгэн гэрээний дагуу харилцан үүрэг хүлээгээгүй бол энэ зүйлийн дагуу гаргасан хүсэлтийн хувьд дурдсан зүйлийн 8-19 дэх заалтыг хэрэглэнэ. Хэрэв талууд дээрх гэрээний дагуу харилцан үүрэг хүлээсэн бөгөөд уг гэрээний оронд энэ зүйлийн 8-19 дэх заалтыг хэрэглэхээр тохиролцож чадаагүй бол дурдсан гэрээний холбогдох заалтыг хэрэглэнэ.

8. Талууд эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлтийг биелүүлэх, эсхүл дурдсан хүсэлтийг хэрэгжүүлэх эрх бүхий холбогдох байгууллагад уламжлах эрх, үүрэг бүхий байгууллага, шаардлагатай тохиолдолд байгууллагуудыг томилно. Энэ зорилгоор байгуулсан байгууллагын тухай Ерөнхий нарийн бичгийн даргад мэдээлнэ. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлт болон түүнд хамаарах аливаа мэдээллийг уламжлах ажиллагааг талуудын томилсон байгууллага харилцан гүйцэтгэнэ. Энэ заалт нь дурдсан хүсэлт, мэдээллийг дипломат шугамаар илгээх, онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд хэрэв энэ нь боломжтой бол, олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллагаар дамжуулан илгээхийг шаардах тухайн талын эрхэд хохирол учруулахгүй.

9. Хүсэлтийг хүлээн авагч талын зөвшөөрөгдсөн хэлээр бичгээр гаргана. Тал бүрийн зөвшөөрөгдсөн хэл болон хэлнүүдийн талаар Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэнэ. Онцгой нөхцөл байдал үүссэн болон талууд харилцан тохиролцсон

тохиолдолд дурдсан хүсэлтийг амаар гаргаж болох боловч уг хүсэлтийг даруй бичгээр баталгаажуулна.

10. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлтэд:

(а) хүсэлт гаргасан байгууллагын тухай мэдээлэл;

б) тухайн хүсэлтэд хамаарах мөрдөн байцаах, эрүүгийн журмаар мөрдөх, байцаан шийтгэх ажиллагааны шинж чанар, үндсэн зүйл, тухайн мөрдөлт, эрүүгийн журмаар мөрдөх, байцаан шийтгэх ажиллагааг хариуцан явуулж буй эрх бүхий байгууллагын нэр, чиг үүрэг;

с) шүүхийн баримт бичигтэй танилцахаас бусад хүсэлтэд холбогдох үйл баримтуудын талаар товч өгүүлэх;

д) хүсч буй тусламжийн тодорхойлолт, хүсэлт гаргагч талын хэрэглэхийг хүсэж буй аливаа тодорхой журмын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

е) хэрэв боломжтой бол холбогдох этгээдийн тухай болон түүний оршин суугаа хаяг, иргэншлийн тухай мэдээ баримт;

ф) нотлох баримт, мэдээлэл цуглуулах, эсхүл арга хэмжээ авах зорилго;

11. Хүсэлт хүлээн авагч тал хэрэв дотоодынх нь хууль тогтоомжийн дагуу хүсэлтийг биелүүлэхэд нэмэлт мэдээлэл шаардлагатай гэж үзсэн, эсхүл уг мэдээлэл нь хүсэлтийг биелүүлэх ажиллагааг хөнгөвчлөх бол нэмэлт мэдээлэл хүсэж болно.

12. Хүсэлт хүлээн авагч тал хүсэлтийг дотоодынхоо хууль тогтоомжийн дагуу түүнд харшлахгүй хэмжээнд, боломжтой бол хүсэлтэд дурдсан журмын дагуу биелүүлнэ.

13. Хүсэлт гаргагч тал хүсэлт хүлээн хүлээн авагч талаас ирүүлсэн мэдээлэл, баримтыг бусад дамжуулж болохгүй бөгөөд хүлээн авагч талтай урьдчилан тохиролцохгүйгээр хүсэлтэд зааснаас бусад мэдээлэл, баримтыг мөрдөн байцаах, эрүүгийн журмаар мөрдөх болон байцаан шийтгэх ажиллагаанд ашиглаж үл болно.

14. Хүлээн авсан хүсэлт болон түүний агуулгын талаарх нууцыг хүсэлтийг биелүүлэхэд шаардлагатайгаас бусад тохиолдолд хадгалахыг хүсэлт гаргагч тал хүлээн авагч талаас шаардах эрхтэй. Хэрэв хүлээн авагч тал нууц хадгалах тухай шаардлагыг хэрэгжүүлж чадахгүй бол энэ тухайгаа хүсэлт гаргагч талд даруй мэдэгдэнэ.

15. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хүсэлтэд дараахь тохиолдолд татгалзсан хариу өгч болно:

а) хэрэв хүсэлт нь энэ зүйлийн заалтуудад нийцэхгүй байвал;

б) хэрэв хүлээн авагч тал тухайн хүсэлтийг биелүүлэх нь өөрийн орны бүрэн эрхт байдал, аюулгүй байдал, нийгмийн дэг журам болон бусад үндсэн эрх ашигт хохирол учруулна гэж үзвэл;

с) хэрэв хүлээн авагч талын дотоодын хуулийн дагуу мөрдөн байцаах, эрүүгийн журмаар мөрдөх болон байцаан шийтгэх ажиллагаа хийгдсэн гэмт хэргийн талаар

гаргасан хүсэлтийг биелүүлэхийг хүлээн авагч талын дотоодын хуулиар өөрийн байгууллагуудад хориглож байвал;

d) хүсэлт нь эрх зүйн харилцан туслалцааны тухай хүсэлтийг биелүүлэх талаарх хүлээн авагч талын эрх зүйн тогтолцооны заалтуудтай зөрчилдөж байвал.

16. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхээс татгалзсан аливаа тохиолдлын үндэслэлийг тайлбарлана.

17. Хүсэлт хүлээн авагч тал гэмт хэргийг мөрдөн байцаах, эрүүгийн журмаар мөрдөх болон байцаан шийтгэх ажиллагаанд саад болно гэж үзвэл эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхийг хойшлуулж болно. Энэ тохиолдолд хүсэлт хүлээн авагч тал түүнээс тогтоож буй болзол, нөхцөлийн дагуу тусламж үзүүлж болох эсэх талаар хүсэлт гаргагч талтай зөвлөлдөнө.

18. Хүсэлт гаргагч талын нутаг дэвсгэрт явагдаж буй мөрдөн байцаах, эрүүгийн журмаар мөрдөх болон байцаан шийтгэх ажиллагаанд туслах, нотлох баримт гаргаж өгөхийг зөвшөөрсөн гэрч, шинжээч болон бусад этгээдийг хүлээн авагч талын нутаг дэвсгэрт байх хугацаандаа хийсэн үйлдэл, зөрчил, шийтгэлтэй нь холбогдуулж хүсэлт гаргагч талын нутаг дэвсгэрт мөрдөх, баривчлах, шийтгэл хүлээлгэх, эсхүл өөр ямар нэгэн байдлаар хувийн эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Гэрч шинжээч болон бусад этгээдийн оролцоо цаашид шүүхийн байгууллагад шаардлагагүй тухай тэдгээрт албан ёсоор мэдэгдсэн өдрөөс хойшхи 15 хоногийн хугацаанд, эсхүл талуудын харилцан тохиролцсон аливаа хугацаанд тэдгээр этгээд тухайн орноос явах боломжтой байсан хэдий ч хүсэлт хүлээн авагч талын нутаг дэвсгэрт сайн дураараа үлдсэн, эсхүл яваад өөрийн хүсэлтээр эргэж ирсэн бол дээрх этгээдүүдийн хувийн аюулгүй байдлын баталгаа нь дуусгавар болно.

19. Хоёр тал өөрөөр тохиролцоогүй бол хүсэлт биелүүлэхэд гарах ердийн зардлыг хүсэлт хүлээн авагч тал хариуцна. Хэрэв хүсэлт биелүүлэх явцад их хэмжээний, эсхүл онцгой зардал шаардагдвал, эсхүл шаардагдахаар бол талууд хүсэлтийг биелүүлэх болзол, нөхцөл, дээрх зардлыг нөхөх аргыг тодорхойлох талаар зөвлөлдөнө.

20. Талууд шаардлагатай гэж үзвэл энэ зүйлийн зорилгод нийцэхүйц бөгөөд түүний заалтуудыг бэхжүүлэх, дурдсан зүйлийн бодит хэрэгжилтийг хангах хоёр болон олон талт хэлэлцээр байгуулах боломжийг хэлэлцэнэ.

8 дугаар зүйл

Байцаан шийтгэх ажиллагааг шилжүүлэх

3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тогтоосон гэмт хэргийг эрүүгийн журмаар мөрдөхтэй холбоотой ажиллагааг нэгээс нөгөөд шилжүүлэх нь байцаан шийтгэх ажиллагааг зохих ёсоор явуулах ашиг сонирхолд нийцэж байгаа тохиолдолд талууд тийнхүү шилжүүлэх боломжийг анхаарч үзнэ.

9 дүгээр зүйл

Сургалт болон хамтын ажиллагааны бусад хэлбэр

1. 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэхийг таслан зогсоох талаар хууль сахиулах үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор талууд

өөрсдийн эрх зүйн болон захиргааны тогтолцоонд нийцүүлэн өөр хоорондоо нягт хамтран ажиллана. Талууд хоёр болон олон талт хэлэлцээр, тохиролцооны үндсэн дээр:

а) Өөрсдийн эрх бүхий байгууллага, албадын хооронд 3 дугаар зүйлийн I дэх хэсэгт заасны дагуу тогтоосон гэмт хэргийн бүхий л хэлбэр болон хэрэв холбогдох талууд ингэх нь зүйтэй гэж үзвэл гэмт үйл ажиллагааны бусад төрлийн холбоонд хамаарах мэдээллийг шуурхай, найдвартай солилцох асуудлыг хөнгөвчлөх харилцааны сувгийг бий болгож ашиглана;

б) 3 дугаар зүйлийн I дэх хэсэгт заасны дагуу тогтоосон олон улсын шинжтэй гэмт хэргийг шалгахад дараахь зүйлийг илрүүлэх зорилгоор өөр хоорондоо хамтран ажиллана:

i) 3 дугаар зүйлийн I дахь хэсэгт заасны дагуу тогтоосон гэмт хэрэгт оролцсон хэмээн сэжиглэгдэж буй этгээд, түүний оршин байгаа газар, үйл ажиллагаа;

ii) дурдсан гэмт хэргийн үр дүнд олсон орлого, хөрөнгийн шилжилт хөдөлгөөн;

iii) мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис, энэхүү конвенцийн I хүснэгт, II хүснэгтэд заасан бодис, дурдсан гэмт хэргийг үйлдэхэд ашигладаг, ашиглахад зориулж бэлтгэсэн багаж хэрэгслийн шилжилт хөдөлгөөн.

с) хувь хүний болон тусгай ажиллагааны аюулгүй байдлыг хангах шаардлагыг анхааралдаа авч, энэ зүйлийн заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор, хэрэв ингэх нь тухайн орны хуулийг зөрчихгүй бол хамтарсан ажлын хэсэг байгуулж ажиллуулна. Дурдсан ажлын хэсэгт орж байгаа аль ч талын албаны хүмүүс нутаг дэвсгэрт нь тусгай ажиллагаа явуулах талын эрх бүхий байгууллагын зөвшөөрлийн дагуу ажиллах бөгөөд дурдсан тохиолдолд нутаг дэвсгэрт нь тусгай ажиллагаа явуулж буй талын бүрэн эрхт байдлыг сонирхогч талууд бүрэн сахина;

д) Зохих тохиолдолд шинжлэх, мөрдөх зориулалтаар аливаа эд зүйлийн загварыг шаардлагатай хэмжээгээр олгоно;

е) эрх мэдэл бүхий байгууллагын болон албаны хамтын ажиллагааг идэвхжүүлэх үүднээс боловсон хүчин, бусад экспертүүд, түүний дотор холбооны ажилтан солилцох явдлыг дэмжинэ.

2. Тал бүр 3 дугаар зүйлийн I дэх хэсэгт заасны дагуу тогтоосон гэмт хэргийг таслан зогсоох үүрэг бүхий хууль сахиулах түүнчлэн гаалийн байгууллагын ажилтныг бэлтгэх тодорхой сургалтын хөтөлбөрийг шаардлагатай хэмжээнд боловсруулж, хэрэгжүүлж, боловсронгуй болгоно. Дурдсан хөтөлбөр нь, тухайлбал, дараахь зүйлийг хамрана:

а) 3 дугаар зүйлийн I дэх хэсэгт заасны дагуу тогтоосон гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох арга;

б) 3 дугаар зүйлийн I дэх хэсэгт заасны дагуу тогтоосон гэмт хэрэгт оролцсон хэмээн сэжиглэгдэж буй этгээдийн чиглэл хөдөлгөөн, арга, ялангуяа дамжин өнгөрүүлэгч улс дахь чиглэл хөдөлгөөн, арга болон холбогдох сөрөг арга хэмжээ;

с) I хүснэгт, II хүснэгтэд заасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын экспорт, импортод тавих хяналт;

d) 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тогтоосон гэмт хэргийн үр дүнд олсон орлого, хөрөнгө, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис, I хүснэгт, II хүснэгтэд заасан бодис, дурдсан гэмт хэргийг хийхэд ашигласан болон ашиглахад зориулсан багаж хэрэгслийн эргэлтийг илрүүлэх, түүнд хяналт тавих;

e) дээр дурдсан орлого, хөрөнгө, багаж хэрэгслийг дамжуулах, далдлах, нуух арга хэлбэрүүд;

f) нотлох баримтыг цуглуулах;

g) чөлөөт худалдааны бүс, чөлөөт боомтуудад хяналт тавих арга зүй;

h) хууль сахиулах орчин үеийн арга зүй.

3. Талууд энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан салбарт тусгай мэдлэг туршлагаа солилцоход зориулсан судалгаа шинжилгээний болон боловсон хүчний сургалтын хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэхэд өөр хоорондоо дэмжлэг үзүүлнэ. Дамжин өнгөрүүлэгч улсуудын тулгамдсан асуудал, онцгой хэрэгцээ, талуудын нийтлэг ашиг сонирхолтой холбоотой асуудал хэлэлцэх болон хамтын ажиллагааг дэмжих зорилгоор, шаардлагатай тохиолдолд бүс нутгийн болон олон улсын хурал, семинар зохион байгуулна.

10 дугаар зүйл

Олон улсын хамтын ажиллагаа болон дамжин өнгөрүүлэгч улсад үзүүлэх тусламж

1. Талууд дамжин өнгөрүүлэгч улс, ялангуяа тусламж, дэмжлэг шаардлагатай хөгжиж байгаа дамжин өнгөрүүлэгч улсад тусламж, дэмжлэг үзүүлэх зорилгоор шууд, эсхүл эрх бүхий холбогдох олон улсын болон бүс нутгийн байгууллагаар дамжуулан хууль бус эргэлтийг таслан зогсоох техникийн хамтын ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх, түүнчлэн үүнтэй холбоотой бусад арга хэмжээг хэрэгжүүлэх замаар хамтран ажиллана.

2. Талууд хууль бус эргэлтийг таслан зогсоох ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд шаардлагатай дамжин өнгөрүүлэгч орны дэд бүтцийг сайжруулахад чиглэгдсэн санхүүгийн тусламжийг шууд болон олон улсын, бүс нутгийн холбогдох байгууллагаар дамжуулан олгох үүргийг хүлээж болно.

3. Талууд энэ зүйлийг хэрэгжүүлэх олон улсын хамтын ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор хоёр болон олон талт гэрээ байгуулж болох бөгөөд үүнтэй холбогдуулж санхүүгийн тохиролцоог анхааралдаа авч болно.

11 дүгээр зүйл

Хяналтан дор хүргүүлэх

1. Хэрэв талуудын үндэсний эрх зүйн тогтолцооны үндсэн зарчимд харшлахгүй бол 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тогтоосон гэмт хэрэг үйлдэхэд оролцсон этгээдийг илрүүлэх, тэдний эсрэг хууль зүйн дагуу ажиллагаа явуулах зорилгоор харилцан хүлээн зөвшөөрсөн хэлэлцээрийн, эсхүл тохиролцооны үндсэн

Бэлтгэгч, импортлогч, экспортлогч, бөөний болон жижиглэн худалдаа эрхлэгчид нь сэжигтэй захиалга, хэлцлийн талаар эрх бүхий байгууллагад мэдээлж хамтран ажиллах замаар энэхүү хяналтын тогтолцоог хэрэгжүүлнэ.

b) Хэрэв I хүснэгт, II хүснэгтэд заасан аливаа бодис нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис хууль бусаар бэлтгэхэд зориулагдсан талаар хангалттай баримт байгаа бол тэдгээрийг хураан авна.

c) Хэрэв мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар бэлтгэх зорилгоор I хүснэгт, II хүснэгтэд заасан аливаа бодисыг экспортлож, импортлож, дамжин өнгөрүүлж байгаа гэж үзэх үндэслэлтэй байвал төлбөрийн хэрэгсэл болон хууль бусаар бэлтгэх үйл ажиллагаа явуулах зорилготой гэж үзэх бусад гол үндэслэлийн тухай талуудын эрх бүхий байгууллагад болон холбогдох албадад аль болох хурдан хугацаанд мэдээлнэ.

d) Экспортлож, импортлож буй бодисын бичиг баримт, шошго шаардлага хангасан байхын шаардана. Ачааны мэдүүлэг, нэхэмжлэл, гаалийн болон тээврийн зэрэг бичиг баримтууд нь I хүснэгт, II хүснэгтэд заасан экспортлож, импортлож буй бодисын нэр, тоо хэмжээ, экспортлогч, импортлогчийн болон боломжтой бол бараа хүлээн авагчийн нэр, хаягийг агуулна.

e) Энэ хэсгийн (d) дэд хэсэгт дурдсан бичиг баримтыг эрх бүхий байгууллагаас шалгах боломж олгох үүднээс наад зах нь хоёр жил хадгална.

10. (a) 9 дэх хэсгийн заалтын нэмэлт болгож, мөн сонирхогч талын хүсэлтээр I хүснэгт, II хүснэгтэд заасан ямар ч бодисыг нутаг дэвсгэрээсээ экспортлогч аливаа тал нь түүний эрх бүхий байгууллагууд импортлогч талын эрх бүхий байгууллагуудад дараахь мэдээллийг өгөхөд анхаарна:

- i) экспортлогч, импортлогч, боломжтой бол бараа хүлээн авагчийн нэр, хаяг;
- ii) I хүснэгтэд заасан бодисын нэр;
- iii) экспортлох бодисын тоо хэмжээ;
- iv) хүлээн авбал зохих боомт, илгээх он, сар, өдөр;
- v) талууд харилцан тохиролцсон аливаа бусад мэдээлэл.

(b) Аль нэг нь энэ хэсэгт дурдсанаас илүү хатуу, чанга хяналтын аргыг хэрэглэх түүний үзэж байгаагаар зохимжтой эсхүл шаардлагатай бол тийм аргыг хэрэглэж болно.

11. Хэрэв аль нэг тал нөгөө талдаа энэ зүйлийн 9, 10 дахь хэсэгт заасны дагуу мэдээлэл өгч байгаа бол мэдээлэл өгөгч тал худалдааны, албаны, бизнесийн, мэргэжлийн нууц болон худалдааны ажиллагааны нууц байдлыг алдагдуулахгүй байхыг мэдээлэл хүлээн авагч талаас шаардаж болно.

12. Тал бүр Хорооноос тогтоосон хугацаанд, Хорооны өгсөн загвар, маягтын дагуу дараахь мэдээллийг хороонд жил бүр өгнө:

а) I хүснэгт болон II хүснэгтэд заасан хураагдсан бодисын хэмжээ, боломжтой бол гарал үүслийн тухай;

б) мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар бэлтгэхэд ашигласан, тухайн талын үзэж буйгаар Хорооны анхаарлыг хандуулах шаардлагатай I хүснэгт буюу II хүснэгтэд заагаагүй бодисын тухай;

с) алдагдах төрөл болон хууль бусаар бэлтгэх аргын тухай мэдээлэл.

13. Хороо нь энэ зүйлийн хэрэгжилтийн талаар Комисст жил бүр мэдээлэх болон Комисс нь I хүснэгт болон II хүснэгтийн зохимжтой, хангалттай байдлыг тогтмол хянана.

14. Энэ зүйлийн заалтууд нь I хүснэгт, II хүснэгтэд дурдсан бодисын найрлагатай боловч дурдсан бодис нь амархан ашиглах, салгаж авах боломжгүй эмийн болон бусад бэлдмэлд хамаарахгүй.

13 дугаар зүйл

Материал, тоног төхөөрөмж

Талууд шаардлагатай гэж үзвэл мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар бэлтгэхэд хэрэглэгддэг материал, тоног төхөөрөмжийн худалдаа, түгээлтийг таслан зогсоох шаардлагатай арга хэмжээг авах бөгөөд энэ зорилгоор хамтран ажиллана.

14 дүгээр зүйл

Мансууруулах ургамлын хууль бус тарималжуулалтыг арилгах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эрэлтийг устгах арга хэмжээ

1. Талуудаас энэхүү конвенцийн дагуу авсан аливаа арга хэмжээ нь 1961 оны конвенц, 1971 нэмэлт өөрчлөлт оруулсан 1961 оны конвенц, 1971 оны конвенцийн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис агуулсан ургамлын хууль бус тариалалтыг арилгах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эрэлтийг устгахад холбогдох заалтаас илүү зөөлөн байж болохгүй.

2. Талууд тухайн орны нутаг дэвсгэрт опиум намуу, кока бут, каннабис ургамал зэрэг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис агуулсан ургамлыг тарималжуулахаас урьдчилан сэргийлэх, түүнийг устгах талаар арга хэмжээ авна. Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүний үндсэн эрхийг хүндэтгэх бөгөөд дурдсан ургамлын хууль ёсны уламжлалт хэрэглээний тухай түүхэн баримт байгаа бол уг хэрэглээ болон байгаль орчныг хамгаалах сонирхлыг харгалзана.

3. а) Талууд хууль бус тарималжуулалтыг устгах хүчин чармайлтын үр нөлөөг дээшлүүлэх талаар хамтран ажиллаж болно. Ийм хамтын ажиллагаа нь ялангуяа эдийн засгийн хувьд хууль бусаар тариалахаас илүү үр ашигтай өөр төрлийн аж ахуйг хөгжүүлэх боломжтой хөдөөгийн дүүргүүдийг иж бүрнээр нь хөгжүүлэхэд чиглэгдсэн байж болно. Хөдөөгийн хөгжлийн талаар тодорхой хөтөлбөр хэрэгжүүлэхдээ зах зээлд нэвтрэх боломж, нөөц, нийгэм-эдийн засгийн нөхцөл зэргийг харгалзан үзэх нь зүйтэй. Талууд хамтын ажиллагааны аливаа бусад хэлбэрийг сонгож болно.

б) Талууд түүнчлэн шинжлэх ухаан, техникийн мэдээлэл солилцох болон устгах талаар судалгаа явуулахад дэмжлэг үзүүлнэ.

с) Хэрэв талууд нэгдсэн хилтэй бол уг хилийн бүсэд мансууруулах ургамлыг хууль бусаар тариалахын эсрэг хамтран ажиллахыг эрмэлзэнэ.

4. Талууд хүмүүсийн зовлонг багасгах, хууль бус тээвэрлэлтэд үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг устгах зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эрэлтийг үгүй болгох, бууруулахад чиглэсэн зохих арга хэмжээг авна. Эдгээр арга хэмжээ нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллага болох Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон бусад олон улсын эрх бүхий байгууллагаас гаргасан зөвлөмж, түүнчлэн 1987 онд болсон Мансууруулах эмийг урвуулан хэрэглэх, хууль бус эргэлтийн талаархи олон улсын бага хурлаас гаргасан Олон талт баримт бичигт тулгуурлаж болно. Талууд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эрэлтийг үгүй болгох, бууруулах талаар хоёр болон олон талт гэрээ хэлцэл байгуулж, бусад тохиролцоонд хүрч болно.

5. Талууд I хүснэгт, II хүснэгтэд заасан түр хурааж авсан, эсхүл хураагдсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг богино хугацаанд устгах, эсхүл хууль ёсоор ашиглах, зохих ёсоор баталгаажуулсан шаардлагатай хэмжээний тийм бодисыг нотолгооны зориулалтаар хэрэглэх талаар шаардлагатай арга хэмжээ авч болно.

15 дугаар зүйл

Арилжааны тээвэрлэгч

1. Талууд арилжааны тээвэрлэгчдийн ашиглаж буй тээврийн хэрэгслийг 3 дугаар зүйлийн I дэх хэсэгт заасны дагуу тогтоосон гэмт хэрэг үйлдэхэд ашиглахгүй байхад шаардагдах арга хэмжээ авна. Үүнд арилжааны тээвэрлэгчидтэй байгуулах тусгай тохиролцоог багтааж болно.

2. Тал бүр арилжааны тээвэрлэгчдээс тэдгээрийн тээврийн хэрэгслийг 3 дугаар зүйлийн I дэх хэсгийн дагуу тогтоосон гэмт хэргийг үйлдэхэд ашиглахаас урьдчилан сэргийлэх талаар зохих ёсны сэрэмжлүүлэх арга хэмжээ авахыг шаардана. Эдгээр сэрэмжлүүлэгт дараахь зүйлийг багтааж болно:

а) Хэрэв арилжааны тээвэрлэгчийн үйл ажиллагаагаа явуулдаг гол газар нь тухайн талын нутаг дэвсгэрт байрладаг бол:

- (i) ажилтнуудыг сэжигтэй бараа, этгээдийг танихад сургах;
- (ii) ажилтны шударга зан чанарыг дэмжих.

б) Арилжааны тээвэрлэгч тухайн талын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг бол:

- (i) бололцоотой үед ачааны дагалдах бичгийг урьдчилан өгөх;
- (ii) чингэлэгт таних тэмдэг бүхий, хуурамчаар үйлдэх бололцоогүй лац хэрэглэх;

(iii) 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тогтоосон гэмт хэргийг үйлдэхтэй холбогдолтой байж болох нөхцөл байдлын тухай холбогдох байгууллагад цаг алдалгүй мэдээлэх.

3. Тал бүр тээврийн хэрэгсэл, ачаанд зөвшөөрөлгүй нэвтрэхээс урьдчилан сэргийлэх, шаардагдах аюулгүй байдлын арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор орж, гарах цэгүүд, гаалийн хяналтын бусад бүсэд арилжааны тээвэрлэгч болон холбогдох байгууллага хоорондын хамтын ажиллагааг хангахыг эрмэлзэнэ.

16 дугаар зүйл

Арилжааны баримт бичиг, экспортын таних тэмдэг

1. Тал бүр хууль ёсоор экспортлож буй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис нь холбогдох баримт бичигтэй байхыг шаардана. 1961 оны конвенцийн 31 дүгээр зүйл, нэмэлт өөрчлөлт оруулсан 1961 оны конвенцийн 31 дүгээр зүйл болон 1971 оны конвенцийн 12 дугаар зүйлийн дагуу шаардагдах баримт бичгээс гадна зарлагын баримт, ачааны дагалдах бичиг, гаалийн болон бусад тээврийн баримт бичиг зэрэг арилжааны баримт бичигт 1961 оны конвенц, нэмэлт өөрчлөлт оруулсан 1961 оны конвенц болон 1971 оны конвенцийн холбогдох жагсаалтад заасны дагуу экспортлож буй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын нэр, экспортлож буй хэмжээ болон экспортлогч, импортлогч болон бололцоотой үед бараа хүлээн авагчийн нэр, хаягийг заах үүрэгтэй.

2. Тал бүр экспортлож буй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын таних тэмдгийг буруу тавихгүй байхыг шаардана.

17 дугаар зүйл

Далай дахь хууль бус эргэлт

1. Талууд олон улсын далайн эрх зүйд нийцүүлэн далай дахь хууль бус эргэлтийг таслан зогсооход аль болох өргөнөөр хамтран ажиллана.

2. Өөрийн улсын төрийн далбааг мандуулсан, эсхүл бүртгэлийн таних тэмдэг, далбаагаа мандуулахгүй байгаа хөлөг онгоцыг хууль бус эргэлттэй холбогдолтой гэж сэжиглэх боломжит үндэслэл бүхий тал түүнийг тэр зорилгоор ашиглахыг таслан зогсооход туслалцаа үзүүлэхийг бусад талаас хүсэж болно. Тийм хүсэлт хүлээн авсан талууд өөрт бололцоотой аргаар туслалцаа үзүүлнэ.

3. Олон улсын далайн эрх зүйн дагуу навигацийн эрх чөлөө эдэлж, өөр талын бүртгэлийн таних тэмдэг үзүүлж, эсхүл төрийн далбаа мандуулж буй хөлөг онгоцыг хууль бус тээвэртэй холбогдолтой гэж сэжиглэх боломжит үндэслэл бүхий тал далбааны эзэн улсад энэ талаар мэдэгдэж, бүртгэлийг нь нотлохыг хүсэж болох бөгөөд нотлогдсон тохиолдолд далбааны эзэн улсаас тухайн хөлөг онгоцны талаар шаардлагатай арга хэмжээ авах зөвшөөрөл хүсэж болно.

4. 3 дахь хэсгийн дагуу, эсхүл хооронд нь хүчин төгөлдөр үйлчилж буй гэрээний дагуу, эсхүл хоорондоо байгуулсан аливаа хэлцэл, тохиролцооны дагуу далбааны эзэн улс хүсэлт гаргасан улсад дараахь эрхийг *inter aria* зөвшөөрч болно:

а) хөлөг онгоцны тавцан дээр гарах;

b) хөлөг онгоцыг нэгжих;

c) хууль бус тээвэрт оролцсон тухай нотлох баримт олдсон тохиолдолд хөлөг онгоц, түүний тавцан дээрх этгээд болон ачааны талаар холбогдох арга хэмжээ авах.

5. Энэ зүйлд заасны дагуу арга хэмжээ авах үед холбогдох талууд далай дахь амь биеийн аюулгүй байдал, хөлөг онгоц болон ачааны аюулгүй байдалд занал учруулахгүй байх, далбааны эзэн улс буюу өөр аливаа холбогдох улсын арилжааны болон хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхгүй байх шаардлагыг зохих ёсоор анхаарна.

6. Далбааны эзэн улс энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүргийн дагуу зөвшөөрөл өгөхдөө хариуцлагатай холбоотой нөхцөл болон бусад нөхцөлийг хүсэлт гаргагч талтай харилцан тохиролцож тодорхойлж болно.

7. Энэ зүйлийн 3, 4 дэх хэсгийн зорилгоор тал нь өөр улсын төрийн далбааг мандуулсан хөлөг онгоц тийм эрхтэй эсэхийг тодруулах тухай хүсэлт, түүнчлэн 3 дахь хэсэгт заасны дагуу илгээсэн зөвшөөрлийн талаарх нөгөө талын хүсэлтэд цаг алдалгүй хариу өгнө. Тал бүр энэхүү конвенцид оролцогч тал болохдоо ийм хүсэлтийг хүлээн авч, хариу өгөх эрх бүхий байгууллага, шаардлагатай бол байгууллагуудыг тодорхойлно. Тэдгээрийг тодорхойлсноос хойш нэг сарын дотор энэ талаар Ерөнхий нарийн бичгийн дарга бусад бүх талд мэдэгдэнэ.

8. Энэ зүйлийн дагуу аливаа ажиллагаа явуулсан тал түүний үр дүнг далбааны эзэн улсад цаг алдалгүй мэдэгдэнэ.

9. Талууд энэ зүйлийн заалтыг биелүүлэх, эсхүл илүү үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор хоёр буюу олон талт гэрээ, тохиролцоо байгуулах боломжийг судална.

10. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан арга хэмжээг зөвхөн цэргийн хөлөг онгоц буюу цэргийн агаарын хөлөг, эсхүл холбогдох зөвшөөрөлтэй бөгөөд төрийн үйлчилгээ үзүүлж буй гэж танигдах таних тэмдэг бүхий бусад хөлөг онгоц, эсхүл агаарын хөлөг хэрэгжүүлнэ.

11. Энэ зүйлийн дагуу аливаа арга хэмжээг хэрэгжүүлэхэд эргийн улсын олон улсын далайн эрх зүйн дагуу эдлэх эрх, хүлээсэн үүрэг болон хэргийн харьяаллаа хэрэгжүүлэх эрхийг зөрчих буюу хөндөхгүй байх шаардлагыг зохих ёсоор анхаарна.

18 дугаар зүйл

Чөлөөт худалдааны бүс, чөлөөт боомт

1. Талууд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис болон I хүснэгт, II хүснэгтэд заасан бодисын хууль бус эргэлтийг таслан зогсоох зорилгоор худалдааны чөлөөт бүс, чөлөөт боомтод тухайн улсын бусад нутаг дэвсгэрт хэрэгжүүлж буй арга хэмжээнээс зөөлөнгүй арга хэмжээ авна.

2. Талууд дараахь арга хэмжээг хэрэгжүүлэхийг эрмэлзэнэ:

a) худалдааны чөлөөт бүс, чөлөөт боомт дахь бараа, хүмүүсийн хөдөлгөөнийг хянах, энэ зорилгоор амралтын болон загас олборлолтын хөлөг онгоц, түүнчлэн агаарын хөлөг, хуурай замын тээврийн хэрэгслийг оролцуулан орж, гарч буй хөлөг

онгоцны ачаа, шаардлагатай үед тэдгээрт байгаа багийн гишүүд, зорчигчид, тэдний ачааг нэгжих зөвшөөрлийг өөрийн эрх бүхий байгууллагад олгох;

b) худалдааны чөлөөт бүс, чөлөөт боомтод орж, гарч буй, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис болон I хүснэгт, II хүснэгтэд заасан бодисыг агуулсан байж болох барааг илрүүлэх тогтолцоо байгуулж, ашиглах;

c) боомтын байгууламжийн орчин тойрон, нисэх онгоцны буудал болон хилийн шалган нэвтрүүлэх цэгт хяналтын тогтолцоо байгуулж, ашиглах.

19 дүгээр зүйл

Шуудан ашиглах

1. Талууд Дэлхийн шуудангийн холбооны конвенцуудын дагуу хүлээсэн үүрэг болон дотоодынхоо эрх зүйн тогтолцооны үндсэн зарчимд нийцүүлэн шууданг хууль бус эргэлтэд ашиглахыг хориглох арга хэмжээ авч, энэ зорилгоор хамтран ажиллана.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан арга хэмжээнд тухайлбал дараахь арга хэмжээ орно:

a) шууданг хууль бус эргэлтэд ашиглахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох нэгдсэн арга хэмжээ авах;

b) I хүснэгт, II хүснэгтэд заасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын шуудан дахь хууль бус илгээлтийг илрүүлэх мөрдөлт, хяналтын арга зүй, багаж хэрэгслийг хууль сахиулах байгууллагын эрх бүхий ажилтнууд нэвтрүүлэх болон ашиглах;

c) эрүүгийн журмаар мөрдөхөд шаардлагатай нотлох баримтыг олж авах зорилгоор зохих ёсны арга хэрэгсэл хэрэглэх боломж олгох хууль тогтоох арга хэмжээ.

20 дугаар зүйл

Талуудын өгөх мэдээлэл

1. Талууд тэдгээрийн нутаг дэвсгэр дээрх конвенцийн хэрэгжилтийн тухай мэдээллийг Ерөнхий нарийн бичгийн даргаар дамжуулан Комисст өгнө, тухайлбал:

a) энэхүү конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор батласан хууль, дүрэм журмын эх бичвэр;

b) шинээр илэрсэн хандлага, хууль бус эргэлтэд орсон хэмжээ, хууль бус эргэлт эрхэлж буй этгээдүүдийн бодис болон арга зүйг олж авсан эх сурвалжийг харгалзан талуудын чухал гэж үзсэн, тэдгээрийн хэргийн харьяалалд хамаарч буй, хууль бус эргэлттэй холбоотой хэргүүдийн тухай тодорхой мэдээлэл.

2. Талууд ийм мэдээллийг Комиссын хүсэлт болгосон хэлбэрээр болон хугацаанд өгнө.

21 дүгээр зүйл

Комиссын чиг үүрэг

Комисс нь энэхүү конвенцийн зорилгод хамаарах бүх асуудлыг авч үзэх бүрэн эрхтэй, тухайлбал:

а) Комисс нь 20 дугаар зүйлийн дагуу талуудын өгсөн мэдээллийн үндсэн дээр энэхүү конвенцийн хэрэгжилтийг хянана;

б) Комисс нь талуудаас хүлээн авсан мэдээллийг шалгасны үндсэн дээр санал, ерөнхий зөвлөмж гаргаж болно;

с) Комисс нь Хорооны чиг үүрэгтэй холбоотой байж болох аливаа асуудалд түүний анхаарлыг хандуулж болно;

д) Комисс нь 22 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу Хорооноос Комиссоор хэлэлцүүлэхээр ирүүлсэн аливаа асуудлаар шаардлагатай гэж үзсэн ажиллагааг явуулна;

е) Комисс нь 12 дугаар зүйлд заасан журмын дагуу I хүснэгт, II хүснэгтэд нэмэлт өөрчлөлт оруулж болно;

г) Комисс нь энэхүү конвенцийн тал болоогүй улсуудад энэхүү конвенцийн дагуу арга хэмжээ авах асуудлыг авч үзэх боломж олгох зорилгоор тэдгээр улсын анхаарлыг энэхүү конвенцийн дагуу Комиссоос гаргасан шийдвэр, зөвлөмжид хандуулж болно.

22 дугаар зүйл

Хорооны чиг үүрэг

1. 21 дүгээр зүйлийн дагуу Комиссын чиг үүрэг, 1961 оны конвенц, нэмэлт, өөрчлөлт оруулсан 1961 оны конвенц болон 1971 оны конвенцийн дагуу Хороо, Комиссын чиг үүргийг хөндөхгүйгээр:

а) Хэрэв Хороо Ерөнхий нарийн бичгийн дарга, эсхүл Комисст ирүүлсэн мэдээлэл, эсхүл Нэгдсэн Үндэстний Байгууллагын байгууллагуудаас өгсөн мэдээллийг хэлэлцээний үндсэн дээр түүний бүрэн эрхэд хамаарах асуудлаар энэхүү конвенцийн зорилго хэрэгжихгүй байна гэж үзэх үндэслэлтэй гэж шийдвэрлэвэл аливаа холбогдох мэдээлэл өгөхийг талд болон талуудад санал болгож болно:

б) 12, 13 болон 16 дугаар зүйлийн хувьд:

(i) Хэрэв Хороо энэ зүйлийн (а) дэд хэсгийн дагуу арга хэмжээ авсны дараа шаардлагатай гэж үзвэл 12, 13 болон 16 дугаар зүйлийн заалтыг биелүүлэхэд тухайн нөхцөл байдалд шаардлагатай байж болох засах арга хэмжээ авахыг холбогдох талд уриалж болно.

(ii) Хороо (iii) дэд хэсэгт заасан арга хэмжээг авахаас өмнө өмнөх дэд хэсгүүдэд үндэслэн холбогдох талтай тогтоосон харилцаагаа нууцад хамааруулна;

- (iii) Хэрэв энэ дэд хэсгийн дагуу Хорооноос талд санал болгосон засах арга хэмжээг холбогдох тал аваагүй нь Хороонд тодорхой болбол тэрээр энэ асуудалд талууд, Зөвлөл болон Комиссын анхаарлыг хандуулж болно. Энэ заалтын дагуу Хорооноос нийтэлсэн аливаа илтгэлд холбогдох тал ингэхийг хүссэн тохиолдолд түүний саналыг мөн оруулна.

2. Ашиг сонирхол нь шууд хөндөгдөж буй асуудлыг энэ зүйлд заасны дагуу хэлэлцэх Хорооны хуралд оролцохыг аливаа холбогдох талд санал болгоно.

3. Энэ зүйлийн дагуу гаргах Хорооны шийдвэр санал нэгтэй биш байх тохиолдолд цөөнхийн саналыг тусгана.

4. Энэ зүйлийн дагуу гаргах Хорооны шийдвэрийг Хорооны нийт гишүүдийн гуравны хоёрын олонхийн саналаар батална.

5. Хороо энэ зүйлийн 1 (а) дэд хэсэгт заасан чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор түүний мэдэлд ирж болох бүх мэдээллийн нууцлалыг хангана.

6. Энэ зүйлд заасан Хорооны хариуцлага нь энэхүү конвенцийн заалтын дагуу талуудын хооронд байгуулсан гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хамаарахгүй.

7. Энэ зүйлийн заалтыг талуудын хоорондын 32 дугаар зүйлийн заалтад хамаарагдах маргаанд хэрэглэхгүй.

23 дугаар зүйл

Хорооны илтгэл

1. Хороо өөрийн эрх мэдэлд байгаа мэдээллийн талаарх дүн шинжилгээ, холбогдох тохиолдолд түүний тайлбар, хэрэв байгаа бол талуудын өгсөн, эсхүл талуудад өгөхийг хүсэлт болгосон тайлбарын агуулгыг Хорооны хүссэн аливаа тэмдэглэл, зөвлөмжийн хамт тусгасан, өөрийн ажлын тухай илтгэлийг жил бүр бэлтгэнэ. Хороо өөрөө шаардлагатай гэж үзсэн нэмэлт илтгэлийг гаргаж болно. Илтгэлийг Комиссоор дамжуулан Зөвлөлд хүргүүлэх бөгөөд Комисс нь илтгэлд зохимжтой гэж үзсэн тэмдэглэл хийж болно.

2. Хорооны илтгэлүүдийг талуудад хүргүүлэх болон үүний дараа Ерөнхий нарийн бичгийн дарга тэдгээрийг нийтэлнэ. Талууд илтгэлийг хязгаарлалтгүйгээр түгээхийг зөвшөөрнө.

24 дүгээр зүйл

Энэхүү конвенцид зааснаас илүү хатуу арга хэмжээ авах

Тал нь түүний үзэж байгаагаар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх болон түүнийг таслан зогсооход зохимжтой, эсхүл шаардлагатай бол энэхүү конвенцид зааснаас илүү чанга буюу хатуу арга хэмжээ авч болно.

25 дугаар зүйл

Өмнөх гэрээг үгүйсгэхгүй байх

Энэхүү конвенцийн заалтууд нь энэхүү конвенцид оролцогч талуудын 1961 оны конвенц, нэмэлт өөрчлөлт оруулсан 1961 оны конвенц болон 1971 оны конвенцийн дагуу хүлээсэн аливаа эрх, үүргийг үгүйсгэхгүй.

26 дугаар зүйл

Гарын үсэг

Энэхүү конвенц нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Вена дахь ажлын байранд 1988 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс 1989 оны 2 дугаар сарын 28-ны өдөр хүртэл, түүнээс хойш Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нью-Йорк дахь төв байранд 1989 оны 12 дугаар сарын 20-ны өдөр хүртэл

а) бүх улс;

б) Нэгдсэн Үндэстний Байгууллагын Намибийн зөвлөлөөр төлөөлүүлэн Намиби Улс;

с) энэхүү конвенцоор зохицуулдаг асуудлаар олон улсын хэлэлцээр байгуулахаар хэлэлцээ хийх, байгуулах, хэрэгжүүлэх эрх бүхий бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын хувьд

гарын үсэг зурахад нээлттэй байна. Уг конвенцийн хүрээнд талууд, улсууд, эсхүл үндэсний албад гэснийг тэдгээрийн эрх хэмжээний хүрээнд эдгээр байгууллагад хэрэглэнэ.

27 дугаар зүйл

Соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах буюу албан ёсоор нотлох акт

1. Энэхүү конвенцийг улсууд, эсхүл Нэгдсэн Үндэстний Байгууллагын Намибийн зөвлөлөөр төлөөлүүлэн Намиби Улс соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх буюу батлах бөгөөд 26 дугаар зүйлийн (с) дэд хэсэгт заасан бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагууд албан ёсоор нотолно. Батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн тухай, эсхүл батласан тухай баримт бичгийг болон албан ёсоор нотлох актад холбогдолтой баримт бичгийг Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

2. Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагууд албан ёсоор нотлох баримт бичигтээ энэхүү конвенцоор зохицуулах асуудлаар ямар эрх хэмжээтэй болохоо мэдэгдэнэ. Эдгээр байгууллага энэхүү конвенцоор зохицуулах асуудлаархи эрх хэмжээнд орсон аливаа өөрчлөлтийн талаар Ерөнхий нарийн бичгийн даргад мөн мэдээлнэ.

28 дугаар зүйл

Нэгдэн орох

1. Энэхүү конвенц нь түүнд аливаа улс, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Намибийн зөвлөлөөр төлөөлүүлсэн Намиби Улс болон 26 дугаар зүйлийн (с) дэд хэсэгт заасан бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагууд нэгдэн ороход нээлттэй байна. Ерөнхий нарийн бичгийн даргад нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулснаар нэгдэн орсонд тооцно.

2. Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагууд нэгдэн орсон тухай баримт бичигтээ энэхүү конвенцоор зохицуулах асуудлаар ямар эрх хэмжээтэй болохоо мэдэгдэнэ. Эдгээр байгууллага энэхүү конвенцоор зохицуулах асуудлаархи эрх хэмжээнд орсон аливаа өөрчлөлтийн талаар Ерөнхий нарийн бичгийн даргад мөн мэдээлнэ.

29 дүгээр зүйл

Хүчин төгөлдөр болох

1. Энэхүү конвенц нь улс, эсхүл Нэгдсэн Үндэстний Байгууллагын Намибийн зөвлөлөөр төлөөлүүлсэн Намиби Улс хорь дахь батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, батласан, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулсан өдрөөс хойш ер дэх хоногт хүчин төгөлдөр болно.

2. Хорь дахь батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, батласан, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулснаас хойш энэхүү конвенцийг соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн, батласан, эсхүл түүнд нэгдэн орсон улс, эсхүл Нэгдсэн Үндэстний Байгууллагын Намибийн зөвлөлөөр төлөөлүүлсэн Намиби Улсын хувьд энэхүү конвенц түүний батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, батласан, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулсан өдрөөс хойш ер дэх хоногт хүчин төгөлдөр болно.

3. Албан ёсоор нотлох актад холбогдолтой баримт бичиг, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгсөн 26 дугаар зүйлийн (с) дэд хэсэгт заасан бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагуудын хувьд энэхүү конвенц нь тийнхүү баримт бичгийг хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш ер дэх хоног болон энэхүү конвенц энэ зүйлийн 1 дэх хэсгийн дагуу хүчин төгөлдөр болох өдрийн аль сүүлчийнхэд нь хүчин төгөлдөр болно.

30 дугаар зүйл

Цуцлах

1. Аливаа тал Ерөнхий нарийн бичгийн даргад бичгээр мэдэгдсэнээр энэхүү конвенцийг цуцалж болно.

2. Уг цуцлалт нь холбогдох талын хувьд Ерөнхий нарийн бичгийн дарга дээрх мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно.

31 дүгээр зүйл

Нэмэлт өөрчлөлт оруулах

1. Аливаа тал энэхүү конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргаж болно. Нэмэлт өөрчлөлтийн эх бичвэр, түүний үндэслэлийг тухайн тал Ерөнхий нарийн бичгийн даргад илгээж, Ерөнхий нарийн бичгийн дарга түүнийг бусад талд илгээж тухайн саналыг хүлээн авч буй эсэхийг нь тодруулна. Ийнхүү нэмэлт өөрчлөлт оруулах саналыг илгээснээс хойш хорин дөрвөн сарын дотор нэг ч тал татгалзсан хариу ирүүлээгүй тохиолдолд түүнийг хүлээн зөвшөөрсөнд тооцож, нэмэлт өөрчлөлт нь тухайн нэмэлт өөрчлөлтийг зөвшөөрсөн тухай мэдэгдсэн баримт бичгийг Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш ерэн хоногийн дараа тийнхүү мэдэгдсэн талын хувьд хүчин төгөлдөр болно.

2. Хэрэв аль нэг тал нэмэлт өөрчлөлтийн саналд татгалзсан хариу өгвөл Ерөнхий нарийн бичгийн дарга талуудтай зөвлөлдөн олонхийн саналыг авч, тэдний хүсэлтээр талуудын өгсөн тайлбарын хамт асуудлыг Зөвлөлд шилжүүлж, Зөвлөл Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн 62 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу бага хурал зарлан хуралдуулж болно. Ийм бага хурлаас гарсан аливаа нэмэлт өөрчлөлтийг нэмэлт өөрчлөлтийн протоколд тусгана. Энэ протоколыг биелүүлэх зөвшөөрлийг Ерөнхий нарийн бичгийн даргад тусгайлан илэрхийлнэ.

32 дугаар зүйл

Маргаан шийдвэрлэх

1. Хэрэв хоёр буюу түүнээс дээш талын хооронд энэхүү конвенцийг тайлбарлах, эсхүл хэрэглэхтэй холбоотой маргаан гарвал талууд маргааныг хэлэлцээ, зөвлөмж авах, зуучлах, арбитр, бүс нутгийн байгууллага, шүүх ажиллагаа буюу өөрийн сонголтоор бусад эв зүйн аргаар шийдвэрлэх талаар зөвлөлдөнө.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар шийдвэрлэж чадахгүй маргааныг маргааны тал улсуудын аль нэгийг нь хүсэлтээр Олон улсын шүүхээр шийдвэрлүүлэхээр шилжүүлж болно.

3. 26 дугаар зүйлийн (с) дэд хэсэгт заасан бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар шийдвэрлэх боломжгүй маргааны тал бол тухайн байгууллага Шүүхийн дүрмийн 65 дугаар зүйлийн дагуу Олон улсын шүүхээс аль санал нь шийдвэрлэх санал байх талаар зөвлөх дүгнэлт гаргуулах хүсэлтийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын аль нэг гишүүн улсаар уламжлуулан Зөвлөлд гаргаж болно.

4. Энэхүү конвенцид гарын үсэг зурах, эсхүл түүнийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, эсхүл түүнд нэгдэн орох үед улс, эсхүл гарын үсэг зурсан, эсхүл албан ёсоор нотлох актыг хадгалуулахаар өгөх, эсхүл нэгдэн орох үед бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага энэ зүйлийн 2, 3 дахь хэсгийг дагаж мөрдөхгүйгээ мэдэгдэж болно. Ийм мэдэгдэл гаргасан талын хувьд бусад тал 2, 3 дахь хэсгийг дагаж мөрдөхгүй.

33 дугаар зүйл

Адил хүчинтэй эх бичвэр

Энэхүү конвенцийн англи, араб, испани, франц, хятад, орос эх бичвэрүүд адил хүчинтэй байна.

34 дүгээр зүйл

Эх хадгалагч

Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү конвенцийн эх хадгалагч байна.

Дээр дурдсаныг нотолж, засгийн газраасаа зохих ёсоор бүрэн эрх олгогдсон дор гарын үсэг зурагсад энэхүү конвенцид гарын үсэг зурав.

Вена хотноо нэг мянга есөн зуун наян найман оны арван хоёрдугаар сарын хорины өдөр нэг жинхэнэ эх хувь үйлдэв.

ХАВСРАЛТ

I хүснэгт	II хүснэгт
N-ацетил атраниловын хүчил	Цууны хүчлийн ангидрид
Изосафрол	Антраноловын хүчил
Лизергиний хүчил	Ацетон
3,4-тетилендиоксифенил-2-пропанон	Тетилэтилкетон
Пиперональ	Пертанганат кали
Псевдоэфедрин	Пиперидин
Сафрол	Хүхрийн хүчил
1-фенил-2-пропанон	Давсны хүчил
Эрготетрин	Толуол
Эрготатин	Этилийн эфир
Эфедрин	Фенилуксусны хүчил
Энэ хүснэгтэд заасан ийм давснууд байж болох бүх тохиолдол	Энэ хүснэгтэд заасан ийм давснууд байж болох бүх тохиолдол (давсны хүчлийн болон хүхрийн хүчлийн давснууд хамаарахгүй)

Төрийн мэдээлэл Тусгай дугаар :
олон улсын гэрээ Бот

F
67.91
T594



2230